



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

СЭТГҮҮЛ ЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ

2025

Монголд гэрэл зургийн алба үүсэж сэтгүүл зүйн хүчирхэг хүчин зүйл, бие даасан урлаг болж хөгжиж төлөвшсөн нь

Орчин үеийн масс-медиа: мэдээний үр нөлөөг дээшлүүлэх боломж, шаардлага

Нэвтрүүлгийн зохиолын агуулга, хэлбэр, хийцийн нэгдэл буюу туурвил зүйн онцлог

Цахим орчинд хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлах боломж

Монгол дахь улс төрийн мэдээллийн манипуляци: мета төлбөртэй сурталчилгааны сангийн өгөгдөлд суурилсан шинжилгээ

Редакцын зөвлөл:

Эрхлэгч:

М.ЗУЛЬКАФИЛЬ

МУИС-ийн Эмерит профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D), Улаанбаатар, Монгол Улс

Редактор:

Д.ИДЭРЖАРГАЛ

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Гишүүд:

Б.БОЛД-ЭРДЭНЭ

МУИС-ийн ШУС-ийн захирал, дэд профессор, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Л.НОРОВСҮРЭН

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D), Улаанбаатар, Монгол Улс

Б.НАРАНБААТАР

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

Т.БААСАНСҮРЭН

Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор, Улаанбаатар, Монгол Улс

Ж.БАТБААТАР

МУБИС-ийн ректор, доктор (Ph.D), профессор, Улаанбаатар, Монгол Улс

Д.ДАГИЙМАА

ХУИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор, Улаанбаатар, Монгол Улс

ВОЛКОВА ИРИНА ИВАНОВНА

Улс Түмний Найрамдлын Их Сургуулийн профессор, Хэл бичгийн шинжлэх ухааны доктор (Sc.D), Москва, ОХУ

ДЕРЕК МОСКАТО

Баруун Вашингтоны Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D) Беллингхам, АНУ

График дизайнер:

Б.ТҮВШИНТӨР

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (MSc), Улаанбаатар, Монгол Улс

Хаяг:

МУИС-ийн хичээлийн II байр, 204 тоот, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим

Утас:

976-77307730-2314

И-мэйл:

zulkaphil@yahoo.com, iderjargal@num.edu.mn

Editorial board members:

Editor-in-chief:

ZULKAPHIL.M

Doctor of Science (Sc.D), Professor Emeritus, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Editor:

IDERJARGAL.D

Doctor of Journalism (Ph.D), Associate Professor, Department of Journalism and Mass Communication, Division of Social Sciences, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Members:

BOLD-ERDENE.B

Doctor of Journalism (Ph.D), Professor, Dean of School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

NOROVSUREN.L

Doctor of Science (Sc.D), Professor, Department of Journalism and Mass Communication, Division of Social Sciences, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

NARANBAATAR.B

Doctor of Journalism (Ph.D), Associate professor, Head of Department of Journalism and Mass Communication, Division of Social Sciences, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

BAASANSUREN.T

Honored Worker of Culture of Mongolia, Doctor (Ph.D), Professor, Ulaanbaatar, Mongolia

BATBAATAR.J

Doctor (Ph.D), Professor, Rector, Mongolian State University of Education, Ulaanbaatar, Mongolia

DAGIIMAA.D

Doctor (Ph.D), Professor, Head of Department of Journalism and Media Technology, Ulaanbaatar, Mongolia

IRINA I.VOLKOVA

Doctor of Philology (Sc.D), Professor, Department of Mass Communication, RUDN University, Moscow, Russian Federation

DEREK MOSCATO

Doctor of Communication (Ph.D), Professor, Department of Journalism, College of Humanities and Social Sciences, Western Washington University, Bellingham, USA

Graphic designer:

TUVSHINTUR.B

Master of Computer science (MSc), Lecturer, Department of Journalism and Mass Communication, Division of Social Sciences, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Address:

Department of Journalism and Mass Communication, National University of Mongolia, 2nd building, #204

Phone:

976-77307730-2314, 976-88402503

E-mail:

zulkaphil@yahoo.com, iderjargal@num.edu.mn

АГУУЛГА

Сэтгүүл зүйн түүх

Т.Баасансүрэн	1
МОНГОЛД ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛБА ҮҮСЭЖ СЭТГҮҮЛ ЗҮЙН ХҮЧИРХЭГ ХҮЧИН ЗҮЙЛ, БИЕ ДААСАН УРЛАГ БОЛЖ ХӨГЖИЖ ТӨЛӨВШСӨН НЬ	
Р.Ш.Нуриден, М.Зулькафиль	10
МОНГОЛЫН КАЗАХ РАДИОГИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛД	
Т.Баасансүрэн	22
ШИНЭ МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛД С.ОЮУНЫ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР	
Р.Ш. Нуриден, А.Т.Дүйшекеева	31
ОЛОН УЛСЫН “ЭРХ ЧӨЛӨӨ” РАДИО СТАНЦЫН “ТУРКСТАН”-Ы РЕДАКЦ БА ЦАГААЧ СЭТГҮҮЛЧИД	

Сэтгүүл зүйн онол, практик

М.Зулькафиль	42
ОРЧИН ҮЕИЙН МАСС-МЕДИА: МЭДЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖ, ШААРДЛАГА	
Т.Өнөрсайхан	51
НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИОЛЫН АГУУЛГА, ХЭЛБЭР, ХИЙЦИЙН НЭГДЭЛ БУЮУ ТУУРВИЛ ЗҮЙН ОНЦЛОГ	
Д.Сандагсүрэн	58
ПОДКАСТ ИРГЭНИЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН ШИНЭ ХАНДЛАГА БОЛОХ НЬ	
Т.Энхтуяа, Д.Дагиймаа	67
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА, ЭРХ ЗҮЙН УХАМСРЫН АСУУДАЛ ЧУХАЛ БОЛОХ НЬ	
С.Бэлгүүнзаяа	78
ТЕЛЕВИЗИЙН ХӨРӨГ НЭВТРҮҮЛЭГ БҮТЭЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	

Сэтгүүл зүйн шүүмж, судалгаа

Г.Мэндхүү, Сайханмэнд	88
ЦАХИМ ОРЧИНД ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙН ТАРХАЛТЫГ ХЯЗГААРЛАХ БОЛОМЖ	
Д.Идэржаргал, Л.Анударь	100
МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН МАНИПУЛЯЦИ: МЕТА ТӨЛБӨРТЭЙ СУРТАЛЧИЛГААНЫ САНГИЙН ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН ШИНЖИЛГЭЭ	

Л.Ариун	112
ТЕЛЕВИЗИЙН УРАН САЙХНЫ КИНОНЫ ҮЗЭЛ САНАА, ДҮРСЛЭЛ ҮЗЭГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙ, НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛД НӨЛӨӨЛӨХ НЬ	
Er, Dengdalai (Эрдэнэдалай), С.Амартүвшин	122
ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖИЙН ШИНЖИЛГЭЭ	
Б.Болормаа	135
ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХУДАЛ МЭДЭЭЛЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА	
Б.Цэвэлмаа, Т.Өнөрсайхан	149
МҮОНР-ИЙН МЭДЭЭ, СУРВАЛЖИЛГЫН СЭДЭВ, ЭХ СУРВАЛЖИД ХИЙСЭН АЖИГЛАЛТ	
Ү Тианбао (Wu Tianbao)	156
БНХАУ-ЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ШИНЭ МЕДИАГИЙН ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГАА	
Байгаль	165
Б.ГАЛААРИДЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН ТОЙМ, СУДАЛГАА	

CONTENT

History of Journalism

Baasansuren.T	1
From Institutional Practice to Independent Art: The Emergence and Professionalization of Photojournalism in Mongolia	
Nuriden R.Sh., Zulikaphili.M	10
The Establishment and Institutional Development of Mongolian Kazakh Radio: Historical and Structural Perspectives	
Baasansuren.T	22
S. Oyun's Contribution to the Development of Modern Mongolian Journalism	
Nuriden R.Sh., Duishekeeva. A.T.	31
The "Turkistan" Editorial Board of the "Liberty" International Radio Station and Exile Journalists	

Theories and Practices of Journalism

Zulikaphili.M	42
Enhancing News Impact in Contemporary Mass Media: Structural, Technological, and Professional Challenges	
Unursaikhan.T	51
Combination of Content, Genre, Format in TV Screenplays and Features of Poetics	
Sandagsuren.D	58
Podcast: A new approach to citizen journalism	
Enkhtuya.T, Dagjmaa.D	67
Climate Change and Public Opinion: Media Influence, Risk Communication, and Legal Consciousness	
Belguunzaya.S	78
Challenges and Solutions in Producing Television Portrait Programs	

Reviews and Researches of Journalism

Mendkhuu.G, Saikhanmend	88
Possibilities to Limit The Spread to Fake Information In The Online Environment	
Iderjargal.D, Anudari.L	100
Political Manipulation In Mongolia: An Analysis Based on Meta Ad Library	

Ariun.L	112
The Influence of The Themes and Portrayals In Television Dramas on Viewers' Psychology and Ocietal Values	
Er, Dengdalai, Amartuvshin.S	122
News Source Diversity in Daily Newspapers: A Content Analysis	
Bolormaa.B	135
Regulation of False Information in the Digital Environment and Trends	
Tsevelmaa.B, Unursaikhan.T	149
Observation on The Content and Format of The MNB News	
Wu Tianbao	156
A Study On Mongolian-Language New Media Users In China	
Baigali	165
Overview and Study of the Journalistic Works of Galaarid.B	

МОНГОЛД ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛБА ҮҮСЭЖ СЭТГҮҮЛ ЗҮЙН ХҮЧИРХЭГ ХҮЧИН ЗҮЙЛ, БИЕ ДААСАН УРЛАГ БОЛЖ ХӨГЖИЖ ТӨЛӨВШСӨН НЬ

Т.Баасансүрэн*

**МУСГЗ, доктор (Ph.D), профессор*

Түлхүүр үгс: Гэрэл зураг, Монгол дахь гэрэл зургийн албаны үүсэл, хөгжил, төлөвшил, эрх баригч нам, засгийн тогтоол шийдвэрүүд, архивын материалууд, 90 жилийн түүх, цаашдын төлөв.

Ардын хувьсгалын анхны жилүүдэд нийслэл Хүрээнд Хятадын худалдаачид, Германы хувийн пүүсүүд ажиллаж, голцуу хүмүүсийн хөрөг зураг авч чамгүй өндөр үнээр борлуулдаг байжээ. Энэ үед В.Бадам, Судар бичгийн хүрээлэнгийн гэрэл зурагчин Б.Чойжинням нарын зэрэг цөөн тооны монгол хүн зураг авч байсан бөгөөд гадаадын эрдэмтэд, монголыг судлаачид, жуулчид тэр үеийн Монгол орны нүүр царай, ард түмний аж амьдралыг гэрэл зурагт буулгаж үлдээжээ.

1921 оны ардын хувьсгалын дараагаар эрх баригч нам, засгаас ардын хувьсгалын үйл хэрэг, шинэ нийгмийн бүтээн байгуулалтыг гэрэл зурагт буулган үлдээх асуудлыг онцгой ач холбогдолтойд үзэж байв. Үүний тод жишээ бол 1930 оны дундуур БНМАУ-ын засгийн газраас ЗХУ-ын засгийн газарт хандаж үндэсний кино, гэрэл зургийн албыг үүсгэн байгуулахад ах дүү ёсны гүн туслалцаа үзүүлэхийг хүссэн явдал юм. Манай хүсэлтийн дагуу зөвлөлтийн кино-хроникийн Москвагийн студийн оператор С.Е.Гусевийг Улаанбаатар хотноо илгээсэн байна.

Энэ үед Монголд үндэсний гэрэл зургийн хөгжил дөнгөж эхлэлийн төдий байв. Улсын хэмжээгээр захиалгаар гадаадын дуугүй сүүдэр шийгээр үйлчилдэг ганцхан кино театр нийслэл хотноо дөнгөж нээгдээд байлаа.

Манай урилгын дагуу кино, гэрэл зургийн албыг үүсгэн байгуулахаар хүрэлцэн ирсэн зөвлөлтийн мэргэжилтэн С.Е.Гусев “Ах дүүгийн найрамдлын хуудсууд” гэдэг номонд дурсан бичихдээ “Уг асуудлыг МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд хэлэлцсэний дараа хурлаас үйлдвэрлэлийн чиглэлтэй кино-фото комбинатыг байгуулахаас ажлаа эхлэхээр шийдвэрлэсэн юм. Фото салбар нь хэд хэдэн гэрэл зургийн газрыг байгуулахад биет туслалцаа үзүүлэх, орон нутгийн сонинуудад ажиллах гэрэл зургийн сурвалжлагчдыг бэлтгэх үүрэг зорилготой

байв” гэжээ. Үүнээс үзэхэд Намын Төв Хороо, Засгийн газраас гэрэл зургийн алба үүсгэн байгуулах явдлыг намын үзэл суртлын ажлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж байсан нь тодорхой байна.

Ардын Сайд нарын Зөвлөлийн 25 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар Монгол кино, зургийн газрыг байгуулах асуудлыг тусгайлан авч хэлэлцжээ. Ардын гэгээрүүлэх Яамны сайдын илтгэлийг Сайд нарын Зөвлөлд сонсоод гаргасан 32 дугаар тогтоолын 1-р зүйлд “Тус улсын үндэсний байдлыг үзүүлэн гаргаж байх кино зургийн үйлдвэрийг аль болохоор сурталчилгаатайгаар үүсгэн байгуулж, цаашид тус улсын кино зургийн хорооноос Кино зургийг хөлсөөр байгуулах ба мөн кино зураг үйлдвэрлэх эл хоёр зүйлийн ажлыг хослуулан гүйцэтгэх газар болговоос зохино” хэмээн заасан байна.

Ингэж манай улсад Гэрэл зургийн газар нь Кино үйлдвэртэй нэгэн зэрэг байгуулагджээ. Энэ нь ч зүй ёсны хэрэг байсан бөгөөд гэрэл зураггүйгээр кино урлагт анхны алхмуудыг хийх бололцоогүй байсан аж. Эхний үед нийтэд үйлчлэн гэрэл зургийг хөлсөөр авч худалдан борлуулдаг байснаа удалгүй нам засгийн бодлогыг гэрэл зургаар сурталчлах ажлыг голлодог болсон байна. Тус гэрэл зургийн салбарын анхны даргаар ажиллаж байсан 83 настай Д.Гончиг гуай (1985 онд) “Кино, гэрэл зургийн комбинат маань одоогийн Улсын филармонийн байранд байрлаж байв. Зөвлөлт улсаас С.Гусев, А.Лебедев нарын зэрэг мэргэжилтэн уригдан ирж, манай С.Дэмбэрэл, Б.Дэмбэрэл, С.Эрдэнэ нарыг дагалдуулан сургасан юм. Тэдний хамт би ч “Лейк” гэдэг аппаратаар зураг авахыг заалгаж эхэлсэн юм.

Д.С.Гусев сургагч мөн “Лейк” гэдэг аппараттай байв. 1936 оны улсын баяр наадмаар бид У-2 гэдэг онгоцоор хотын дээгүүр нисч зураг авч билээ. Кино үйлдвэрийн хоёр давхар барилгын том танхим тэр аяараа гэрэл зураг дэлгэн тавьсан лаборатори болж байлаа. 1937 онд залуучуудын соёлын ордонд гэрэл зургийн үзэсгэлэн байгуулж үзүүлэхэд хотынхон ихэд сонирхож байв” гэж дурсан ярьж үлдээснийг миний бие 1985 онд өөрийн номонд оруулж, түүнээс хойш уг баримт сэтгүүл зүйн судлаачдын судалгааны хэрэглэгдэхүүн болж ашиглагдаж ирсэн байдаг юм. Анхны гэрэл зурагчид маань өөрсдийн авсан зургаа ийнхүү үзэсгэлэнгээр дамжуулан олон түмэнд дэлгэн үзүүлж, сонин хэвлэлд нийтлүүлж эхэлжээ. Мөн албан байгууллагуудын захиалгаар үйлчилдэг байсан байна. Тэр үед гэрэл зургийг амьдрал практикт нэвтрүүлж, шинжлэх ухааны ололтыг сурталчлах нь өргөн олон түмнийг танин мэдүүлж соён гэгээрүүлэх ач холбогдол бүхий хувьсгалжуулагч үр нөлөөтэй шинэлэг арга хэлбэр болж байсныг тэмдэглэвэл зохино. Тийм учраас гэрэл зургийн ажлыг хөгжүүлэн бэхжүүлэх талаар дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байв. Наад захын зарим жишээг дурдъя. Намын Төв Хорооны бүгд хурлаас нийт аймгийн төвүүдэд уран зураг ба гэрэл зургийн газрыг байгуулж, түүнийг удирдах хүмүүсийг бэлтгэх зорилгоор уран зурагч ба гэрэл зурагч нарыг бэлтгэх курсийг 1946 онд зохион байгуулах шийдвэр гаргаж байв. БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг 1948-1952 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний төслийг намын XI их хурлаар хэлэлцээд гаргасан тогтоолд 1952 он гэхэд улсын хэмжээгээр зургийн газар 46-тай болох заалт өгч байлаа.

“Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний зорилгод уялдсан улс ардын аж ахуйн төлөвлөгөөг биелүүлэх хэрэгт ард түмнийг дайчилсан кино журнал ба фото зураг, плакатуудыг тогтмол гаргаж байхыг” МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1947 оны 4-р сарын 5-ны өдрийн хурлаас Урлагийн хэрэг эрхлэх газарт даалгаж байсан байна.

Клуб, улаан булангуудад хямд үнэтэй фото үзэсгэлэнгүүдийг тогтмол гарган сурталчилж байх үүргийг Намын Төв Хорооны ээлжит бүгд хурлаас Урлагийн хэрэг эрхлэх хороонд өгч байжээ.

Эдгээр удирдамж чиглэл, тодоорхой заалтууд нь олон жилийн турш тууштай хэрэгжиж ирсэн байна. Улсын гэрэл зургийн газраас гаргаж байсан төрөл бүрийн сэдэвчилсэн самбарыг өргөн олон түмэнд хүргэдэг нэг гол цэг бол хот, хөдөө дэх олон зуун клуб, улаан булан, соёлын ордон, театрууд байжээ. Гудамж, талбайд гэрэл зургийг ил тодоор самбарт дэлгэн үзүүлдэг сурталчилгааны үр нөлөөтэй хэлбэр Монголд 1970-аад оноос буй болжээ.

Өөр нэг сонин баримт дурдъя. МАХН-ын Төв Хорооны 1939 оны 5-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар Уран сайхны хүрээлэнгийн даргын илтгэлийг тусгайлан авч хэлэлцээд гаргасан тогтоолд тэмдэглэхдээ:

“Улаанбаатар хот ба зарим том аймгуудын төвд улсын фото гэрэл зургийн газрыг байгуулж, фото зургийн эргэлтийг хангахын тулд 8 сарын наана 5 буюу 6 аймагт зураг авах газар байгуулж дуусгасан байхыг хүрээлэнгийн удирдлагад үүрэг болгон даалгасугай. (1940 онд) Улаанбаатар хотод шинэ үлгэр жишээ бүхий том фото зургийн газрыг нээн байгуулсугай. Шинжлэх ухааны хүрээлэнгийн фото зургийн газар ба кино зургийн газрууд хүчийг хавсарган нэгтгэх тухай боловсруулан хянаж гүйцэтгэхийг Шинжлэх ухаан ба Уран сайхны хүрээлэнд даалгасугай. Олон нийтийн фото зургуудын яс чанарыг сайжруулан үнийг хямдруулах ажлыг хүрээлэн ба Монгол кино зургийн хорооноо даалгасугай. Фото зургийн сониныг онц сонирхолтой ба утга чанартайгаар гаргаж, түүний номер бүрийн товёог төлөвлөгөөг нарийн чандаар боловсруулан ажиллаж, захиалах явдлыг өргөтгөж, мөн зохиолчдоос уул сониныг цаг тухайд саадгүй хүлээн авдаг болгох зэрэг ажлууд дээр туйлын их анхаарал тавиваас зохино. Өөрийн сайн дураар зураг авагчдыг бүртгэн үзэж, тэд нарын цаашдын хөгжлийг бэхжүүлэхийн тулд сайн дурын зураг авагчдын бүлгэмийг байгуулж, зааж удирдах багшийг гаргаж өгөх ба хамгийн тэргүүнд улс төр, олон нийтийн төв болох клубийг ашиглан сайн дурын зурагчдын авсан зургуудаар тусгай үзэсгэлэнг байгуулах зэрэг ажлуудыг Монгол кино хорооноос эрхлэн зохиож ажиллаваас зохино” гэж заажээ.

Энэ бол гэрэл зураг ба баримтат киноны сурталчилгааг ихээхэн ач холбогдолтойд үзэж, түүнийг хөгжүүлэхэд онцгой халамж анхаарал тавьж байсныг харуулж байна. Сэтгүүл зүйн үүднээс онцгой сонирхол татаж буй нэг зүйл бол дээрх тогтоолд фотог Намын Төв Хороо сонины нийтлэлийн нэг чухал хэлбэр гэж үзэж “Фото зургийн сониныг онц сонирхолтой ба утга чанартайгаар гаргаж, түүний номер бүрийн товёог төлөвлөгөөг нарийн чандаар боловсруулан ажиллаж, захиалах явдлыг өргөтгөхийн” чухлыг зааж байсан явдал юм.

Өөрөөр хэлбэл эл баримтаас үзэхэд БНМАУ-д өнгөрсөн зууны гучаад оны сүүлчээс гэрэл зураг сонин сэтгүүлүүдийн үйл ажиллагаанд тууштай нэвтэрч хөгжиж эхэлжээ гэж хэлж болохоор байгаа юм. Энэ нь Монгол дахь хэвлэх үйлдвэрийн хөгжил дэвшилтэй нягт уялдаж улам гүнзгийрсэн байдаг бөгөөд тус улсад шинжлэх ухааны төрөл бүрийн салбар, тухайлбал хэвлэлийн салбарын хар цагаан зураг бүхий өндөр хэвлэл, өнгөт зурагт шилжсэн гүн хэвлэлийн үйлдвэрлэл хөгжихийн хэрээр сонин сэтгүүлүүд, ном товхимлуудын нүүр царайг чимж өнгө зүс, утга агуулгыг төгөлдөржүүлэх болсон байна.

Харин Монголын сэтгүүл зүйн үүсэл хөгжилтөд чухал байр суурь эзэлсээр ирсэн гэрэл зургийн сурталчилгааны өсөлт хөгжилт, ур чадварын талаарх судлал,

шүүмжлэлийн дорвитой бүтээл өнгөрсөн хугацаанд харьцангуй бага, бараг үгүй шахам явж ирсэн бөгөөд доктор, профессор Ломбын Норовсүрэн 2019 онд сэтгүүл зүйн онол, практикийн асуудлаарх цуврал 21 ботийнхоо 20-р ботийг “Фото сэтгүүл зүй”-гээр гаргаж, 2025 онд Цэрэндоржийн Батбаатар “Монголын фото сэтгүүл зүйн хөгжлийн судалгаа” сэдвээр сэтгүүл зүйн ухааны докторын зэрэг (Ph.D) хамгаалснаар тэрхүү хоосон орон зай арилж цэгцэрч эхэлснийг зориуд тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Гэрэл зураг бол сэтгүүл зүйн хөгжилд хорь, хориннэгдүгээр зууны шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлж, түүний итгүүлэн үнэмшүүлэх чадварыг хэд дахин нэмэгдүүлсэн онцгой гоц үзэгдэл, цаашдын хөгжлийнх нь нэг үндсэн хүчирхэг чиглэл бүхий ирээдүйтэй урсгал үнэхээр мөн бөгөөд үзэгчид, уншигчдын нүд, сэтгэл, зүрхийг зэрэг зэрэг татаж чаддаг гайхалтай хосгүй урлаг юм.

Энэ чухал албанд ухамсарт бүх амьдралаа зориулсан гэрэл зургийн ахмад ажилтнуудаа өнөөдөр бид 90 жилийнх нь ойн босгон дээр гүн хүндэтгэлтэйгээр дурсан санах учиртай. В.Бадам, Б.Чойжинням, Гомбожав, Ц.Дагдандорж зэрэг гэрэл зургийн нэрт мастерууд энэ салбарт үр бүтээлтэй ажиллаж байв. Тэдний халааг М.Цэрэнжамц, Б.Сүхээ, Д.Самдан, Ц.Нина, Б.Улятайхүү, Ш.Сайханбаяр, Р.Энхбат зэрэг дунд залуу үеийнхэн залгамжлан авсан байдаг. Улсын гэрэл зургийн газрын даргаар олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, тус улсад гэрэл зургийн урлагийг хөгжүүлэх, мэргэжлийн фото сэтгүүлчид бэлтгэх, гэрэл зургийн салбарын материаллаг баазыг бэхжүүлэх үйлсэд хүчин зүтгэж ирсэн Д.Гончиг, Д.Лувсандагва, Ц.Хичээнгүй, П.Эрдэнэ зэрэг үе үеийн дарга нар, лаборант Д.Мөнх-Очир, Д.Сувд, Д.Чимэдцэрэн зэрэг олон хүнийг мэргэжил нэгт нөхөд нь бахархалтайгаар талархан дурсаж байдаг билээ. Манай ахмад ажилтан Лувсанжамц, Пунцагцэрэн, Дэжид, Махвал, Намжилмаа, Цэрэндулам, Хүүхлээ, Чавганц нарын зэрэг олон хүнийг өнөөдөр үүн дээр бас нэмж нэрлэх ёстой.

Гэрэл зургийн алба анх үүсэн байгуулагдахад урьд нь гэрэл зураг авдаг байсан В.Бадамыг сургагч багшаар нь ажиллуулжээ. Анхны гэрэл зургийн газар нь залуу боловсон хүчнийг гэрэл зургийн урлагт шамдан суралцуулахыг нэн чухалчилж байв. Үүний нэг тод жишээ бол 1940 онд гэрэл зурагчны нэг сарын курсийг нээн ажиллуулж, төгсөгчдийг бүх аймагт илгээж байсан явдал юм. 1939 оноос Кино зургийн хорооны гэрэл зургийн тасаг нь “Төвийн гэрэл зургийн газар” болон өргөжжээ. Тэр үед “Манай газар дотроо гавьяатны зургийн тасаг, энгийн зургийн тасаг гэсэн хоёр тасагтай, 27 хүний орон тоотой, 39940 төгрөгийн цалингийн төсөвтэй, аж ахуйн тооцоотой бие даасан авсаархан газар болон өргөжөөд байв” гэж Гэрэл зургийн албаны анхны дарга нарын нэг Д.Лувсандагва гуай дурсан ярьж байсан болно.

Төвийн гэрэл зургийн газар нь “Лейк”, ЗХУ-д үйлдвэрлэсэн “Фед” маркийн нарийн хальсны, 9x12 см-ийн хэмжээний /шилээр авдаг/ “фотокор”, 18 x 24см-ийн хэмжээний /мөн шилээр авдаг/ “Аналмат” зэрэг цөөн хэдэн аппараттай байсан бөгөөд нийслэл хотноо бүтээгдэхүүнээ борлуулдаг 4 мухлагтай байжээ.

Гавьяатны зургийн тасаг нь К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин, Эрнест Тельман, Клара Цеткин, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан зэрэг олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтнүүд болон өөрийн орны нам, засгийн удирдагчдын хөргийг дагнан хийдэг, өргөн олон түмэнд сурталчилдаг байсан байна.

Энгийн зургийн тасгийнхан төрөл бүрийн сурвалжлага хийж, судалбар зураг авч, улсын баяр наадмын болон түүхэн чухал үйл явдлуудын зургийг татаж улс

орныхоо түүхийг бичилцэх гавьяат үйлсэд идэвхтэй оролцож байжээ. Мөн улсын сайн малчин, тэргүүний ажилчид, ударникуудын зургийг авч төвийн сонин, хэвлэл-“Намын үнэн”, “Үндэсний эрх”, Үйлдвэрчний эвлэлийн хэвлэл “Ажилчны зам”, ардын цэргийн “Улаан од” сонинд нийтлүүлдэг байжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 216 дугаар тогтоолоор Урлагийн хэрэг эрхлэх хорооны харьяанд Кино зургийн архивыг анхлан байгуулжээ. Сүүлд буюу 1967 онд Сайд нарын Зөвлөлийн 184 дүгээр тогтоолоор Урлагийн хэрэг эрхлэх хорооноос Улсын архивын хэрэг эрхлэх газрын харьяанд шилжиж Кино, гэрэл зураг, дуу авианы улсын архив нэртэй болсон байна.

Төвийн гэрэл зургийн газар нь 1957 оноос БНМАУ-ын Соёлын Яамны харьяа Улсын гэрэл зургийн газар болон өргөжжээ (Дарга нь Ц.Хичээнгүй). Энэ сацуу улс орны хөгжлийн хэмжээ далайц, хэрэгцээ шаардлагаас уламжлан хүн амд өдөр тутам үйлчлэх зориулалттай нийтийн ахуй үйлчилгээний чиглэлийн гэрэл зургийн салбарууд нийт аймаг, хотод байгуулагдан бэхжиж Улсын гэрэл зургийн газар нь гэрэл зургийн дотоод, гадаад сурталчилгааг дангаар хариуцах болсон байна. 1950 оны 5 дугаар сарын 28-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс “Гэрэл зургийн мэдээллийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” хэмээх 248 дугаар тогтоолыг гаргажээ. “Сонин, сэтгүүлийн газрууд ба гэрэл зургийн үзэсгэлэнг сайн чанарын зургаар хангах, тус орны хөгжил, амьдралыг манай орны ба бусад орны ард түмэнд гэрэл зургаар сурталчлах ажлыг сайжруулах, зурагчдын хүчийг зөв хуваарилан төвлөрүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, хөдөлмөр ба материал хэмнэх зорилгоор” гэж уг тогтоолд тодотгож заагаад кино үйлдвэрийн дэргэдэх гэрэл зургийн газрыг өргөтгөж Урлагийн хэрэг эрхлэх хорооны харьяанд аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахаар шийдвэрлэсэн байдаг юм. Хар цагаан болоод өнгөт гэрэл зургийн лабораториуд, үзэсгэлэн чимэглэлийн тасаг, гэрэл зургийн архив зэргийг шинээр бүрэлдэхүүнд нь буй болгон байгуулж бэхжүүлсэн байна.

1979 онд Дээд газрын шийдвэрээр Соёлын яамны Улсын гэрэл зургийн газар, МРТУХ-ны гэрэл зургийн ерөнхий редакц хоёрыг нэгтгэж МРТУХ-ны харьяа Улсын гэрэл зургийн газар болгон өргөтгөж тус улсын гэрэл зургийн дотоод, гадаад сурталчилгааны бүх ажлыг энэ газарт хариуцуулсан байна. Улсын гэрэл зургийн газрын үүрэг зорилго ийнхүү улам нарийн тодорхой болон өргөжиж, материаллаг бааз, боловсон хүчний хувьд ихээхэн бэхжиж иржээ. 1984 он гэхэд тус газарт гадаад дотоодын дээд, дунд сургууль төгссөн мэргэжлийн сэтгүүлчид, ажилчид ажиллаж тухайн цаг үеийнхээ хамгийн орчин үеийн аппарат хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байв. Улсын гэрэл зургийн газар нь ах дүү социалист орнуудын мэдээллийн агентлагуудтай өдөр тутмын холбоотой ажиллаж, өөрийн орныг хилийн чанадад системтэй сурталчилж байсан. Улсын гэрэл зургийн газарт түүхийн үнэт баримт болсон 75 мянга гаруй хальс хадгалагдаж, жилээс жилээс баяжиж байв. Тэдгээрийн дотор үнэ цэнээрээ алтан фондод зүй ёсоор орох олон зуун, мянган зураг байсан юм. Дахин давтагдашгүй түүхийн эдгээр үнэт зургуудыг онцгой хайрлан хамгаалж зөвхөн улсын чанартай томоохон үзэсгэлэн, олон хувиар гаргах сурталчилгааны самбар, альбом, зурагт танилцуулга хэвлүүлэх зэрэгт ашиглуулж байсан. Мөн гадаад орнуудад байгуулж байсан гэрэл зургуудын үзэсгэлэнгүүдийг тус газраас эрхлэн бэлтгэж байсан болно. Гэрэл зургийг МРТУХ-нд буюу МОНЦАМЭ агентлагийн мэдэлд төвлөрүүлж ажиллуулахаар шийдвэрлэсэн нь Монголд гэрэл зургийн сурталчилгаа чанарын шинэ түвшинд гарах боломжийг буй болгож манай сэтгүүл зүйн цаашдын хөгжилд хүчтэй түлхэц үзүүлсэн байна. Улсын гэрэл зургийн газар өөрийн орны хөдөлмөрчид, албан байгууллагуудын хэрэгцээг хангах зорилгоор

хэвлэлийн захиалгын дагуу “БНМАУ-д”, “Ах дүү ЗХУ-д” гэрэл зургийн сонинг тус газраас тогтмол сар бүр гаргаж байсны зэрэгцээ социалист орнуудын мэдээллийн агентлагуудад жилд дунджаар өөрийн эх орныг сурталчилсан 3-4 мянган зургийг илгээж, төвийн сонин, хэвлэлүүдийг гэрэл зургаар хангаж байлаа.

Монголд гэрэл зургийн алба үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойн жил-1985 оны эхний хагасад тус газрын хамт олон “Аугаа их ялалтын 40 жил, “БНМАУ-1985 онд”, “Их наадмын хөдөлгөөний түүхээс”, “Хүнсний зорилтот программ” зэрэг гэрэл зургийн 15 нэр төрлийн самбарыг олон мянган хувиар хийж, түүхэн үйл явдалд зориулсан 12 үзэсгэлэнгийн зургийг чанартай сайн бэлтгэн гаргаж байв. Үүний зэрэгцээ хилийн чанадад олон мянган зураг илгээж өөрийн эх орны хөгжил цэцэглэлт, монголын ард түмний аж амьдралыг сурталчилсан байна.

Гэрэл зургийн урлагийг хөгжүүлэх, өөрсдийн ур чадварыг дээшлүүлэх, сонин, хэвлэлд нийтлэгдэж байгаа зургийн чанарыг сайжруулах талаар манай сэтгүүлчид туйлын өндөр идэвх чармайлттай ажиллаж байлаа. Монголын сэтгүүл зүйн хөгжилд өөрийн байр суурь, дуу хоолойтой гэрэл зургийн түүхэн замнал, хөгжлийн өвөрмөц онцлогийн талаар өгүүлсэн хамтын бүтээлийг хэвлэлд бэлтгэж, оны шилдэг зургийг тогтмол шалгаруулж, төрөл бүрийн сэдвээр уралдаан зарлан дүгнэж байв. Олон улсын уралдаанаас Монголын сэтгүүлчид олон арван шагнал хүртэж байсан. Сэтгүүлч М.Цэрэнжамц, Ц.Нина, Б.Улятайхүү нар өөрсдийн уран бүтээлийн бие даасан үзэсгэлэнг Улаанбаатар хот, аймгуудаар гаргаж хөдөлмөрдөөс талархал хүлээж байлаа. 1983 оноос эхлэн МРТУХ, МСХ-ноос эрхлэн жил бүр гэрэл зургийн үзэсгэлэнг хамтран гаргадаг сайхан уламжлалтай болсон билээ. Энэ ажил ерээд он хүртэл тасралтгүй үргэлжилсэн.

Улсын гэрэл зургийн газрын хамт олон “Социалист Монгол”, “Өнөөгийн Монгол”, “Монгол орноор” альбомыг чанартай бэлтгэн хэвлэлд шилжүүлж “Оддын ахан дүүс”, “Халх гол дахь зарлаагүй дайн”, “Хөвсгөл” альбом болон “Говь”, “Хангай”, “Ардын урлаг”, “Хөдөө аж ахуй”, “Аж үйлдвэр” зэрэг зурагт танилцуулгуудыг бэлтгэн хэвлэж өргөн олон түмэнд сурталчилж байв. Энэ бүхэн нь Монголын ард түмэн шинэ нийгмийг хэрхэн байгуулж байгааг түүхэнд мөнхлөн үлдээхэд бүхэлдээ чиглэж, хойч үедээ манай үеийнхний үлдээсэн түүхэн баримт, Монголын фото сэтгүүлчдийн “Өдрийн тэмдэглэл”-ийн нэг чухал гэрэлт хуудсууд болж үлдсэн юмаа. Гэрэл зургийн түүхэн ач холбогдол үнэхээр аугаа. Үйл явдлыг уран зурагт гэхэд гэрэл зураг шиг тийм түргэн шуурхай, яг бодит байдлаар нь буулган үлдээх аргагүй. Гэрэл зурийг уран дүрслэлийн нийтлэл гэж хэлж болно.

Өнгөрсөн зууны ерээд онд Монгол Улс хүнлэг ардчилсан нийгэмд шилжсэнээр гадаад харилцаа нь улам өргөжиж Монголын талаарх гэрэл зургийн мэдээллийг МОНЦАМЭ агентлаг дэлхий нийтэд улам өргөн дэлгэр далайцтайгаар тасралтгүй цацах болсон юм. Ази, Номхон далайн улс орнуудын мэдээллийн агентлагуудыг эгнээндээ нэгтгэсэн ОАНА-д МОНЦАМЭ агентлаг өдөр тутам гэрэл зургуудын болоод дүрст мэдээллийг нийлүүлэх болсноор Монголын талаарх сурталчилгаа дэлхийн бүх улс оронд түгээмэл хүрэх болсон билээ. Зөвхөн ганц АНУ-д гэхэд МОНЦАМЭ агентлагийн тэдгээр мэдээ мэдээлэлийн жараад хувийг ашигладаг гэсэн статистик бий.

Монголд гэрэл зургийн алба үүсэж, хөгжиж, төлөвших үйл явцыг анхааралтайгаар ажиглан шинжиж үзэхэд дараах бодит шийдмэг алхмууд, хүчин зүйлс шийдвэрлэх нөлөө үзүүлжээ гэж хэлж болохоор байгаа юм. Үүнд:

-Хүн төрөлхтөн, улс орнуудын хөгжил дэвшилд шинжлэх ухаан, техникийн

хувьсал хүчтэй нөлөө үзүүлж гэрэл зураг, кино урлаг үүсэн, хэвлэх үйлдвэр жинхэнэ утгаараа бадран мандаж, Монгол орноор аялсан гадаадын аялагч жуулчлагчид Монгол орон, монголчуудын аж амьдралыг сүүдэр зурагт буулгаж дэлхий дахинд хургэж эхлэсэн, 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн зарлаж тунхагласан Богд хаант Монгол Улсын Засгийн газар өөрийн гэсэн гэрэл зурагчидтай болсон зэрэг нь тус улсад фото урлаг үүсэж хөгжих аятай таатай хөрс суурийг бүрдүүлсэн;

-1921 онд ардын хувьсгал ялж анхны сонин сэтгүүлийг гаргаж, үндэсний мэдээллийн МОНТА буюу МОНЦАМЭ агентлагийг үүсгэн байгуулж дотоод, гадаад сурталчилгааг эрчимжүүлэн, хүн ардаа танин мэдүүлж соён гэгээрүүлэхэд үндсэн эргэлт гарган соёл, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлж, үндэсний ном товхимол хэвлэж эхэлсэн нь гэрэл зургийг идэвхтэй ашиглах үүд хаалгыг нээж нийгмийн бодит хэрэгцээ шаардлагыг буй болгосон;

-Эдгээрийг эш үндэс болгож БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн 1935 оны 10-р сарын 11-ний өдрийн хурлаар “Монголд кино, гэрэл зургийн алба байгуулах тухай” асуудлыг тусгайлан хэлэлцээд 32 дугаар тогтоол гаргаж “Тус улсын үндэсний байдлыг үзүүлэн гаргаж байх кино зургийн үйлдвэрийг аль болох сурталчилгаатайгаар үүсгэн байгуулж, цаашид... кино гэрэл зургийг үйлдвэрлэх эл хоёр зүйлийн ажлыг хослуулан гүйцэтгэх газар болговоос зохино” хэмээн заасан, улмаар ЗХУ-ын Засгийн газарт хандаж уг зорилгоо амьдрал, практикт амжилттай хэрэгжүүлсэн;

-Энэхүү эхлэлээ эрчимтэй бататган хөгжүүлж засгийн эрх баригч намын их, бүгд хурлаар Монголд гэрэл зургийг хөгжүүлэх асуудлыг удаа дараа авч хэлэлцэж удирдамж шийдвэр гаргасан, тэдгээрийг нь НТХ-ны Улс төрийн Товчооны хурлаас болон Засгийн газраас тогтоол гаргах замаар дэс дараатайгаар тууштай биелүүлэн хэрэгжүүлж материаллаг баазыг бүрдүүлэн, боловсон хүчнээр хангасан;

-Уг ажлыг урлаг, уран бүтээл, сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэж үзэн БНМАУ-ын Соёлын Яам, улмаар МРТУХороо, МОНЦАМЭ агентлагт хариуцуулж холбогдох лаборатори, техник хэрэгсэл, аппарат хэрэгсэл, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж бэхжүүлсэн;

-МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимээс эхлээд улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиудад фото сэтгүүлчийн мэргэжлээр цөөн тооны боловч үндэсний боловсон хүчин бэлтгэж эхэлсэн, ЗХУ, Герман зэрэг гадаадын улс оронд хүмүүсээ энэ чиглэлээр илгээж сургах болсон;

-Нийслэл Улаанбаатар хот болон аймаг, хотод уран бүтээлчдийн гэрэл зургийн үзэсгэлэнг дэлгэн үзүүлэх үйл ажиллагааг хэвшүүлж, гэрэл зургийн үүсэл, хөгжил, төлөвшлийн асуудлаар сурах бичиг, гарын авлага, холбогдох бусад ном зохиол хэвлэгдэж нийтийн хүртээл болгосноор гэрэл зургийн сурталчилгаа эрчимжиж мэргэжлийн уран бүтээлчдийн төдийгүй сонирхогчдын тоо хэмжээ эрс өсөн нэмэгдсэн; (Т.Баасансүрэн. Монголд гэрэл зургийн алба үүсэж хөгжсөн нь. УБ. 1985, М.Лхагвасүрэн, Л.Элбэгзаяа. Гэрэл зураг. УБ. 2008, Д.Энхтайван. Ертөнцийг дүрслэх урлаг. УБ. 2008, Л.Норовсүрэн. Фото сэтгүүл зүй /сурах бичиг/ УБ. 2012, С.Бадамханд. Та аппаратаа бүрэн ашиглаж чаддаг уу? УБ. 2014, В.Баттулга. Ертөнцийг гэрлээр бичих урлаг. УБ. 2015, “Монголын гэрэл зурагчид” 1935-2015. УБ. 2015, Н.Гансүх. Гэрэл зураг унших, ойлгох, тайлбарлах, авах түлхүүр. УБ. 2015, Вандандоржийн Баттулга. Ертөнцийг гэрлээр бичих урлаг. УБ. 2018, Вандандоржийн Баттулга, Цэрэндоржийн Батбаатар. Монголын гэрэл зургийн түүхэн товчоон. УБ. 2020, Цэрэндоржийн Батбаатар. Монголын фото сэтгүүл зүйн

хөгжлийн судалгаа /Сэтгүүл зүйн доктор /PhD/-ын зэрэг горилсон бүтээл. УБ. 2025)

-XX оос XXI зууны шинжлэх ухаан, техникийн хувьсгалын хүчтэй хөгжил нь сэтгүүл зүй, нэн ялангуяа телевизийн салбар, цахим сэтгүүл зүйд хүчтэй нөлөө үзүүлж гэрэл зураг хүн төрөлхтөн, түүний дотор монгол түмний өдөр тутмын үйл амьдралын хэрэгцээ сонирхол болж хөгжлийн цоо шинэ шатанд гарсан; (теле сувгийн мэдээ мэдээлэлд гэрэл зургийг баримт болгож ашиглах, хүн бүр гар утсаар гэрэл зураг авах нь бүх нийтийн хөдөлгөөн болж хувирсан зэрэг);

-Ардчилсан нийгмийн хөгжлийг дагаад Монголд зөвхөн МСНЭ хийгээд сонин хэвлэл, мэдээллийн байгууллагууд, цахим сайтууд төдийгүй ГАММА зэрэг хувийн хэвшлийн гэрэл зургийн агентлаг, уран бүтээлийн хамтлаг, нэгдэл буй болж, гэрэл зурагчид, фото сэтгүүлчдийг эгнээндээ нэгтгэсэн Монголын гэрэл зургийн нийгэмлэг (1993 он, Ц.Нина, Р.Энхбат, Ц.Батзориг, нарын санаачилгаар) байгуулагдаж, “Гэрэл, сүүдэр” (1993) анхны гэрэл зургийн дагнасан сэтгүүл гарч, Сүхбаатарын талбайн гэрэл зурагчдын бүхэл бүтэн хамтлаг буй болж олон нийтэд үйлчлэх болсон;

-“Монголын шилдэг гэрэл зураг” уралдааныг холбогдох байгууллагаас жил бүр зохион байгуулж “Гран при” шагнал олгох болсон, Цэвэгмидийн Батзоригийн зэрэг шилдэг уран бүтээлчдийн нэрэмжит оны шилдэг гэрэл зургийн уралдаан шалгаруулж эхэлсэн;

-1993 онд анх үүссэн Монголын гэрэл зурагчдын нийгэмлэг 2005 онд буюу Монголд гэрэл зургийн алба үүсэж хөгжсөн түүхт 75 жилийн ойгоор Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо болж үйл ажиллагаа, зохион байгуулалтын хувьд улам бэхжиж хөгжсөн, 2006 онд анхдугаар их хурлаа хуралдуулж үйл ажиллагааны зорилго зорилтоо тодорхойлж тууштай ажиллаж эхэлсэн, Монголын гэрэл зургийн урлагийн зөвлөл байгуулагдсан (2013);

- Монголын гэрэл зургийн уран бүтээлчдийн бүтээл туурвилууд нэг биш удаа олон улсын уралдаан тэмцээнд шалгарч, гэрэл зурагчдын олон улсын хамтарсан сурвалжлагууд зохиогдох болж, “Өнөөдрийн Монгол 2018”, “Өнөөдрийн Монгол, 2019” хөтөлбөр болоод үзэгчдийн дунд нэр хүндтэй “Хүрээлэн” амьд ертөнцийн цуврал төсөл, “Монголын өв соёлын судалгаа, гэрэл зургийн “Эгэл” төсөл, “Хигашикава олон улсын гэрэл зургийн фестиваль-2019” зэрэг тэмдэглэлт содон үйл явдлууд байнга зохиогдох болсон;

-Эцэст нь онцгойлон тэмдэглэж хэлэх тодотгол нь өнгөрсөн 90 жилд Монголын гэрэл зургийн урлагийг хөгжүүлэхийн төлөө хоёргүй сэтгэлээр ухамсарт бүх амьдрал, уран бүтээлээ зориулж фото сэтгүүл зүйн урлагт үнэнчээр үйлчилж ирсэн үе үеийн уран бүтээлчид, өнөөдөр ч зүтгэсээр, бүтээж туурвисаар яваа зуу зуун фото сэтгүүлчид, тэднийг нэгтгэсэн мэргэжлийн редакц хамт олон ... зэрэг болно.

Дүгнэлт

Нэг. Ахуй соёлын үйлчилгээ хийгээд улс орны тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн сурталчилгааны хосолмол чанарыг өөртөө агуулан шингээж анх үүссэн монголын гэрэл зураг өнгөрсөн ерэн жилийн хугацаанд өсөлт дэвшлийн өвөрмөц үе шатуудыг дамжин хөгжих явцдаа Монгол Улс, монгол үндэстний амьдрал, тэмцлийн содон сонирхолтой мөчлөгүүдийн хөдөлшгүй үнэн бодит, амьд тод түүхийг бүтээж мөнхлөн үлдээжээ.

Хоёр. Хөгжил дэвшлийн энэхүү түүхэн урт замналыг туулахдаа Монголын

гэрэл зураг манай сэтгүүл зүйн нэгэн чухал, өөр юугаар ч орлуулшгүй итгүүлж үнэмшүүлэх хүчирхэг хүчин зүйл болж хөгжиж төлөвшсөнийг онцгойлон тэмдэглэж байна.

Гурав. Шинжлэх ухаан, техникийн түргэн хурдацтай хөгжил дэвшил ХХI зууны хүн төрөлхтөнийг, түүний дотор монгол үндэстнийг бүх нийтээр гэрэл зургийн боловсролтой хэрэглэгчид-сонирхогчид болгож өөрчилсөн нь бодит үнэн мөн боловчиг гэрэл зургийн урлагийн хамгийн том, хамгийн гоц илэрхийлэл, амин сүнс, үндсэн гол үзүүлэлт нь ухааныг ундруулж, увидсыг гайхуулсан фото мастеруудын гэрэл, сүүдрийн хосгүй нандин зохицолт мэдрэмж мэргэн мэлмий, торгон харааны тольт тусгал хэвээрээ байгааг эрхбиш тэмдэглэн хэлэх нь зөв болов уу.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Тугалхүү Баасансүрэн. (2009). *Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь* (Цуврал 7 боть, дэд дэвтэр: 1921 оны ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил). Улаанбаатар.
- Ломбо Норовсүрэн. (2021). *Сэтгүүл зүй* (21 боть зохиол, XX боть: Фото сэтгүүл зүй). Улаанбаатар.
- Вандандорж Баттулга., & Цэрэндорж Батбаатар. (2020). *Монголын гэрэл зургийн түүхэн товчоон*. Улаанбаатар.
- Цэрэндорж Батбаатар. (2025). *Монголын фото сэтгүүл зүйн хөгжлийн судалгаа* Докторын зэрэг горилсон судалгааны бүтээл. Улаанбаатар.

Summary

This article provides a concise historical overview of the emergence and development of Mongolia's photography service over roughly ninety years, tracing its roots from the early twentieth century—when only a few Mongolian photographers and foreign scholars documented everyday life—through the post-1921 period in which the state and ruling party recognized photography as a vital tool for documenting and promoting the new society, invited Soviet specialists, and, through key decisions such as the 1935 resolution, established film and photography institutions in parallel.

It shows how consistent policies to open studios nationwide, train photo correspondents, organize exhibitions, and supply newspapers with high-quality images led to the institutionalization of photography within the press, how the 1950s–1980s saw the consolidation of a State Photography Office with laboratories, archives, international agency links, and a vast historical collection, and how the democratic transition expanded the field through private agencies, professional associations, specialized publications, and competitions, concluding that photography has both preserved Mongolia's living history and become an irreplaceable force.

Keywords: Photography; the emergence, development, and maturation of Mongolia's photography service; ruling party and government resolutions and decisions; archival materials; a ninety-year history; future prospects.

МОНГОЛЫН КАЗАХ РАДИОГИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛД

Р.Ш.Нуриден*,
М.Зулькафиль**

**Л.Н.Гумилевын нэрэмжит Евразийн Үндэсний Их Сургуулийн
Сэтгүүл зүй, цахим хэвлэлийн тэнхимийн дэд профессор, доктор
(Ph.D), Астана, Казахстан.*

***МУИС-ийн эмерит профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)*

Түлхүүр үгс: Баян-Өлгийн радио, радио нэвтрүүлэг, радио сэтгүүл зүй, интернет радио, аймгийн радио, нэвтрүүлгийн төрөл зүйл.

Оршил: Монгол Улсад соёл, боловсрол, зохион байгуулалтын ажлыг анх хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хийж эхэлсэн түүхтэй. Гэхдээ 1934 онд анхны нэвтрүүлгээ цацсан Монголын үндэсний радио бол улс орны амьдралд онцгой байр эзэлдэг. Монголын радиогийн өсөлтийн замнал, хөгжлийн алхмууд нь аймгуудад радиогийн үйл ажиллагааг эхлэх урьдчилсан нөхцөл болсон юм. 1934 оны 9-р сард Монголын ард түмэн үндэсний радиогийн анхны нэвтрүүлгийг сонссон бөгөөд энэ өдөр Монголын радиогийн төрсөн өдөр болон түүхэнд бичигдэн үлджээ (Нуриден, 2012).

1947 оны 4-р сарын 19-нд тусгай тогтоолоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэд Улсын радио нэвтрүүлгийн ба радиожуулалтын хороо байгуулагдсан бол 1952 онд Монголын радиог Олон улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын (ОИРТ) гишүүнээр элсүүлжээ.

1959 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Улсын радио хороо, МОНЦАМЭ агентлаг, “Орчин үеийн Монгол Улс” сэтгүүлийг нэгтгэн Мэдээллийн ба радиогийн хэрэг эрхлэх газрыг байгуулсан байна. 1960 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчийн зарлигаар Мэдээллийн ба радиогийн хэрэг эрхлэх газрыг Сайд нарын зөвлөлийн Мэдээлэл, радиогийн улсын хороо болгосон нь Монголын радиогийн материал техникийн бааз, нийтлэл нэвтрүүлгийн цар хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн зөв бүтэц бүрэлдэх нөхцөл болжээ (Норовсүрэн, 2010).

Зөвлөлт Холбоот Улс анхны радио зангилааг 1930-аад онд байгуулж өгсөн бол гучин жилийн дараа Лениний нэрэмжит радио станц Монголын нийслэлд дахин байгуулагдсан. Үүний ачаар түүний нийт хүчин чадал нь 3.6 дахин, радио

цэгүүдийн тоо 7.6 дахин нэмэгдсэн. 1960-1980 оны хооронд радио зангилааны тоо 71-ээс 367 болж өссөн (Современная Монголия, 1964). Судлаач, доктор Г.Дэлэгийн тэмдэглэснээр 1970-аад оны үед “Монголд 1934 онд хэдхэн мянган цэг ажиллуулах хүчин чадалтай 1-10 квт-ын хүчтэй жижиг радио станцаар нэвтрүүлгээ эхэлж байсан бол одоо 150 хүртэл квт-ын чадалтай Лениний нэрэмжит радио төв, Баян-Өлгийн радио станц зэрэг өндөр хүчин чадал бүхий дамжуулах станцуудтай болж, ... өдөр тутмын нэвтрүүлгийн цаг 12 дахин нэмэгдэж, радио өргөн нэвтрүүлэг 100 гаруй, тогтмол булан 40 гаруй, тусгай нэвтрүүлэг, радио сонин, сэтгүүлтэй болжээ” (Дэлэг, 2014).

1989 онд радио, телевизийн шинэ төв ашиглалтад орсон. 1990 оноос хойш Их Британи, Хонконг, Хятадын компаниуд хамтран “Эйшасат” олон улсын сансрын хиймэл дагуулыг хөөргөсөн бөгөөд Монгол Улс энэхүү хиймэл дагуулын нэг транспондерийг түрээслэх боломжтой болжээ. Эдгээр арга хэмжээний ачаар бүх сумын төвүүд үндэсний телевизийн нэвтрүүлгийг үзэх боломжоор хангагдсан. Улаанбаатар дахь “Азиасат” хиймэл дагуулын газрын станц ашиглалтад орсноор Монгол Улс олон улсын “Интелсат” болон “Азиасат” холбооны системд холбогдсон. Мөн “Жарык-Искра” хиймэл дагуулын системээр дамжуулан Алматыгаас нэвтрүүлэг сонсох боломжтой болжээ.

Монголын ОНМХ-ийн хөгжлийн эхний шатанд казах хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүсэж, казахууд 50-иад онд радио нэвтрүүлгийг монгол хэлээр сонсож байжээ. Энэ талаар архивт дараах баримт бичиг хадгалагдан үлджээ: “Аймгийн төвийн мэдээ долоо хоногт хоёр удаа тасралтгүй цацагдаж байна. Сумдад анхны чанга яригчдыг 1950 оны 12-р сард суурилуулж, радио нэвтрүүлгийг хүлээн авч эхэлсэн. Чанга яригч хариуцсан хүмүүс хотын мэдээг ухуулагчид болон бусад хүмүүст зориулж казах хэл рүү орчуулан сурталчилж, 2-3 удаа давтан сонсож, суртал ухуулгын ажил хийж байна. Бид анхны радиод зориулж дулаан байшин, арван боодол түлээ бэлдэж, Улаан булангийн дарга Бадарчийг хоёр өдрийн семинарт хамруулж, 1950 оны 12-р сарын 16-ны өдөр сумын хүмүүс цугларч, анх радиогийн дууг сонссон. Нийт 166 хүн цугларч сонирхсон. Мөн бид тэр өдөр радиогоор цацагдсан малыг өвлөөс эсэн мэнд гаргах тухай өгүүллийг бичиж аваад малчдад тараасан. Цаашид тогтмол радиотой болохын тулд бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд 500 метр гуур утас, 10 ширхэг бэхэлгээний шил, 10 ширхэг төмөр өлгүүр хандивлана уу” (Эфир друзей, 1977).

Радиогийн түүхийг өгүүлсэн эдгээр мөрүүд тус аймгийн казахууд 1950 оны 12-р сарын 16-нд Улаанбаатар хотоос анх монгол хэл дээрх нэвтрүүлгийг сонссоныг гэрчлэх баримт мөн.

1956 оноос хойш Монголын радио станцууд орос, хятад, казах хэлээр нэвтрүүлэг цацаж эхэлсэн. Энэ бол Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн хоёр дахь үе шат байв. Казах хэл дээрх анхны нэвтрүүлэг 15 минут үргэлжилдэг байв. Тухайн үед казах хэл дээр мэдээ бэлтгэдэг тусгай баг байгаагүй тул нийслэлд суралцаж буй казах оюутнууд бэлтгэж, нэвтрүүлдэг байсан. Жишээлбэл, тухайн үед 15 минутын нэвтрүүлгийг АУДС-ийн оюутан Ж.Хайрол уншдаг байжээ. Дараа жил нь ажилтан нэмэгдэж, М.Хизатыг ажилд авчээ. Радиогийн анхны ажилтнууд нь Б.Базилхан, А.Хабылахат, Алматы хотын Абайн нэрэмжит Багшийн дээд сургуулийг төгссөн Х.Кулдан, Залике нар байв.

Арван таван минутын нэвтрүүлэгт гол төлөв сониноос бэлтгэсэн мэдээлэл багтдаг байжээ. Нийслэл Улаанбаатараас казах хэлээр мэдээ цацаж эхэлсэн нь

томоохон түүхэн үйл явдал байв. Учир нь тухайн үед аймаг бүр өөрийн гэсэн радио зангилаатай байв. Ирэх жил Улаанбаатараас казах хэлээр нэвтрүүлэг цацаж эхэлсний 70 жилийн ой тохионо.

Судалгааны арга зүй: Бид эл өгүүллийн объект болгон Монголын болон Баян-Өлгий аймгийн радиогийн архивын материалуудыг голлон ашигласан. Өнгөрсөн зууны 30-аад оноос нэвтрүүлэг цацаж эхэлсэн Монголын радио, 60-аад оны дунд үеэс үйл ажиллагаагаа эхэлсэн Баян-Өлгий аймгийн радиогийн түүх, үүсэл, хөгжлийн талаар сонин, сэтгүүл, вэбсайтуудад нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүд болон нийтлэлүүдийг авч үзсэн. Тэдгээрийг нэгтгэн дүгнэх, сэдэвчилсэн болон агуулгын дүн шинжилгээ хийх аргуудыг голлон ашигласан. Материалуудыг сэдэв, бичлэгийн төрөл зүйл, мэдээллийн эх сурвалжийн ашиглалтын түвшингээр нь шинжилсэн. Шинжлэх ухааны эргэлтэд орсон баримт бичгүүдэд үндэслэн уг өгүүлэлд радиогийн зохион байгуулалт, техникийн хүчин чадлыг сайжруулах, улс төр, олон нийтийн болон соёл, боловсролын ажлыг сурталчлахад гүйцэтгэсэн үүргийг, мөн радио нэвтрүүлгийн агуулга хагас зуун гаруй жилийн хугацаанд сайжирч, орчин үед нийгмийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн урагшилж байгаа талаар өгүүлсэн. Нийгмийн шинжлэх ухааны судалгааны зарчимд үндэслэн цогц, системчилсэн дүн шинжилгээ хийсэн. Монгол Улсын, тэр дундаа Баян-Өлгий аймгийн радио станцуудын нэвтрүүлгийг түүхэн болон харьцуулан судлах аргаар шинжилж, цогц дүн шинжилгээ хийх явцад дээрх радио станцуудын өнөөгийн хөгжлийг орчин үеийн үйл явц гэж үзэх боломжийг бидэнд олгосон юм.

Судалгааны онолын үндэс болгон Р.Нуриден (1997), Н.Омашев (1995), Г.Дэлэг (1971-1972), М.Зулькафил (1998), А.Минис, А.Сарай (1960), В.Н.Ярошенко (1976), С.Х.Барлыбаева (1994), Л.Норовсүрэн (2010), Д.Дагиймаа (2009), Д.Батжаргал, Г.Мэндхүү (2015) нарын радио нэвтрүүлэг, радио сэтгүүл зүйн талаарх шинжлэх ухааны бүтээлүүдийг ашиглав.

Мөн энэхүү өгүүлэлд шинжлэх ухааны эргэлтэд орсон аймгийн радиогийн архивын баримт бичгүүдийг авч үзсэн. Социализмын үеийн Монгол Улсын болон аймгийн радиогийн туршлагыг практик талаас нь авч үзэх гол шалтгаан нь өмнөх үед болон одоогийн хөгжлийн явцыг харьцуулах явдал юм. Монголын казах радио нь олон жилийн туршлага хуримтлуулсны ачаар орон нутгийн нийгэм, эдийн засаг, соёл, боловсролын хөгжилд багагүй хувь нэмэр оруулсан байдаг.

Үр дүн ба хэлэлцүүлэг: Цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхсан казах сэтгүүлчдийн ажлын үр дүнд 1965 онд радио нэвтрүүлгийн редакцыг Улаанбаатараас Баян-Өлгийд шилжүүлсэн. Энэ онд Чехословакийн тусламжтайгаар тус аймагт баригдсан радио станц ашиглалтад орсон. Энэхүү радио станцын дамжуулах хүчин чадал нь 60 кВт буюу 500 км зайд зориулагдсан байжээ. Казах нэвтрүүлэг аймгийн өнцөг буланд тархаж эхэлсэн бөгөөд Баян-Өлгийгээс гадна Ховд, Увс аймгуудад сонсох боломжтой байв. Эхэндээ энэ редакц орон нутгийн оршин суугчдад зориулж 30 минутын нэвтрүүлэг явуулдаг байсан бөгөөд мөн тийм хэмжээний нэвтрүүлгийг гадаадад байгаа казахуудад зориулдаг байв. Тухайн үед радио нэвтрүүлгийг бэлтгэдэг ажилтны тоо арав хүрэхгүй байсан. Радиогийн ерөнхий редактороор М.Хизатыг томилжээ.

Нэвтрүүлгийн агуулга, чанар, техникийн асуудлыг редактор, хоёр сурвалжлагч, найруулагч, зураглаач, дөрвөн техникч хариуцаж байв. “Баян-Өлгий аймгаас ярьж байна” гэсэн үгээр эхэлсэн анхны нэвтрүүлэг “Кенес” хэмээх домборын аялгуугар (күй) эхэлж, хагас цагийн нэвтрүүлэгт аймгийн намын хорооны суртал ухуулгын

асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Сонгыбай үг хэлж, олон нийтэд радио нэвтрүүлгийг төрөлх хэлээрээ цацаж байгаад баяр хүргэж, радиогийн өмнө тулгарч буй ажлуудыг тайлбарлав. Баяр ёслолын шинжтэй энэхүү анхны радио нэвтрүүлэгт “Монгол бол миний эх орон” нэртэй өгүүлэл, Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг, Н.Шериязданы “Өнөөгийн Баян-Өлгий” гэсэн зураглалыг багтаасан бөгөөд төгсгөл нь концертоор үргэлжилжээ. Энэхүү концертод 1959 онд Баян-Өлгийд байгуулагдсан анхны ардын хөгжмийн зэмсгийн найрал хөгжмийн аянд дуу, домборын аялгууг тоголж, цуур хөгжимчин Калек, домборчин Ахмет, дуучин Хибатдолда нар казах урлагийн гайхамшигийг харуулсан байдаг. Нэвтрүүлгийг алдарт “Телконыр” аялгуугаар төгсгөжээ. Тус аймагт анхны нэвтрүүлгээ ийм маягаар эхлүүлсэн энэхүү редакц өөрийнхөө хөтөлбөрийг малчин, ажилчин, сургуулийн хүүхдүүдэд зориулсан түүхтэй юм.

Баян-Өлгийн радиогийн хөгжлийг дараах үе шатуудад хуваан үзэж болно.

Эхний үе нь 1965-1975 оныг хамардаг бөгөөд суртал ухуулгын ажлаараа ард түмнийг гэгээрэл, боловсрол, урлаг, соёлд уриалж байсан; Хоёр дахь үе нь 1975-1986 он юм. Энэ үед аймгийн радио нь Монголд социалист аж төрөх ёс, социалист уралдаан, социализмын үзэл санааг голлон сурталчилж байв. Радио ч өөрийн цаг үе, нийгэмд үйлчилсэн нь тодорхой.

1970-аад он хүртэл аймгийн радио сониноос бэлэн мэдээ уншиж, дуу, ёс заншил, уламжлалын тухай яриагаар хязгаарлагдаж байв. 1967 оны нэгдүгээр сарын 12-ны “Залуу үе” нэвтрүүлэгт яруу найрагч О.Солдатханы “Баатарлаг үйлс мөнхөд оршино” шүлэгтээ 1939 оны Халх голын дайнд оролцсон цорын ганц казах хүн Мазимын Икейн баатарлаг гавьяаг магтан дуулсан байдаг. Энэ нэвтрүүлгийн дараа хүмүүс баатрын тухай идэвхтэй ярьж эхэлсэн. Харин 30 жилийн дараа л түүнд Монгол Улсын баатар цолыг нэхэн олгожээ.

Сэтгүүлчид хагас цагийн нэвтрүүлэгт мэдээллийн нэвтрүүлгийн төрлийг өргөжүүлж, хэд хэдэн шинэ булан нээж, “Хот айлын амьдрал”, “Соёл ба амьдрал”, “Залуу үе” зэрэг нэвтрүүлгүүд шинээр цацагдаж эхэлсэн нь Казахстаны “Шалкар” нэвтрүүлгийн үлгэр жишээ байсан гэж хэлж болно.

Далаад оны үед радио нэвтрүүлгийн чанар мэдэгдэхүйц сайжирсан. Учир нь тусгай мэргэжилтэй боловсон хүчин редакцад ирж эхэлсэн бөгөөд тэд онолыг практиктай хослуулахад чухал үүрэг гүйцэтгэжээ. Радио нэвтрүүлгийг төрөл зүйлийн хувьд баяжуулж байгаа нь ажиглагдаж, “Цаг үе ба үйл явдал”, “Намын амьдрал”, “Хот айлын соёл”, “Эмэгтэйчүүд”, “Сургууль ба эцэг эх” зэрэг 20 орчим булан шинээр нээж, янз бүрийн сэдэв, чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэх болжээ.

Энэ үед редакц идэвхтэн бичигчдэд анхаарал хандуулж, тэднийг радиогийн ажилд татан оролцуулж эхэлсэн. Учир нь 1976 оны 12-р сарын 7-нд болсон Монголын сэтгүүлчдийн III их хурал, Идэвхтэн бичигчдийн улсын III зөвлөгөөнөөс тэдний бичих ур чадварыг дээшлүүлэх, төрөл зүйлийг эзэмших гол зорилтыг тавьсан юм. Эдгээр уулзалтад зөвхөн аймгийн сэтгүүлчид төдийгүй идэвхтэн бичигчид ч оролцсон. Дээрх арга хэмжээний дараа тодорхой ажлуудыг практикт хэрэгжүүлж эхэлжээ.

Сум бүрд 5-7 хүний бүрэлдэхүүнтэй идэвхтэн бичигчдийн хэсэг зохион байгуулагдаж, аймгийн “Жана өмир” сонин нийтлэл, түүний онцлогийн талаар тусгай хичээл явуулж, түүнийг “Идэвхтэн сурвалжлагчдад тусламж” гэсэн буланд тогтмол нийтэлдэг байв. 1970-аад онд хөдөө орон нутгаас захидал бичдэг хүн

гарын арван хуруунд багтдаг байсан бол 1980-аад онд радиогийн редакц идэвхтэн сурвалжлагч, орон нутгийн бичигчдээс 1100 орчим захидал, сонсогчдоос 1000-1200 хүсэлт хүлээн авч, нэвтрүүлэгт оруулж, жил бүр 1450-1560 хүртэл материал бэлтгэдэг болжээ. Тэдгээрийг “Радиод захидал ирлээ”, “Захидлын эзэн-ард түмэн”, “Хөдөлмөрчдийн захидал” гэсэн булангаар нэвтрүүлдэг байв.

МАХН-ын III их хурал, БНМАУ-ын 60 жилийн ой, Халх голд Японы милитаристуудыг бут цохисны 45 жилийн ойг тохиолдуулан “Жана өмир” сонин, радиогийн редакц 1984 оныг “Идэвхтэн бичигчдэд”-д зориулав. Энэ арга хэмжээ нь олон нийттэй холбоо тогтооход чухал нөлөө үзүүлжээ. Нэгэн идэвхтэн бичигч: “Би аймгийн радио, сонинд орон нутгийн сурвалжлагчаар 10 орчим жил ажиллаж байна. Бичсэн зүйл чинь хэвлэгдэж үүрд дурсагдах нь маш их баяр баясгалан, харин захидал эсвэл утсаар дамжуулсан зүйлийг чинь радиогоор мэдээлж, хязгааргүй орон зайд тархах нь түүнээс ч илүү баяр юм. Ялангуяа радиогоор суртал ухуулга хийх үед малчид маш их баярлан хүлээж авдаг. Тэд үүнийг радио долгионоор сонсоход тэдний ажил, амьдралд гэсэн хүсэл тэмүүлэл нь улам ихээр нэмэгддэг. Ийм чухал үүрэг гүйцэтгэж буй радиогийн бүх идэвхтэн сурвалжлагчдад баяр хүргэж, би цаг үеийн шаардлагад нийцүүлэн бичихийг хичээх болно” гэж ярьсан бол өөр нэг идэвхтэн бичигч айл бүрийн хормойд заларсан радио хүлээн авагч бол бидний итгэлт найз, оюун санааны урам хайрлагч гэж нэмж хэлсэн байдаг. Үүнээс үзэхэд радио аймгийн иргэдийн амьдралд гүн нэвтэрч, айл бүрийн дотно зөвлөгч нь болж чадсныг мэдэрч болно.

Цаг үеийн нөлөөгөөр 80-аад онд нэвтрүүлгийн 60 хувь нь улс төрийн, 40 хувь нь хөгжмийн болж өөрчлөгдөж, редакцын алба дуу хөгжмийн сангаа нэмэгдүүлэхэд байнга анхаарч ажиллах болжээ. Тэр үед гэхэд энэ санг 2500 нэгж дуу, хөгжим бүрдүүлж байсан нь өндөр үзүүлэлт юм. Радио нэвтрүүлгийн редакц нь 1965 онд байгуулагдсанаасаа хойш хөгжлийн ийм үе шатуудыг туулж ирсэн түүхтэй юм.

Өөр нэг онцлон хэлэх зүйл бол Монголын бүх сэхээтний төлөөлөгчид сонин, радиог байнга дэмжиж, бүтээлээ толилуулдаг явдал юм. Олонд танил уран бүтээлчдийн үзгийг хурцлахад сонин, радио чухал үүрэг гүйцэтгэсэн. Тиймээс зохиолчдын эдгээр амжилт нь гол төлөв олон нийтийн мэдээллийн хэрэгслээс үүдэлтэй юм.

1986 онд эхэлсэн гурав дахь үеийг шинэчлэлийн эрин үе гэж нэрлэдэг. Эдгээр жилүүдэд Москвад эхэлсэн ардчиллын үйл явц нь Монголыг ч хамарч, Зөвлөлтийн эзэнт гүрний үзэл суртлын хүлээнээс чөлөөлсөн юм. 1986 оны эхээр болсон МАХН-ын XIX их хурлаар нийгэмд болж буй шинэчлэлд шинэ хандлага шаардлагатай байгааг тэмдэглэж, эхний шатанд гол чиглэлийг эдийн засгийн механизм руу шилжүүлэхийн ач холбогдлыг онцолсон. Тиймээс хэвлэл, радио, телевизийн гол зорилго нь улс орны өөрчлөлтийг ард түмэнд сурталчлах, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх, бүтээлч уур амьсгалыг хэвшүүлэх явдал чухал гэдгийг онцлон заасан байдаг.

Монголын сэтгүүлчдийн V их хурал 1987 оны 11-р сарын 11-12-нд болж, Их хурлаас дэвшүүлсэн асуудлуудыг шийдвэрлэх, тавьсан зорилтуудыг биелүүлэхийн тулд сэтгүүлчид ажлаа хэд хэдэн чиглэлээр явуулж эхэлсэн. Эхнийх нь хөдөлмөрийн хамт олон, хувь хүмүүсийн бодит, ажил хэрэгч үйл ажиллагааг сурталчлах, хүнд суртал, дур зоргоороо авирлах, хайхрамжгүй байдал зэрэг сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн хоцрогдлыг арилгах, хоосон баримтуудыг тоочих бус оршиж буй дутагдлын шалтгааныг илрүүлэх,

эцсийн үр дүнд хүрэх зэрэг асуудлаар ил тод бичих явдал байв. Түүнчлэн, 1988 онд болсон БНМАУ-ын Төв Хорооны V бүгд хурал нийгмийн эдийн засаг, улс төрийн тогтолцоо, нийгэм, оюун санааны амьдралыг шинэчлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон байдаг.

ОНМХ-үүд өөрчлөн байгуулалтын чухал асуудлуудад анхаарлаа хандуулж, олон нийтийн хүсэн хүлээж буй сэдвүүдийг хөндөх, нийгэмд шүүмжлэлт уур амьсгалыг бүрдүүлэх, ардчилал, ил тод байдлыг хэвшүүлэх чиглэлд идэвхтэй алхам хийж, ажлын арга барилдаа багагүй өөрчлөлт оруулж чадсан. Цаашид нийтлэл, нэвтрүүлгийн чанарыг улам сайжруулахад онцгойлон анхаарч эхэлсэн. Олон нийтийн хүсэн хүлээж буй сэдвүүд ч хангалттай байсан. Ялангуяа хэл, шашин шүтлэг, ёс заншлын асуудал бүдгэрч эхэлсэн үед Монголын казахууд ардчиллын үр дүнг ашиглан өөрсдийн санаа бодол, тулгамдсан асуудлуудаа радиогоор дамжуулан дэвшүүлэн тавьдаг болжээ.

1990 онд Монголд ардчилсан хувьсгал тайван замаар ялалтад хүрсэн. IV Их хурлыг зарлан хуралдуулж, БНМАУ-ыг Монгол Улс гэж нэрлэх болсноо тунхагласан. Ийм улс төрийн өөрчлөлтийн дараа нэг намын коммунист улсаас олон намын тогтолцоотой парламентын ардчилсан улс болсон түүхтэй. Монгол Улсын шинэ Үндсэн хуулиас марксизм-ленинизмд үнэнч байх, коммунист намын тэргүүлэх үүргийн тухай заалтуудыг авч хаясан. Улс орны улс төрийн өөрчлөлт, ардчилал ба ил тод байдал, эдийн засгийн шинэчлэл, нийгмийн нөхцөл байдал нь хэвлэл мэдээллийн ажилтнуудыг зоригжуулж, тэд үндэсний асуудлын талаар зоригтой ярьж, радио нэвтрүүлгийн агуулга нь эрс сайжирсан.

1435 метрийн урт долгионоор цацдаг Баян-Өлгий аймгийн радио станц нэвтрүүлгээ өөр чиглэлд эргүүлж, үндэстнээ түлхүү боддог, тэдний ирээдүйн төлөө тэмцдэг, казах нэрийг дэлхийд таниулах чадвартай агуу хүч, хурц хэрэгсэл болон хувирчээ. Өмнө нь хагас цагийн нэвтрүүлэгт бэлтгэсэн материал нь багтахгүй зарим чухал материалыг хэсэг хэсгээр нь хувааж, хэдэн өдөр үргэлжлүүлэн нэвтрүүлдэг байв. 1989 оноос хойш эфирийн цаг хоёр дахин нэмэгдэж, гадаад нэвтрүүлэг ч мөн адил хэмжээгээр цацагдаж эхэлсэн. Ийнхүү Баян-Өлгийн радио долоо хоногт 14 цаг, жилд 730 цаг нэвтрүүлэг цацдаг болжээ. Нэвтрүүлгийн эфирийн цаг нь нэмэгдсэн үед нэвтрүүлгийн бодлогод нийцэхгүй, тулга тойрсон хэдэн асуудлын хүрээнд эргэлдсэн, тархай бутархай, эмх замбараагүй байдал ажиглагдах болсныг сонсогчид тэр даруй анзаарч, редакцияд санал бодлоо илэрхийлсэн нь дутагдлаа засахад чухал нөлөө үзүүлжээ.

Баян-Өлгийн радиогийн редакц үндэсний асуудлын талаар ил тод ярьж, казахуудыг өмнө тулгарч буй зарим асуудлыг нэвтрүүлэгтээ оруулах нь нэмэгдсэн. Радиоог сонсож эхэлснээс хойш нэлээд хугацаа өнгөрсөн ч сонсогчид сүүлийн жилүүдийнх шиг шинэлэг мэдээ, мэдээллийг сонсож байгаагүй юм.

Ялангуяа хэл, нүүдэл суудлын асуудал; уламжлал, үндэсний онцлог, хүмүүжил; соёл, шашны асуудал; зах зээлийн эдийн засаг; “эсэргүү”-гийн он жилүүд; дайны мартагдсан баатрууд (1939 оны Халх голын дайн) зэрэг сэдвүүд радиогийн хөтөлбөрт гол байр эзлэх болов. Ийм сэдвүүдийг хамруулахын тулд редакц шинэ булангууд нээж, нэвтрүүлгүүдийг агуулгаар нь бүлэглэж, мөн сонсогчдын мэдээллийн эрэлт хэрэгцээг түлхүү анхаардаг болжээ.

Долоо хоногт нэг удаа цацагддаг “Цаг үе ба үйл явдал” нэвтрүүлгийн хамрах асуудлуудын хүрээ нь өргөн бөгөөд цаг хугацааны явцад болсон үйл явдлуудыг тайлан, сурвалжилга, ярилцлагын хэлбэрээр тоймлон харуулдаг байсан. Хагас

сар тутмын “Хот айлын амьдрал” нэвтрүүлэг нь “Малчин ба зах зээл”, “Хүн ба газар”, “Өвөө минь хоньчин байсан”, “Асуу, бид хариулна”, “Надад хэлэх зүйл байна”, “Бидний ярилцлага” гэсэн булангаар малчин, тариачин түмний амьдрал ахуй, ололт амжилт, тулгамдсан асуудлуудыг нэлээд өргөн хүрээнд тусгадаг байв. Мөн “Хүн ба хууль”, “Редакцын шуудан”, “Сургууль-Эцэг эх”, “Хот айлын соёл”, “Эмэгтэйчүүд” зэрэг нэвтрүүлэг болон сурагчид, залуучуудад зориулсан “Яргуй”, “Залуу үе” зэрэг радио сэтгүүлүүд хамрах асуудал, мэдээллийн багтаамж, танин мэдэхүйн ач холбогдлоороо сонсогчдын талархлыг хүлээж байв. Радио сэтгүүлүүд ирээдүйд үйлчлэхийг гол зорилго болгож байлаа.

“Яргуй” радио сэтгүүлийн “Ардын сурган хүмүүжүүлэх ухаан” буланд хүүхдэд зориулсан үндэсний тоглоом, зугаа цэнгэл, зан үйл, хүүхдүүдийг амьдралд бэлтгэх, энгийн ардын боловсролын сургаалын талаар мэдээлэл өгдөг. Эдгээр сэдвээр ахмад настан, багш, эрдэмтдийн яриа, үнэт зөвлөгөөг тогтмол өгдөг байв. “Сурагчдын санал бодол” буланд сургууль, багш, найз нөхөд, боловсрол, хүмүүжил, хүрээлэн буй орчин, соёлын болон оюун санааны баялаг, хүнлэг ёс зэрэг янз бүрийн сэдвээр хүүхдүүдийн өөрсдийн үзэл бодол, сэтгэгдлийг нэвтрүүлдэг байв.

“Авьяаслаг хүүхдүүд”-эд сурлага хөдөлмөрөөрөө тэргүүлсэн, үлгэр дууриал үзүүлсэн авьяаслаг хүүхдүүд, мөн тамирчин, домборчин, яруу найрагч хүүхдүүдийг сурталчилж, хөтөлбөрт авьяаслаг хүүхдүүдийг оролцуулж, урлагт тэмүүлэх хүсэл эмэлзлийг нэмэгдүүлэв. “Эмээгийн үлгэр” булангаар дамжуулан ардын болон дэлхийн зохиолчдын үлгэр, домог, ахмадуудын хууч яриаг нэвтрүүлж, “Яргуй” концертын “Айгөлөк” хөтөлбөрийг баяр хүргэх, амжилт хүсэх, мэндчилгээ; тодорхой дуу эсвэл домборын аягууны түүх, зохиогчийн намтар, бүтээлийн гоо зүйн учир утга; хүүхдүүд өөрсдөө бэлтгэж, тусгай хальсанд бичиж илгээсэн эсвэл студид тусгайлан бичсэн бүхэл бүтэн концерт гэсэн гурван өөр чиглэлээр зохион байгуулдаг байжээ.

“Хойч үеийнхээ төлөө”, “Алдартнаас суралц” буланд үндэстний болон дэлхийн ард түмний нэрт хүмүүсийн амьдрал, тэдний сургаал үгс, яруу найраг, бүтээлүүдийг танилцуулж, энэ нэвтрүүлгийг бэлтгэх үйл явцад сурагчид өөрсдөө идэвхтэй оролцож, тэд сонирхолтой, утга төгөлдөр захидал илгээдэг байв.

Өдөр бүр есөн цагаас арван цагийн хооронд олны хүртээл болдог нэвтрүүлгийн агуулга, хэлбэр байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг. Үүний нэг нь шашны сэдэв юм. Монголын казахуудын шашин шүтлэг мартагдахын даваан дээр тулж, үндэстний зүрх сэтгэлийг зовоосон эмзэг асуудлын нэг байв. Монголын ард түмний хувь тавилан нь казах ард түмний хувь тавилантай холбоотой бөгөөд төстэй юм. Тиймээс Казахстаны казахуудыг нөмөрсөн хар шуурга тэднийг ч амар тайван орхисонгүй. 1921 оны “Ардын хувьсгал” нь юуны түрүүнд шашны эсрэг тэмцсэн. Олон зууны турш бий болсон ёс заншил, уламжлал, түүх, урлаг, хэл, шашин шүтлэг нь 30-40-өөд оны үймээний золиос болсон байдаг.

Хэнд ч дийлдэшгүй хүч Баруун Монголын казахын ард иргэдийг ч хамарч, үндэсний манлайлагчид хэчнээн зөвлөлдсөн ч гарах гарц олж чадсангүй. Дайснаас зугтах цаг аль хэдийнэ өнгөрч, Баруун хилийг харуулын цэргүүд манаж байв. Олон нийтэд нөлөө бүхий хүмүүс, шашны зүтгэлтнүүд, молда нарыг байгаа газраас нь зэвсэг барьсан хүйтэн царайтай эрчүүд барьж эхлэв. Монголын казахуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийн удирдагч Т.Дауйтбай мөн энэ халдлагын золиос болжээ. Энэ бол Монголын казахуудын хувьд “хэлж ирсэн гамшиг” байв. Урьд өмнө нь ийм хядлага болж байгаагүй бөгөөд түүхч И.Цоодол 2000 казах иргэнийг

баривчилсан гэж бичсэн байдаг.

Исламын шашны эсрэг ширүүн тэмцэл өрнөж, арав орчим сүм хийд, шашны газруудыг устгасан. Коран судар, шашны ном, эртний түүхэн бичвэрүүдийг шатааж, тогтсон шашны ёс, уламжлалт ардын ёс заншлыг хориглох хандлага газар авсан. Зөвхөн өнгөрсөн зууны 90-ээд оноос л Исламын ертөнц Монгол Улсад мусульманчууд амьдардаг гэдгийг мэдэж эхэлсэн бөгөөд Турк, Саудын Араб, Англи, Пакистан, Бангладеш, Египет зэрэг орнуудын мусульман шашны байгууллагуудын төлөөлөгчид ирдэг болжээ. Удалгүй Монголд Мусульманы нийгэмлэг байгуулагдаж, анхны сүм хийдүүд баригдаж, хуучин клуб, суртал ухуулгын газруудад Баасан гарагийн шашны залбирал үйлдэж эхэлсэн ажээ.

Энэ үед өөр нэг үр дүнтэй мэдээллийн хэрэгсэл бол радио байв. Сонсогчид итгэл үнэмшил, мэдлэг мэдээллээр дүүрэн Баян-Өлгийн радиогийн шашны нэвтрүүлгийг тэсэн ядан хүлээдэг болсон. Радио нь Турк, Казахстаны шашны сургуульд суралцаж буй оюутнуудын тухай, мөн 67 жилийн дараа Меккед очиж мөргөл үйлдсэн 16 хүний аяллын талаар олон түмэнд мэдээлж байв. “Өв уламжлал” нэвтрүүлгээр хүмүүст итгэл үнэмшил, сайн сайхныг шингээсэн Коран судар, шашны сургаал, өдрийн таван удаагийн залбирлын тухай яриа тогтмол өрнүүлж, түүнд сонсогчид онцгой анхаарал хандуулдаг болжээ.

1991 онд Монголын Мусульманы нийгэмлэгийн тэргүүн хажы Кадырын Сайран анх удаа Турк руу шашны сургуульд суралцуулахаар 40 хүүхдийг дагуулан явсан. “Дээр үед нэрт яруу найрагч Ахыт Хажы ийшээ тийшээ явахдаа очиж чадаагүй Истамбулын талаарх мөрөөдлийг “Хажы-Баян” зохиолдоо өгүүлсэн байдаг. Эрт дээр үеэс казахуудын зүрх сэтгэлд ойр байсан энэ хотод өнөөдөр Ахытын ач, зээ нар шашны сургуульд явах болсон” гэж эхэлдэг Ж.Кекейн “Дөчин зул” нэртэй өгүүлэл нь танин мэдэхүйн болон хүмүүжлийн чухал ач холбогдолтой юм. Арван минутын радио яриа таны зүрх сэтгэлийг эзэмдэж, оюун санааг тань гэрэлтүүлнэ. Нэвтрүүлэг Үлимжийн Ахытын шүлгээр төгсдөг. Энэ нь бас утга учиртай юм. Ү.Ахыт бол Коран сударт мусульманчуудын өдөр тутмын амьдралд шаардлагатай зарчмууд агуулагдадаг гэдгийг гүн гүнзгий мэддэг, өөрөө түүнийг төгс эзэмшсэн цөөхөн соён гэгээрүүлэгчийн нэг байв. Тиймээс тэрээр амьдралын зарим сөрөг үйлдлийг шашин шүтлэг, шашны аргаар засахыг хичээдэг. Казахстанд нэр нь тийм ч алдартай биш ч Шинжаан, Хобдын казахуудад Абайгаас дутахгүй нөлөө үзүүлсэн яруу найрагчийн “Иман мизам” хэмээх богино туульсыг ард түмний дундаас бичиж аваад тэтгэвэрт гарсан ахмад Халез радиод илгээсэн байдаг. Энэ шүлгийг нэвтрүүлэгч домборын аялгуутай хослон уншсан нь сонсогчдод онцгой сэтгэгдэл төрүүлжээ. Ахмад сэтгүүлч С.Магаунигийн “Ахытын Абай Касымовтой хийсэн уулзалт” (Баян-өлгий радио. 1993.24.02) радио яриа нь зөвхөн Монголын казахуудын төдийгүй дэлхийн нийт казахуудын хэрэгцээнд нийцсэн гайхамшигтай бүтээл юм.

Ардчиллын ялалт нь Баян-Өлгийн радиогийн хөгжлийг урагшлуулж, эрч хүчийг нь нэмэгдүүлсэн юм. Үйл ажиллагаагаа өөрчлөн шинэчилж, сонсогчдынхаа зүрх сэтгэлийг эзэмдэхийн хэрээр иргэдээс ирэх үнэ цэнэтэй захидлууд тоо ч эрс нэмэгдэж, ганц жилийн дотор редакцияд ирсэн захидлын тоо 3000-аас хол давжээ.

Баян-Өлгийн радио үгийн эрдэнсийг асгаж, тэднийгээ домборын аялгуугаар чимэж, дуу хуураар баяжуулж, сонсогч түмэнд олон сайхан нэвтрүүлгээр бэлэг барьсан. Тэдгээрээс хамгийн алдартай нь “Казахуудад буянаа хайрласан хонь жил” радио зохиомж юм. Энэ бүтээл казах түмний хөргийг бүтээсэн гэж хэлбэл хэтрүүлэг болохгүй. Бид энэ бүтээлээс радиогийн бүх элементийг, тухайлбал уран

нийтлэлийн өнгө аяс, хөгжмийн чимэглэл, үйл явдлын өрнөл, оргил үе, тайлал, шийдэл зэргийг олж чадна.

1949 оноос хойш Абай, Шакарим, Мухтар зэрэг агуу хөвгүүдийн өлгий нутаг Семейд цөмийн зэвсгийн туршилт явуулж, олон жилийн турш 500 орчим цөмийн дэлбэрэлт хийж, мянга мянган хүний эрүүл мэнд, амь насанд хор хөнөөл учруулсан туршилтын талбайг хаах зарлиг гарсан. Энэхүү буян хишгээ хайрласан нутгаас Токтар Аубакиров сансарт ниссэн зэрэг чухал үйл явдлуудын цаашдын хөгжил нь түүхийн гүн рүү хөтөлж, сайн үйлсийг алдаршуулж, сонсогчдод дахин нэг эрч хүч өгсөн түүхтэй. Энэ тухай нэвтрүүлгийг сонсож суухад Монголын казах уран бүтээлчид түүхээс тусгаарлалгүйгээр олон жилийн турш хадгалж ирсэн мөрөөдөл, хүсэл бодлоо илэрхийлж байгааг мэдэрч болно. Үндэсний тусгаар тогтнол, түүнд хүрэх нь бүтээлийн шийдвэрлэх цэг, казах дүр төрхийг тодорхойлох мөч юм. Цаашид сэтгүүлч тухайн үеийн улс төрийн үйл явдлын үнэн дүр төрхийг хэлж чаддаг. Радиогийн энэхүү бүтээлийг шинэчлэлийн үед төрсөн шилдэг урлагийн бүтээл гэж хэлж болно.

Баян-Өлгийн радиогийн редакцын хамгийн өвөрмөц онцлогуудын нэг бол аман зохиолын баялаг өвийг ашиглан нэвтрүүлгээ түүн дээр үндэслэн явуулдаг явдал юм. Радиод хатуу зарчим байдаггүй. Түүний гол зорилго нь ард түмэнтэй харилцах, сонсогчдын эрэлт хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, түүний гол эх сурвалж, эхлэлийн цэг нь аман зохиолын баялаг сан юм. Казахын хариагч ойлгомжтой болгон буцааж өгөх нь радио сэтгүүлчдийн эрхэм зорилго мөн.

1993 оны 3-р сарын 1-нд радио долгионоор олон нийтэд сауын хэмээх зар-уриалга гаргасан. Казахын уламжлалын дагуу талийгаачийн жилийн ойг тэмдэглэхээс нэг жил эсвэл хэдэн сарын өмнө орон даяар олон нийтэд зар хүргэдэг. Энэ нь Кожаберген баатрын нас барсан жилийн ойг тэмдэглэх тухай зар байжээ.

1993 оны 3-р сарын 23-нд онгоцны ослоор цаг бусаар нас барсан иргэдийн тухай мэдээ тус аймгийн ард түмний сэтгэл зүйд маш хүчтэй нөлөөлсөн. Энэхүү эмгэнэлт явдалтай холбогдуулан байгууллага, хувь хүмүүсээс талийгаачийн төрөл төрөгсдөд эмгэнэл илэрхийлсэн захидлууд редакцад тасралтгүй ирж байв. Үүний дагуу радио долгионоор цацагдсан тайтгарал, эмгэнэл нь ард түмний сэтгэлийг хөдөлгөсөн юм. Гурван өдөр үргэлжилсэн гашуудлын мэдээ аймгийн тэнгэрийг ниргэх шиг болов. Энэхүү ослоор авьяаслаг яруу найрагч Жанжуны Какей нас барсан нь аймгийн нийт иргэдэд учирсан хүнд гарз байв. Яруу найрагчид гашуудлын шүлгээ уншиж, радио долгионоор сэтгэлийн үгээ түмэнд түгээж байлаа. Үүний нэг нь аявьяаслаг яруу найрагч Х.Тойлыбайн шүлэг байв.

Радио нь ард түмний үеэс үед дамжин уламжлагдан ирсэн аман зохиолыг шинэ хэлбэр, агуулга болгон баяжуулж, өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бичгийн уран зохиолыг бүрдүүлэхэд хосгүй үүрэг гүйцэтгэсэн. Нэрт зохиолчид төрөл зүйл бүрт өөрийн гэсэн ул мөрөө үлдээсэн. Ялангуяа уламжлалт яруу найргийн салбарт хэнээс ч ичдэггүй гайхалтай бүтээлүүд туурвигдсан. Энэ талаар ард түмний маань үргэлж хайрлаж, сонсдог байсан туульсын найраглалууд үлгэр дуурайлал болсон. Гэсэн хэдий ч ахмад үеийнхэн сонирхон уншиж, цээжээр уншдаг байсан Б.Ахтан, Д.Даниял, Ж.Икрамбек зэрэг яруу найрагчдын туульсын гайхамшигт бүтээлүүд өнөөдөр мартагдаж эхэлсэн бололтой. Тиймээс ийм үнэт бүтээлүүдийг радио сонсогчдын анхааралд толилуулж байна. “Эдгээр талын нүүдэлчид яруу найрагт дуртай, сэтгэл санаа нь уужим, сэтгэх чадвар сайтай байдаг нь нүүдэлчний санаа зовох юмгүй, амар тайван амьдралтай холбоотой эсвэл мөнхийн цэлмэг хөх

тэнгэрийн дор хязгааргүй тал нутагт амьдралаа өнгөрөөдөг тул байгалийг бурхан мэт шүтэг болсонтой холбоотой байх. Татар нэртэй ард түмний дунд казахууд яруу найргийн авьяас чадвараараа эхний байранд ордог байх” гэсэн Шоканы санал бодол одоо ч хуучраагүй хэвээрээ байна.

Сэтгүүлчид бусдын яриаг өөрсдийн бодлоор шүүж, хэлний соёлыг сайжруулах арга замыг байнга эрэлхийлж байдаг хүмүүс. Эцсийн эцэст бичих урлагийн гол бүрэлдэхүүн хэсэг нь хэл, гоо сайхан нь ч хэл юм. Нэвтрүүлгийн хэл нь хэмжээнээс үл хамааран цэвэр, үнэн зөв, хурц байх ёстой. Баян-Өлгийн радиогийн нэвтрүүлгүүдийг шинжлэхдээ тэдгээрийн хэлний цэвэр, бодлын үнэн зөв байдал, үгсийн илэрхийлэл зэргийг анзаарсан. Сонсогч нь эдгээр гурван нөхцөлийг биелүүлэхэд үргэлж нөлөөлөгч нь, санаачлагч нь байдаг бөгөөд тэд хэлний соёлыг эзэмшихэд идэвхтэй оролцдог. Сүүлийн үед радио нэвтрүүлэгт эрс өөрчлөлтүүд гарч, илүү чанартай, утга учиртай болсон. Ийм шинэчлэлийн нэг бол “Акшам” нэвтрүүлэг юм. Сонсогчдыг содон сонирхолтой шинэ мэдээ, оновчтой хошин шогоор өөртөө татаж чаддаг. Хамгийн олзуурхууштай зүйл бол хөтлөгчдийн ярианы соёлын өсөлт юм. Эфирт хиймэл байдал ч, хэт их өнгө будаг ч тохирохгүй. Түүнчлэн жүжигчний зохиомол дүр, хэмжээнээс хэтэрсэн уран сайхны мэдрэмж ч илүүц байдаг. Уламжлалт чанараа хадагласан казах хэлний өнгө аяс, энгийн харилцан ярианы урлагийг эзэмшихийг уриалсан сонсогчдын захидлууд редакцын ажилд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

Казахстаны хэвлэлүүдийг уншихад “ойлгомжгүй” үг хэллэг маш их тааралддаг. Бид өдөр тутмын амьдралд утга төгөлдөр, чамин гоё үг, өгүүлбэрийг ховор хэрэглэдэг. Тиймээс сонсогч сонин, радиогоос ярианы урлаг, хэлний ид шидийг сурахыг хичээж, санал бодлоо редакцияд илгээдэг. Аймгийн радио сувгаар илэрхийлэгдэж буй хэлний талаарх санал, хүсэл, үзэл бодлын нэг хэсэг нь чухам үүнтэй холбоотой юм.

Монголын казахууд хошин шог, цэцэн мэргэн үг, уран илтгэх чадварт дуртай. Радио ням гарагийн утга зохиолын үдшийг хошин шогчид болон тэдний бүтээлд зориулдаг нь үүнтэй холбоотой байж болох юм. Монголын нэрт шог зохиолчид М.Гүрсэд, Ц.Доржготов, Ш.Цэнд-аюуш, Ж.Барамсай нарын бүтээлийг орчуулж радио долгионоор олны хүртээл болгодог. Казахстаны зохиолчдын бүтээлүүд ч мөн анхаарлын төвд байдаг. Сонсогчдод казах зохиолчдын хошин шогийн богино хэмжээний бүтээлүүдийг, мөн сэтгүүлчдийн шог яриаг ч тогтмол өгдөг. Тэдний ихэнх нь өдөр тутмын амьдралаас эхтэй компани нээх, бизнес эрхлэх, хурдан баяжихыг мөрөөдөх зэрэг хөгжилтэй үзэгдлүүд байдаг.

Ерөнхийдөө аймгийн радио нэвтрүүлэг нь үгийн эрх чөлөө, энгийн чөлөөт ярианд суурилдаг. Заримдаа радио эссе, радиогийн зохиомж, сурвалжилга нэвтрүүлдэг бөгөөд тэдний ихэнх нь олны анхаарлыг татах томоохон үйл явдалд, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зориулагдсан байдаг. Эрдэмтэд, зохиолчид, ахмад настан, сурагчид байнга захидлаар харилцдаг. Зарим материалыг тусгай захиалгаар ч бэлтгэдэг бөгөөд тэдгээрийг гол төлөв хөтлөгчийн уншсан яриагаар нэвтрүүлдэг.

Аймгийн радио нэвтрүүлгийг олон нийтэд хүргэдэг гол хүний нэг бол хөтлөгч. Тиймээс Камар, Жанузак нарыг аймгийн ард түмэн маш сайн мэддэг. Тэд нэг цагийн нэвтрүүлгийг илүү сонирхолтой болгохын тулд жижиг хэсэг болгон задлахгүйгээр утга зохиол, урлагийн бүхэл бүтэн цогц бүтээл болгон олон нийтэд хүргэдэг.

Баян-Өлгий аймгийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бол үндэсний сэтгүүл

зүйн салшгүй хэсэг юм. Аймгийн радио нь үүнийг бий болгосон Монголын сэтгүүл зүйг үлгэр дуурайл болгон хөгжиж байна. Тиймээс монгол хэлээр чөлөөтэй ярьдаг казах сэтгүүлчид хоёр хэлээр бичиж чаддаг. Онцлон хэлэх өөр нэг зүйл бол тус аймагт амьдардаг монгол, урианхай, тува зэрэг нутгийн ард түмэн казах хэлээр сайн ярьдаг бөгөөд бие биенээ хүндэлдэг.

Хоёр хэлийг төгс эзэмшсэн Монголын казах сэтгүүлчид тус улсын хүндэтгэлийг хүлээдэг. Ахмад сэтгүүлч Р.Шынай МУСГЗ, Ардын зохиолч цолоор, олон жил тус радиог тэргүүлж байсан сэтгүүлч Р.Сураган МУСГЗ цолоор шагнагдсан бол А. Хаблахат, Н. Сейилхан, М. Хизат, Ш. Жанузах, Т. Бодаухан, Б. Шамей, А. Белей зэрэг олон сэтгүүлч “Монголын радио, телевизийн тэргүүний ажилтан”, “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагджээ. Ибрайн Хутай дайнд амь үрэгдсэн офицер Ж.Жанабилханы баатарлаг гавьяаг дүрслэн харуулсан бүтээл туурвиж, 48 жилийн дараа мартагдах шахсан залуу эрийг “Улаан туг”-ийн одонгоор нэхэн шагнасан бөгөөд түүний баатарлаг үйлсийг олон түмэнд хүтээл болгосон сэтгүүлчийг “Цэргийн алдар” медалиар шагнасан байдаг.

Өнөөдөр Баян-Өлгийд аймгийн олон нийтийн радио, сонин, сэтгүүл, телевиз, богино долгионы радио зэрэг арав гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор 60 жилийн түүхтэй аймгийн радио бол өдөр бүр тогтмол нэвтрүүлэг явуулдаг, орон нутгийн иргэдийн үзэл бодлын индэр болж тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цорын ганц мэдээллийн хэрэгсэл бөгөөд “Монголын төр засгийн бодлого, шийдвэрийг казахын ард түмэнд хүргэх, сурталчлах, ард иргэдийг соён гэрээрүүлэх, эх хэлээрээ төрөл бүрийн мэдээлэл хүлээж авах, Монголын казахуудын үндэсний урлаг, утга зохиолыг хөгжүүлэх үйлст үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэж ирсэн” (Зулькафиль, 2024), цашид ч гүйцэтгэх болно.

Дүгнэлт: Бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нэгэн адил ардчилсан өөрчлөлтүүд радио нэвтрүүлгийг сайжруулж, үндэсний оюун санаанд чухал нөлөө үзүүлсэн. Ардчилсан нийгмийн эдийн засгийн зах зээлд шилжсэн бусад орнуудын ОНМХ-ийн ажилтнуудын нэгэн адил Монголын сэтгүүлчид ч зах зээлийн дарамтыг туулж өнгөрүүлсэн. Гэсэн хэдий ч энэхүү бэрхшээлийг тэвчээртэйгээр даван туулсан сэтгүүлчид цаг үеийн шаардлагаас хоцрохгүй урагшилж, сонсогчдын оюун санаа, мэдлэгийн санг баяжуулж, үндэсний ОНМХ-ийн системийн салшгүй нэг хэсэг болон хөгжиж байна.

Өнөөдөр Баян-Өлгийн радио нь дэлхийн болон үнэсний сэтгүүл зүйн хөгжлтэй хөл нийлүүлэн алхаж, өөрийн гэсэн вэбсайттай болсон. Олон хүн радиогийн нэвтрүүлгүүдтэй интернэтээр танилцаж, санал бодлоо тогтмол илэрхийлдэг. Баян-Өлгийн казах радиогийн албан ёсны вэбсайт нь www.baiolke.com бөгөөд портал нь “Нүүр хуудас”, “Залуус”, “Хууль эрх зүй”, “Тулгамдсан асуудал”, “Ярилцлага”, “Түүх”, “Шилдэг өгүүлүүд”, “Уран зохиол”, “Нийгэм”, “Казах радио”, “Дүү минь, чи хаана явна?” зэрэг булантай. “Дүү минь, чи хаана явна?” булангаар уулзаж чадаагүй олон жил болсон хамаатан садан, найз нөхдийг эрж хайдаг онцлогтой. Энэ сайт нь цаг үеийн чухал үйл явдал, танин мэдэхүйн ач холбогдолтой янз бүрийн мэдээллийг нийтэлдэг. Үүнээс гадна “Алтан сан” буланд БНМАУ-ын Ардын жүжигчин Ж.Хибатдолдагийн болон яруу найрагч П.Муратын үгэнд бичигдсэн эх орон, эцэг эх, төрсөн нутгийн тухай дууны цомирлогийг сонсох боломжтой. Дүгнэж хэлэхэд, Баян-Өлгий аймгийн казах радио нь жаран жилийн турш аймгийн ард түмний оюун санааны найдвартай түнш байж, тэднийг казах түмний баялаг өв уламжлал, соёл, дуу хуураар цэнэглэн үндэсний сэтгүүл зүйтэй зэрэгцэн эрчимтэй хөгжиж байна. Баян-Өлгийн казах радиогийн аймгийн сонсогчдын соёл, мэдлэг

боловсролыг дээшлүүлэх, казах түмний өв уламжлал, ёс заншил, үнэт зүйлсийг олон нийтэд сурталчлахад гүйцэтгэсэн үүрэг нь үнэлж баршгүй бөгөөд Монгол Улсын Засгийн газраас санхүүждэг цорын ганц орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Нуриден Р. (2012). *Олон улсын радио сэтгүүл зүй* (казах хэл дээр). Алматы.
 Норовсүрэн Л, Ариунзаяа Н. (2010). *Радио сэтгүүл зүй*. УБ.
 “Современная Монголия”. 1964.№9.
 Дэлэг Г. (2014). *Монголын хэвлэл* (хоёр дахь хэвлэл). Боть III. УБ. .
 “Эфир друзей”. М., 1977.
 Зулькафиль М. (2024). *Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд*. Боть II. УБ.
 Арлыбаева, С. Х. (1994). *Вещание на Азиатском континенте*. Алматы.
 Батжаргал, Д., & Мэндхүү, Г. (2015). *Радиогийн тухай А-Я хүртэл*. Улаанбаатар.
 Дагиймаа, Д. (2009). *Радио сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар.
 Дэлэг, Г. (2014). *Монголын хэвлэл* (2 дахь хэвлэл, Боть III). Улаанбаатар.
 Норовсүрэн, Л., & Ариунзаяа, Н. (2010). *Радио сэтгүүл зүй*. Улаанбаатар.
 Зулькафиль, М., & Чойсамба, Ч. (2015). *Журналистика Монголии: от первой газеты до онлайн прессы*. Иркутск.
 Зулькафиль, М. (2024). *Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд* (Боть II). Улаанбаатар.
 Маукараулы, А. (1992). *Монголын казахууд* (казах хэл дээр). Шалкар, №15.
 Монголын ХМХ-ийн мониторингийн судалгаа. (2015). Улаанбаатар.
 Минис, А., & Сарай, А. (1960). *БНМАУ-ын казахуудын түүхээс* (казах хэл дээр). Баян-Өлгий.

Summary

Kazakhs living in Mongolia have their own press, radio, and television program. Mass media for Kazakhs living outside their national environment serve not only for propaganda, but also to answer questions about how they preserved, changed, and developed their language, religion, history, literature, and culture.

Bayan-Ulgii regional radio occupies a special place among them. This year marks the 60th anniversary of the start of broadcasting of this radio. Studying Mongolian and Kazakh radio journalism, over the years I have developed my own experience, which has become a model of regional autonomous broadcasting.

The purpose of this scientific article is to analyze the history and main stages of the development of Bayan-Ulgii radio, through an overview of the history of Mongolian radio broadcasts that appeared in the second half of the 1930s, as an integral part of it. It is also necessary to prove that radio is one of the key mass media that continues to maintain cultural ties, promoting the Kazakh language and literature, history, the unity of the nation, their indigenous origin, in the state in which they live.

Keywords: Bayan-Ulgii radio, regional radio, mass media, radio broadcasts, mass media, broadcasting, radio journalism.

ШИНЭ МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛД С.ОЮУНЫ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Т.Баасансүрэн*

**МУСГЗ, доктор (Ph.D), профессор*

Түлхүүр үгс: Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, С.Оюуны сэтгүүлчийн үйл ажиллагаа, нийтлэлийн үр нөлөө ба үр ашиг, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, хөрөг найруулал, ярилцлага.

Зохиолч, яруу найрагч Санжаажавын Оюуны эзэмшсэн мэргэжил нь эмч боловч эрхэлж ирсэн ажил алба нь гол төлөв хэвлэл мэдээллийн салбартай холбоотой юм. Тэрбээр “Монгол телевиз”-д болон “Хөдөлмөр”, “Ардын эрх” сонинд сурвалжлагч, “Эрдэнэсийн чуулга” сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга, бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэвлэлийн албаны ажилтнаар ажиллаж байв. “Мөнхийн үсэг” хэвлэлийн компанид “Болор судар” хэвлэлийн газрын эрхлэгчээр ажиллаж, “Эрүүл энхийн төлөө”, “Ардын эрх”, “Энэ долоо хоног” зэрэг хэвлэлийг гаргалцаж явжээ. Сэтгүүл зүйн төрөл, зүйлээр олон арван бүтээл туурвиж, бие даасан хоёр гурван ч ном хэвлүүлж уншигчийн хүртээл болгожээ. Тэгэхлээр түүнийг мэргэжлийн сэтгүүлч гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Үзэг, цаас нийлүүлж Монголын утга зохиол, сэтгүүл зүйд урваж шарвалгүйгээр үнэнчээр зүтгэж эхэлсний 60 жилийнх нь ой энэ 2025 онд тохиож буйг бэлэгшээж өнгөрсөн хугацаанд сэтгүүл зүйн чиглэлээр туурвисан бүтээлүүдэд нь ажиглалт шинжилгээ хийж үзлээ.

“Сонин хэвлэлд бичсэн зүйл зөндөө байх юм. Хорь шахам жилээ сэтгүүл зүйн чиглэлийн ажилд зориулсан хүнд байлгүй яахав. Мэдээ, сурвалжилга, сурвалжилсан тэмдэглэл, хөрөг найруулал, ярилцлага, асуудал дэвшүүлсэн өгүүлэл гээд хэвлэлийн бүх л төрлөөр бичиж байж” гэж тэрбээр “Цаг хугацааны урсгалд” номынхоо оршилд тэмдэглэжээ (Оюун, 2011, х.3). “21 ертөнц, 21 таталбар, 21 эмч” нэртэй, 1999 онд хэвлэгдсэн өөр ч нэг нийтлэлийн ном байна. Хот, хөдөөгийн 21 эмчийн ажил үйлс, дотоод сэтгэлийн ертөнцийг нээн үзүүлэхийг хичээжээ. Өөрөө С.Оюун эмч хүн болохоор хэр баргийн сэтгүүлчийн олж харж чадахгүй нарийн ширийн зүйлийг мэргэжлийн үүднээс гярхайгаар нээж үзүүлсэн нь эрхгүй мэдрэгдэж байлаа. Бас Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбатын бичиж нийтлүүлсэн “Тэнгэрийн цаг” номыг эмхлэн цэгцэлж, ариутган шүүлцэхэд идэвхийлэн оролцжээ.

Монголын сэтгүүл зүйн салбарт амьдралынхаа хориод жилийг зориулсан түүний

нийтлэлүүдийг ерөнхийд нь асуудал дэвшүүлсэн өгүүлүүд, хөрөг найрууллууд, ярилцлагууд гэсэн нийтлэл бичлэгийн үндсэн гурван жанрт хувааж үзэж болохоор санагдлаа.

Сэтгүүл зүйд үр нөлөө, үр ашиг гэсэн үндсэн шалгуур үзүүлэлт байдаг юм. Бичиж хэвлүүлсэн нийтлэл, нэвтрүүлэг нь уншигч, үзэгч, сонсогч олон түмэнд ямар шинэ сэргэг, тэргүүний дэвшилт ашигтай мэдээлэл өгөв, тэр нь улс нийгмийн урагшлах хөгжил дэвшилд яаж нөлөө үзүүлэв, өөрөөр хэлбэл ямар бодит үр дүн авчрав гэдгийг хэмжиж тогтоодог шалгуур үзүүлэлтүүд юм. Утга зохиолд зохиогч ямар дүр бүтээв гэдгийг онцолж голлон авч үздэг бол сэтгүүл зүйд ямар үр өгөөж гаргав гэдгийг гол хэмжүүр болгодог гэсэн үг.

Энэ үүднээс С.Оюуны нийтлэлүүдийг шинжиж үзсэн гэдгээ хэлье. Эхлээд асуудал дэвшүүлсэн өгүүлүүдийнх нь талаар. Тэрбээр “Ямар азаар бид хоцрогдов оо”, “Сүлдэндээ тахисан адуу минь”, “86 насанд нь хар үс ургажээ”, “Мартаж болшгүй ёс заншил” зэрэг цөөнгүй асуудал дэвшүүлсэн нийтлэл бичсэн байна. “Ямар азаар бид хоцрогдов оо” хэмээх өгүүлэлдээ зохиогч Монгол Улс, монголчууд хөгжил дэвшлийн “хоцрогдлынхоо” ачаар онгон зэрлэг, унаган тансаг байгальтайгаа үлдэж чаджээ. Өнөөдөр ийм улс орон тийм ч олон биш байна. Хөгжингүй орнууд өндөр “дэвшлийнхээ” ачаар амьсгалах цэвэр агааргүй, уух цэвэр усгүй, гишгэх онгон газаргүй болжээ. Алт гэж юу юм бэ, идэх үү, уух уу, өмсөх үү? Усгүй, агааргүй, эрүүл газаргүй болсон цагт хичнээн алт байгаад ч яах вэ? Бидэнд онгон зэргэлэг уудам цэлгэр газар нутаг байна. Түүнийгээ яаж зарж үнэд хүргэх вэ гэдгийг л бодё л доо хэмээн “Ардын эрх” сонинд 1992 онд бичиж 25 жилийн хөгжлөөр түрүүлсэн Японыг гүйцэх үү, 2000 жилд ч бүтээхгүй газар нутгаа хайрлах уу гэж уншигчдаас асууж байгаа бол “86 насанд нь хар үс ургажээ” нэртэй өөр нэг нийтлэлдээ Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын харьяат иргэн А.Доржханд 86 насанд нь толгойн цагаан үс нь унаж шинээр хоёр жилийн турш хар үс ургажээ. Нүд нь хараа орж, шинээр араа шүд ургажээ. Ийм тохиолдол Монголд анх удаа боллоо. Эмийн ургамлыг нутгийнхаа оточ маарамбаар заалгасан тэр хүн Хөвсгөлийн уулсын их ой тайгад эмийн ургамал түүхээр гарахдаа баруун солгойгүй ургамал түүж идээд, дуу аялаад явдаг нэгэн байж. Чухам аль ургамал нь түүний үсийг хар болгож, хараа оруулж, араа шүд ургажээ. Ийм тохиолдол Монголд анх удаа боллоо. Харин ганцхан зүйл ил тодорхой байна. Тэр нь Хөвсгөлийн ой тайгад хүний насжилтын генид үйлчилдэг, бас организмыг залуужуулдаг ид шидтэй өвс ургамал байна. Анагаах ухаан үүнийг анхааралдаа аваачээ. Их тайгын өвс ургамлаар өөрөө өөр дээрээ туршилт хийсэн энэ хүнд тохиолдсон илбэ жилбэ, ид шидийн гэлтэй оньсгын учир начрыг олж тайлаачээ гэж асуудал дэвшүүлж уриалсан байх жишээтэй ажээ.

Нам, төрийн төв хэвлэлээс эрхлэн гаргаж байсан “Шинэ хөдөө” сонины 1988 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн дугаарт С.Оюуны “Мартаж болшгүй ёс заншил” /Нууцхан тэмдэглэдэг баяраа ил болговол ямар вэ/ хурцхан шүүмжлэлт өгүүлэл нийтлэгдсэн нь тухайн цаг үед санаанд оромгүй явдал болж нийгмийг тэр чигээр нь хуйлруулан шуугиулсан байна. Зохиолч, сэтгүүлч С.Оюун “Эцэг өвгөд минь бидэнд олон сайхан ёс заншил өвлүүлжээ. Түүний нэг нь хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдөр ахмад настантайгаа ёс төртэй золгодог явдал юм. Төрөл төрөгсөдтэйгөө ингэж золгон мэндчилдэг байсны ачаар монгол хүн сөөн үеэ мэддэг байсан гэлцдэг.

Монголчуудын олон зуун жил тэмдэглэж ирсэн уламжлалт баяр-Цагаан сарын шинийн нэгний ёслолыг эдүгээ “цээрлэж” нэгдэлчдийн баяр гэдэг орчин цагийн нэр зүүлгэжээ. Цагаан сараар шинэлэх гэдэг бол зөвхөн малтай хүний баяр биш, бүх ард түмний хүндэтгэлт баяр” гэж бичээд “дорно дахины төлөөлөл өнөөдөр дэлхий дахинд их сонирхогдож байна. Гэтэл бид он тооллын баяраа “цээрлэж”

байгаа нь хачирхалтай бишүү? Аливаа үндэстэнд бахархах, ялгарах онцлог ёс, зан заншил уламжлагдан үлддэг, түүнийг эрхэмлэн хайрладаг байх учиртай... хоёр хоногийн амралттай баяруудаас нэг өдрийг нь сар шинийн баярт шилжүүлж, ардын уламжлалт баяраа “нууц байдалд” тэмдэглэхээ боливол яасан юм бэ гэж бодогдох юм” хэмээн асуудал дэвшүүлэн хөндөж тавьсан аж.

Эл өгүүлэл уншигчдад таашаагдаж “Шинэ хөдөө” сонины редакци хэдхэн хоногийн дотор тэдний захидалд дарагдсан байна. МУИС-ийн эрдэмтэн багш Ш.Чоймаа “Цагаан сар нэгдүгээрт монгол хүн бүрийн нэг нас нэмсний баяр, хоёрдугаарт өвлийг өнтэй давж хавартай золгосны баяр, гуравдугаарт билгийн тооллын шинэ жилийн баяр юм” гэдгийг онцлоод манай эриний өмнөх гуравдугаар зууны сүүлчээр монгол нутагт хүчирхэгжин мандсан Хүннү улсын үеэс цагаан сарыг ёслон тэмдэглэдэг болжээ. XIII-XIV зууны үед монголчуудын нийгмийн хэв заншил болж тогтсон ажээ. Энэ тухайг Италийн жуулчин Марко Поло /1254-1324/, Францын ван IV Людвикийн элчээр Монголд ирж байсан Г.Рубрик зэрэг хүмүүс ном тэмдэглэлдээ тодорхой бичжээ... Өвөг дээдсээс уламжилж ирсэн энэ сайхан хэв заншлаа малчин ардын үр сад бид нийтээрээ тэмдэглэдэг болбол зүйтэй гэж бодох юм” хэмээн С.Оюуны санаачилгыг талархан дэмжсэн бол эрдэм шинжилгээний ажилтан Г.Гэндэнсүрэн шинийн нэгний баярын уламжилж ирсэн дэг журам, зан үйл, тоглоом наадмын өвөрмөц өв соёлын тухай тодотгон өгүүлж, ард түмнийхээ ийм сайхан зан үйлийг үргэлжлүүлж сахин хамгаалах шаардлагатай гэж саналаа бичжээ. Сүхбаатар аймгаас Ч.Содномцэрэн, Н.Энх-Амгалан, Ж.Дорж нар уг баярыг “ил гаргаж” бүх нийтийн баяр болгож тэмдэглэх нь зүйтэй гэж дэмжсэн бол Дорноговь аймгийн Хажуу-Улааны АДХ-ын Гүйцэтгэх захиргааны нарийн бичгийн дарга Ж.Лхагважав “Сумын төв, суурин газрын нилээд хүн цагаан сараар аав ээждээ очиж золгоод ирье гэж чөлөө гуйх юм. Өвгөд хөгшид нь үр хүүхдээ хүлээж суугаа болохоор “чөлөө өгөхгүй” гэх аргагүй” гэж зовлонгоо тоочоод цагаан сарыг уламжлал ёсоор нь хадгалахыг хүсэлт болгосон байна.

Төв аймгийн Угтаалын сангийн аж ахуйн уншигч Б.Төмөрцоож “Монголчуудын цагаан сар” гэж том баяр байдгийг гадаадынхан сайн мэддэг гэнэ лээ. Гэтэл түүх шаштирт орсон тэр баяр маань яваандаа алга болох юм биш биз гэж асуусан бол Булган аймгаас малын их эмч Л.Дашням “Мартаж болшгүй ёс заншил”-ыг ная гарсан настай аав ээждээ уншиж өгсөн чинь “их чухал санал байна. Хүү минь чи дэмжиж юм бич” гэхээр үүнийг бичлээ. Цагаан сараа үндэсний сайхан баяр хэвээр нь байлгай” гэж “Шинэ хөдөө” сонины редакцад ханджээ. “Оюутан нөхөд маань С.Оюуны өгүүлийг уншаад “Цагаан сарын шинийн нэгнийг улс даяар нууж хаах зүйлгүй, хот хөдөө хаа ч эрх тэгш тэмдэглэдэг баяр болгоё гэсэн санал гаргасныг анхааралдаа авна уу” гэж ЗХУ-ын Эрхүү хотод сурдаг оюутан Ш.Төмөрбаатар бас бичсэн байна. Иргэдээс ирүүлсэн эдгээр санал бодол, захидлыг “Шинэ хөдөө” сонин үргэлжлүүлэн нийтэлж, улмаар МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд тэдний захидлуудыг С.Оюуны асуудал дэвшүүлсэн нийтлэлийн хамт хавсарган илгээжээ. Удалгүй Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч Монгол Улс, монголчууд бүх нийтээрээ уламжлалт Цагаан сар-шинийн нэгний шинэ жилээ ёслол төгөлдөр тэмдэглэдэг болсон байна.

Зохиолч, сэтгүүлч С.Оюуны асуудал дэвшүүлсэн энэ нийтлэл нь ард түмний анхааралд хүрч, тэдний талархлыг хүлээж, улмаар Засгийн эрх баригч МАХН, БНМАУ-ын Засгийн газрын тогтоол шийдвэр гарах үндэслэл болж өгчээ. Өөрөөр хэлбэл С.Оюуны “Мартаж болшгүй ёс заншил” асуудал дэвшүүлсэн өгүүлэл өмнөө тавьсан зорилгодоо хүрсэн байна. “Үнэн” сонины оны шагнал, МСХ-ны “Ган үзэгтэн” шагнал хүртсэн байна. Үр нөлөө, үр өгөөж нь гарчээ гэж хэлж болно. Сэтгүүлч С.Оюун ч өөрийн намтар түүхэнд “Би Монгол Улсад нууцан тэмдэглэдэг байсан нэгдэлчдийн баярыг ил тод нийтээр тэмдэглэдэг Цагаан сар шинийн нэгэн”

болгож хувиргахад үг хэл, үзгийн хурцаараа өөрийн хувь нэмрээ оруулсан хүн шүү гэж хэлж бичих бүрэн эрхтэй болж байгаа юм.

Нэр бүхий тодорхой нийтлэл нь өргөн олон түмний анхаарал татаж, улмаар төр засгийн тогтоол шийдвэр болж гаран улс, нийгмийн цаашдын хөгжил дэвшил, ахуй заншилд нөлөөлөхүйц хэмжээнд хүрч хэвшиж тогтоно гэдэг бол маш том үзүүлэлт. Ийм тохиолдол шинэ Монгол Улсын өнгөрсөн зуу гаруй жилийн түүхэнд тийм ч олон биш. Цэрэндоржийн Балдоржийн “Далай ээж маань цаазын тавцанд”, Ширнэнгийн Цэен-Ойдовын “Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ” гэх зэрэг цөөн нийтлэлийг л нэрлэн дурьдаж болох юм.

Зохиомж хийгээд дүр дүрслэл, үг хэллэг, найруулга зүй зэрэг утга зохиол, сэтгүүл зүйн мэргэжлийн шалгуур тавьж ур хийц талаас нь авч үзэх юм бол С.Оюуны бүтээсэн хөрөг найрууллууд онцгойрон ялгарч “зохиогч нь аргагүй л зохиолч, яруу найрагч С.Оюун мөн байна” гэж хэлж байх шиг санагдсаныг онцлон тэмдэглэе. Тэр “С.Удвал нэгэн хувь заяа”, “Домог болсон генерал”, “Пагважавын Нямдаваа”, “Гэрэлт од буюу түүхээ тогоруу”, “Гал сортой хоньд”, “Далд фронтод 23 жил”, “Захирал Нарантуяа”, “Цэнхэрийн цэнхэр сарлаг”, “Бүргэд”, “Могодын бурхан эмч” “Цахилдагны толгой шарласан намар”, “Жирийн боловч жирийн биш хүн” зэрэг олон хөрөг найруулал бүтээжээ.

Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлүүд дотор дүр бүтээж болдог ганцхан жанр байдаг юм, тэр нь найруулал. Бусад нь бол үгүй, бодит үнэнийг л хүүрнэн өгүүлнэ, баримтыг голлоно. Харин хөрөг найруулалд нүдэнд үзэгдэж, сэтгэлд хоногшсон содон сонирхолтой дүр бүтээх боломжтой. Үүний гайхамшигтай тод жишээ нь Бямбын Ренчиний “Их говийн зоригтон хүмүүс”, Мөнгөний Бизьяагийн “Өвлийн нүүдэл” зэрэг алдарт нийтлэлүүд юм. С.Оюуны “Цаг хугацааны урсгалд” түүврийн “Хөрөг, найруулал” хэмээх бүлэг болон “21 ертөнц, 21 таталбар, 21 эмч” номын агуулгыг үүнд хамааруулж болохоор байна. “Цаг хугацааны урсгалд” номонд нь 19 хөрөг найруулал багтжээ. Ер нь Санжаажавын Оюуны сэтгүүл зүйн бүтээлд найруулал, хөрөг, таталбар зэрэг уран нийтлэл зонхилох байр суурийг эзэлж байна. Хэмжээ нь урт нуруу биш товч тодорхой, ойролцоогоор 3-9 хуудсанд багтааж зохиомжлон хайрцаглахыг эрмэлздэг ажээ. Өгүүлэн хүүрнэж, дүрслэн зураглах аргаар гол төлөв хөрөг найрууллаа бүтээдэг нь ажиглагдлаа. Үе үехэн од мичид адил онцгой содноор гэрэлтсэн ончтой бөгөөд донжтой тодотголыг шигтгэж өгдөг нь уншигчдын сонирхлыг татаж байна.

Баримт түшиж ярья. “С.Удвал нэгэн хувь заяа” хөрөг найруулалд “Удвал гэж хэн бэ? Зүрхнээсээ би асуулаа. Нарны туяа, сарны гуниг, хонгорзулын хувь заяа санаанд буув” гэсэн өгүүлбэрээр эхлээд “Түүнийг би гэрэл гэгээтэй, утгатай уянгатай, ухаан авьяас тэгш нэгэн ертөнц гэж ойлгодог.. Утга зохиолын хувь тавилантай тохиолдсон бүсгүй заяа бол харанхуй шөнө нарыг тэмцэж төрсөн цэцгийн нас юм. ...Удвал гуайн тухай бичнэ гэдэг бол их далайн эрэгт очоод гайхан дуу алдахтай адил байлаа. Гэвч тэр далай миний сэтгэлд цалгиан давалгаалж байна. Хүчирхэг их далай. Их хүн” гэх зэрэг үг, өгүүлбэрээр цааш үргэлжилж байна. Ийм эхлэл уншигчдын сонирхлыг татна. Хөтөлнө гэсэн үг.

Хэсэгхэн хүүрнэлийн дараагаар зохиогч хөргийн баатраа улам тодотгож МЗЭ “Түүнийг дарга байхад зохиолчдыг хамгаалдаг ганц газар нь байлаа... Сархдад дийлдсэн онгодын “бурхад” түүний өмнө “чичирч” байх нь үнэн гэдэг өрөвдөлтэй, хүндэтгэл гэдэг яруу харагдсан. Зохиолчид түүнд хайртай байсан, бас түүнээс аядаг, хүндэлдэг байсан” хэмээжээ.

“Удвал гуайг би гүнээ хүндэтгэн хайрладаг. Миний хайр аглаг хөвчийн горхи хоёр адилхан ариун цэнгэг бизээ. Хэзээ ч би тэр хүн рүү “урсаж” байсангүй. Бас хэзээ

ч тэр хүнээс “урваж” байсангүй” гэж түүнд хандах өөрийн хүндлэлийг илэрхийлээд “Номундарь” өгүүллэг, “Ховор хүн” тууж, “Хүргэн хүү” киноноос ишлэж Сономын Удвал гэдэг энэ хүчирхэг эмэгтэй монголын үргэлжилсэн үгийн уран зохиолын төрөлд өөрийн оргилыг нэгэнт бүтээжээ гэсэн байна. /Санжаажавын Оюун. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн. Цаг хугацааны урсгалд. УБ.2011 он, 36-39 дэх тал/.

“С.Удвал нэгэн хувь заяа” хөрөг найрууллаас Монгол Улсын нийгэм, улс төрийн нэрт зүтгэлтэн, манай утга зохиолын нэгэн сүмбэр оргил болсон зохиолч Сономын Удвалын дүр төрх алтан наран адил хэт их тод биш юмаа гэхэд арван тавны саран авхайгаас ер дутах юмгүй, тод томруун хэн хүнд мэдрэгдэж танигдаж, харагдаж чадаж байгаа юм. С.Оюун сэтгүүлч гэхээсээ илүүтэйгээр зохиолч, яруу найрагчийн нүдээр түүнийг харж Зохиолчдын байгууллагын дахин давтагдашгүй нэгэн том удирдагч, монголын утга зохиол дахь үргэлжилсэн үгийн зохиолын өөрийн оргилыг бүтээж чадсан хүчирхэг эмэгтэй хэмээх санааг хөрөг найруулалдаа илэрхийлэн гаргаснаараа өөрийн гэсэн өвөрмөц содон дүр болсон байна. Гурав дөрөвхөн хуудас хөрөгт С.Удвал гэдэг их далай, их хүний дүрийг бүх талаас нь нэгэн зэргээр нээж дэлгэн үзүүлнэ гэдэг боломжгүй зүйл, тийм учраас тухайн баатрынхаа зөвхөн нэг талыг, нэг чанарыг илүү тодотгож цохон тэмдэглэсэн нь зохиомжийн зөв шийдэл болсон санагдлаа.

Зохиогч “Домог болсон генерал” хөргөө ч мөн ийм зарчмаар урлаж Монгол улсын хилийн цэрэгт насаа барсан Ш.Арвай генералийн дүрийг цэргийн жанжин гэх үүднээс нь голлож бус харин бүр хэн ч санаж бодоогүй өөр өнцгөөс буюу Шинжлэх ухааны гавьяат ажилтан яагаад болов гэдгээс нь онцгойлон дурьдаж, тэгэхдээ сонсогчоос доктор болсон түүхийг нь, жирийн хилчнээс домогт генерал болох хүртэлх туулж өнгөрүүлсэн амьдралын замналтай нь холбож сүлжилдүүлэн зохиомжилжээ.

“Сая генерал Шинжлэх ухааны гавьяат ажилтан болж найраа хийхдээ намайг урьсан юм. Найрын эхэнд генерал “Мартаж болохгүй маргад эрдэнийн эх орон” гэсэн шүлэг уншиж, миний хувьд тэр нь ёстой сюрприз байлаа. Яасан ч сайхан уншдаг юм, яаж ч тийм урт шүлгийг эрдмийн тэр их ажлын хажуугаар цээжлээд байж бадаг юм. Хилийн генерал хүн хилийнхээ тухай шүлэг уншихад шал өөр юм” гэж С.Оюун өгүүллээд “Хилийн цэргийнхнийг би эх орноо гэсэн сэтгэлтэй хүмүүсийн тунгаамал нь гэж боддог. Дэслэгч генерал Шавийн Арвай тэдний дунд гялалзаж байгаа шижи нь” гэсэн үг өгүүлбэрээр шигтгэж өөрийн үнэлэлт дүгнэлтийг өгчээ. /мөн номын 46 дахь тал/.

Тунгаамал нь, шижи нь гэж шүр сувд адил нүдэнд тодхон тусах эл тодотгол нь “Домог болсон генерал” хөрөг найрууллын үндсэн гол санаа, агуулгыг илэрхийлсэн амин сүнс нь мөн гэдэг нь уншигчдад хялбархан ойлгогдож байгаа юм. Хилийн цэргийн түүхэнд томоохон байр суурь эзэлдэг домогт генерал Шавийн Арвайн хөргийг бүтээхдээ зохиогч бусдын тэр бүр үл мэдэх өнцгөөс харж, түүнийг шүлэг, дууны үг бичдэг, ая зохиож, баян хуур хөгжим янзтай дарна. Бас морин хуур хачин гоё тоглоно. Үнэхээр билэг танхай генерал даа гэж хамт ажиллагч генералаар нь хэлүүлж буй нь утга санааг улам гүнзгийрүүлжээ.

С.Оюун нэг биш маш олон эмч нарын тухай, олны танил академич П.Нямдаваа, сэтгүүлч С.Жамбалдорж нарын зэрэг эрхмүүдийн хөргийг бүтээсэн байна. “Захирал Л.Нарантуяа” хөрөгтөө Цэргийн эмч, анагаахын шинжлэх ухааны доктор Л.Нарантуяагийн тухай зураглан өгүүлжээ. Хөргийнхөө эхэнд өнгөрсөн зууны ерээд онд Монголд захирал гэдэг нэршил моод болж дэлгэрснийг дурдаад харин Нарантуяа бол жинхэнэ захирал, энэ нэрэндээ тохирох бүсгүй гэж уншигчдын анхаарлыг найрууллын гол баатартаа хандуулан “Нарантуяагийн тас тас инээх сайхан. Инээхэд нь олон жижиг эрвээхэй цагарч тасалгаа мянга мянган эрвээхэйн

далавчинд долгиолж түүний яриаг огт сонсоогүй хүний хүртэл царайд инээмсэглэл тодордог юм. Ажилдаа жаргалтай хүн тэгж инээж чаддаг. Амьдралдаа жаргалтай хүн бас тэгж инээж чаддаг” /мөн номын 67-69 дэх тал/ гэх зэргээр дүрээ тодотгон дүрсэлжээ. Энэ бол хөрөг найруулал бүтээх С.Оюуны өвөрмөц арга аж.

“Уламжлалт анагаахын эмч” найруулалдаа оточ Баатарын дүрийг товойлгон гаргаж уншигчдын анхаарлыг ардын эмнэлгийн арга ухаанд чиглүүлж цөөнгүй сонирхолтой мэдээлэл өгсөн бол “Галын тэргүүн шугаманд” 22 жил” хэмээх хөрөгтөө эхлээд асрагч, улмаар сувилагч болж, эцэст нь өөрийн дурласан анестезиологч сувилагчийн мэргэжлийг эзэмшсэн Өөдөс гэдэг эмчлүүлэгчдээс ер нь хэн ч мэддэггүй, далд ажиллаж арын албыг, тэгэхдээ хамгийн амин чухал үйлийг бүтээдэг эгэл жирийн атлаа эгэлгүй баатарлаг эмэгтэйн тухай өгүүлжээ. Анестезиолог гэдэг нь мэдээ алдуулагч, өвчингүй болгож унтуулагч гэсэн утгатай үг агаад аливаа мэс заслын үйл ажиллагааны үндсэн гол хэсэг нь юм байна.

С.Оюун найрагч мэргэжлийн эмчийн хувьд мэс засал хийлгэж аюулт өвчнөөсөө ангижирч салсан эмчлүүлэгчид “Мэс засалчийнхаа нэрийг тогтоохоос биш хэн гэдэг сувилагч унтуулж мэдээ алдуулсныг асуудаг ч үгүй. Үнэндээ анестезиологчид үгүй бол мэс засал үгүй. Дууцныг алдаршуулсан хөгжимчид, онгоцыг бэлтгэсэн техникчид шиг юм бүхний ард даруухан үлддэг, хамгийн хэрэгтэй, хамгийн үнэтэй улс гэдгийг эмнэлгийнхэн л мэднэ” хэмээн “Галын тэргүүн шугаманд” 22 жил” хөрөг найрууллаараа чанга дуугаар тодотгон хэлж байна, сэдвийн онцгой чухал ач холбогдол чухам үүнд оршино.

Дээр дурьдсан баримтуудаас харахад зохиолч, сэтгүүлч С.Оюун нь хөрөг найрууллаа бүтээхийн тулд уйгагүй эрэл хайгуул хийж, бусдын олж хараагүй өнцгөөс найрууллын баатраа олж харж, дүрээ тодотгон зохиомжлохыг хичээнгүйлэн эрмэлздэг нь мэдрэгдэж байна. Энэ бол мэргэжлийн сэтгүүлчийн бүтээлч илэрхийлэл, уран бүтээлийнх нь чанарыг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм.

“Цэгмид: Норолхоо эгч тэнгэрийн орноос хий гэж хэлсэн байх”, “М.Амбага: Шинээр кодлогдсон анагаах ухаан гэж нэрлээд байна”, “Чингис хааны нутгаар”, “Ц.Одсүрэн: Сая төрсөн хүүхэд уйлахад...”, “Ж.Оюун: Чулуу эмэнд ордог эрдэнэ” гэх зэрэг гарчигтай олон ярилцлагын зохиогч эзэн нь Санжаажавын Оюун юм. Асуудал дэвшигчлэсэн өгүүллүүдийнх нь агуулга санаа түүний ярилцлагуудаас ч мөн мэдрэгдэж үнэртэх агаад хөрөг найрууллуудад нь үе үе очис үсрэх шиг, одод гялбалзах шиг таашаал мэдрүүлдэг ончтой чамин зураглал, “олз энэ мөн шүү дээ” гэж дуу алдмаар онцын тансаг тодотгол нь ч бас тааралдах ажгуу. Өөрөөр хэлбэл ярилцлагууддаа сэтгүүл зүйн бусад төрөл, зүйлийн элементүүдийг чадмаг ашиглаж сурсан нь анхаарал татаж байгаа юм.

Жишээ нь “Шинээр кодлогдсон анагаах ухаан гэж нэрлээд байна” ярилцлагын эзэн, Монгол Улсын Төрийн шагналт доктор, профессор М.Амбага түүнд дорнын анагаах ухааны нарийн ширийнийг эсийн түвшинд тайлбарлаад орчин үеийн эмнэлэг, эмийн сангууд бизнес хөөн шуурч буйг шүүмжилж “Эмч эмнэлгийнхний ёс зүй алга болоод байна. Оточ нарт тийм юм байгаагүй, тэд чинь бурханы өмнө тангараг өргөсөн улс... Бидэнд философи алга болчихлоо шүү дээ. Бидэнд айх зовох юм алга, намаас айхаа больсон, төрөөс айхаа больсон, бурханаас айхаа больсон” /мөн номын 162 дахь тал/ гэж хэлж байхад “Чулуу эмэнд ордог эрдэнэ” ярилцлагын эзэн доктор Ж.Оюун өөрийнх нь төрж өссөн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын ой болж олон хүнийг хотоос урьж аваачжээ. Тэгсэн атлаа нутаг уснаасаа төрж гарсан цорын ганц эмэгтэй доктороо урьсангүй гэнэ. Ж.Оюун доктор сумандаа зориулж дуу бичиж ая зохиолгоод хүрч очиход сумын удирдлагууд нь тэр ч компанийн захирал, энэ ч компанийн эзэн гэж дагаж гүйлдээд өөрийг нь олж ч харахгүй байж. “Би сургуульдаа ном бэлэглэх гэсэн юм. Үг хэлүүлнэ үү” гэсэн зурвасыг хурлын

тэргүүлэгчдэд илгээж зөвшөөрөл аван индэрт гараад “Энэ удаагийн ой мөнгөтэй хүнийх болж байгаа юм байна. Ирэх ой нь эрдэмтэй хүнийх болох болтугай” / номын 184 дэх тал/ гэж хэлээд номоо өргөн барьжээ. Тэгж хэлэхэд нь л дөнгөж сая нутгийн удирдлагууд түүнийг олж харцгаажээ гэж С.Оюун сэтгүүлч бичсэн байна.

Нийгмийн шилжилт, өөрчлөлт шинэчлэлтийг дагаад гарч ирж буй сөрөг үзэгдэл, хүний нийгмийн ёс суртахууны тулгамдсан хурц асуудлуудыг хөндөж тавьжээ. Энэ бол ёс зүйтэй сэтгүүл зүйн дэвшүүлэн тавибал зохилтой асуудлын нэг яах аргагүй мөн.

Эх барих эмэгтэйчүүдийн эмчтэй хийсэн өөрийн ярилцлагынхаа эхэнд уншигчдын сонирхлыг татахуйц оршил өгүүлэмж хийсэн нь анхаарал татав. “Эмч хүн мэргэжлээсээ болоод баярлах, түгших нь өөр өөр байдаг. Тухайлбал эх барихын эмч сая төрсөн хүүхэд уу аа, уу аа гэж ертөнцөд дуугаа сонсгон, ирснээ зарлахад баярладаг. Монгол Улсын нэг иргэнийг хүлээж авч байгаа нь тэр. Харин төрсөн эх цус алдахад түгшиж эхэлдэг. Цус алдалт бол чимээгүй дуу алдалт. Эмч гар угаахын хооронд л литр цус гуначихна. Ердөө л 1-2 минут гэсэн үг. Эхэсийг тэжээж байсан бүдүүн бүдүүн судаснаас хоромхон зуур их цус алдахад эхийн амь нас үхлийн ирмэгт хүрдэг болохоор тэд цуснаас айдаг...”

Эх барих эмэгтэйчүүдийн эмч Цогзолын Одсүрэн 5000 шахам эхийг төрүүлжээ. 2 сая гаруй иргэний 5000-ыг нь Одсүрэн эмч хүлээж авсан гэсэн үг. 5000 гэдэг нь нэг сумын хүн амтай тэнцэх тоо юм” гэсэн байна /номын 172 дахь тал. Ц.Одсүрэн. Сая төрсөн хүүхэд уйлахад.../. Ийм эхлэлийг уншсан хүн заавал цааш нь ахиулж уншина, улмаар дуусгана. Эндээс С.Оюун эмчийн өндөр мэдлэг, мэргэжлийн сэтгүүлчийн торгон мэдрэмж мэдрэгдэж байгаа юм.

“Цус алдалт бол чимээгүй дуу алдалт” /Ц.Одсүрэн: Сая төрсөн хүүхэд уйлахад.../. Энэ ганц богино өгүүлбэр надад алтан мөнгөн ялтас шижиртэн гэрэлтэх адил санагдсан. Шигтгээ гэдэг энэ юм. “Органик түүхий эдийг сүү, айраг, шар сүүнд номхотгодог юм байна. Өөрөөр хэлбэл боловсруулдаг гэсэн үг... Төмөр дутсан хүнд пират гэдэг чулуу хэрэглэдэг байж. Хүхэртэй чулуу л даа. Чулууг нь бид олсон. Найрлаганд нь алт, мөнгө, мышьяк гээд ховор элементийн нэгдэл байсан. Энэ чулууг номхотгох арга нь үхрийн маханд боогоод нурамлах арга юм байна. Би хийж үзсэн. Халуун үнсэнд булна гэсэн үг. Үхрийн маханд боогоод нурамласан чинь мах нь цагаан өнгөтэй судалтай болоод гараад ирсэн. Яагаад гэвэл мышьяк гэдэг хортой бодис нь маханд үлдчихсэн хэрэг. Шинжлэх ухааны аргаар мышьякийг нь салгана гэвэл хэдэн мянган долларын техник хэрэгтэй болно” /Ж.Оюун: Чулуу эмэнд ордог эрдэнэ/ гэжээ.

Энд зөвхөн гайхалтай сонин хариулт төдийгүй, **номхотгоно, нурамлана** гэх зэрэг эх сайхан монгол үг хэллэг гялталзан гялбалзаж утга агуулгыг улам тодруулан ойлгомжтой болгож байгаа болно.

Зохиолч, сэтгүүлч С.Оюуны сэтгүүл зүйн бүтээлүүдтэй ойртон танилцаж шинжилж үзэхэд энэ мэт олон ололт амжилт, бусдад хэрэгтэй санаа авахуулахуйц зүйл зөндөө байна. Гэхдээ шүүмжилж хэлмээр ч юм бас тааралдаж байна. Жишээ нь МУСГЗ, сэтгүүлч С.Жамбалдоржийн тухай “Жирийн боловч жирийн бус хүн” хэмээх хөөрхөн хөрөг бүтээжээ. Зохиомж нь ч, бичвэр нь ч аль аль нь сонирхолтой юм. Есөн жижиг хөргөөс нэг том хөргийг хөврүүлэн хөвөрдөж цогцлоон урласан байна. Зургаа дахь хөрөг нь “Монголын сэтгүүл зүйд “ярилцлага” гэдэг төрлийг /жанр гэдэг утгаар хэрэглэсэн болов уу/ С.Жамбалдорж бий болгожээ” гэсэн өгүүлбэрээр эхэлж байгаа юм /номын 64 дэх тал/.

Энэ бол арай биш юмаа. Монголын утга зохиол ба сэтгүүл зүйд анхны

ярилцлага нь алдарт “Монголын нууц товчоо”-нд тусгалаа олсон байдаг. 1913 оны 3 дугаар сарын 6-нд анхных нь дугаар хэвлэгдсэн “Шинэ толь хэмээх бичиг” ба түүний үргэлжлэл болж гарсан “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд ярилцлага гэдэг бичлэгийн зүйл бий. 1921 оны ардын хувьсгалын дараагаар хэвлэгдсэн сонин, сэтгүүлүүдэд, түүний дотор “Үнэн” сонинд ярилцлага цөөнгүй гарч байсныг бид бүгдээрээ сайн мэднэ. Сэтгүүлч С.Жамбалдорж нь “Монголын залуучууд”, “Хөдөлмөр” сонины эрхлэгчээр ажиллаж байхдаа ярилцлагыг хөгжүүлэхэд хүчтэй түлхэц үзүүлсэн байж болно. Өөрөө ч үлгэр жишээ болохуйц олон ярилцлага бичиж туурвисан байхыг үгүйсгэхгүй. С.Жамбалдорж бол үнэнхүү авьяаслаг сэтгүүлч, монголын сэтгүүл зүйн түүхэнд нэр нь дуурсагдах ёстой сэтгэлгээний шинэчлэгч уран бүтээлч мөн үү гэвэл мөөн. Хэдий тийм боловч түүнийг монголын сэтгүүл зүйд ярилцлага гэдэг бичлэгийн зүйлийг бий болгожээ, түүнийг үндэслэжээ гэж үзэж хараахан болохгүй ээ. Үүнийг би тухайн цаг үед нь С.Оюун болоод С.Жамбалдоржид хэлж байснаа мартаагүй байна.

“Пагамжавын Нямдаваа” гэдэг хөрөгт зохиогч “Тэр хэзээ ч би гэж хэлдэггүй. Энэ засгийн газрын сайдууд дотроос МАХН-ын даргад нэр дэвшсэн ганц хүн нь. Нэрээ дор нь татсан. Нэг шийдвэр гаргасан бол түүнээ өөрчлөх дургүй. Ер нь хэлсэн үг, хийсэн үйлдлээ зөв гэж өөртөө итгэлтэй байдаг хүн” /номын 51 дэх тал/ гэсэн дүгнэлт хийжээ. Академич П.Нямдавааг мэдэх хүмүүс энэ дүгнэлттэй санал нэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ энд нэг жижигхэн эндүүрэл байна. П.Нямдаваа сайд “нэрээ дор нь татсан” гэдэг худлаа. Би тэрхүү бага хуралд сууж байсан амьд гэрчүүдийнх нь нэг. МАХН-ын дарга Намбарын Энхбаяр намынхаа Бага хуралд Б.Энэбиш, П.Нямдаваа, Ө.Энхтүвшин гэсэн 3 хүний нэрийг Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгуулахаар нэр дэвшүүлж санал болгосон юм. Өлзийсайханы Энхтүвшин надаас тохой өндөр мэдлэг, туршлагатай академич П.Нямдавааг Намын дарга Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшүүлж байхад миний бие түүнтэй өрсөлдөх нь зохисгүй гэж үзэж байна, нэрээ татлаа гэсэн. Харин академич П.Нямдаваа босч уг хэлэн Ө.Энхтүвшин нэрээ татсанд харамсаж байна. Монголд бид ардчилсан нийгмийг байгуулахыг зорьж байгаа. Ардчиллын үнэт зүйлсийн нэг нь аливаа сонгуульд адил тэгш оролцож шударгаар өрсөлдөх явдал юм. Энэ соёлд та бид суралцах шаардлагатай байгаа учраас би нэрээ татахгүй гэж хэлж байсан юм. Б.Энэбиш, П.Нямдаваа хоёр өрсөлдөөд Энэбиш нь Бага хурлын гишүүдээс олонхийн санал авч МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон билээ.

Энэ мэт жижиг сажиг алдаа мадаг зохиолч, сэтгүүлч С.Оюуны бүтээлүүдэд мэр сэр үзэгдэж байгааг эрхбиш хэлэх ёстой болов уу. Би Оюуныг зохиолч- сэтгүүлч гэсэн хоршоо үг, хосолмол утгатай нэр томъёогоор тодорхойлж ахин дахин хэлээд байгааг ажигч гярхай судлаачид аль хэдийнэ ажиглаж анзаарсан гэдэгт итгэлтэй байна. Зохиолч, сэтгүүлч хэмээх хос морьтой уран бүтээлчдийн ихэнхэд нь нийтлэг тохиолддог нэг гэм согог бол уянга халилын хэтрүүлэг. Давс хужрыг нь илүүдүүлчих гээд байдаг юм. Яагаад гэвэл тэдний ургуулан бодож ундруулан бялхуулах мэдэрхүй, сэрэл сэтгэхүй нь бусдаас илүүтэй хөгжсөн болоод тэр. Түүнийхээ ач буянаар ч дүрэлсэн, бас бадарсан, бүр шүүрс алдмаар тод сайхан дүрүүдийг бүтээж байдаг, тэр нь ч уншигчдад илүүтэй хүрч наалддаг онцлогтой.

Утга зохиол, сэтгүүл зүй хоёр бол нэг “сэвэн”-гийн хоёр тал. Утга зохиолд дүр бүтээж тансаг гоёмсог зохомжлохыг голлоно. Харин сэтгүүл зүйд болохоор зөвхөн үнэн бодит баримтад тулгуурлаж мэдээлнэ. Санаанаасаа нэмж чимж зохомжилж болохгүй, тэгвэл буруудна. Ялгаа нь ердөө л энэ.

МУСГЗ, Төрийн шагналт яруу найрагч, зохиолч-сэтгүүлч Санжаажавын Оюуны сэтгүүл зүйн бүтээлүүдэд ажиглалт шинжлэл хийснээ хураангуйлан базаж, дүгнэж үзэх юм бол:

Нэг. Шинэ Монголын сэтгүүл зүйг хөгжүүлэхэд тэрбээр өөрийн ухамсарт амьдралынхаа хориод жилийг зориулж, нэн ялангуяа цагаан нөмрөгт баатруудын гавьяат үйлсийг сурталчлан орчин үеийн анагаах ухааны ололт амжилтыг уламжлалт анагаахын увидаст гайхамшигтай хослуулж түгээн дэлгэрүүлэхэд үлгэр дуурайл үзүүлж оройлон манлайлж оролцсон нь үнэн байна.

Хоёр. Түүний гал цогтой нийтлэлүүд /асуудал дэвшүүлсэн өгүүллүүд, хөрөг найрууллууд ба ярилцлагууд/ нь нийгэм, хүн ардад хүрч нөлөөлөх, итгүүлэн үнэмшүүлэх чадвараараа бусдаас онцгойрон ялгарч байна.

“Мартаж болшгүй ёс заншил”/Нууцхан тэмдэглэдэг баяраа ил болговол ямар вэ/ асуудал дэвшүүлсэн өгүүллийнх нь мөрөөр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч Монголын уламжлалт цагаан сарыг бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг үндэсний баяр болгосон баримт үүний хамгийн тод нотолгоо юм.

Үүн дээр нэмж хэлэхэд түүний бичиж нийтлүүлсэн хөрөг найрууллын баатар Сарайдамба Монгол Улсын гавьяат эмч, улмаар Ардын эмч, Полоо гавьяат малчин, нийт сувилагчдаас Өөдөс анх удаа эрүүл мэндийн гавьяат ажилтан, багш П.Долгор, эмч Нарантуяа нар Монгол Улсын хүний гавьяат эмч болсон байх жишээтэй ажээ. Энэ бол С.Оюуны нийтлэлийн үр нөлөөг илтгэсэн өөр нэг тэмдэглэлт үзүүлэлт мөн болно.

Гурав. С.Оюуны сэтгүүл зүйн бичвэрүүд нь цомхон өрөлттэй, богинохон хэмжээтэй, од мичид адил гялбалзаж гялтганасан ончтой, донжтой шигтгээнүүдээр элбэг баян байгаа нь сэтгэлийг сэргээж, итгэлийг бадрааж буйг эцэст нь зориуд олзуурхан тэмдэглэсүү.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Санжаажав, О. (2011). *Цаг хугацааны урсгалд*. Улаанбаатар.

Санжаажав, О. (1999). *Хорин нэгэн ертөнц, хорин нэгэн таталбар, хорин нэгэн эмч*. Улаанбаатар.

Summary

This article examines the contribution of journalist S. Oyun—Honored Cultural Worker of Mongolia and State Prize laureate—to the development of modern Mongolian journalism. It highlights the effectiveness and social impact of her work and its role in strengthening journalism’s civic function. The study focuses on her major genres, including analytical articles on pressing social issues, portrait essays, and interviews. Through these forms, Oyun raised urgent public problems, encouraged debate, and promoted responsibility in journalism. The findings suggest that her writings influenced public awareness and advanced professional practice, making her an important figure in Mongolia’s journalistic modernization.

Keywords: S. Oyun; journalistic legacy; effectiveness of journalism; analytical articles; portrait essay; interviews

ОЛОН УЛСЫН “ЭРХ ЧӨЛӨӨ” РАДИО СТАНЦЫН “ТУРКСТАН”-Ы РЕДАКЦ БА ЦАГААЧ СЭТГҮҮЛЧИД

Р.Ш. Нуриден*,
А.Т.Дүйшекеева**

** Л.Н.Гумилевын нэрэмжит Евразийн Үндэсний Их Сургуулийн Сэтгүүл зүй,
цахим хэвлэлийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), Астана, Казахстан.*

*** Ж.Баласагыны нэрэмжит Киргизын Үндэсний Их Сургууль, Сэтгүүл зүй
ба Олон нийтийн харилцааны хүрээлэнгийн доцент, доктор (Ph.D), Бишкек,
Киргизстан*

Түлхүүр үгс: Дэлхийн хоёрдугаар дайн, легион, цагаачлал, радио “Эрх чөлөө”,
радио нэвтрүүлэг

Оршил. “Эрх чөлөө” радиог үүсгэн байгуулагч нь 1951 оны 2-р сарын 8-нд Нью-Йорк хотод байгуулагдсан Оросын ард түмнийг чөлөөлөх Америкийн хороо бөгөөд дэлхийн орос болон үндэсний цагаачдын эрх чөлөөг хамгаалах, Оросын оюун санааны өвийг хадгалах, дэмжихэд нь туслах зорилготой байв. Тус хорооны анхны ерөнхийлөгч нь UPI агентлагийн Москва дахь сурвалжлагч асан, дараа нь “Reader’s Digest” сэтгүүлийн ахлах редактороор ажиллаж байсан Южин Лайонс байв. Мөн тус хороонд “Time” сэтгүүлийн дэд ерөнхийлөгч Аллен Гровер, Харвардын их сургуулийн профессор Уильям Эллиот, сэтгүүлч Уильям Г.Чемберлен, Айзек дон Левин (Вачнадзе, 1975) нар багтжээ.

1951 оны 11-р сарын 7-нд энэ хорооноос хэвлэлийн шуурхай мэдэгдэл гаргаж, түүнд «ЗХУ-аас цагаачлан ирсэн 11 байгууллага, тэр дундаа Оросын тав, Орос бус зургаан улс төрийн байгууллага Зөвлөлт засгийн дэглэмийг нураахын тулд хамтран ажиллахаа зарлажээ». Энэхүү шийдвэрийг дээр дурдсан байгууллагуудын Висбаден (Герман) хотод болсон бага хурлын сүүлчийн өдөр гаргасан бөгөөд большевикууд засгийн эрхэнд гарсан өдөртэй давхцаж байв. ЗХУ-ын эрх мэдлийн эсрэг тэмцэлд уриалах нийм оролдлого өмнө нь ч гарч байсан. Гэвч нэг нь ч амжилтанд хүрч байгаагүй. Энэ бага хуралд: “Оросын улс төрийн таван байгууллага, гүрж, белорус, армян, азербайжан, Хойд Кавказ, Туркстаны ард түмний улс төрийн байгууллагуудын төлөөлөгчид бид большевикуудын дарангуйллаас чөлөөлөхийн

The “Turkistan” Editorial Board of the “Liberty” International Radio Station and Exile Journalists. **Nuriden R.Sh. (Ph.D), Duishekeva A.T. (Ph.D).**

төлөөх тэмцэлд Зөвлөлт Холбоот Улсын бүх ард түмнийг коммунист дарангуйллыг устгах, өөрөө өөрийгөө удирдах, өөрсдийн хувь заяаг ардчиллын замаар шийдэх, коммунист боолчллын эсрэг эрх чөлөө ба энх тайвны төлөөх тэмцэлд уриалж байна” гэж тунхаглажээ. Энэхүү тунхагт Нью-Йорк дахь төв байгууллагын Ардын түмний эрх чөлөөний төлөөх тэмцлийн лигээс Борис Николевский, Үндэсний Хөдөлмөрийн Холбооноос Виктор Байдалакофф (Герман), Оросын ард түмний эрх чөлөөний төлөөх тэмцлийн холбооноос Борис Яковлев, Оросын ардын хөдөлгөөн (ард түмнийг дэмжигчид)-өөс Александр Керенский (Нью-Йорк), Оросыг чөлөөлөх тэмцлийн холбооноос проф. Серж Мельгунофф (Парис), мөн Гүржийн Үндэсний зөвлөлөөс (Парис), Азербайжаны Үндэсний Эв нэгдийн хорооноос (Анкара), Хойд Кавказын коммунистуудын эсрэг холбооноос (Мюнхен), Белорусын ардчилсан бүгд найрамдах холбооноос (Парис), Армений эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн холбооноос (Штутгарт) болон Туркстаны үндэсний хорооноос (Мюнхен) төлөөлөгчид гарын үсэг зуржээ (Бережкова, 1993).

Цагаачилсан алашчуудын* анхных бол Мустафа Шокай байв. М.Шокайгаас хойш янз бүрийн чиглэлээр дээд боловсролтой, маш чадварлаг мэргэжилтнүүд байсан бөгөөд тэдний дотор Алихан Ага, Карыс Канатбай, Мажит Айтбай, Алиасхар, Сайран, Асанкайгы, М.Дара нарыг нэрлэж болно.

ЗХУ-ын эсрэг дуусашгүй тэмцэл зарласан цагаачдын 11 байгууллагын нэг болох Туркстаны үндэсний хороог тэргүүлж байсан Карыс Канатбай уул уурхайн өндөр боловсролтой инженер мэргэжилтэй байжээ. К.Канатбайг олон үйл явдалд гүйцэтгэсэн түүхэн үүргийг харгалзан Туркстаны үндэсний тусгаар тогтнолын төлөө зүтгэсэн М.Шокайн дараа орох ёстой “Алаш”-ийн зүтгэлтэн гэж үзэж болно (Оралтай, 1991).

Дэлхийн хоёрдугаар дайны үеийн үйл ажиллагаатай холбогдуулан америкчууд хожим нь түүнийг олзолж, алдарт “Дахау” хорих лагерьт хэдэн сар хорьжээ. Гэвч тэрээр германчуудын эрх ашгийн төлөө бус Туркстаны үндэсний эрх ашгийн төлөө үйлчилсэн нь тодорхой болсон учраас Карыс шоронгоос суллагдажээ. Түүний үлдсэн амьдрал нь «Туркели» (“Түрэг улс”) хороотой холбоотой байв. Тэрээр “Эрх чөлөө” радиод ажиллаагүй ч 80-аад он хүртэл казах хэлний редакцын нэвтрүүлгүүдийн улс төрийн агуулгад ихээхэн нөлөө үзүүлжээ. Америкийн “Оросыг судлах хүрээлэн”-тэй хамтарч ЗХУ-ын эсрэг ажилласан, үндэсний байгууллагын үндэслэгч байсан, Германы тагнуулын сургуулийг дүүргэсэн тэрээр өөрийнхөө үндэстний тусгаар тогтнолыг хүсэн хүлээж, хилийн чанадад байхдаа ч амьдралынхаа сүүлчийн өдөр хүртэл ард түмнийхээ эрх ашгийг хамгаалах эрхэм үүргээ биелүүлсээр ирсэн юм. Цогтой тэмцэгч К.Канатбай 1982 оны 11-р сарын 25-нд 71 насандаа таалал төгссөн тухай “Эрх чөлөө” радио гүнээ харамсан мэдээлсэн билээ (Канатбайн тухай, 1982).

“Эрх чөлөө” радиогийн анхны ажилтнууд бол олзлогдсон, аргагүйн эрхэнд цагаач болсон казах сэхээтнүүд байв. Зөвлөлтийн үеийн бүтээлүүдэд бүгд дайсан мэт дүрслэгдсэн байдаг. Хувь заяатай эвлэрэхээс өөр аргагүй болсон тэдний хувьд эх орон руугаа явах зам бүрэн хаалттай байв. Сталины ганц үг, нэг сум дайнд олзлогдогсдын амьдралыг шийдэж байсан тул тэд гадаадад цагаачлан үлдэхээс өөр зам байгаагүй. Ирсэн зарим хүн амьдралынхаа талыг шоронд өнгөрөөсөн. “Эрх чөлөө” радиогийн “Туркстан”-ы редакцияд ажиллаж байсан иргэд нь «Туркели» үндэсний хорооны гишүүд байв. “Эрх чөлөө”-д анх ажиллаж байсан хүмүүсийн нэг бол Асанкайгы гэдэг нэрээр олонд танигдсан Мауликеш Кайыпалды юм. Тавиад оны үед буюу “Эрх чөлөө” радио станц байгуулагдаад удаагүй нээгдсэн “Туркстан”-ы редакцияд ажиллаж байсан цагаачдын нэг бол Даулет Тагыберли байв.

Тэрээр 70-аад оны дунд үе хүртэл Асанкайгын дараа казах хэлний хэлтсийг удирдаж байсан бөгөөд К.Канатбайтай хамтран Казахстанд зориулсан нэвтрүүлгийн үзэл баримтлалыг боловсруулжээ (Козыбаев, 1986). Даулетын эрүүл мэнд нь муудаж, тэтгэвэрт гарсны дараа түүний оронд Жакибай Бапыш гэдэг хүн иржээ.

Энэхүү судалгааны өгүүллийн зорилго нь “Эрх чөлөө” радиод ажиллаж байсан эдгээр цагаачдын уран бүтээлтэй танилцуулж, Казахстаны тусгаар тогнолыг мөрөөдөж, хил хязгааргүй радио долгионоор казах сонсогчидтой харилцаж байсан радио нэвтрүүлгийн сэдэв, агуулга, зорилгыг тодорхойлоход оршино. Мөн тэдний гадаад орнууд дахь казах сонин, сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлүүдтэй танилцуулах зорилготой юм.

Судалгааны арга зүй

Олон улсын “Эрх чөлөө” радио станцын казах хэлний хэлтэс нээгдэхдээ түүнийг “Туркстан”-ы редакц гэж нэрлэсний, мөн цагаачлалын асуудлын ч түүхэн шалтгаанууд байжээ. Тиймээс сэдвийг тодруулахын тулд түүхчлэн үзэх арга зүйн хүрээнд цагаач сэтгүүлчдийн бүтээлүүдэд сэдэвчилсэн болон агуулгын дүн шинжилгээ хийх аргыг хэрэглэсэн. Радиод ажиллаж байсан цагаач сэтгүүлчдийн уран бүтээлийг судлахын тулд радиогийн архивын материалуудыг түлхүү ашигласан. Мөн шинжлэх ухааны эргэлтэд орсон сонин, сэтгүүлүүдэд гарсан баримт бичгүүд болон өгүүллүүд ч анхаарлын гадна үлдсэнгүй. Цагаачлалын сэтгүүл зүйг түүхчлэн үзэх болон харьцуулан судлах аргаар авч үзэж, цогц, системтэй судалгаа хийгдсэн. “Цагаачлалын хэвлэлд Зөвлөлтийн эрх баригчдын бүдүүлэг алдааг шүүмжилсэн нь үг хэлэх эрх чөлөөний тод илрэл юм” (Бакенова, 2024) гэсэн үзэл бодол нь радио нэвтрүүлэгтэй ч шууд холбоотой юм.

Судалгааны бүтээлийн тойм

“Эрх чөлөө”, “Чөлөөт Европ” зэрэг олон улсын радио станцуудын нэвтрүүлэг дайны дараагаар цацагдаж эхэлсэн бөгөөд дээрх станцуудын үйл ажиллагааны сэргэлт “хүйтэн дайн”-ы үетэй давхацсан түүхтэй. Тиймээс Казахстанд ч, гадаадад ч олон улсын радиогийн өргөн нэвтрүүлгийн судалгаанд энэ асуудлыг үл тоомсорлох боломжгүй юм. Эдгээр радио станцууд бүгд “хүйтэн дайны” үр хөврөл гэдэг нь тодорхой. Эхний үед эдгээр радио станцууд дайнд олзлогдсон цагаачдыг ажиллуулж эхэлсэн. Гадаад улс төрийн суртал ухуулгын үр дүнтэй хэрэгсэл бол олон улсын радио нэвтрүүлэгт “дайсны дүр”-ийг бүтээх явдал байлаа. ЗХУ-ын олон улсын улс төрийн сэдвээр бичсэн ном, судалгааны бүтээлүүдийг жагсаах нь нүсэр том ажил болох тул энд цөөн хэдийг дурдсан юм. Тэдний тоонд “Эрх чөлөө” радиогийн талаар яригдсэн сэтгэгдлүүдийг ч багтааж болно. Юуны өмнө радиогийн ажилчид цагаачид байсан болохоор “ухамсаргүй бүдүүлэг”, “Эх орноосоо урвагчид”, “адгийн новшнууд” гэх мэт нэр зүүж, “казах” гэж бичвэл “үндсэрхэг үзэлтэн”, “ард түмэн” гэж бичвэл “түрэг үзэлтэн” гэж цоллуулдаг байжээ.

Хэдийгээр Г.А. Арбатов [7], Н.А.Голядкин [8], В.М. Карелина [9], Ю.Б. Кашлев [10], А.Ф.Панфилов [11], А.Шилкин [12] нарын бүтээлүүд зөвлөлтийн үзэл суртлын үүднээс бичигдсэн боловч түүхэн үйл явдлуудын талаар тодорхой мэдээлэл өгдөг онцлогтой.

Казахстан тусгаар тогтнолоо олж авсны дараагаар олон улсын радио сэтгүүл зүйн чиглэлээр, тэр дундаа “Эрх чөлөө” радиогийн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан [13], шинэ агуулга бүхий сурах бичгүүд зохиогдсон [14]. Гэхдээ ганц хоёр судалгаагаар асуудлыг шийдэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Ялангуяа

сэтгүүл зүйн түүхэнд “Цагаачлал дахь казах сэтгүүл зүй”-г хараахан судлаагүй байна. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь уг сэдвийг цаашид гүнзгийрүүлэн судлахад тодорхой нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Үр дүн ба хэлэлцүүлэг

Төрөлх нутагтаа “дуу хоолойгоо” хүргэхийг зорьсон “эрх чөлөө”-нийхэн улс орон, газар шороо, эх орноо гэсэн сэтгэлийн үгийг агаарын долгионоор дамжуулж, тэд цогтой тэмдэгчид Мустафа, Магжан, Ахмет шиг үг, үзэл бодлоо хүргэсээр байв. Бид атар газрыг эзэмшлээ гэж тэнгэрт далбаагаа мандуулж байхад “Эрх чөлөө”-ий казахууд хайр найргүй хагалсан газар нутгаа, цөөнх болсон эх орноо өрөвдөж, сэтгэлийн үгээ хэлж байлаа. Казахууд өвөг дээсийн уламжлалт мэргэжил - малгүй болж, бэлчээр нь хумигдаж, үүний цаана “оросжуулах” бодлого нуугдаж байгаа гэсэн тэдний үгийг улс үндэстнийг турхирч, хагалан бутаргах санаа гэж үзэн ядаж, ардын дайсанд тооцож байв. Казахстан нь Оросын хараат улс, хэл, шашин шүтлэгээ алдаж, казах сургууль, цэцэрлэг цөөрсөөр байна гэсэн мэдээллийг нь “зөвлөлтийн аж төрөх ёс”-ыг гүтгэн доромжилсон гэж үзээд хараалын үгээр бөмбөгдөж байлаа.

Дайны үед “Милли Туркстан” сэтгүүлийг Европт олзлогдсон Дундад Ази, Казахстаны мусульман шашинтнуудад тарааж байжээ. Энэхүү сэтгүүл цагаачдын уран бүтээлд ихээхэн анхаарал хандуулсан онцлогтой. Тухайн үед энэ сэтгүүлд Асанкайгы, хуурч Коркыт зэрэг нууц нэр байнга тааралддаг байв. Хожим нь хуурч Коркыт нь яруу найрагч Мажит Айтбаев, Асанкайгы бол зохиолч Мауликеш Кайыпалды байсан нь тогтоогдсон. Мауликеш сэтгүүлийн хуудаснаа Магжан, Сакен, Бейимбет, Жусупбек, Ильяс, Ахмет, Алихан, Алимхан нарын бүтээлийг нийтэлж, олон нийтэд танилцуулж байжээ.

“Эрх Чөлөө”-д анх ажиллаж байсан хүмүүсийн нэг бол Асанкайгы гэсэн нууц нэрээр олонд танигдсан Мауликеш Кайыпалды юм. Түүний мэргэжлийн талаар янз бүрийн санал бодол байдаг. Заримдаа түүнийг Ленинградын их сургуулийн философийн факультетийг төгссөн гэж ярьдаг ч түүнийг сайн мэддэг, Германд нэг хороонд хамт ажиллаж байсан Хамза Абдуллыны дурсамжид: “Мауликеш 21 настайдаа Москвагийн их сургуулийн хэл, уран зохиолын факультетийг онц төгсөж, Алматын их сургуульд оросын уран зохиолын хичээлийг зааж, уран бүтээлээ хоёр хэл дээр зэрэг туурвидаг байсан” (Абдуллин, 1993) хэмээн тэмдэглэсэн байдаг. Сүүлийн үед утга зохиол судлаач, хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн М.Таж-Муратын М.Кайыпалдын тухай судалгаа нь бидэнд өнөөг хүртэл үл мэдэгдэх бие хүнийг өргөн хүрээнд нь танилцуулж, багагүй шинэ мэдээлэл өгсөн бүтээл юм (Таж-Мурат, 2024). Түүний шүлэг, өгүүллэгүүд казах, орос хэлээр дайны өмнө Казахстан болон Москвагийн сэтгүүлүүдэд хэвлэгдэж байжээ. Нэг хэсэг нэрт яруу найрагч Жамбул Жабасевын оруулагчаар ажиллажээ. Дайн хүртэл тэрээр И.Байзаков, К.Аманжолов, Н.Манашев, Г.Сланов, А.Жумагалиев нартай найзалж байв. Хэдийгээр Эх орноосоо хол байгаа хэдий ч өөрийнхөө мэдлэг боловсрол, хүч чадлаа их үлсэд зориулсан М.Кайыпалды Берлинд орчуулагчийн найман сарын курс дүүргэж, улмаар Майн дахь Франкфуртын их сургуулийн Германы гүн ухаан, англи хэлний факультетэд суралцжээ.

Хэл сайн мэддэг, эрдэм мэдлэг хуримтлуулсан М.Кайыпалды ард түмнийхээ бахархал болох хүн байсныг эдгээр үйл хэргээс нь харж болно. Харамсалтай нь, хувь тавилан түүнд тэр аз жаргалыг заяасангүй. Үүнийг мэдэрсэн мэт энэхүү шүлгийг герман хэлнээс үгчлэн орчуулан үлдээжээ.

Зорчигчоос би асуув:

“Зорьсон газар чинь хаана вэ?”

“Гэртээ харьж явна, харьж явна” гэж
гэгэлзсэн сэтгэлээр хариулав.

Холын хүнээс би асуув:

“Хүрэх газар чинь хаана вэ?”

“Хайртай гэртээ харьж явна” гэж
хайрын үгээр хариулав.

Аяны хүнээс би асуув:

“Аз жаргал чинь хаана цэцэглэдэг вэ?”

“Миний гэрт, ганцхан миний гэрт!” гэж
мэхийн ёсолж инээмсэглэв.

“Зүрхэнд чинь ямар гал байна?” гэж

зорчигч надаас асуувал:

“Орон гэртээ харьж чадахгүй би,

Одоо надад Эх орон үгүй!” гэж хариулна.

Германы сэтгүүлүүдэд түүний уран зохиолын өгүүллэгүүд нь нийтлэгддэг байснаас гадна “Диваажингаас ирсэн амь дүйх үг” роман нь герман хэл дээр хэвлэгджээ.

Бид “Эрх чөлөө” радиогийн санд хадгалагдаж буй Асанкайгын хэд хэдэн радио нэвтрүүлгийг Астана дахь Үндэсний эрдмийн номын сангаас олсон. Эдгээр нь улс төрийн сэдэвт зориулагдсан, мөн Казахстаны сонинуудад нийтлэгдсэн өгүүллүүдэд хийсэн тойм, тайлбарыг агуулдаг. “Казахын улс төрийн уянгын яруу найраг” радиоярианд тэрээр “Казахын уран зохиол” сонинд нийтлэгдсэн “Казахын яруу найргийн хөгжил” сэдэвт өгүүллийг шүүмжилсэн байдаг. Тэрээр “С.Сейфуллины шүлгүүд нь Маяковскийн шүлгийн хэлбэрийг дуурайж, казахын яруу найрагт агуулга төдийгүй бүтэц, хэмнэл нь өөр, найруулга зүйн тогтолцоо, аялгуу нь өөр шүлгийн шинэ хэв маягийг нэвтрүүлж, зөвлөлт казахын яруу найргийг улс төрийн уянгын шүлгээр баяжуулсан” (Асанкайгы, 1967) гэсэн мөрүүд нь коммунистуудын санаанаас зохиосон зүйл гэж дүгнэжээ.

Хоёр дахь радиояриа нь орос хэл дээр хэвлэгддэг “Простор” сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэлд зориулагдсан бөгөөд казах романы тухай социалист реализмыг шүүмжилжээ. Октябрийн хувьсгалын 50 жилийн ойн босгон дээр хэвлэгдсэн энэхүү өгүүлэлд хувьсгалаас өмнө казахуудад роман байгаагүй гэсэн үзэл бодлыг няцааж, Ж. Аймауытовын “Дамели”, “Хөгшин Кожах”, М.Ауэзовын “1916 он” нэртэй түүхэн романыг үүний жишээ болгон авч тайлбарласан байдаг (Асанкайгы, 1967). Үүнээс жаран жилийн өмнө бид Жүсипбек зэрэг казах зохиолчдын бүтээлийн тухай ярих боломжгүй байсан нь тодорхой юм.

Мэдээж харилцаа холбоо тааруу үед сонин, сэтгүүлийг хүссэн цагтаа хүлээж авах боломж хомс, мэдээлэл авахад маш хүнд хэцүү байсан. Гэсэн хэдий ч “Эрх чөлөө” радиогийн ажилтнууд баримтыг зохиох гэж оролдсонгүй, харин Казахстанд хэвлэгдсэн сонин, сэтгүүлийн шүүмжлэлт материалуудыг ашигласан. Түүнчлэн Казахстан радиогийн Пакистаны нутаг дэвсгэрээс бэлтгэж ирүүлдэг нэвтрүүлгүүдийг ярианы сэдэв, үндэс болгодог байжээ.

Изар голын эрэгт, нуман хэлбэртэй гурван давхар томоохон байшинд байрлах тус радиод сэтгүүлчдэд ажиллах бүх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдаг. Энд хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдээс гадна номын сан, архив хүртэл бий. Казах хэлний редакция “Социалист Казахстан”, “Казахын уран зохиол”, “Ленинч залуу”, “Соёл ба ахуй” зэрэг сонины хуучин дугааруудыг үдэж, маш нямбай эвхэж хадгалсан байдаг. Номын санд нь казах ном ч их бий. Мөн томоохон судалгааны төв нь дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээллийг шүүн тунгааж, шаардлагатай мэдээллүүдийг бүртгэж хадгалдаг байна.

Асанкайгы – М.Кайыпалды “Эрх чөлөө” радиод удирдах алба хааж байсан үед буюу 1969 онд хотын захад төмөр замын хажууд толгой нь хагарсан байдалтай цогцос нь олдсон бөгөөд энэ талаар хожим 1993 оны гуравдугаар сарын 1-ний өдөр радиогоор мэдээлсэн байдаг.

“Эрх чөлөө” радио нэвтрүүлгээ цацаж эхэлсэн цагаас ЗХУ-ын аюулгүй байдлын байгууллагууд түүнд онгойцлон анхаарал тавих болов. Тэд хүн алахаас ч буцсангүй. Тухайлбал, 1954 онд Азербайжан хэлний редакцын ерөнхий эрхлэгч Абдрахман Фаталыбей, мөн радиотой ямар ч холбоогүй сэхээтэн цагаачид халдлагад өртсөн. Улсын Аюулгүй байдлын хорооноос тусгайлан бэлтгэгдсэн тагнуулч 1957 онд Глеб Лебедийг, 1959 онд Степан Бандера нарыг хөнөөжээ.

1981 оны 2-р сарын 21-нд Мюнхен дэх “Чөлөөт Европ” болон “Эрх чөлөө” радио байрладаг Английн цэцэрлэгт хүрээлэнд бөмбөг дэлбэрч, 8 хүн амь үрэгдсэний 6 нь станцын ажилтан, 2 нь гудамжид явж байсан энгийн иргэн байсан. Барилгын төв хэсэг бүрэн эвдэрч, Польш, Чехословак, Унгарын редакцууд томоохон хохирол амссан байдаг. Хожим нь энэ үйлдлийн эзэн нь ХХ зууны нэрт алан хядагч Ильич Рамирес Санчес байсан нь тогтоогджээ (Террорист ХХ века, 1991).

Өнгөрсөн зууны 50-иад онд буюу “Эрх чөлөө” радио станц байгуулагдаад удаагүй байхад нээгдсэн “Туркстан”-ы редакцияд ажилласан цагаачдын нэг нь Асанкайгын дараа 70-аад оны дунд үе хүртэл казах хэлтсийг удирдаж байсан Даулет Тагыберли юм. Тэрээр Карыс Канатбайтай хамтран Казахстанд зориулсан өргөн нэвтрүүлгийн үзэл баримтлалыг боловсруулсан. Д.Тагыберли казах хэлтсийг удирдаж байсан үед “Туркстан” хэмээх ерөнхий нэрээр нэрлэгдэж байсан редакц нь «Туркстан-3» болон өөрчлөгдөж казах хэлний алба байгуулагджээ.

Бид Хасен Оралтайн хувийн сангаас Даулетын орос хэл дээр бичигдсэн хоёр нэвтрүүлгийг олсон. Тэдний нэг нь 67 жилийн өмнө агаарын долгионоор цацагдсан “Мустафа Чокай - Туркстаны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэгч” (нас барсны 18 жилийн ойд зориулав) гэсэн нэртэй юм (Тагыберли, 1959). Цагаач сэтгүүлчид эх орондоо хүлээн зөвшөөрөгдөөгүй Мустафагийн тухай ярихаас уйдаагүй. Түүний нас барсан өдөрт зориулан жил бүр мэдээ материал бэлтгэн олон нийтэд хүргэдэг цагаач сэтгүүлчдийн тогтоосон уламжлалд үнэнч байдал өнөөг хүртэл үргэлжилж байна.

Тайлбарын хэлбэрээр бичигдсэн хоёр дахь нэвтрүүлэг нь “Зөвлөлтийн радиодарангуллын дуу хоолой” нэртэй бөгөөд түүнд Москвагийн мэдэлд байдаг Зөвлөлтийн радио нэвтрүүлгүүд коммунист суртал ухуулгад тулгуурладаг талаар дэлгэрэнгүй өгүүлж, нэлээд ул суурьтай дүн шинжилгээ хийжээ. Олон улсын гадаадын радио станцуудын үйл ажиллагааг үүний эсрэг жишээ болгон ашигласан байв. Нэвтрүүлгийг “Бидний тэмцэл коммунист дарангуйлал нуран унатал үргэлжилж, хайрт Эх орондоо ард түмнийхээ хүсэл зоригийн дагуу нийт иргэдээ эрх чөлөөтэй амьдрал, ажил хөдөлмөрөөр хангасан үндэсний ардчилсан төрийг

байгуултал тэмцээр байх болно” (Тагыберли, 1960) гэсэн үгээр төгсгөжээ. Орос хэл дээр бичигдсэн энэхүү тайлбарт Даулетын хамт зохиогчийн хувьд Бердимурат хэмээх нэр ч тааралддаг. Аман Бердимурат бол “Эрх чөлөө” радиогийн туркмен хэл дээрх нэвтрүүлгийг үндэслэгч бөгөөд Ашхабад хотод хуулийн чиглэлээр боловсрол эзэмшсэн байжээ.

Даулетын эрүүл мэнд нь муудаж, тэтгэвэрт гарсны дараа түүний оронд Жакибай Бапыш гэдэг хүн иржээ. Тэрээр дайны эхэн үед олзлогдож, 1945 онд шоронгоос оргосон ч хүнд нөхцөлд ядарсан Жакибай удаан хугацаанд өвчтэй байжээ. Өвчин нь эдгэсний дараа 1952 онд Нюрнберг дэх Радио инженерийн дээд сургуульд элсэн орж, “Эрх чөлөө” радио станцын нөлөөгөөр сургуулиа төгссөн. Дараа нь радиод ажилд орж, нэвтрүүлэг бэлтгэхэд идэвхтэй оролцож эхэлжээ.

1970-аад онд “Туркстан”-ы редакцыг үндэстнүүдийн хэлтэс болгон тус тусад нь хуваах асуудал тавигдахад 1955 оноос хойш радиод ажиллаж байсан Жакибай Бапыш казах хэлтсийг удирдах болжээ. Тэрээр радиогийн сурвалжлагч Исет Бичертэй хийсэн ярилцлагадаа “Даулет өвчтэй байсан үед би түүний үүргийг орон гүйцэтгэж байсан. Даулет тэтгэвэрт гарснаас хойш гурван сарын дараа буюу 1976 оны есдүгээр сард намайг албан ёсоор энэ албанд томилсон. Цөөн хүнтэй, ажил ихтэй байв. Дээрээс нь Барууны ардчилсан орнуудад хүн бүр өөрийнхөө ажил, мэдлэг чадвараа амьдралд хэрэгжүүлэхийн төлөө тэмцдэг. Тухайлбал, редакцад шинэ ажилтан авах, тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх, нэвтрүүлгийн эфирийн цагийг уртасгах гэх мэт ажил миний эрүүл мэнд муудахад ч нөлөөлсөн. Гэхдээ хүн өөрийнхөө хүн чанараа бодоод бүгдэд нь тэсдэг юм байна. Би ч тэссэн. 1988 онд тэтгэвэрт гарахаас өмнө тавьсан зорилгуудыг биелүүлж чадсан гэж боддог” гэж өгүүлжээ. Радиод 33 жил ажилласан Жакибай 1940 онд 18 настайдаа Кызылорда мужийн Кармакшы дүүргээс цэрэгт татагджээ. Түүнээс хойш тэрээр төрсөн нутгаа хэзээ ч харж байгаагүй. Дараа нь Дим хэмээх татар эхнэртэй, хоёр хүүхэдтэй байсан тухай сонинд бичсэн байдаг. Энэ бүхнээс хэдийгээр хагас зуун жил өнгөрсөн ч казахын ард түмэнд тохиолдсон гай зовлон нь түүний үр хүүхдийн хувь заяанаас нь тодоос тод харагддаг.

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Патрик фон цур Мюлен (Герман): “Яагаад ихэнх хоригдол тусгай хороонд элсэхийг зөвшөөрсөн бэ? Ямар шалтгаануудыг дурдаж болох вэ? Юуны өмнө хүн болгон өөрийгөө хуарангаас аврах арга замыг хайсан нь тодорхой. Учир нь өлсгөлөн, нүцгэн, өрөвдөлтэй, гэм зэмгүй хүмүүс асар их зовлон амссан. Зовж зүдэрч, өвдөж чаналсан хүмүүст эрүүл мэндийн тусламж үзүүлэхийн оронд шууд буудаж алдаг байсан” (Мюлен, 1971) гэж бичсэн байдаг. Ийм аргагүй байдлаас арай гэж амьд үлдсэн хүн бүр амьдралаа бодож, ямар нэг аргаар амь зуухын төлөө хүчин зүтгэсэн нь тодорхой. Бидний дээр дурдсан цагаачдын амьдрал, ахуйг эргэн харвал үлгэр домогт гардаг үхэж, дахин амилдаг Самрук шувуутай зүйрлэж болно. Тэд хоёр ертөнцийг холбосон гүүр болж, Герман ба Зөвлөлтийн учруулсан зовлонг даван туулсан. ЗХУ хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэдний талаар хамгийн бохир заваан үг, хараалаа харамгүй нийтэлдэг байсан. Бүр жүжгийн хэлбэрээр ч олон нийтэд хүргэсэн. Тэр бүтээлүүдийн гарчиг нь хүртэл үзэн ядах мэдрэмжийг агуулж байлаа. Тухайлбал, “Казахын уран зохиол” сонинд нийтлэгдсэн “Агаарын долгион дахь новшнууд” өгүүлэлтэй холбогдуулан олон жил цагаачлан эх орондоо буцаж ирсэн Ж.Акбергенов хэмээх зохиогч “Урвагчид урвагчаараа үлддэг” нийтлэлдээ “Эрх чөлөө”-д хамт ажиллаж байсан боловч тэнд үлдсэн хүмүүсийг хайр найргүй шүүмжилжээ. Уг нийтлэлд Канат Карысбай, Даулет Тагыберли, Жакибай Бапыш, тэр ч байтугай Мустафа

Шокай нарыг доромжилж, “нохой, гөлөг”-тэй зүйрлэсэн байдаг. Мөн “Социалист Казахстан” сонинд нийтлэгдсэн өгүүлэл ч дээрх бүтээлийн өрөөсөн дугуй юм. “Үнэн зэвэрдэггүй буюу “Эрх чөлөөнийхөн”-д хэлэх үг” гэсэн гарчиг өгч “улс орноосоо дайжсан тэнгүүд”, “хөөрхий тэнүүлчид”, “далан худалчид” гэх мэт болон бусад цөөнгүй хараалын үгээр бөмбөгдөж, “социалист амьдралын үнэн зэвэрдэггүй” гэсэн итгэл үнэмшлээр нийтлэлээ төгсгөжээ.

Дүгнэлт

Америкийн хорооны тэргүүн Южин Лайонс Висбадены бага хурлыг болон түүний тунхаглалыг “асар их ач холбогдолтой түүхэн үйл явдал” гэж нэрлэжээ. Ийм үйл явдлын дараа Баруун Европт радио станц нээх тухай яригдаж эхэлсэн бөгөөд үүний бэлтгэл ажлын тухай 1952 оны 6-р сард Штарнберг (Бавари) хотод болсон бага хурлын үеэр хэлэлцэж, тус хороог ЗХУ-д суугаа АНУ-ын Элчин сайд асан, адмирал Алан Г.Керк тэргүүлэхээр болжээ. Түүний тусламжтайгаар радиогийн комисс байгуулагдаж, Оросын болон үндэсний цагаачлалын хөдөлгөөнүүдээс бүрдсэн редакторууд, сэтгүүлчид, захирлуудыг цуглуулж, уг хороо ирээдүйн радио станцад санхүүгийн тусламж үзүүлэхээр тогтжээ.

Станцын студиуд, удирдлага болон хяналтын байгууллагууд нь Мюнхенд, өргөн нэвтрүүлгийн байгууламжууд нь Лампертхаймд (Герман) байрлахаар болжээ. 1953 онд “Большевизмээс чөлөөлөх нь” радио анх эфирт гарахад ажилтнууд нь ердөө хоёрхон антен, 10 кВт-ын богино долгионы хоёр дамжуулагчтай байв. Нэвтрүүлэг цацагдаад 15 минут өнгөрмөгц Зөвлөлтийн саатуулагчид идэвхжиж эхэлсэн түүхтэй. 1953 онд уг радио хоногт 12 цагийн нэвтрүүлгийг орос хэл дээр дамжуулж байсан бөгөөд үүний ердөө 20 минут нь шинээр бэлтгэсэн мэдээлэл, үлдсэн цаг нь өмнөх нэвтрүүлгүүдийн давталт байв. Тэр үед “Эрх чөлөө” радиод Төв Ази болон Казахстаны сонсогчдод зориулсан үндэсний редакц байгаагүй бөгөөд тэдний сонсогчдод зориулсан хөтөлбөрийг “Туркстан” хэмээх ганцхан редакцад бэлтгэдэг байсан нь дараах хэдэн шалтгаантай холбоотой байв. Нэгдүгээрт, боловсон хүчинтэй холбоотой байсан бол хоёругаарт, цагаачлал дахь улс төрийн асуудал хүчтэй нөлөөлсөн. Радио станц нээх асуудал хөндөгдөхөд цагаачдын дунд бичих чадвартай казах, узбек хангалттай байсан ч киргиз, туркмен, тажик зэрэг мэргэжилтэн маш цөөн байв. Мюнхен хотын орчимд оршин суугчид, ялангуяа К.Канатбай тэргүүтэй «Туркели» хорооныхон “Эрх чөлөө” радиог санхүүжүүлэгчидтэй ярилцахдаа Төв Ази, Казахстаны сонсогчдод зориулсан нэвтрүүлгийг зөвхөн нэг редакцад бэлтгэхийг санал болгож, тодорхой шалтгаануудыг дурджээ. Учир нь тэд Төв Азийн улс болгонд тус тусад нь редакц байгуулбал киргиз, туркмен, тажикууд радиогийн гадна үлдэх болно гэдгийг ойлгосон. Мөн Дундад Ази, Казахстанас цагаачлан ирсэн сэхээтнүүд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд “Туркстан”-ы нэгдлийн нэрийн өмнөөс ярьж заншсан хүмүүс байжээ.

Цагаачдын энэ асуудлын талаарх шийдвэрийг зөв гэж үнэлэх ёстой. Бүх туркстанчууд нэгдвэл радиод хангалттай жин дарах болно гэж бодоод редакцад авах ажилтны тоог анхнаасаа тохироогүй нь тэдний алдаа байв. Мэдээж энэ тал дээр тэдэнд гомдох ч, шүүмжлэх ч хэцүү. Учир нь хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байсан туршлага багатай төв азийнхан хувийн үндэсний эрх ашгийг бус, нэгдмэл зорилгыг чухалчилж байв. Түрэг гаралтай ард түмнийг “Туркстан” нэрийн дор нэгтгэж буйг колоничлолын эсрэг, үндэстнүүдийн эрх чөлөө, эрх тэгш байдлын төлөөх тэмцэл гэж дүгнэвэл цагаачид ч мөн адил тэр зорилгын төлөө хамтран ажиллаж, нэгдэн хүчин зүтгэхийг зорьж байсныг мэдэж болно.

Станц байгуулагдаж, ажилчдаа авч эхлэхэд л радиогийн удирдлагууд нэг редакцад таваас илүү ажилтан олгох боломжгүй гэдгээ мэдэгдсэн. Үүний үр дүнд “Туркстан”-ы редакц ч таван хүнтэй ажлаа эхлүүлэхээс өөр аргагүй болжээ. Ингээд нэг казах, нэг узбек, нэг туркмен, нэг киргиз, нэг каракалпак гэсэн таван үндэстний төлөөлөл нэгдэж нэвтрүүлгээ бэлтгэж эхэлжээ.

“Эрх чөлөө” радиогийн “Туркстан”-ы редакцад ажиллаж байсан цагаачид аливаа түүхэн үйл явдал Эрх чөлөө, Хүчирхийлэл гэсэн хоёр үндэстэй гэж үзээд Оросын хуучин колони байсан ард түмнийг гутаан доромжилсон большевизмийн эзэнт гүрний бодлого, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг зогсож байв. Тэд үйл ажиллагаагаар ард түмний түүх, уламжлал, зан заншил, соёл, хэл, олон зуун жилийн амьдралын хэв маягийг уландаа гишгэсэн харгис тоталитар дэглэм, үзэл суртлыг устгахад хүчин чармайлт гаргасан юм. Энэ тэмцэлд цагаач нийтлэлч Мустафа Шокайг үлгэрлэн дуурайж байв. Учир нь нэрт эрдэмтэн, уран илтгэгч, авьяаслаг нийтлэлч Мустафа цагаач байхдаа Туркстаны ард түмний амьдралыг дэлхий дахинд сурталчилсан сонин сэтгүүл зохион байгуулж, хэвлүүлэх ажилд идэвхтэй оролцож байжээ. Тэрээр Москва, Ташкент, Алматы, Оренбургт хэвлэгддэг большевикуудын сонин, сэтгүүлээс авсан тодорхой жишээ, тоо баримтад тулгуурласан Зөвлөлт Орос ба Төв Азийн тухай гүн гүнзгий агуулгатай өгүүлүүд, онолын судалгаа, түүхэн болон улс төрийн тоймыг Истанбул, Парис, Берлин, Лондон, Варшав зэрэг хотуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олны хүртээл болгож байв. Гэсэн хэдий ч түүний санаа сэтгэл өөрийн гардан гаргаж байсан Истанбул дахь “Шинэ Туркстан”, Берлин дэх “Залуу Туркстан” сэтгүүлд төвлөрч, Лондонд англи хэлээр, Парист франц хэлээр, Варшавт польш хэлээр хэвлэгддэг байсан Оросын эзэн хааны нийгэмлэгийн “Азийн тойм” сэтгүүлийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж байв. “Ийнхүү тэрээр Барууны орнууд төдийгүй Турк, Хятад, Америкт байсан цагаачдынхаа нэрт удирдагч болсон юм” гэж нэрт зохиолч А.Алимжанов бичсэн байдаг.

“Эрх чөлөө” радиогийн сэтгүүлчид өөрсдийн оюун санааны удирдагч Мустафа Шокайгийн үлгэр жишээг даган дуурайж, зөвхөн баримтад тулгуурласан нэвтрүүлгүүдээ дэлхий даяар түгээж байсан түүхтэй юм.

“Эрх чөлөө” радиогийн цагаачдаас эхэлж, урт удаан хугацаанд үргэлжилсэн эдгээр сэтгүүлчдийн бүтээлийг онцлон тэмдэглэх бидний зорилго бол гадаадад байсан ч сайн үйлсийн анхдагч нь байсан, радио станцыг анхнаас нь удирдаж, дэлхийн мэдээллийн системийн эгнээнд нэгдсэн сэхээтнүүдийн тухай шинэ үзэл бодлыг төлөвшүүлэх, эх орон нэгтнүүдийг ардын дайсан гэж үздэг байсан нь Зөвлөлт засгийн эзэнт гүрний үзэл суртлын үр дүн байсныг, Эх орноосоо хол байсан ч тэдний нэг нь ч үндэстнийхээ дайсан байгаагүй, “Алаш”-ийн сайн сайхны төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж явсныг бодит мэдээлэл баримтуудаар нотлох, олон нийтэд итгэл үнэмшил төрүүлэхэд оршино. Бидний бүтээл, хичээл зүтгэл бага ч гэсэн хувь нэмэр оруулж чадах юм бол бидний эрхэм зорилго биелэгдсэн хэрэг болох юм.

“Эрх чөлөө” радиогийн 70 гаруй жилийн турш цацсан нэвтрүүлэг нь казахын сэтгүүл зүйн санг баяжуулж, ирээдүйд цөөнгүй судалгааны үндэс байх болно. Цаг хугацаа өнгөрөх тусам түүний түүх, утга зохиол, соёлын ач холбогдол өнөөдрийнхөөс ч илүү байх болно гэдэгт бид итгэлтэй байна.

**Алаш- нам, гишүүдийн уриа, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчид*

Эшлэл

- Вачнадзе, Г.Н. (1975). *Антенны направлены на Восток* (с. 117). Москва.
- Бережкова, С.Б. (1993). “Железный занавес” был звукоприемником. *Вестник МГУ*, сер. 10(2), 54.
- Оралтай, Х. (1991). *Алашчууд. Азат*, (21). (казах хэл дээр)
- Канатбайн үхлийн тухай. (1982, 25 ноября). *Эрх чөлөө* радио. (казах хэл дээр)
- Козыбаев, С.К. (1986). *Ядовитые стрелы* (с. 36). Алма-Ата: Казахстан.
- Бакенова, Р.Ш. (2024). “Залуу Туркстан” сэтгүүл дэх М. Шокайн нийтлэл. *Л.Н. Гумилевын нэрэмжит Евразийн үндэсний ИС, Журналистика цуврал*, (1(146)), 160. (казах хэл дээр)
- Шилкин, А. (1976). *Диверсия без динамита* (с. 117). Москва.
- Абдуллин, Х. (1993). *Мустафа ба Магжан- Туран улсын суут ухаантнууд* (с. 111). Алматы: Жазушы. (казах хэл дээр)
- Таж-Мұрат, М. (2024, 26 июля). Зохиолч Мауликеш Кайбалдины тухай. *Уран зохиол* портал сайт. Алматы. (казах хэл дээр)
- Асанкайгы. (1967, 3 декабря). Казахын улс төрийн уянгын яруу найраг. *Эрх чөлөө* радио. Мюнхен. (казах хэл дээр)
- Асанкайгы. (1967, 21 декабря). Казах романы тухай. *Эрх чөлөө* радио. Мюнхен. (казах хэл дээр)
- Террорист XX века. (1991). *Новое время*, (45), 27.
- Тагиберли, Д. (1959, 27 декабря). Мустафа Чокайоглы – борец за свободу и независимость Туркстана (К 18-ой годовщине со дня смерти). *Радио Свобода*. Мюнхен.
- Тагиберли, Д., & Бердимурат, А. (1960, 8 мая). Советское радио – рупор диктатуры. *Радио Свобода*. Мюнхен.
- Патрик фон цур Мюлен. (1971). *Между свастикой и советской звездой (О Туркстанском легионе)*. Дюссельдорф.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Абдуллин, Х. (1993). *Мустафа ба Магжан- Туран улсын суут ухаантнууд*. Алматы: Жазушы. (казах хэл дээр)
- Арбатов, Г.А. (1970). *Идеологическая борьба в современных международных отношениях: Доктрина, методы и организация внешнеполитической пропаганды империализма*. Москва.
- Асанкайгы. (1967, 3 декабря). *Казахын улс төрийн уянгын яруу найраг. Эрх чөлөө радио*. Мюнхен. (казах хэл дээр)
- Асанкайгы. (1967, 21 декабря). *Казах романы тухай. Эрх чөлөө радио*. Мюнхен. (казах хэл дээр)
- Бакенова, Р.Ш. (2024). “Залуу Туркстан” сэтгүүл дэх М. Шокайн нийтлэл. *Л.Н. Гумилевын нэрэмжит Евразийн үндэсний ИС, “Журналистика” цуврал*, 1(146), 160. (казах хэл дээр)
- Бережкова, С.Б. (1993). “Железный занавес” был звукоприемником. *Вестник МГУ*, сер. 10(2), 54.
- Вачнадзе, Г.Н. (1975). *Антенны направлены на Восток* (с. 117). Москва.
- Голядкин, Н.А. (1990). *Зарубежное иновещание*. Москва.
- Карелина, В.М. (1990). *Радиовещание за рубежом*. Москва.
- Кашлев, Ю.Б. (1988). *Информационный взрыв. Международный аспект*. Москва.
- Канатбайн үхлийн тухай. (1982, 25 ноября). *Эрх чөлөө* радио. (казах хэл дээр)

- Козыбаев, С.К. (1986). Ядовитые стрелы. Алматы: Казахстан.
- Нуриден, Р.Ш. (1997). Казах хэл дээр мэдээлэл түгээдэг гадаадын радионууд: Нэг сэдэвт зохиол. Алматы. (казах хэл дээр)
- Нуриден, Р.Ш. (2012). Олон улсын радио сэтгүүл зүй: Сурах бичиг. Алматы. (казах хэл дээр)
- Оралтай, Х. (1991). Алашчууд. Азат, №21. (казах хэл дээр)
- Панфилов, А.Ф. (1984). Радиовойна: история и современность. Москва.
- Патрик фон цур Мюлен. (1971). Между свастикой и советской звездой (О Туркестанском легионе). Дюссельдорф.
- Таж-Мурат, М. (2024, 26 июля). Зохиолч Мауликеш Кайбалдины тухай. Уран зохиол портал сайт. Алматы. (казах хэл дээр)
- Тагиберли, Д. (1959, 27 декабря). Мустафа Чокайоглы – борец за свободу и независимость Туркстана (К 18-ой годовщине со дня смерти). Радио Свобода. Мюнхен.
- Тагиберли, Д., & Бердимурат, А. (1960, 8 мая). Советское радио – рупор диктатуры. Радио Свобода. Мюнхен.
- Террорист XX века. (1991). Новое время, (45), 27.
- Шилкин, А. (1976). Диверсия без динамита. Москва.

Summary

During the 1,418-day World War II, which involved 60 countries and 120 million people, more than 1,366,000 people from Kazakhstan were drafted into the Soviet armed forces in connection with the mobilization carried out throughout the Soviet Union. Most of them died due to lack of preparation for war, fell into the hands of the Germans and became prisoners of war. Nazi Germany used the surviving prisoners of war for its own purposes and created legions. One of them was the Turkestan Legion. This committee also included young writers and poets who were prisoners of war and fell into the hands of Nazi Germany, and since the road to return to their homeland was closed, they became forced emigrants. Most of the second wave of emigrants settled in Germany (primarily in Munich, where there were many emigrant organizations) and America. Thus, the emigration that arose after World War II was replenished with prisoners. In addition, during those difficult times of World War II, writers and poets wrote valuable works, published newspapers and magazines for their publication, and worked on the radio. Although the war is over and 80 years have passed since Victory Day, this topic has still not been sufficiently studied. The article tells about the emigrants who worked for Radio Liberty, and analyzes and studies their work.

Keywords: World War II, legion, emigration, radio Liberty, radio broadcast

ОРЧИН ҮЕИЙН МАСС-МЕДИА: МЭДЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖ, ШААРДЛАГА

М.Зулькафилъ*

**МУИС-ийн эмерит профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)*

Түлхүүр үгс: Олон нийтийн харилцаа, масс-медиа, гейткипер, мэдээллийн үр нөлөө, чухал үйл явдал, драм, медиа-үйл явдал

Олон нийтийн харилцааны (коммуникаци) мөн чанар нь мэдээлэл дамжуулахад оршино. Дэлхийд энэ ойголтыг судлах оролдлого XX зууны 20-иод оноос эхэлсэн бөгөөд энэ нь нэг талаар, олон нийтийн харилцааны хэрэгслүүдийн эрчимтэй хөгжилтэй, нөгөө талаар ОНМХ чухам юу дамжуулах вэ гэдгийг тодруулах явдалтай холбоотой байв. Мэдээлэл гэж чухам юуг хэлэх вэ гэсэн асуудлын эргэн тойронд өрнөсөн маргаан медиагийн салбарынхны дунд жинхэнэ мэдээлэл гэдэг бол шинэ мэдээ мөн гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүрч, мэдээ гэдэг нь дэлхийд болон тухайн оронд болж буй сүүлийн үеийн чухал үйл явдлын тухай мэдээжийн баримтуудаас зарчмын хувьд эрс ялгаатай шинэ мэдээлэл мөн гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Нийгмийн хөгжлийг дагаад сэтгүүл зүй, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, тэр дундаа бичлэгийн төрөл зүйл, сэтгүүлчийн ур чадвар, мэдээллийн үйлдвэрлэлийн үйл явц байнга өөрчлөн шинэчлэгдсээр байна. ОНМХ-ийн хамгийн гол бүтээгдэхүүн болох мэдээг бүтээх үйл явц, түүний дотоод хэлбэр, тусгаж буй объект, үр нөлөөний асуудалд ч өөрөөр хандах болсон. Манай орны хувьд бичлэгийн төрөл, зүйлийн дотроос хамгийн сайн судлагдсан нь мэдээ гэж хэлж болно. Энэ сэдвээр доктор Ч.Чойсамба нэг сэдэвт зохиол бичиж эрдмийн зэрэг хамгаалж (6), сурах бичиг бичиж олны хүртээл болгосон (7) бол проф. Л.Норовсүрэн (5), М.Зулькафилъ (4), Т.Баасансүрэн (2) болон бусад судлаачдын (3, 6, 8) нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, судалгааны өгүүлэлд тодорхой хэмжээгээр тусгалаа олсон байдаг. Гэхдээ орчин үеийн медиагийн мэдээнд гарч буй зарим өөрчлөлт, үр нөлөөг дээшлүүлэх талаар бичигдсэн бүтээл ховор юм. Тиймээс энэхүү өгүүлэлд орчин үеийн медиагийн мэдээний зарим онцлог, түүний үр нөлөө тусгаж буй үйл явдлын онцлог шинжүүдээс шалтгаалах асуудал, үр нөлөөг дээшлүүлэх боломж, шаардлагын талаар тусгаж, дээрх орон зайг нөхөхөд зохих хувь нэмэр оруулах зорилго тавьсан юм. ОНМХ-ийн сүүлийн үеийн мэдээллийн хөтөлбөр, мэдээний боолт зэргийг судалгааны объект болгон авч, агуулгын дүн шинжилгээ, харьцуулан судлах, түүвэрлэн сонгох, түүхчлэн үзэх зэрэг сэтгүүл зүйн судалгаанд түгээмэл хэрэглэдэг зарим аргыг түлхүү хэрэглэхийг хичээсэн болно.

Орчин үеийн масс-медиагийн мэдээ гол байр эзэлдэг мэдээллийг олон нийт

бодит байдлын тусгал мөн гэж хүлээн авдаг нь түгээмэл. Гэхдээ энэ бодит байдал радио, телевизийн хөтөлбөр, өдөр тутмын сонин болон мэдээллийн сайтуудын дамжуулж буй мэдээлэлтэй харьцуулашгүй үй түмэн үйл явдал болж байдаг бодит ертөнцөөс эрс ялгаатай гэдэг нь тодорхой. Үүний тодорхой жишээ бол ердийн өдөр тутмын сонин мэдээллийн агентлагуудаас ирж буй шинэ мэдээллийн зөвхөн 25 хувийг л нийтэлдэг явдал юм (McCombs, 1997). Учир нь бид мэдээллийн хөтөлбөр болон сонины материалуудыг бэлтгэх явцад дэлгэц, эфирийн цаг, сонины зай талбай, тухайн ОНМХ-ийн нийтлэлийн бодлого зэрэг цөөнгүй хүчин зүйлийн үр дүнд боловсруулсан, шилж сонгож авсан мэдээллийг хүлээж авдаг. Өөрөөр хэлбэл, “Мэдээлэл бол ертөнцийн тодорхой нэг тоймыг л багтаадаг хүрээ” (Tuchman, 1987) төдий зүйл болж үлдэнэ. Мэдээллийг сонгон авч боловсруулах явцад хэрэглэж буй шүүлтүүрээс шалтгаалан бодит байдлын гажуудал ч гардаг нь энгийн үзэгдэл. Бодит байдлын агуулгыг хоёр, гурван минутад багтаах боломжгүй, жинхэнэ үйл явдал бол янз бүрийн зөрчлөөс, хурц өнцгүүдээс, сөрөг зүйлсээс бүрддэг. Телевиз бол үзэгчдийн мэдрэмжээр тоглох зорилгоор үйл явдлын бодит байдлыг гоёж чимдэг өгүүллэгчийн үүргийг түлхүү гүйцэтгэдэг. Үүний үр дүнд бодит ертөнцийн амар ч үйл явдал ер бусын, сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц байлаа ч урьдчилж бэлтгэсэн хэлбэрт шахагдах нь тодорхой.

Өнгөрсөн зууны 40-өөд оны үед Г.Лассуэл “gate-keeping” (гейткипер-хаалга сахигч)-ийн үйл явц болон радиогийн редакторуудын буюу “хянагч”-дын талаар хийсэн судалгааг эс тооцвол 70-аад оны дунд үе хүртэл олон нийтийн харилцааны мэдээллийн үйлдвэрлэлийн асуудал бага судлагдсан байдаг. Харин судлаач Д.Уайт энэ асуудлыг тусгайлан судалж мэдээллийн үйлдвэрлэлийн үйл явцад “мэдээллийг цуглуулагчид” (newsgatherers) ба “мэдээллийг боловсруулагчид” (news processors) гэсэн хоёр бүлэг хүмүүс оролцогчийг тодорхойлжээ (White, 1950). Нэг дэх нь мэдээллийг цуглуулж, бичдэг сэтгүүлч сурвалжлагчид бол хоёр дахь нь эх бичвэрийг хянан боловсруулдаг уран бүтээлчид юм. Мөн хоёр дахь бүлэгт тухайн мэдээллийг эфирт гаргах, сонинд нийтлэх эсэхийг шийддэг “хянагчид” буюу “гейткипер”-үүд багтдаг байна.

Дараа дараагийн бүтээлүүдэд гейткиперүүд шийдвэр гаргахад нөлөөлдөг тэдний мэргэжлийн ур чадвар, өвөрмөц сэтгэлгээ, тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын ажлын дүрэм журам, бичигдээгүй хэм хэмжээ, мэдээллийг хянан шалгахад цаг хугацаа хүрэлцэхгүй байх, хууль зөрчиж магадгүй гэсэн айдас, ашиг орлогын төлөө зүтгэх зэрэг маш их хүчин зүйлийн тухай цөөнгүй судалгааны бүтээл гарсан бөгөөд тэд Д.Уайт сэтгүүлчид зөвхөн баримт цуглуулагчид төдийгүй болж байгаа үйл явдлыг бодитой тусгагчид гэдгийг дутуу үнэлсэн гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Сүүлийн үед гарсан зарим бүтээлд гейткиперүүдийн үүргийг тодорхойлохдоо мэдээллийг боловсруулах бодит үйл явцыг хэт хялбаршуулан үзүүлэх хандлага ажиглагдах болсон. Тухайлбал, ВВС-д олон жил ажиллаж, тулгамдсан асуудлыг редакц дотроо сайн мэддэг С.Худ ихэнх медиагийн байгууллагуудад гейткипер гэдэг нь нэг талаар, тухайн үйл явцад оролцогчдын мэргэжлийн үйл ажиллагааны салшгүй хэсэг, нөгөө талаар төрөлжсөн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг төдий идэвхгүй ажиллагаа гэж үзээд энэ бол “...тухайн өдрийн сэдвийг тодорхойлдог ахлах редактор, зураг авах хэсэгт заавар зөвлөгөө өгч, ажил үүргийг хуваарилдаг эрхлэгч, мөн нэвтрүүлэгт оруулах киноматериалуудыг сонгодог киноредактор, эх бичвэрийг бэлтгэдэг уран бүтээлч, нэвтрүүлгийн бүтцийг хянаж, мэдээллийн дарааллыг тогтоож, түүнийг эцсийн хэлбэрт оруулдаг жижүүр редактор” (Hood, 1972) гэсэн байдаг. Үүнээс Барууны сэтгүүл зүйд гейткиперийг бидний ойлголтоос

хамаагүй өргөн хүрээнд авч үздгийг ажиглаж болно.

Ер нь ОНХМ-ийн практикаас үзэхэд сэтгүүлчид юуны тухай бичиж байгаад хэт өнгөцхөн хардаад өнгөрдөг нь мэдрэгддэг. Орчин үеийн ХМХ дэх мэдээллийн ихэнх хэсгийг мэдээллийн агентлаг, янз бүрийн албан байгууллагууд, албаны хүмүүс, хэвлэлийн төлөөлөгчид зэрэг хоёдогч эх сурвалжагчаас авсан байдаг. Сэтгүүлчид тэднийг боловсруулж, тодорхой хэлбэрт оруулж, нийтлэхэд бэлэн болгох буюу “худалдаанд гаргах” бэлтгэлээ хангадаг. Ийм маягаар зөвхөн гейткиперүүдээс гадна сэтгүүлчид өөрсдөө мэдээллийг боловсруулж, шүүн тунгаадаг. Үүний үр дүнд мэдээллийг боловсруулах үе шат болгонд мэдээ өөрийнхөө нүүр царайг, заримдаа агуулгыг өөрчилж тухайн ХМХ-ийн үзэл суртал, арилжааны эсвэл өөр зорилгоосоо шалтгаалан олон нийтэд дахин боловсруулагдсан, бодлого зорилгод нийцсэн, заримдаа бүр мушгин гуйвуулсан байдалтай хүрдэг нь түгээмэл. Мэдээллийг үйлдвэрлэх үйл явцын дээр дурдсан бүх шинжүүд нь нийлээд бодит байдлын тухай мэдээлэл болох бөгөөд үүнийг уламжлал ёсоор ОНМХ-ийн хамгийн гол үүрэг гэж үздэг. Ийм мэдээллийн үнэ цэнэ нь үнэн бодитой, товч тодорхой байх явдал юм. Медиагийн бусад бичлэгийн төрөл, зүйлийн хувьд мэдээллийн бүтээгдэхүүний зохиомол, хиймэл шинж нь улам тод ажиглагддаг.

ОНМХ-ийн үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтын зөвхөн нэг л талыг товчхон авч үзэхдээ медиа үйлдвэрлэлийн зохион байгуулалтын үндэс хэр зэрэг чухал гэдгийг амархан ажиглаж болно. Учир нь мэдээллийн бүтээгдэхүүний эцсийн шинж чанар нь энэ хүчин зүйлээр тодорхойлогддог, чухам үүнд тухайн ХМХ үйл ажиллагаа явуулж буй нийгэм -улс төрийн шинжтэй олон тооны, олон янзын гадаад нөлөөлөл тусгалаа олдог. Гэхдээ энэ бүхэн нь тухайн мэдээллийн тусгаж буй үйл явдлын хэв маяг, үндсэн ба хоёрдогч шинж чанарыг агуулсан эсэхээсээ шууд шалтгалдаг. Одоо энэ талаар өгүүлье.

Мэдээж аливаа мэдээллийн үр нөлөө, нөлөөлөх чадвар нь юу бичиж байгаагаас ихээхэн шалтгаална. Өдөр тутмын шинэ мэдээллийн хөтөлбөрийн гол зорилго нь аль болох нийгмийн ач холбогдолтой, чухал үйл явдлын талаар шуурхай мэдээлэхэд оршино. Тэгвэл чухам ямар үйл явдлыг чухал ач холбогдолтой гэж тодорхойлох вэ? Чухал мэдээ болохын тулд тухайн үйл явдал наад зах нь таван гол шинжийг агуулсан байх ёстой. Чухал мэдээ болж байгаа үйл явдал болгон тэр таван шинжийн бүгдийг нэгэн зэрэг агуулахгүй байж болох ч дор хаяж хоёр, гурвыг зайлшгүй агуулж байж мэдээллийн хөтөлбөрийн үндэс суурь нь болох учиртай. Тийм гол шинж нь их байх тусам үйл явдал ОНМХ-ийн анхаарлыг татна, бас олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх магадлал өндөр байдаг.

Нэгдүгээрт, аливаа чухал мэдээнд *гол баатар* байх ёстой. Тийм баатар байх нь үзэгч өөртэй харьцуулж үзэх замаар нэлээд төвөгтэй, зөрчилтэй мэдээллийг бүрэн хүлээж авах боломж бүрддэг. Нэг үе гэрэл зургийн сурвалжилга болон ярилцлагад үр дүнтэй гэдгийг баталж чадсан энэ аргыг сүүлийн үед мэдээнд өргөн хэрэглэдэг болсон. Харамсалтай нь манай телевизийн зарим мэдээнд гол баатрыг хоёрдугаар байранд тавьж, тухайн үйл явдлын ерөнхий дүр зургийг голлон гаргахыг оролдох, эсвэл хэд хэдэн эх сурвалжийн яриаг хэт нурууу өгч үзэгчдийг залхаадаг явдал түгээмэл ажиглагддаг. Үүнээс болж чухал үйл явдлыг хэт хялбаршуулах, ойлгомжгүй болгох, сэтгүүлчийн өөрийн үзэл бодол давамгайлах, өрөөсгөл дүгнэлт хийхэд хүргэдэг.

Хоёрдугаарт, үйл явдалд *драм, сонирхол, үзэл бодлын тэмцэл* байх учиртай. Бид тухайн мөчид үзэж буй нэвтрүүлгийн агуулгаас үл хамааран телевиз бол

үзэгчийг хөгжөөх, зугацуулах зорилготой гэсэн уламжлалт ойлголтоос одоо хүртэл салж чадаагүй байна (Zillmann, 1991) гэсэн судаачийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үзэгчдийн хувьд УИХ дахь маргаан мэтгэлцээний тухай сурвалжилгаас Сүхбаатарын талбай дахь жагсагчдыг цагдаа нар хөөж, хүчээр тараахыг оролдож буй мэдээ бол хамаагүй сонирхолтой, илүү үр нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ зөрчилдөж буй талуудын тэмцэлд хэт их анхаарал хандуулах нь янз бүрийн үзэл бодлыг харуулах эерэг талтай боловч зөрчил, хүчэрхийллийг хэтрүүлэн мэдээлэх сөрөг талтай. Энэ нь зарим тохиолдолд хүлээн авагчдад үзэж буй хүчэрхийлэл нь хэвийн үзэгдэл мэт буруу төсөөлөл төрүүлдэг. Манай сэтгүүлчид ийм драм, зөрчилтэй үйл явдлыг зөв сонгож чадаагүйн улмаас эдийн засаг, эрүүл мэнд, боловсролын гэх мэт чухал асуудлуудыг сонирхолгүй, нуршуу, ойлгомжгүй, тойм төдий мэдээлэлэх явдал түгээмэл юм. Үүнийг бид МҮОНРТ-ээс эхлээд арилжааны аль ч телевизээс ажиглаж болно.

Гуравдугаарт, чухал үйл явдал *идэвхтэй үйлдлийг* агуулсан байх ёстой. Энэ онцлог шинжийг нэлээд хийсвэр агуулга бүхий мэдээллийг өлгөсөн “дэгээг” ашиглах аргаар харуулж болдог. Тухайлбал, инфлац өссөнийг худалдан авагчдын үнийн өсөлтийн талаарх өөрсдийн үзэл бодлыг илэрхийлсэн цуврал сурвалжилгыг дэлгүүрүүдээс бэлтгэх замаар үзүүлж болно. Ийм “дэгээг” ашиглах боломжгүй чухал үйл явдалд сэтгүүлчид харьцангуй бага анхаардаг нь ажиглагддаг. Тухайлбал, сүүлийн тавин жилд ихэнх оронд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн эрс багасч, Барууны орнуудаас импортоор авах нь нэмэгдсэн. Энэ бол олон орны хувьд тулгамдсан асуудал болсоор байна. Үүнд сэтгүүлчид маш бага анхаардаг. Энэ нь “дэгээ”-гийн үүргийг гүйцэтгэж чадахуйц тодорхой үйл явдлыг олж чадахгүй байгаатай холбоотой юм.

Хэрэв үйл явдал дээр дурдсан гурван шинжийг агуулж буй нөхцөлд телемэдээнд чухал материал болох нь тодорхой. Учир нь дэлгэцэнд товч агуулга бүхий дуу дүрс бүхий хэсэг (sound bites) маягаар өгөх боломжтой. Мэдээллийн хөтөлбөрийн дүрст өгүүлэмж нь маш богинохон хугацаанд багтах ёстой. Энэ бол бичигдээгүй хууль. Тийм учраас багагүй цаг хугацаа шаарддаг үйл явдлыг мэдээллийн хөтөлбөрт оруулах нь харьцангуй ховор үзэгдэл. Дэлхийн телевизийн туршлагаас үзэхэд телемэдээний дүрст өгүүлэмжийн хэсгүүдийн үргэлжлэх хугацаа нь тогтмол багасч байна. Тухайлбал, 1968 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай мэдээний дүрст өгүүлэмжийн үргэлжлэх хугацаа нь 43 секунд байсан бол 1988 онд ердөө 8 секунд болж багассан байдаг. Харин манайд эсрэгээр мэдээний үргэлжлэх хугацаа нь нэмэгдэх хандлагатай байна. Зарим телевизийн мэдээ 10-12 минут үргэлжлэх нь энгийн үзэгдэл юм.

Дөрөвдүгээрт, үйл явдлын *шинэлэг тал*, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн *хэм хэмжээнээс гажих* явдал юм. Гэхдээ онцгой мэдээллийн ихэнх мэдээ нь гэнэтийн биш байдаг нь түгээмэл. Тухайлбал, улс төр, эдийн засгийн мэдээллийн ихэнхийг чухал хурал цуглааны үед хэлэх үг, ярианы өнгө аяс, гарах шийдвэрийн талаар баримжаагаар мэддэг туршлагатай сэтгүүлчид тайлбарладаг. Урьдчилж төсөөлж байсан хүрээнд багтаагүй мэдээ бол сэтгүүлчдийн анхаарлыг илүү ихээр татах болно. Хэрэв үйл явдал жирийн бус байх тусмаа тийм боломж эрс нэмэгддэг. Тухайлбал, цахилгаан мотоциклийн машинтай мөргөлдсөний улмаас амь эрсдэсэн хүний тухай бүх ХМХ-ийн анхаарлыг татах мэдээ биш бол хар тамхи хэрэглэж мансуурсан үед энгийн иргэдийг хутагласнаас хүний амь эрсдэсэн үйл явдал бараг бүх телевизийн мэдээллийн хөтөлбөрийн “хадаас” мэдээ болох нь тодорхой.

“Энгийн хэм хэмжээнээс халих” гэдэг ойлголтыг тухайн үйл явдалтай

холбогдуулан янз бүрээр тодорхойлж болно. Тоон үзүүлэлтийн үүднээс хандвал аливаа үйл явдлын давтамжтай холбоотой бөгөөд ингэхдээ маш ховор тохиолддог үйл явдал бол хэм хэмжээнээс гажсан шинж болох юм. Ердийн хэм хэмжээний үүднээс хандвал үйл явдлыг оролцогч нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн болон хууль эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг харгалзан авч үздэг. Мөн үйл явдлын гол баатар нь оршиж буй нийгмийн тогтолцоог хорлон сүйтгэх зорилго агуулж байвал бас л хэм хэмжээнээс хальсан үйлдэл болдог. Тийм учраас судлаачдын тодорхойлсноор ердийн хэм хэмжээний үүднээс хандах нь тоон үзүүлэлтийн хандлагатай харьцуулахад аливаа үйл явдал хэм хэмжээнээс хэр зэрэг хальсныг үнэн зөв үнэлэх боломж олгодог (Pritchard, 1997) давуу талтай юм.

Чухал үйл явдлын сүүлчийн буюу тав дахь үндсэн шинж бол тухайн үед ОНМХ-үүдийн анхаарлын төвд байгаа, өөрөөр хэлбэл аль хэдийн тухайн цаг үеийн хөтөлбөр болж хувирсан *сэдвүүдтэй холбогдох* боломж юм. Энэ сэдвүүдийн заримыг нь мөнхийн сэдвийн хүрээнд багтааж болно. Хүний уг мөн чанарын болон түүний гадаад илрэлүүдийн хоорондох мөнхийн зөрчил утга зохиолын, тэр дундаа жүжгийн цөөнгүй гайхамшигт бүтээл төрөхөд нөлөөлснийг бид мэднэ. ОНМХ-ийн хувьд ийм сэдвийг шуугиан дэгдээсэн луйварын гэмт хэрэг, эрх мэдэлтнүүдийн ёс зүйн доголдлын тухай мэдээллүүд гүйцэтгэдэг гэж хэлж болно. Үүний тод жишээ бол АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоныг огцруулахад хүргэсэн 1972-1974 оны алдарт Уторгейтийн, мөн Моникагийн хэрэг, манайд бол 1990 -ээд оны үеийн “Баатаргейт”-ийн хэрэг, сүүлийн үеийн нүүрсний, ногоон автобусны хэрэг зэрэг цөөнгүй сэдэв юм. Энэхүү илчлэн шүүмжилсэн мэдээ материалуудаас үүссэн нийгмийн сэтгэл зүйн давалгаа нь эдгээр хүмүүсийн үйлдэл нь хүний жам ёсны мөн чанарт болон ёс зүйн ердийн хэм хэмжээнд үл тохирсон явдалтай шууд холбоотой байсан түүхтэй. Гэхдээ энд шуугиан дэгдээсэн шүүмжлэл нийгмийн чухал үйл явдал, асуудлуудаас олон нийтийн анхаарлыг хөндийрүүлэхэд нөлөөлөх, төөрөгдүүлэхэд хүргэдэг сул талтай гэдгийг мартаж болохгүй.

Өөр нэг мөнхийн сэдэв бол эрх мэдэлтнүүд ба энгийн иргэдийн хоорондох сөргөлдөөн бөгөөд энэ нь мэдээллийн байнгын эх сурвалж болох нь түгээмэл юм. Мэдээний байнгын сэдвийн нэг бол ёс суртахууны асуудалтай холбон үздэг сайн ба муугийн хоорондох тэмцэл байдаг. Тухайлбал, хүрээлж буй орчныг цэвэр байлгахын төлөө “сайн” тэмцэгч ба байгаль орчныг бохирдуулдаг “муу” үйлдвэр г.м. Мөн төр засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чадваргүй байгааг, муу удирдагчаас болж төрийн өмчит компаниуд дампуурч байгааг шүүмжилсэн үр ашиг ба үр ашиггүй байдлыг харьцуулах аргыг ашигласан мэдээ ч цөөнгүй. Дээр дурдсан мөнхийн сэдвүүдээс гадна ОНМХ нарийн тооцсон тодорхой хугацааны дараа анхаарлаа тогтмол хандуулж байдаг сэдвүүд байдаг. Үүнийг гол төлөв мөчлөгт, хуанлит сэдэв гэж нэрлэдэг. Тухайлбал, тухайн орны Ерөнхийлөгчийн шинэ жилийн мэндчилгээ, цагаан сар, наадмын үйл явдал, зарим оронд хавар болгон торнадо хуй сахинаас хамгаалах тухай асуудал, манайд хаврын шар усны үер, өвлийн болон шинэ хичээлийн жилийн бэлтгэл зэрэг сэдвийг нэрлэж болно. Ийм үйл явдал мэдээллийн хөтөлбөрт тодорхой байр эзлэх нь тодорхой. Учир нь тийм үйл явдлууд байгалийн давтамж, хүмүүсийн зан үйл, төр засгаас авах уламжлалт арга хэмжээтэй холбоотой учраас мэдээллийн хөтөлбөрт тусгалаа олдог. ОНМХ-ийн анхаарлыг татахуйц чухал үйл явдлын үндсэн шинжүүдийг агуулаагүй боловч мэдээллийн хөтөлбөрт тодорхой байр эзэлдэг нь үүнтэй холбоотой юм.

Бидний дээр урдсан чухал үйл явдлын үндсэн таван шинжээс гадна ОНМХ-ийн анхаарлыг татахуйц прагматик өвөрмөц шинжүүдийг агуулсан үзэгдэл, баримтууд

байдаг.

Нэгдүгээрт, мэдээ хэнийг ч *гутаан доромжлох, хэн нэгний сэтгэлийг шархлуулах* ёсгүй, өөрөөр хэлбэл энгийн ёс журмын хэм хэмжээнд нийцсэн байх ёстой. Үүнийг манай сэтгүүл зүй дэх нэлээд газар авсан дутагдал гэж хэлж болно. Хүүхдийн зургийг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй нийтлэх, хэн нэгнийг тавлах, далд утгаар доромжлох, хүний ор хөнжлийн асуудал, хувийн нууц руу орох зэрэг сэтгүүл зүйн энгийн зарчим, шаардлагыг зөрчсөн мэдээ мэдээлэл түгээмэл байна. Үүнийг ямар ч ХМХ-ээс олж болно. Гэхдээ энд нэг зүйлийг анхаарах шаардлагатай. Энэ хэм хэмжээг хэт сахих гээд оролдох нь шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудын талаар олон нийтэд цаг алдалгүй мэдээлэхэд саад болох тохиолдол гардаг. Үүний тодорхой нэг жишээ бол 1980-аад оны эхэнд АНУ болон Барууны зарим оронд өргөн дэлгэрсэн ДОХ-ын халдварын асуудалд ОНМХ-үүд хэт хайнга хандсан явдал юм. Үүний учир нь тухайн үед энэ халдварыг тараасан хамгийн түгээмэл үйлдэл болох шулуун гэдсээр бэлгийн харьцаанд орох явдлыг дурдахгүй өнгөрөхийг хичээж байсантай хобоотой байжээ (Meuer, 1996).

Хоёрдугаарт, үйл явдлын тухай мэдээ мэдээлэл, сурвалжилга түүнд *яв цав тохирсон, итгэл үнэмшил төрүүлэх* чадвартай байх ёстой. Харамсалтай нь эргэлзээ төрүүлэхүйц, итгэхэд бэрх цуурхлын шинжтэй баримт агуулсан мэдээ, сурвалжилга түгээмэл биш юмаа гэхэд хааяа тааралддаг нь үнэн. Тийм шаардлага янз бүрийн хов живийн шинжтэй цуурхал, сенсацын үнэн худлыг тодруулахад эерэг нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой. Гэхдээ зарим тохиолдолд ХМХ өөрийн хяналтын нөлөөгөөр олон нийт зайлшгүй мэдэх ёстой чухал зүйлийн тухай мэдээлэхгүй өнгөрөх нь түгээмэл юм. Тухайлбал, нөлөө бүхий улс төрч, эрх мэдэлтний авилгатай холбоотой эсэх, эсвэл ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудалд болгоомжтой хандах, үр дагвараас нь айх зэргийг хэлж болно.

Гуравдугаарт, тухайн үйл явдлын талаар маш *товч, тодорхой ярих*, өөрөөр хэлбэл телевизийн мэдээний 45 секундэд, сонины товч мэдээнд багтах боломжтой байх ёстой. Гэхдээ өөрийнхөө ажлын талаар хүлээн авгчдад дэлгэрэнгүй мэдээлэхийг хүсэгчид, тэр дундаа эрдэмтэн судлаачид, улстөрчид, баялаг бүтээгчид мэдээний товч тодорхой байх шинжийг дутуу үнэлэх явдал бий. Мэдээний товч тодорхой байх шинж нь телевизээс үүсэлтэй гэж үздэг боловч үнэн хэрэг дээрээ масс-медиа бий болохоос өмнө түүхэн хүмүүсийн олны хүртээл болж, олон нийтийн ой санамжид хадаглагдан үлдсэн алдарт хэллэгийн үндсэн шинж байжээ. Үүний тод жишээ бол IV Людовикийн “Төр бол Би”, Юлий Цезарийн “Ирлээ, харлаа, яллаа”, орчин үеийн жишээ болгон Рональд Рейганы “Хар тамхичдад зүгээр л “Үгүй” гэж хэл” зэрэг үг юм.

Хэрэв телемэдээний гол онцлог нь товч, тодорхой байх шинж (үйл явдлыг газар дээрээс нь сурвалжилсан мэдээний дээд хэмжээ нэг минутаас хэтрэх ёсгүй) бол бусад ХМХ-үүд үгүйлэгдэж буй тухайн цаг мөчийн мэдрэмжийг нөхөхийн тулд үйл явдалд нэмэлт дүн шинжилгээ хийх замаар мэдээлэх өөр хувилбарын стратегийг хэрэглэдэг. Судлаачийн сүүлийн 100 жилийн туршид тогтмол хэвлэлийн мэдээнээс бусад бүх нийтлэлийн хэмжээ нь томорч, хоосон баримт тоочих, нуршуу тайлбар, тойм голлох болсон (Barnhurst, 1976) гэж дүгнэсэн нь манай сонин, сэтгүүлүүдэд ч хамаатай юм.

Чухал үйл явдлын сүүлчийн хоёрдугаар зэргийн шинж бол түүний үр дагаврын ХМХ-ийн хүлээн авагчдад *нөлөөлөх боломж, нөлөөллийн хэмжээ* юм. Хэрэв аймгийн радио, телевиз нийт үндэсний эсвэл дэлхий дахины ач холбогдолтой

мэдээлэл дамжуулсан тохиолдолд орон нутгийн сонсогчдын сонирхол ба энэ үйл явдлын хооронд ямар нэг холбоо тогтоох магадлал тун бага. Тухайлбал, Афганистан эсвэл Иракт босогчдод барьцаалагдсан орон нутгийн иргэдийн тухай, эсвэл Пакистаны эдийн засгийн буруу бодлогоос болж орон нутгийн нэгэн үйлдвэр хаагдсан тухай мэдээлэл орон нутгийн сонсогчдод чухал биш гэдэг нь тодорхой. Харин улс орны үндэсний эрх ашгийг хөндсөн, тухайлбал УИХ-ын чуулган дээр нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах талаарх маргаан мэтгэлцээн, эсвэл олон улсын зэвсэгт бослого болж буй бүс нутагт цэрэг явуулах талаарх Засгийн газрын шийдвэрийн талаарх мэдээ орон нутгийн цөөнгүй уншигчийн сэтгэл зүйд нөлөөлөх нь дамжиггүй.

Судалгаанаас үзэхэд хүлээн авагчдын анхаарлыг татах, тодорхой нөлөө үзүүлэх хамгийн найдвартай арга бол тусгаж буй үйл явдлын тухай мэдээнд чухал үйлд явдлын үндсэн болон хоёрдугаар зэргийн шинжүүдийн бүгд, эсвэл тодорхой хэсэг нь байгаа эсэхийг тод харуулах явдал юм. Тийм шинжийн тоо нь их байх тусам тухайн үйл явдал ХМХ-ийн ч, хүлээн авагчдын ч анхаарлыг татах болно. Үүнийг сэтгүүл зүйн онолд өргөн утгаар нь *мэдээний үр нөлөөний асуудал* гэж ойлгодог юм.

Үйл явдлын шинжүүдийг ийм маягаар эрэмблэхийн арга зүйн ач холбогдол нь сэтгүүлчийн практик ажилд чухал үүртэй гэж үздэг. Учир нь сэтгүүлч дээр дурдсан шинжүүдийн тусламжтайгаар хүлээн авагчдад тийм үйл явдал чухал мэдээ болохыг тодорхой харуулж чадна. Чухал үйл явдлын дээрх шинжүүдийг амжилттай хэрэглэж чадсны жишээ бол 2022 онд Олимпын аварга, МУ-ын хөдөлмөрийн баатар, нэрт тамирчин Н.Түвшинбаярын согтууруулах ундаа хэрэглэсэн үед найз Э.Энхбатын амь насыг хохироосон хэргийн талаарх мэдээллүүд юм. Энэ нь чухал үйл явдлын бараг бүх гол шинжийг агуулж чадснаараа онцлогтой. Анхаарлын төвд урьд олон нийтийн хайр хүндэтгэлийг хүлээж байсан одоо ноцтой гэмт хэрэгтэн болсон хүн учраас сэтгүүлчид сайн ба муу, хувь хүн ба жинхэнэ мөн чанар зэрэг мөнхийн сэдвүүдийг ашиглаж чадсан нь олон нийтийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлсөн.

Заримдаа ОНМХ-үүд мэдээний ямар ч гол шинжүүдийг хангаж чадахааргүй үйл явдлын талаар өгүүлж, түүнийг янз бүрийн нөхцөл байдалтай холбох замаар олон нийтийн анхаарлыг татаж чухал мэдээний хэмжээнд хүргэхийг оролддог. Үүнийг *медиа-үйл явдал* эсвэл зохиомол үйл явдал гэж нэрлэдэг. Медиа-үйл явдал гэдэг нь нэг ёсны савангийн хөөс, сүр бадруулсан шинжтэй боловч ач холбогдол багатай, гол төлөв ХМХ-ийн анхаарлыг татахын тулд тусгайлан зохион байгуулдаг улс төрийн үйл явдал байдаг бөгөөд дараа нь тэд үүнийг хөөрөгдөж, зарим тохиолдолд сенсаац болгохыг эрмэлздэг (Американа, 1996). Ийм зохиомол үйл явдлын гол шинж нь ХМХ бүрт тусгайлан зориулсан медиа-форматын хүрээнд бүтээсэн хэвшмэл загвар бөгөөд тэдний тусламжтайгаар мэдээллийн хөтөлбөрийг бүтээдэг. Ийм мэдээ үр дүнд хүрч, олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх нь тун ховор. Энэ аргыг эзэмших нь сэтгүүлчийн практик үйл ажиллагааны дэг журмын алгоритмын нэгэн адил медиа-үйл явдлуудыг амархан бүтээхэд нөлөөлдөг. Манай ОНМХ-д сонирхолгүй, улиг болсон хэдэн сэдвийн хүрээнд эргэлдсэн, пиарын болон сурталчилгааны шинжтэй мэдээ, мэдээлэл элбэг байгаа нь чухам үүнтэй холбоотой юм. Ер нь сэтгүүл зүйн практикт олон нийтийн анхаарлыг татахын тулд ач холбогдол багатай үйл явдалд зохиомол өнгө аяс, дүр төрх оруулж сүржин мэдээ болгох тохиолдол манай аль ч ХМХ-д түгээмэл тааралддаг.

Энэ бүхнийг дүгнэж хэлэхэд мэдээний үр нөлөө гэдэг нь зөвхөн сэтгүүлчийн

уран чадвар, тухайн ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, менежментээс гадна сэтгүүлчийн сонгож авсан объект нь чухал үйл явдлын үндсэн болон хоёрдугаар зэргийн шинжүүдийг хангаж байгаа эсэхээс шууд шалтгаална. Тиймээс манай ОНМХ-үүд медиа-үйл явдал гэж нэрлэгддэг зохиомол үйл явдлаас зайлсхийж, аль болох бичих объектэд бүтээлч сэтгэлгээгээр хандаж, зөв сонголт хийх нь мэдээний үр нөлөөг дээшлүүлэх чухал арга болох юм. Үүнд сэтгүүлчийн практик, туршлагаас гадна сэтгүүл зүйн суурь болон онолын мэдлэг чухал үүрэгтэй гэдгийг мартаж болохгүй.

Эшлэл

- McCombs, M. E., Shaw, D. L., & Weaver, D. (Eds.). (1997). *Communication and democracy: Exploring the intellectual frontiers in agenda-setting theory*. Mahwah, NJ: Lawrence Erlbaum Associates.
- Tuchman, G. (1987). Mass media values. In A. A. Berger (Ed.), *Television in society*. New Brunswick, NJ: Transaction Books.
- White, D. (1950). The gatekeepers: A case study in the selection of news. *Journalism Quarterly*, 27.
- Hood, S. (1972). The politics of television. In D. McQuail (Ed.), *Sociology of mass communications*. Harmondsworth.
- Zillmann, D. (1991). Television viewing and physiological arousal. In J. Bryant & D. Zillmann (Eds.), *Responding to the screen: Reception and reaction processes*. Hillsdale, NJ: Lawrence Erlbaum Associates.
- Pritchard, D., & Hughes, K. D. (1997). Patterns of deviance in crime news. *Journal of Communication*, 47(3).
- Meyer, P. (1996). News media responsiveness to public health. In C. Atkin & L. Wallack (Eds.), *Mass communication and public health: Complexities and conflicts*. Newbury Park, CA: Sage.
- Barnhurst, K. G., & Mutz, D. (1996). American journalism and the decline in event-centered reporting. *Journal of Communication*, 47(4).
- Американа. (1996). *Англо-русский лингво-страноведческий словарь* (Под ред. Г. В. Чернова). Москва: Полиграмма

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Американа. (1996). *Англо-русский лингво-страноведческий словарь* (Под ред. Г. В. Чернова). Москва: Полиграмма.
- Баасансүрэн, Т. (2009). *Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр: XX зууны эхэн үеийн монголын чөлөөт хэвлэл. Улаанбаатар; Дөтгөөр дэвтэр: Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. Улаанбаатар.*
- Байгальмаа, Ч., нар. (2008). *Мэдээ. МХХ*. Улаанбаатар.
- Зулькафиль, М. (2007). *Орчин үеийн сэтгүүл зүй. Улаанбаатар.*
- Зулькафиль, М. (2009). *Сэтгүүлчийн ур чадвар-I*. Улаанбаатар: Сорхон цагаан.
- Норовсүрэн, Л. (1996). *Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. Улаанбаатар.*
- Норовсүрэн, Л. (2008). *Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. Улаанбаатар.*
- Содов, Л., нар. (1963). *Сонин бичлэгийн төрөл зүйлээс. Улаанбаатар.*

- Чойсамба, Ч. (2000). *Монгол сонины мэдээний түүх, онол практикийн асуудлууд*. Улаанбаатар.
- Чойсамба, Ч. (2000). *Монгол сонины мэдээ*. Улаанбаатар.
- Чойсамба, Ч. (2001). *Сонины мэдээллийн бичлэгийн төрөл*. Улаанбаатар.
- Эрдэнэ, Ч. (1996). *Мэдээний машин*. Улаанбаатар.
- Barnhurst, K. G., & Mutz, D. (1996). American journalism and the decline in event-centered reporting. *Journal of Communication*, 47(4).
- Hood, S. (1972). The politics of television. In D. McQuail (Ed.), *Sociology of mass communications*. Harmondsworth.
- McCombs, M. E., Shaw, D. L., & Weaver, D. (Eds.). (1997). *Communication and democracy: Exploring the intellectual frontiers in agenda-setting theory*. Mahwah, NJ: Lawrence Erlbaum Associates.
- Meyer, P. (1996). News media responsiveness to public health. In C. Atkin & L. Wallack (Eds.), *Mass communication and public health: Complexities and conflicts*. Newbury Park, CA: Sage.
- Pritchard, D., & Hughes, K. D. (1997). Patterns of deviance in crime news. *Journal of Communication*, 47(3).
- Tuchman, G. (1987). Mass media values. In A. A. Berger (Ed.), *Television in society*. New Brunswick, NJ: Transaction Books.
- White, D. (1950). The gatekeepers: A case study in the selection of news. *Journalism Quarterly*, 27.
- Zillmann, D. (1991). Television viewing and physiological arousal. In J. Bryant & D. Zillmann (Eds.), *Responding to the screen: Reception and reaction processes*. Hillsdale, NJ: Lawrence Erlbaum Associates.

Summary

This article discusses innovative trends in modern media news and factors that help enhance the effectiveness of news. It argues that the effectiveness of news depends on the extent to which the subject chosen by the journalist meets the primary and secondary characteristics of an important event. The author identifies the following as the primary characteristics of news: having a protagonist, having a form of tension or conflict, containing action, novel and timely, and not conforming to generally accepted norms; whereas the secondary characteristics include not humiliating anyone, credible and able to inspire confidence, clear and concise, and the consequences of the event have the potential to influence the recipients.

Keywords: mass communication, mass media, gatekeepers, information effects, important events, drama, media event

НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИОЛЫН АГУУЛГА, ХЭЛБЭР, ХИЙЦИЙН НЭГДЭЛ БУЮУ ТУУРВИЛ ЗҮЙН ОНЦЛОГ

Т.Өнөрсайхан*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)*

Түлхүүр үгс: Нэвтрүүлгийн зохиол, сценар, синопсис, агуулга, хэлбэр, хийц, зохиомж

Оршил. Телевизийн бүтээлийн эцсийн гол зорилго үзэгчдэд таалагдах, тэдний сонголтоор дамжуулж нөлөөллийг үүсгэх байдаг. Үзэгч үзэж байна, эсвэл үзэхгүй байна гэсэн хоёр зарчим үйлчилнэ. Үзэгчид сонголтоо хийхдээ хийц, хэлбэрийг бус агуулга буюу тухайн нэвтрүүлгээр гарч буй сэдвийн сонирхолтой байдалд ач холбогдол өгдөг. Гэтэл үзэгч тухай нэвтрүүлгийн талаар бүлгийн яриа үүсгэх, эсвэл бүлгийн болон ганцаарчилсан үзэлт алийг нь ч хийсэн дан ганц агуулгыг бус түүнтэй хамт хэлбэр, хийцийг сонгож байдгаа өөрөө анзаардаггүй. Агуулгыг баяжуулж, үзэх, сонсохуйн түвшинд сонирхолтой, анхаарал татам болоход хэлбэр болон хийц чухал үүрэг гүйцэтгэнэ.

Телевизийн бүтээл холимог (hybrid) шинж чанартай. Үзэл санаа, үүргийн түвшнээс нь салгаж үйлдэхүйн буюу бүтээлийн шинж чанарын хувьд авч үзвэл ном хэвлэл, дуу хөгжим, театрын дүрслэхүйн хэв шинжийг нэгтгэн түүнийгээ мэдээллийн технологиор дамжуулан бэлтгэдэг онцлогтой юм. Тэгэхээр нэвтрүүлэг агуулга-сэдэв, хэлбэр-төрөл зүйл, хийц-формат гэсэн гурван нэгдлийн хүрээнд хийгддэг байна. Туурвил зүй буюу эртний грекийн *poietike* гэсэн утга санаанд өргөн утгаараа дүрслэн илэрхийлэх арга хэрэгслүүдийн тогтолцоог бүхэлдээ хамруулдаг бол явцуу утгаараа уран сайхны бүтээлийн хэлийг судалдаг. Дээрх гурван нэгдэл дэлгэцийн бүтээлийн өгүүлэхүйн болон дүрслэлийн хэлийг илэрхийлдэг учраас туурвил зүйн үүднээс телевизийн зохиолд аль нэгийг нь салгаж авч үзэх боломжгүй юм.

Эртний Грекийн их сэтгэгч Аристотель, юмыг үйлдлээр нь дуурайлгадаг учраас эмгэнэлт жүжигт нэн тэргүүнээ чухалчлагдах хэсэг нь тайзны засал, дараад нь хөгжмийн эвлүүлэг болон үгээр илэрхийлэх хэсэг ордог. Учир юу вэ гэвэл чухамхүү үүний хүчээр дуурайлагдгаас болно. Үгээр илэрхийлэх гэж би

Combination of Content, Genre, Format in TV Screenplays and Features of Poetics.
Unursaikhan.T (Ph.D)

үг холбож найруулахыг, хөгжмийн эвлүүлэг гэж үзтэл учир холбогдол нь нийтэд илэрхий зүйлийг тус тус бодож хэлж байна. Цаашилбал эмгэнэлт жүжигт үйлдлийг дуурайлгадаг бөгөөд тэрхүү үйлдлийг зохиолд гарах ямар нэг хүмүүс хийнэ. Тэд зан чанар, санаа бодлын талаараа нэг гойд шинжтэй байх ёстой учир санаа бодол, зан байдал гэдэг хоёр зүйлийн шалтгаанаас үйлдэл аяндаа урган гарч, тэдгээрийн ачаар хэн бүхэн нэг бол амжилт олж, эсвэл амжилт эс олно. Үйлдлийг дуурайлгах нь зохиолын явдал (фабула) мөн (Аристотель, Туурвил зүй, 1969) гэж өгүүлэхүйн нэгдмэл хэлбэр болох үг, үйлдэл, дүрслэлийг бүтээлд салгаж ойлгох боломжгүй гэдгийг тодорхойлсон байна.

Телевизийн нэвтрүүлгийн зохиол нь дээр дурдсанчлан холимог хэв шинжтэй, үзэгчдийн анхаарал төвлөрлөлт дээр тогтдог онцлогтой учраас хөдөлгөөнт буюу динамикт бүтцийг чухалчилдаг. Тиймээс агуулга, хэлбэр, хийц нь нэг талаараа нэгэн цул болохын зэрэгцээ нөгөө талаараа бие биеийхээ илэрхийллийг нөхөж байдаг.

Аристотелийн театрын бүтээлийн үгэн илэрхийлэмжээс гадна (фабула) үйлдлээр агуулгыг нөхөж байдаг гэсэн санаа нь телевизэд хэлбэр болон хийцийн түвшинд илэрч байдаг. Хүн юмны дүрслэлийг дуртайяа сонирхон хардгийн учир гэвэл түүнийг үзээд нэгж юмыг, жишээлэхэд энэ бол тийм ийм юм гэж шүүн хэлэлцэж сурахад байдаг ажээ. Хэрэв урьд үзээгүй юм байвал дүрслэгдсэн зүйл нь дуурайлгаснаараа биш, нарийн хийцээрээ юм уу, эсвэл өнгө будгаараа, эсвэл энэ мэт бас өөр ямар нэгэн шалтгаанаар таатай санагддаг байна (Аристотель, Туурвил зүй, 1969) гэж хүн өгүүлж буй агуулгаас гадна хэлбэр хийцийг хардаг. Ингэхдээ бодит байдалд нийцэж байна уу гэхээсээ илүүтэй өөрт нь ямар сэтгэгдэл төрүүлж байна, таалагдаж байна уу, үгүй юу гэдэгт анхаарлаа хандуулдаг талаар өгүүлжээ.

Эртний их сэтгэгчийн томъёолсон үйлдэл, дүрслэлээр илэрхийлэх тухай ойлголт ингэж телевизийн гол цөм ухагдахуун болсоор байна. Түүний бүтээлийн туурвил зүйн талаарх байр суурийг үгийн илэрхийллийг үйлдлээр давхар заавал гаргаж байж дэлгэцийн бүтээл бий болно. Агуулга түүх, өгүүлэн илэрхийлэх хэлбэр, дүрсэн өгүүлэмж гэсэн гурван ерөнхий хэсэг нь бүтээлийг бүрдүүлнэ гэж Сеймур Чатман хүний туршлага, сэтгэлгээ, нийгмийн харилцааг “түүх” хэлбэрээр бүтэцжүүлж, утгыг нь тайлбарладаг өгүүлэхүйн онолын тухай бүтээлдээ (Chatman, Story and Discourse: Narrative Structure in Fiction and Film, 1978) улам бататган бичиж, өөрийн томъёоллыг бий болгосон байдаг. С.Чатман бүтээлийн бүтвэрүүдийг дараах байдлаар томъёолон авч үзсэн байна.

Дээрх бүтвэрүүдийг тус тусад нь хөгжүүлэхээс гадна зохиолд гүйцэтгэх үүрэг, бий болгох нөлөөллийг нь багцлан авч үзсэн байна. Нэгдүгээрт, дээрх графикт дүрсэлсэн үйлдэл, үйл явдал, дүрүүд, орчин зөрчил харилцан хамаарал гэсэн дөрвөн дэд хэсэг бүтээлийн хэлбэрийг буюу дамжуулж буй хэлбэрийг, хоёрдугаарт хүмүүс эд зүйл, зохиогчийн ертөнцийг үзэх үзэл гэсэн дэд хэсэгт бүтээлийн мөн чанарыг, гуравдугаарт өгүүлэхүйг дамжуулж буй бүтэц нь бүтээлийг илэрхийлж буй хэлбэр, дөрөвдүгээрт үгэн болон синематик дүрслэлд хамаарах дэд хэсэг нь бүтээлийн илэрхийллийн мөн чанар, бүрдүүлэгч хүчин зүйлс мөн гэж тодорхойлжээ.

Тэгэхээр телевизийн бүтээлийн туурвил зүйг ганцхан үгэн илэрхийлэмжийн давамгайллаар авч үзэж болохгүй байх нь. Хэрэгслийн онцлогт байдлаас хамаарч агуулга, хэлбэр, хийц нэгэн цогц болж туурвилыг илэрхийлнэ.

Телевизийн бүтээлд агуулга-хэлбэр-хийц нь юу үзүүлэх-яаж үзүүлэх-ямар байдлаар илэрхийлэх вэ гэсэн ерөнхий байдлаар томъёологдоно. Үүнийг гадаад болон дотоод хэд хэдэн байдлаар зохиолд тусгадаг. Эхний ээлжинд иж бүрэн

байдлаар нь авч үзэж, үйл ажиллагааны дарааллаар зохион байгуулсныг телевизийн зохиолын цогцолбор гэж нэрлэдэг. Зохиолын цогцолбор нь мэдүүлэг, ерөнхий төлөвлөгөө, синапсис эсвэл аннотац (товч танилцуулга), зохиолын төлөвлөгөө, зохиол, найруулагчийн (эвлүүлгийн) зохиол гэсэн зургаан хэсгээс бүрдэнэ.



График 1. Сэймур Чатманы “Өгүүлэхүйн онолын бүтвэрүүд”

Зохиолын цогцолборын гол цөм нь зохиол болон найруулагчийн зохиол юм. Зохиолд агуулга нь тийм байна, хэлбэр нь ийм байна, хийцийг тэгнэ гэж салгаж ойлгодоггүй. Харин анхнаасаа цул болгож нэг санааг илэрхийлэх гурван замын хүрээнд зохиолын үйл явдлын өрнөлийн шугамыг баримталж бичдэг. Өөрөөр хэлбэл, нар мандаж өглөө болж буйг нэг сцен гэж үзвэл “өглөө боллоо” гэж бичиж нэвтрүүлэгч унших, ярилцлагын нэвтрүүлгийн эхлэл тайлбаргүй шилжилтийн дүрс болгох, эсвэл орчны чимээтэй нь цуг бие даасан дүрсэн өгүүлэмжийн эхлэл болгох зэргээр олон талт байдлаар зохиолын эхлэл болгож ашиглаж болно.

Өөрөөр хэлбэл, нэвтрүүлгийн зохиолыг бүрдүүлэгч дээрх гурван хүчин зүйлийг зохиолын цогцолборын гол цөм болох зохиол, найруулагчийн зохиолд тусгаж үүнийгээ өгүүлэмжийн онолын бүтцийн дагуу зохион байгуулна. Эмгэнэлт жүжиг бүрд зангилаа, тайлал гэсэн хоёр хэсэг бий. Нэгдэх нь гаднах хэрэг явдлууд, мөн түүний дотор багтах заримыг ёс мэт хамарна. Нөгөө хоёр дахь нь үүнээс бусдыг хамарна. Зохиолын эхнээс аваад шилжих эргэлт хүртлэхийг би зангилаа гэж нэрлэж байна. Харин тайлал гэж энэхүү шилжилтийн эхнээс аваад төгсгөл хүртэл үргэлжилж байгаа хэсгийг нэрлэж байна. (Аристотель, Туурвил зүй, 1969) Аристотелийн бүтээлийн талаарх энэ байр суурийг өгүүлэхүйн онол туурвил зүйн үүднээс С.Чатман бүтвэрийн хувьд үйл явдал, үзэл бодол, дүрүүд, орчин, сэдэв, зөрчилдөөн, хэв маяг гэх зэргээр, зохиолын бүтцийг эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл гэж задалж үзжээ. Энэ байдлаас харахад Аристотелиос Чатман хүртэл онолчид өгүүлэх, үзүүлэхүйн хоршил болсон бүтээлийг хүлээн авагчдад таалагдах, сонирхолтой байх, туурвигчдын талаас өгүүлж буй мэт боловч өргөн утгаар нь авч үзвэл мэдээллийг утгатай бүтээх, хүнийг болон өөрийгөө ойлгох арга замыг үйлдэхүйн түвшинд хэрхэн бий болгохыг бичиж үлдээсэн (Bruner, 1990) юм.

Дээр дурдсанчлан нэвтрүүлгийн зохиолын цогцолборыг бүрдүүлэгч гол цөм нь зохиол өөрөө юм. Түүнийг хэлбэр, хийцийн хувьд улам нарийсгаж, гүнзгийрүүлэгч

нь найруулагчийн зохиол билээ. Нэвтрүүлгийн зохиолыг төлөвлөгөө маягаар урьдчилж бичихээс гадна төгссөн буюу эцсийн байдлаар бүрэн зохиол хэлбэрээр бичнэ. Телевизийн нэвтрүүлгийн төрлөөс хэзээ, яаж бичих нь шууд хамаарна. Үйл явдлыг хөөсөн мэдээллийн, шинжлэлт хэлбэрийн нэвтрүүлгүүдийн зохиолыг төлөвлөгөө хэлбэрээр бичдэг бол уран сайхны болон төрөл бүрийн шоу, “тавилттай” зохион байгуулалттай нэвтрүүлгүүдийн зохиолыг бүрэн дуусгаж, найруулагчийн зохиолтой хамтатган авч явдаг. Ийм бүрэн хэмжээний зохиолууд гарцаагүй С.Чатманы өгүүлэхүйн онолын дагуу нэвтрүүлгийн зохиолын бүтвэр болох үйл явдал, үйлдэл буюу өгүүлэгдэхүүн (хэрэг явдлын учир зүйн дараалал), дүр, орчин, зөрчил харилцаа, утга сэдэв, үгэн болон синематик дүрслэлээр илэрхийлэгдэж, үйл явдал эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл гэсэн дарааллаар үзэгдлүүдийг өрснөөр бүтдэг.

Ингэхдээ композиц буюу зохиомжийг зөв зохион байгуулах нь чухал юм. Зохиомж агуулжсан хэлбэр болохын хувьд тусгаж буй бодит байдлын зүй тогтол, зохиогчийн ертөнцийг үзэх үзэл, уран сайхны арга, үзэл санаа – гоо зүйн болон бичлэгийн төрөл зүйлтэй холбоотой зорилтуудаас шууд шалтгаалдаг. Зохиомжид сэтгүүлчийн ур чадвар голлох үүргийг гүйцэтгэдэг.

Өөрөөр хэлбэл, зохиомж бол сэтгүүлчийн сэтгэлгээ, практик туршлага, арга зүй, онолын мэдлэгийн царааг илэрхийлдэг онцлогтой. Онолын хувьд ерөнхий гурван хэлбэрээр зохиомжилж болдог. Нэгдүгээрт, үйл явдал цаг хугацаагаар зохиомжилж болно. Илүү цэгцтэй, дараалалтай болгодог зохиомжийн хувилбар. Хоёрдугаарт, логикийн учир шалтгаан-үр дагаварт тулгуурласан зохиомжийн хэлбэр байж болно. Ийм тохиолдолд дүрслэн үзүүлэх хэлбэр буюу бусдаас содон байдлыг сонгон авч тал бүрийн анализ дүгнэлт хийх, үйл явдлын өрнөлийг олон талаар ургуулан сэтгэж харуулах, үйл явдал үзэгдлийн холбоотой талыг эрэлхийлэх. Гуравдугаарт, тойрог буюу эхлэл төгсгөлийн нэг цэгтэй байх, гол дүрийг товойлгох, эсвэл олон дүрийг сөргөлдүүлэн тавих, янз бүрийн жилүүдэд болсон үйл явдлыг ижил төстэй байдлаар нь багцлан зэрэгцүүлж зохиомжлох гэсэн хувилбарууд байж болно. Тухайн нэвтрүүлгийн төрөл зүйл, агуулга сэдвээс гадна зохиолч сэтгүүлчийн арга туршлага, мэдрэмж, сэтгэлгээ зохиомжийг бүтээхэд гол үүргийг гүйцэтгэнэ.

Нэвтрүүлгийн зохиол дэлгэцийн онцлогийг давхар агуулж байдаг. Тиймээс синематик илрэлд дүрс, орчны чимээ, ярилцлага, тайлбар бичвэр, хөтлөлт, дуугүй дүрс, дуутай дүрс, хөгжим, шилжилт гэх мэт олон хэсэг багтана. Техникт шууд суурилсан байдлаар авч үзвэл хамгийн энгийнхээ төрөл бүрийн дуу болон дүрсний эффект, цэнхэр болон ногоон тайз (хромо кей), хослол зураг зэрэг багтана. Нэвтрүүлгийн зохиолд агуулга, хэлбэр, хийцийг ижил түвшинд илэрхийлэхэд нэгж хэсэг болсон сцен чухал үүрэгтэй. Сцен буюу үзэгдлийг телевизийн нэвтрүүлгийн зохиолд ерөнхий хоёр зарчмаар ашигладаг. Тодорхой нэг газар, нэг сэдэв, агуулгын хүрээнд өрнөж буй үйл явдлыг өгүүлэхээсээ гадна дэлгэцийн онцлогт байдлыг давхар илэрхийлж тухайн сцениг сонирхолтой байлгах үүднээс синематик бүтцийн зохистой харилцан хамаарлыг авч үздэг. План буюу хэсэгчилсэн дүрсний үргэлжлэх хугацаа, зураг авалтын өнцөг, дүрсийг утгажуулах олон аргыг хэрэглэхээс гадна синематик илрэл болох үргэлжилсэн дүрс бүхий тайлбарын араас ярилцлага өгөх, орчны чимээт дүрс өгөх гэх зэргээр бүтцийн хувьд олон янз байдлаар дараалуулж авч үзнэ. Үзэгчид уйтгартай нэг хэвийн урт ярилцлага, урт тайлбар бүхий дуу, дүрсийг үзэх сонирхолгүй байдаг учраас нэвтрүүлэг олон сценээс бүрдэж, агуулгын хувьд нэг хэмнэлээр өрнөж байж болох ч хийцийн хувьд зогсолтгүй хөдөлгөөнт хэв шинжийг агуулж байх ёстой юм. Ингэхдээ зохиомжийн бүтцээ алдахгүй, ямар

хэлбэрийн нэвтрүүлэг хийж байгаа үндсэн зарчмаасаа гажихгүй байх нь юуны түрүүнд анхаарах тал болдог.

Дээрх онол, арга зүйн хэв шинжийг хамгийн тод илэрхийлдэг нэвтрүүлэг бол ток шоу юм. Агуулгын хувьд ток шоууг нэгдүгээрт, “эмэгтэйчүүдийн сэдэв” буюу гэр бүл, хайр дурлал, ахуйн шинжтэй, хоёрдугаарт, тодорхой нэг сэдвээр дагнасан, гуравдугаарт, цаг үеийн сэдэвтэй, тухайн үед болж буй гол асуудлыг ярилцдаг гэсэн гурван ерөнхий хүрээнд тодорхойлж, ангилдаг.

Хэлбэрийн тухайд олон талын эх сурвалжаас бүрдсэн ярилцлага, хэлэлцүүлгийн нэвтрүүлэг юм. Хийцийн хувьд авч үзвэл “ток шоу” гэсэн өөрийн давтагдашгүй форматтай нэвтрүүлэг билээ. Ток шоуны хийц буюу формат нь оролцогчдын бүтцээс шууд хамаарна. Юуны түрүүнд бүтцийг үндсэн болон дагах гурвалжингийн томъёоллоор тодорхойлдог. Үүнд, А1-оролцогч 1, Б1-хөтлөгч, В1-уур амьсгалыг шууд мэдэрч байгаа танхимын үзэгч гэж үндсэн гурвалжингийн харьцаагаар тодорхойлдог. Зөвхөн энэ харьцаагаар хийцийг хязгаарлаж үзвэл таблойд шоу болно. Бүтцийн хувьд бүрэн ток шоуны хийцийг дээрх үндсэн гурвалжингаас гадна А2- оролцогч 2, Б2-хөндлөнгийн шинжээч, В2-танхимаас бусад байдлаар холбогдож буй үзэгчид гэж ангилдаг.

Ток шоуны формат буюу хийцийг оролцогч талуудын бүтцийн бүрэн байдлаар тодорхойлж, зохиолыг 3-5 хэсгээр зохиомжилдог. Ингэхдээ нэгдүгээр хэсэгт А1 оролцогч буюу үйл явдлын эхлэл, зангилааг тавигч тал, хоёрдугаар хэсэгт үйл явдлыг өрнүүлэх тал буюу А2 оролцогчийн тухайн асуудлын талаар байр суурь, гуравдугаар хэсэгт хөтлөгч төвтэй буюу бодит байдлыг газар дээрээс нь хийсэн сурвалжилгууд, дөрөв болон тав дахь хэсэгт хөндлөнгийн шинжээчид, танхимын үзэгчид, дэлгэцээр үзэж байгаа болон бусад хэлбэрээр хүлээн авч байгаа хүмүүсийн дунд хэлэлцүүлэг өрнүүлдэг. Ингэхдээ хэсэг тус бүр дотроо эхлэл, туйл, төгсгөлтэй байхаас гадна дэд хэсгүүд өөрсдөө бие даан тухайн нэвтрүүлгийн эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөлийг бүрдүүлнэ.

Дэд хэсгийг зохиомжлохдоо нэгдүгээрт, ямар байсан-өмнө нь ямар байсан, хоёрдугаарт, юу тохиолдсон-ийм нөхцөлд байдалд орсон эргэлтийн цэг юу байв, гуравдугаарт, үр дүн эсвэл үр дагавар- одоо яаж байна гэсэн гурван асуултын хүрээнд эхлэл-зангилаа, туйл, тайллыг тодорхой болгодог. Дэд хэсгийн оролцогч бүр энэ асуултын хүрээнд ярилцана. Телевизийн бүтээлд дэлгэцийн онцлогийг байнга харуулж, мэдрүүлэх шаардлагатай байдаг учраас туйл буюу оргил хэсгийг илэрхийлэхдээ санамсаргүй гэнэтийн зочин, оролцогчийн амьдралын нууцлаг хэсгийн баримтыг дүрс бичлэг, захидал, зургаар үзүүлэх, гол дүрийн баатрын эсрэг зан чанарыг харуулах үйл явдлын баримт дэлгэх, гол сэдэвтэй холбоотой цоо шинэ асуудал гаргаж ирэх, хүчтэй цочрол мэдрэмж өгөх хөгжим, дуу чимээгээр нөлөөлөх зэрэг аргуудыг ашиглаж болдог. Энэ бол эргэлтийн цэг буюу зөрчлийг дэлгэцийн хэлний онцлогт тулгуурлаж гадны оролцоотойгоор илэрхийлж буй арга юм. Нөгөө талаар нэвтрүүлгийн зохиолд зөрчлийг сэтгэл зүйн болон оролцогчийн үг яриа, үйлдэлд тулгуурлаж дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр гурван хэсгээр илэрхийлдэг. Үүнд, биеийн буюу бодит байдлын зөрчил, байгалийн хуулийн эсрэг эсвэл нөхцөл байдлын эсрэг буюу дагуу, нийгмийн буюу хүн хоорондын харилцааны, өөрөө өөртэйгээ үүсгэсэн зөрчил буюу сэтгэл зүйн гэж ангилж, үүнийг дагасан нөхцөл байдлыг зохиолдоо тусгаж болдог.

Дэд хэсгүүдийн бүтэц, зохиомжийг зохиолын агуулгын түвшинд ингэж гаргахаас гадна бүтэн нэвтрүүлгийн хувьд хийцээрээ илэрхийлж гаргагдаараа ток

шоу өвөрмөц нэвтрүүлэг юм. Өөрөөр хэлбэл, нэгдүгээр дэд хэсэг тэр чигээрээ эхлэл, хоёрдугаар дэд хэсэг өрнөл болдог бол гуравдугаар дэд хэсэг туйл буюу эргэлтийн цэг болж нэвтрүүлгийн баг туйлыг бүрдүүлэгч элемент болдгоороо онцлогтой юм.

Энэ бүх олон талт байдлыг нэгтгэж базаж, нэгдсэн нэг зохиол болгоход телевизийн зохиол бичих хоёр аргыг ашиглана. “Хоёр эгнээт” хувилбар буюу эхний эгнээг дүрслэлийн эгнээ гэж тодорхойлж, дүрс дууны тодорхой тайлбаруудыг бичдэг. Харин хажуугийн эгнээнд зохиогчийн бичвэр, тайлбар, ямар ярилцлага, хэн өгсөн зэргийг дэлгэрэнгүй бичдэг хайрцагласан хувилбар юм. Хоёр дахь хувилбар нь утга зохиолын хэлбэр буюу шууд цувуулан доош бичдэг онцлогтой. Энэ тохиолдолд дүрслэл болон тайлбар бичвэрүүдийг ар араас нь цувуулж бичдэг учраас ремарк буюу үйл явдлын нэмэлт тайлбаруудыг заавал дагуулж хийх шаардлагатай болно.

Үндсэн зохиолоос гадна түүнийг дагаж гарсан найруулагчийн зохиол бичигдснээр нэвтрүүлгийн багийн ажил өрөөнөөс гарч зураг авалтын талбай руу шилжлээ гэсэн үг юм. Нэвтрүүлгийн зохиолын зураг авалт дуусаагүй байхад цогцолборын хувьд дууссан гэж үзэж хааж болохгүй. Магадгүй зураг авалтын талбайд нөхцөл байдлаас шалтгаалж зохиолд өөрчлөлт орохыг үгүйсгэх аргагүй. Ийм эрсдлийг уран бүтээлийн баг урьдчилж тооцоолж зохиолд олон хувилбарт ремарк хийсэн байх шаардлагатай болдог. Гэхдээ ямар ч тохиолдолд нэвтрүүлгийн зохиолд эхнээсээ тэнцвэртэйгээр барьж чадсан агуулга, хэлбэр, хийцийн нэгдлийг хангаж бүтээлийн онцлогоос гажилгүй зураг авалтыг дуусгах нь нэгэнт дэлгэцэд гарсны дараа учирч болох эрсдэлээс сэргийлэх нэг арга юм.

Зарим төрлийн нэвтрүүлэг үйл явдлыг хөөж сурвалжлан хийдэг учраас бүрэн хэмжээний зохиол эхлээд бичих боломжгүй байдаг. Ийм үед зохиолын цогцолборын бас нэг чухал хэсэг болох нэвтрүүлгийн төлөвлөгөөг бичдэг. Нэвтрүүлгийн бүрэн зохиолтой харьцуулахад нэгбүрчлэн нэгж хэсгүүдийг шигтгэж бичих боломжгүй ч өгүүлэхүйн онолд тодорхойлсноор, агуулга, хэлбэр, хийцийн зохистой харьцааг тодорхой хэмжээгээр тохируулах боломжтой юм. Телевизийн сэтгүүл зүй гэнэтийн, санамсаргүй үйл явдлаар дүүрэн байдаг ч гэлээ тодорхой бүтээлийг бүтээх хэм хэмжээ, зохиолын бүтэц байдаг учраас түүнд тохируулж урьдчилан төлөвлөгөөг гарган ажиллаж болдог.

Тэгэхээр ямар ч төрлийн дэлгэцээр цацагдаж буй нэвтрүүлэг, мэдээ, сурвалжилга бол гэнэтийн санаандгүй, агуулгад тушигдсан дүрсний цуглуулга биш билээ. Түүний хэлбэр, хийцийг давхар илэрхийлж бүрэн мэдээлэл дамжуулах нь сэтгүүлчийн ур чадварын илэрхийлэл юм. Нэвтрүүлгийн зохиолын агуулга, хэлбэр, хийцийн нэгдэл нь мэдээллийг утгатай бүтээх, зорилготой хүргэх, гоо зүйтэй дамжуулах сэтгүүл зүйн үйл ажиллагаа болохоос гадна өргөн утгаараа хүнийг, нийгмийг, өөрийгөө ойлгох арга замыг үйлдэхүйн түвшинд хийж буй мэргэжлийн бүтээл юм.

Эшлэл

- Аристотель. (1969). *Туурвил зүй* (М. Гаадамба, Орч., х. 31). Улаанбаатар.
Аристотель. (1969). *Туурвил зүй* (М. Гаадамба, Орч., х. 27–28). Улаанбаатар.
Аристотель. (1969). *Туурвил зүй* (М. Гаадамба, Орч., х. 46). Улаанбаатар.
Chatman, S. (1978). *Story and discourse: Narrative structure in fiction and film*. London: Cornell University Press.
Bruner, J. (1990). *Acts of meaning*. Harvard University Press.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Аристотель. (1969). *Туурвил зүй* (М. Гаадамба, Орч.). Улаанбаатар.
Мэндхүү, Г., & Өнөрсайхан, Т. (2014). *Телевизийн тухай А-Я хүртэл*. Улаанбаатар.
Наранжаргал, Х. (2013). *Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж*. Улаанбаатар.
Телевиз. Соёл урлагийн тайлбар толь (VII боть). (2022). Улаанбаатар: СУИС.
Bruner, J. (1990). *Acts of meaning*. Harvard University Press.
Chatman, S. (1978). *Story and discourse: Narrative structure in fiction and film*. London: Cornell University Press.

Summary

The article discusses the tv show's screenplay and narrative features according to Chatman's structuralist model of narrative text. The combination of content, format and genre of a tv show's script is not only a journalistic activity that creates information with meaning, but also a professional work that, in a broad sense, creates a way to understand people, society at an operational level.

Keywords: Program script, scenario, synopsis, content, form, structure, composition.

ПОДКАСТ ИРГЭНИЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН ШИНЭ ХАНДЛАГА БОЛОХ НЬ

Д.Сандагсүрэн*

**Сити Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш
(Ph.D)*

Түлхүүр үгс: Подкаст, рийл, аудио блог, дижитал платформ, видео, инфографик дүрслэл, олон тэмдэгтийн орчин, иргэний сэтгүүл зүй

Оршил. Мэдээллийн технологи боловсронгуй болох бүр мэдээлэл дамжуулах шинэ шинэ арга хэрэгслүүд бий болсоор байна. Тухайлбал, иргэний сэтгүүл зүй дижитал платформ (Facebook, WhatsApp, Instagram, Tik Tok, UB info, YouTube гэх мэт) хэлбэрээр мэдээллийг хүлээн авах буюу дамжуулдаг иргэдийн идэвхтэй оролцооны сэтгүүл зүй болтлоо өргөжин хөгжиж байна. Энэ нь иргэний сэтгүүл зүйд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн сацуу, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, бусдад дуу хоолойгоо хүргэх, олон түмнийг мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Өнөөгийн Z үеийнхэн рийл, блог, пост, подкаст гэх мэт мэдээлэл дамжуулах, хүлээн авах аргуудыг илүү өргөн хэрэглэж өөрсдийн үзэл бодол, өөрт байгаа шинэ сэргэг мэдээллийг бусадтай хуваалцах боллоо. Эдгээрийн дотроос бид өнөөдөр подкаст буюу буюу аудио видео бичлэгийн талаар тухайлан авч үзэх юм. Бид подкаст яагаад өнөө үеийн социал ертөнцөд мэдээлэл дамжуулах гол арга хэрэгсэл болж байгаа учир шалтгааныг тодруулж, подкастын мэдээлэл дамжуулах онцлог, түүний давуу болон сул талыг гаргахыг зорих юм. Энэхүү өгүүллийг бичихдээ ажиглалтын болон агуулгын шинжилгээний арга, анкетын асуулгын аргыг хэрэглэсэн болно.

Хэлэлцүүлэг ба үр дүн. Эдүгээ мэдээлэл дамжуулах уламжлалт аргуудыг өргөн хэрэглэж байгаа ч, залуу үеийнхний хэрэгцээ шаардлагыг дагаад мэдээлэл дамжуулах, хүлээн авах арга маш хурдтай өөрчлөгдөж байна. “Мэдээллийг илүү хялбар аргаар хүргэх оролдлого сэтгүүл зүйн уламжлалт арга барилыг үндсээр нь өөрчлөхөд хүргэж байна. “Амьд” мэдээ өмнөх “хуучин” мэдээнүүдийг шахсаар байна” (Зулькафил, 2013).

“Турав дахь мянган жилд хүн өөрийн тухай ярих, үзэл бодлоо чөлөөтэй хуваалцах, фото зураг, видеороликийн тусламжтайгаар өөрийгөө илэн далангүй танилцуулах боломж олгосон харилцааны цоо шинэ хэрэгслүүд бий болсон.

Смартфон харилцааг улам амар хялбар болгож, зохиогч бүрийг мэдээллийн үйл явцын идэвхтэй оролцогч болгон хувиргаж байна. ...Тэд шинэ технологийн тусламжтайгаар өөрсдийн медиа орчныг бий болгох замаар мэдээллийн нийгмийн ач холбогдлыг тодорхойлох болов” (Зулькафиль М, 2019).

Шинэ үеийнхэн бол мэдээллийг дэлгэцээр хүлээн авдаг онцлог бүхий хэрэглэгчид. Визуаль богино мэдээлэл тэдний мэдээлэл харилцааны гол онцлог болжээ. Өөрөөр хэлбэл, тэд өмнөх үеийнхэн шиг мэдээллийг унших, сонсох, төсөөлөх, тархиндаа боловсруулах, оюун дүгнэлт хийх бус, олон тэмдэгтийн орчинд боловсруулсан дүрслэл бүхий мэдээллийг нүдээр үзэж, тархиндаа шууд хүлээн авдаг гэдгээрээ онцлог байна. Үүнд нь тоон технологийн дэвшил, ялангуяа цахим орчны мэдээллийн харилцаа ихээхэн нийцэх болжээ. Визуаль буюу видео, инфографик дүрслэлтэй богино хэмжээний хялбаршуулсан мэдээллийг л тэд илүүд үзэж байна.

Дээрхээс харахад үзэх+сонсох гэдэг нь тэдний мэдээллийн харилцааны гол арга болох нь тодорхой байна. Ингэж хэрэглэгчдийнхээ мэдээлэл харилцааны онцлогт зохицсон контент бэлтгэн түгээж байгаа нь өнөөгийн иргэний сэтгүүл зүйн хувьд хэрэглэгчдийнхээ сонирхол+хэрэгцээг мэдэрч буй хэрэг гэж хэлж болно. Үүгээрээ дамжуулан хэрэглэгч залуу үе тэнгийнхнээ нийгэм, улс төрийн амьдралд татан оролцуулж, санаа бодолд нь нөлөөлөх зорилго нь ч олон нийтийн харилцаа, сэтгүүл зүйн үйл ажиллагааны шинэ үзэгдэл болж байна.

Өнөөдөр фэйсбүүк, твитер, тик ток тэдний хэрэглээнээс бүрэн гараагүй ч, залуучууд хиймэл оюуныг ашиглан виртуал ертөнцөд дэлгэцийн зураг, рийл постер зэргийг өөрийн таашаал, хэрэгцээнд зориулан бүтээн ашиглах болов. Open AI-ийн ChatGpt, Хятадын DeefSeek хамгийн хялбар хэрэглээ бүхий хиймэл оюун ухааны апп-ыг саяхан гаргаж шуугиан тарьж байсан бол өнөөдөр Илон Маскийн X AI компани Grok-3 хэмээх хамгийн сүүлийн ухаалан платформуудыг танилцуулж, сая сая хэрэглэгч үнэгүй татаж аван хэрэглэж эхэллээ.

Дижитал хэрэгсэл нь бичвэр, дуу хоолой, өнгө, зураг болон бусад шинэ элементүүдийг ашиглан контентийн агуулгыг хүлээн авахад илүү хялбар болгож байна. Эдгээр нь энэ үеийн хэрэглэгчийн агуулгыг хялбар байдлаар хүлээн авдаг зан байдалд илүү дөхөм байна. Өнөө үеийн социал хэрэглэгчид аливаа зүйлийн учрыг олох, оюун дүгнэлт хийхээсээ илүүтэй, учрыг товч тодорхой тайлбарласан, мэдээллийг визуаль болон сонсох байдлаар хүлээн авах хүсэл сонирхолд бүрнээ нийцэж буй.

5G, 6G сүлжээ тархсанаар видео мэдээлэл хурдан дамжуулах боломж нэмэгдсэн бөгөөд хүмүүс ч үзэх нь ихэсчээ. Мультимедиа мэдээ нь дижитал сэтгүүл зүйн нэг төрөл болж өргөжлөө. Өөрөөр хэлбэл, “Бид уламжлалт утгаар нь ойлгодог сэтгүүл зүйн төгсгөлийн шатанд зогсож байна” (Е., 1992). Уламжлалт сэтгүүл зүйн үргэлжлэл нь мэдээж дижитал сэтгүүл зүй болох нь ойлгомжтой байна. Өнөөдөр уламжлалт сэтгүүл зүйн хэрэгслүүд мэдээ, мэдээллийн бичлэгийг үгээр сайжруулахын зэрэгцээ интерактив ажиллагаа, дүрс бичлэг, виртуал бодит байдал гээд янз бүрийн элементүүдээр баяжуулахаар чармайдаг болов.

Хэрэглэгчид учрыг бүрэн тодруулсан, үйл явдалд дүн шинжилгээ хийсэн бэлэн мэдээг шаардах болсон учир мэдээлэгч нь тоймчийн ур чадварыг тодорхой хэмжээнд эзэмшсэн байхаас гадна бодит байдлыг тухай бүрт нь ажиглаж, баримтыг задлан шинжилж, тайлбарлах хэрэгтэй болж байна. Мэдээллийг дамжуулах дээрх онцлогт подкаст илүү тохиромжтой, хүсэн буй шаардлагуудыг хангаж байгаад

л учир нь оршиж байна. Тиймээс подкаст сүүлийн үед залуучуудын мэдээлэл дамжуулах, хүлээн авдаг гол арга хэрэгсэл болж хувирч байна.

Подкаст бол зөөврийн компьютер, iPod эсвэл ухаалаг гар утсаар сонсох боломжтой аудио программын форматын шинэ медиа сегмент юм. Өөрөөр хэлбэл, онлайнаар татаж аваад сонсох боломжтой аудио нэвтрүүлэг, эсвэл үзэх+сонсох боломжтой телевизийн цуврал эсвэл блог юм.

Подкастын гол онцлог нь сонсогч өөрт хэрэгтэй сэдвийг өөрөө сонгодог тул хөтлөгчийн яриа ойр дөт, ойлгомжтой байдаг. Мөн сонсоход хялбар. Харин хөтлөгчийн хувьд өөрийн контентийг олон төрлийн платформын тусламжтайгаар сая сая хэрэглэгчдэд хүргэх боломжтой гэдгээрээ онцлог байна.

Подкаст анх АНУ-д үүссэн ч одоо олон оронд тархжээ. Эдүгээ дэлхий даяар 600 сая шахам хүн подкастыг идэвхтэй сонсож байна. Зөвхөн АНУ-д подкастыг 129.9 сая хүн тогтмол сонсож байна. Подкаст сонсдог нийт хүмүүсийн 61.6 хувийг шинэ үеийнхэн болох millennials болон generation-үүд эзэлж байгаа зэргээс харахад подкаст нь залуучуудын өргөн хэрэглээ болжээ.

Залуучуудын дунд подкаст өргөн хүрээнд тархаж буй нь дараах учир шалтгаантай гэж үзэж болохоор байна. Үүнд:

Хүртээмжтэй байдал. Хэн ч өөрийн сонирхсон дурын сэдвээр ямар ч форматыг бараг бүх платформуудаас татан авч сонсох боломжтой.

Энгийн хэрэглээ. Сонирхогч гүйлтийн дасгал хийх, ажилдаа явах, ирэх, түгжрэлд зогсох, хол замд жолоо барьж явах, гэр орноо цэвэрлэх гээд ямар ч үед подкастыг сонсох боломжтой.

Олон платформоор дамждаг.Подкастуудыг YouTube, Spotify, Google Podcasts, Pocket Casts, Yandex.Music, VKontakte, PodFM болон бусад маш олон платформ дээр үзэж сонсох боломжтой.

Бүтээхэд хялбар байдал. Сургуулийн сурагчаас эхлээд жирийн иргэн хэн ч зохиогч байж болно [1].



График 1. Подкастын хэлбэрүүд

Подкастын үндсэн форматууд нь: Аудио блог, ярилцлага, ток шоу, дугуй

ширээний яриа, хөтлөгчдийн шууд яриа, дуу хөгжим байгаа юм. Эдгээрээс хамгийн түгээмэл формат нь аудио блог, ярилцлага, хөтлөгчийн шууд яриа байдаг.

Өнөөдөр АНУ болон Их Британи зэрэг сонсогч ихтэй орнуудад тогтмол явуулдаг алдартай подкастууд олон байна. Тухайлбал,

АНУ-д

1.Жои Роганы туршлагауд

2.Cloolest podcast

3.Такер Карлсоны шоу

4.Ер бусын явдлууд

5.Муудсан манго

Их Британид:

1.Үүнээс бусад нь улс төр

2.Пол Брансонтой ярилцах хэрэгтэй

3.Жо Роганы туршлагауд

4.Стивен Бартлетын өдрийн тэмдэглэл зэргийг нэрлэж болно. Эдгээр нь подкаст сонирхогчдын хамгийн их хандалттай блогуудаар тодорсон бөгөөд залуучуудын сонсох дуртай контент болжээ.




График 2. Хандалтын байдал

Дээрх графикаас харахад залуучууд хөгжөөнт болон цэнгээнт контентыг хамгийн их сонсдог болох нь харагдаж байна. Тэрчлэн нийгэм, соёлын агуулгатай аудио контент хандалт сайтай байна. Харин улс төрийн сэдэвтэй контент эхний 5-д ороогүй байгааг залуучууд улс төрийн асуудлыг төдийлөн сонирхдоггүй гэдгээр тайлбарлаж болох юм.

Цахим эриний үеийнхний нэг онцлог бол технологийн аливаа шинэчлэл хамгийн амархан дасан зохицдог, шинэ технологийн шийдлийг тэр дор нь хүлээн авдаг зэрэг давуу байдал нь подкастыг өргөн хэмжээнд хэрэглээ болоход нь гол түлхэц болжээ. Подкаст сонсогчдын дийлэнх нь 18-34 насныхан байгаа юм. АНУ-д 12-оос

дээш насны хүн амын 47% нь сард дор хаяж нэг удаа сонсдог. Эдгээр насныхны сонсогчдын тоо 2020-37%, 2023-42%, 2024-47% болж өсөж байна [2].

Долоо хоногт 1 цаг подкаст сонсдог үзэгчдийн тоогоор Өмнөд Африк тэргүүлж байна. Тус орны хүн амын 68 хувь нь сонсдог бол Саудын Араб 59 хувь, Индонези 57 хувиар удаалж байна.

2023 онд дэлхий даяар контент үзэгчдийн тоо 506.9 сая байсан бол 2024 онд 546.7 сая болж өсчээ. Харин энэ 2025 онд энэ тоо 584.1 сая, 2026 онд 619.2 сая, 2027 он гэхэд 651.7 саяд хүрнэ гэж тооцоолж байна



График 3. Подкаст сонсогчдын тоон өсөлт

Подкаст нь залуучуудын мэдээлэл авах хамгийн түгээмэл арга болох төдийгүй, цаашид хэрэглэгчдийн тоо эрчимтэй нэмэгдэх төлөв харагдаж байна. Үүнээс үзэхэд подкаст нь иргэний сэтгүүл зүйн шинэ хандлага болох нь тодорхой байна.

Сонирхдог сэдвийн тухайд хүйс, наснаас ихээхэн хамаардаг байна. Тухайлбал, хөгжөөнт болон цэнгээнт, бүтээлч байдал, кино урлагийн салбарын контентыг залуучууд ихэвчлэн сонсдог бол аж төрөхийн ухаан, эрүүл ахуй, уламжлалт эмчилгээ, фермерийн болон таримал ургамлын тухай мэдээллийг ахмад настнууд ихэвчлэн сонсдог. Yandex Music-ийн статистик мэдээллээс харахад үзэгчдийн дийлэнх нь шинэ зүйл сурч, хөгжихийн тулд подкаст сонсдог [3] гэжээ.

Дээрх диаграммаас үзэхүл YouTube сувгаар хамгийн их хандалт хийдэг болох нь харагдана. Үүний дараа Spotify, удаалаад Apple Podcasts бичигджээ. Подкастын аудио бичлэгийг байршуулах платформууд дотор Google Podcasts, Yandex.Music, SoundCloud платформууд ч өндөр нэр хүндтэй байр эзэлж байна. Тухайлбал, Spotify гэхэд 205 мянган видео контент бүхий сантай. Тус платформ өнөөдрийг хүртэл 170 сая хандалт аваад байгаа юм.

Бид Улаанбаатар хотод амьдардаг залуучуудын дунд Google forms болон анкетын асуулга ашиглан судалгаа хийсэн. Google forms-ын судалгаанд нийт 31 хүн, анкетын асуулгад нийт 25 хүнийг хамруулсан. Эдгээр асуулгын үр дүн ерөнхийдөө ойролцоо байсан тул бид зөвхөн Google forms-ын судалгааны үр дүнг энд ашигласан болно. “Та подкастын хэрэглэгч үү?” гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын 80.6 хувь нь “тийм” гэсэн хариулт өгчээ. Үүнээс харахад манай сошиал хэрэглэгчид

подкастыг сайн мэддэг, бас идэвртэй хэрэглэгч гэдэг нь харагдав.



График 4.Хамгийн их дамжуулалттай платформууд

4.Та подкастын хэрэглэгч үү?
31 responses




График 5. Монгол дахь подкаст хэрэглэгчдийн байдал

Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзэхэд нийт хэрэглэгчдийн 46.7 хувь нь 26-35 насны залуучууд байна. Харин 20 хувь нь 15-25 насныхан байгаа юм. Нийтэд нь авч үзвэл хэрэглэгчдийн 66.7 хувь нь 15-35 насныхан байна. Эндээс подкаст бол залуучуудын хэрэглээ гэдэг нь харагдана. Тэдний сонирхол, хэрэгцээнд энэхүү мэдээллийн шинэ арга аль хэдийнэ нэвтэрсэн гэж үзэж болохоор байна.

Манай подкаст зохиогчдын контент агуулгыг авч үзэхэд ихэвчлэн өөрсдийн үзэл бодол, тодорхой асуудлаар байр сууриа илэрхийлэх, эсвэл улс төрийн нөлөөлөгчдийн гол хэрэгсэл болгож буй нь харагдаж байна. Тухайлбал, “Ideree Ag-iinaa” подкаст ихэвчлэн улстөр, бизнесийн сэдвийг сонирхож буй үзэгчдэд зориулагдсан байдаг. Түүний мөнгө санхүүгийн ашигтай зөвлөгөө, хэрхэн санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн тухай хувийн туршлага, мөнгөн хуримтлал үүсгэх тухай түүний ашигтай зөвлөгөөнүүд, улс төр, эдийн засгийн бодлогыг задлан

шинжилсэн блогууд нь маш их хандалттай, зөвхөн залуучууд төдийгүй, улс төрчид, энгийн дунд насныхны сонирхлыг ихээхэн татдаг. Подкаст хөтлөгч А.Идэрбат эдүгээ 500 мянга орчим дагагчтай гэж мэдээлдэг.

1.Таны нас

30 responses




График 6. Монгол дахь подкаст сонсогчдын насны байдал

Тэрчлэн Р.Gantulga-ын “GanGan”, зохиолч, найруулагч С.Баярсайханы “Цус цэвэр, нэр цэвэр”, Ү.Амарбатын “Man”, “Хөх тэнгэр” радиогийн “Хөх тэнгэр” зэрэг тогтмолжсон видео контентууд байна. Мөн “GAMEDAY”, “LITTLE MOM”, эдийн засагч Т.Баярхүүгийн өөрийн нэрээр нэрлэсэн “Төмөрдөшийн Баярхүү”, өмгөөлөгч Л.Батжав, “Амагаа Амагаа” гээд маш олон контент бүтээгчид залуучуудын идэвхтэй хандалтыг авах болжээ.

Подкастын үргэлжлэх хугацаа дунджаар 30 минутаас 1 цаг юм. Үргэлжлэх хугацаа нь форматаас хамаардаг.

Хүмүүс подкастаас юу хүсдэг вэ?

- Юу болсон талаар мэдээлэл авах

-Эргэн тойрон дахь ертөнцтэй танилцах

-Шинэ хообий, амжилттай яваа хүмүүсийг туршлагыг сонсох

-Ер бусын адал явдлыг үзэх

-Эрүүл мэндийн сайн зуршил, эрүүл амьдралын хэв маяг

-Мэргэжилтний зөвлөгөө

-Хөгжилтэй яриа, ер бусын хошигнол зэргийг сонсох үзэх хүсэлдээ хөтлөгдөн подкастыг сонгодог байна.

Нийт подкаст сонсогчдын ашиглаж байгаа хэрэгслийг авч үзвэл:

Mobile Phone-70%, Computer/Laptop-12%, TV -7%, Tablet-5%, Smart speaker-5% байна. Өөрөөр хэлбэл, нийт хэрэглэгчдийн 70 хувь нь ухаалаг гар утас, дараа нь таблет, PC, Laptop ашигладаг нь харагдаж байна.

Подкастыг байнга сонсож үзэх нь үзэгч сонсогчийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургах, аливаа зүйлийн учрыг тунгаан бодохоос зайлсхийхэд хүргэж болох юм. Нөгөө талаар подкастыг бүтээгчид нь янз бүрийн боловсролтой, төрөл бүрийн

мэргэжлийн хүмүүс байгаа учраас сэдвийн хувьд олон янз байх боловч, агуулгын чанар, тайлбарлах процессын түвшин янз бүр байгаа юм.

Подкаст бүтээгчид нь мэргэжлийн бус тул мэдээлэл нь үнэн бодитой байх, баримтаар нотлогдсон байх, хүлээн авагчийн хэрэгцээ шаарлагыг хангасан байх гэх мэт сэтгүүл зүйн наад захын шаардлагыг хангахгүй байгаа зэрэг дутагдлууд анзаарагдлаа.

Дүгнэлт

Хүссэн хүн бүр зөөврийн компьютер, iPod эсвэл ухаалаг гар утас ашиглан интернэтээс татаж аван сонсох боломжтой аудио болон видео форматын шинэ медиа сегмент болох подкаст нь иргэний сэтгүүл зүйн шинэ хандалга болох нь дараах байдлаар нотлогдож байна. Үүнд:

-Шинэ үеийнхэн болох millennials болон Z generation үеийнхэн мэдээллийг ихэвчлэн дэлгэцээр хүлээн авдаг бөгөөд визуаль богино мэдээлэл тэдний мэдээлэл харилцааны гол онцлог юм. Өөрөөр хэлбэл, тэд олон тэмдэгтийн орчинд боловсруулсан дүрслэл бүхий мэдээллийг нүдээр үзэж, тархиндаа шууд хүлээн авдаг гэдгээрээ онцлог байна.

-Цахим эриний үеийнхний өөр нэг онцлог бол технологийн аливаа шинэчлэл хамгийн амархан дасан зохицдог, шинэ технологийн шийдлийг тэр дор нь хүлээн авдаг зэрэг давуу байдал нь подкастыг өргөн хэмжээнд хэрэглээ болоход гол түлхэц болжээ.

-Хэрэглэгчдийнхээ мэдээлэл харилцааны дээрх онцлогт зохицсон шинж чанар бүхий контент бэлтгэн түгээж байгаа нь өнөөгийн иргэний сэтгүүл зүйн хувьд хэрэглэгчдийнхээ сонирхол+хэрэгцээг мэдэрч буй хэрэг гэж хэлж болно.

-Подкастаар дамжуулан хэрэглэгч залуу үе тэнгийнхнээ нийгэм, улс төрийн амьдралд татан оролцуулж, санаа бодолд нь нөлөөлөх зорилго нь ч олон нийтийн харилцаа, сэтгүүл зүйн үйл ажиллагааны шинэ үзэгдэл болж байна.

-Өнөө үеийн сошиал хэрэглэгчид аливаа зүйлийн учрыг олох, оюун дүгнэлт хийхээсээ илүү учрыг товч тодорхой тайлбарласан, мэдээллийг визуаль болон сонсох байдлаар авах хүсэл сонирхолд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

-Харин бэлэн тайлбартай мэдээлэл нь үзэгч сонсогчийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургах, оюун дүгнэлт хийх, бүтээлчээр сэтгэх, учрыг тунгаан дүгнэлт хийхээс зайлсхийх зэрэгт дасгах муу талтай байж болох юм гэж үзлээ.

Эшлэл

- Болд-Эрдэнэ, Б. (2012). *Интернэт сэтгүүл зүй*. Улаанбаатар.
 Норовсүрэн, Л. (2005). *Иргэний сэтгүүл зүй*. Улаанбаатар.
 Зулькафил, М. (2013). Мэдээллийн технологи ба уламжлалт сэтгүүл зүй.
МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. Сэтгүүл зүй сэтгүүл, 14(393), 17.
 Зулькафил, М. (2019). *Сэтгүүл зүйн тайлбар толь*. Сэтгүүл зүйн судалгааны
 бүтээлүүд, Боть XIV, 154.
 Katz, E. (1992). The end of journalism. Notes on watching the war. *Journal of Com-
 munication*, 42(3), 9 pp.
 Skillbox. (n.d.). *Что такое подкасты, почему они популярны и зачем нужны*

- бизнесу*. Retrieved December 29, 2025, from <https://skillbox.ru/media/marketing/chto-takoe-podkasty-pochemu-oni-populyarny-i-zachem-nuzhny-biznesu/>
- ConvertMonster. (n.d.). *Что такое подкасты и как использовать в бизнесе и жизни*. Retrieved December 29, 2025, from <https://convertmonster.ru/blog/marketing-blog/chto-takoe-podkasty-kak-ispolzovat-v-biznese-i-zhizni/>
- Cumulus Media. (n.d.). *Podcast stats*. Backlinko.com. Retrieved December 29, 2025, from <https://backlinko.com/podcast-stats>

Summary

Citizen journalism has been developing through digital platforms such as Facebook, WhatsApp, Instagram, TikTok, UB Info, and YouTube, where citizens actively engage in both receiving and disseminating information. This trend significantly enhances public participation in citizen journalism and serves as an important mechanism for individuals to express their views, make their voices heard, and contribute to the dissemination of information within society.

In the contemporary digital era, members of Generation Z have increasingly adopted diverse means of communication such as reels, blogs, posts, and podcasts to both disseminate and consume information. These platforms enable individuals to express their personal opinions and share innovative and insightful content with broader audiences.

This paper specifically focuses on podcasts as a form of audio and video communication. It aims to examine the underlying factors contributing to the growing prominence of podcasts as a major medium for information dissemination in today's social media landscape. Furthermore, the study seeks to identify the distinctive characteristics of podcasts and to analyze their strengths and limitations as a tool for modern communication.

Keywords: Podcast, reel, audio blog, digital platform, video, infographic visualization, multimedia environment, citizen journalism.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫГ БҮРДҮҮЛЭХЭД ЭРСДЭЛИЙН ХАРИЛЦАА, ЭРХ ЗҮЙН УХАМСРЫН АСУУДАЛ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Т.Энхтуяа* Д.Дагиймаа**

**ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн
докторант,*

***ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн
эрхлэгч, доктор (Ph.D)*

Түлхүүр үгс: Олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн нөлөө, эрсдэлийн харилцаа, эрх зүйн ухамсар, уур амьсгалын өөрчлөлт

Оршил. Сүүлийн арван жилүүдэд дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа уур амьсгалын өөрчлөлт нь зөвхөн байгаль орчны төдийгүй нийгмийн, эдийн засгийн, хууль эрх зүйн, соёлын асуудал болон хувирч байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ оролцоог хангах гол нөхцөл нь олон нийтийн ухамсар, ойлголт, мэдээлэлд суурилсан итгэлцэл юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл түгээх, бодлогын хэрэгжилтэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. Хэвлэл мэдээлэл нь хүмүүсийн үзэл бодол, итгэл үнэмшил, шийдвэр гаргалтад шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг бөгөөд үүгээрээ олон нийтийн санаа бодлын төлөвшил, төрийн бодлого, нийгмийн хандлагад хүчтэй нөлөөлөл үзүүлж байдаг.

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь байгаль орчны бодлогын хүрээнд чухал байр суурь эзэлж байгаа хэдий ч эрх зүйн ухамсар, мэдээллийн хүртээмж, иргэдийн оролцооны түвшин харилцан адилгүй байна. “Байгаль орчныг хамгаалах тухай” (1995), “Агаарын тухай” (2012) хуулиуд болон “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” зэрэг баримт бичгүүд нь төрийн бодлогын хүрээнд уур амьсгалын асуудлыг тодорхойлсон ч, эдгээрийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд олон нийтийн мэдээллийн боловсрол, соёл, ухамсрын түвшин гол хүчин зүйл болдог.

Climate Change and Public Opinion: Media Influence, Risk Communication, and Legal Consciousness. **Enkhtuya.T (MA), Dagiiamaa.D (Ph.D)**

Иймд энэхүү өгүүлэл нь уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн санаа бодол бүрэлдэх үйл явц, хэвлэл мэдээллийн нөлөө, эрсдэлийн харилцааны онолын үндэс, эрх зүйн ухамсрын төлөвшлийн ач холбогдлыг онолын үүднээс авч үзэх зорилготой юм. Арга зүйн хувьд чанарын шинжилгээ болон онолын харьцуулалтын арга хэрэглэв.

Олон нийтийн санаа бодлын тухай ойлголт. Мерриам Вебстерийн толь бичигт “public opinion” буюу “олон нийтийн санаа бодол”-ыг нийгэм доторх олон хүний ерөнхий хандлага, тухайн асуудал эсвэл үйл явдлын талаархи нийтлэг үзэл санаа” (Ж. С. Мерриам, 1847) гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл нийгэм, олон нийтийн аливаа нэг асуудалд хандаж буй байр суурь, үзэл санааг “олон нийтийн санаа бодол” хэмээнэ гэж толь бичиг тайлбарласан байна.

Нийгмийн шинжлэх ухааны хамгийн олон салбарт хамаардаг “олон нийтийн санаа бодол” хэмээх ойлголтыг 19-р зууны хоёрдугаар хагасаас хойш эрчимтэй судалсаар ирсэн байдаг. Энэ чиглэлийн судлаачид дундаас Липпманы судалгаанууд анхаарал татдаг бөгөөд тэрээр “Олон нийтийн санаа бодол” (Lippmann, 1922 [1992]) /Public Opinion/ бүтээлдээ “хийсвэр орчин” (pseudo-environment) гэсэн ойлголтыг анх удаа гаргаж ирсэн. Тэрээр үүнийгээ хүн өөрийн сэтгэл санаа, итгэл, айдас, соёлын нөлөөгөөр хийвэр орчинг бүтээж оюун санаандаа ямар нэгэн дүр зураг бүтээдэг. Түүндээ үндэслэн үзүүлдэг хариу үйлдлийн үр дагавар нь бодит ертөнцөд гардаг хэмээн тайлбарлажээ. Тиймээс хүний зан төлөв, шийдвэр гаргалт нь ихэнхдээ бодит бус, төсөөллийн орчинд хийсэн ойлголтын үр дүн байдаг (Lippmann, 1922 [1992]) хэмээн тайлбарладаг. Хэн нэгэн бүх мэдээлэллийг чөлөөтэй авдаг бол түүнд тогтсон үзэл бодлыг өөрчлөхөд амаргүй. Харин мэдээлэлд хаалт тавьснаар, хүмүүс юуг харах, юуг үл харахыг тодорхойлж, бодит байдлын оронд зориуд бүтээгдсэн дүр зургийг хүлээн авах нөхцөл бүрддэг хэмээн үздэг ойлголт юм.

Германы нэрт философич, нийгмийн онолч Юрген Хабермас (Jürgen Habermas) 1962 онд “The Structural Transformation of the Public Sphere” номондоо Public sphere буюу олон нийтийн орон зай гэдэг ойлголтыг анх системтэй тайлбарласан байдаг. “Хүмүүс тэгш эрхтэйгээр, чөлөөтэй нийгмийн чухал асуудлуудын талаар хэлэлцэж, санал бодлоо солилцох, төрийн шийдвэрт нөлөөлөх боломж бүхий нээлттэй, эрүүл харилцааны орон зай” (Habermas, 1962) нь нийгмийн орон зай юм хэмээсэн. Иргэд хоорондоо ухамсартайгаар, логик үндэслэлтэй төрийн бодлого, нийгмийн асуудлыг хэлэлцэж, мэтгэлцээн өрнүүлэх орчинг олон нийтийн орон зай гэж авч үзсэн. Иргэд төр, бизнесийн ашиг сонирхлоос ангид мэтгэлцээд төрийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг жинхэнэ олон нийтийн үзэл бодол бүрэлдэх үйл явц гэж үзсэн.

Харин доктор Б.Болд-Эрдэнэ олон нийтийн харилцааны үр нөлөөний асуудлыг өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэйг онцлоод “мэдээллийн хэрэгсэл хүмүүсийн гадаад орчин цаг үеийн талаарх “дүр зураг”-ийг тэлснээр тэдний санаа бодолд нөлөөлдөг, нөгөө талаар ОНМХ нь хүмүүс хоорондын харилцааг өдөөгч, адилсал, дууриаллын нэгэн эх сурвалж болох нь олон судалгаагаар нотлогджээ... ОНМХ нь хувь хүнтэй бус, харин нийгмийн бүлэг, тогтолцоо, эсвэл цогц хүрээтэй харилцдаг болох нь” (Б.Болд-Эрдэнэ, 2017) хэмээсэн.

Хэвлэл мэдээллийн нөлөө. Ард түмний санаа бодлыг чиглүүлэх, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх ажлын ихэнхийг төрийн зүтгэлтэн, сэтгүүлч эсвэл илтгэгч нар хийдэг хэмээн зарим судлаачид тэмдэглэж байв. (Carballo, 2018) XVIII зууны төгсгөл, XIX зууны эхэн үед олон нийтийн санаа бодол нь нийгмийн нэгэн чухал хүчин зүйл болон төлөвшсөн гэж түүхчид санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг. (Gunn,

1983)

20-р зууны дунд үеэс олон нийтийн санаа бодолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөөг авч үзсэн, судлаачид олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд хэвлэл мэдээлэл маш хүчтэй нөлөөлж байна хэмээн дүгнэсэн. Эдгээр судалгааны хүрээнд ажанда сэттинг /agenda- setting/ болон дуугүй байдлын эрчлээ /spiral of silence/ онолууд гарсан байна.

Дуугүй байдлын эрчлээ буюу “the spiral of silence” онолыг Германы нийгэм судлаач, Элизабет Ноэль-Нойманы дэвшүүлсэн. Энэ онолын гол санаа нь хүн өөрийн үзэл бодлын эсрэг олонх байгаа нөхцөлд бусдын гадуурхалт өртөхөөс эмээн өөрийн санаа бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэхээ хязгаарладаг. Энэхүү айдас болгоомжлол нь цаашаа эрчлээс мэт улам хүчээ авч өргөждөг хэмээн үздэг аж. Тэр тусмаа мэдээллийн хэрэгсэл нийгэмд ямар үзэл бодол зонхилж байгааг тодорхойлоход томоохон үүрэг гүйцэтгэдэг бөгөөд олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхийн зэрэгцээ энэ талаар хувь хүмүүсийн төсөөлөлд хүчтэй нөлөө үзүүлж чаддаг байна. Энэ онолоор олонхийн санал давамгайлан, цөөнхийн санал алдагдаж хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой нэг үзэл санааг түлхүү хүргэн олон нийтийн санааг нэг тийш нь хэлбийлгэх хүчтэй механизм гэж үздэг.

Ажанда сеттинг гэдэг бол улс оронд болж байгаа энэ олон үйл явдал, үзэгдэлд юу нь чухлыг тодорхойлоход мэдээний үзүүлэх үр нөлөөний тухай онол юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүмүүст ямар асуудал илүү чухал болохыг зааж чиглүүлдэг. Иргэдийн анхаарал, маргаан, үүрэг хариуцлагыг мэдээллийн урсгалаар чиглүүлдэг гэж үздэг онол юм. (May, 2013) Судлаач А.Оюунгэрэл “Ажанда сеттинг нь микро түвшинд буюу нэгж хэвлэл, мэдээллийн байгууллага, нэгж хөтөлбөрийн хувьд яригдах онол юм. Харин макро түвшинд энэ онолыг ажанда бийлдинг гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл ажанда бийлдинг гэдэг бол хэвлэл, мэдээлэл, засгийн газар болон иргэд нийгмийн бодлогын асуудалд нөлөөлөхийн тулд явуулдаг хамтын үйл ажиллагаа юм. Энэ нь шийдвэр гаргах түвшинд зарим асуудал чухал болж ирэх нөхцөлд явагддаг төвөгтэй процесс юм” (А.Оюунгэрэл, 2008) хэмээсэн нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай бодлого, шийдвэр, хөтөлбөрийг ажанда бийлдингийн зарчмаар Засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллага хамтран ажиллах нь зүйтэй юм гэсэн санал дэвшүүлж байгаа юм.

Хүрээний онол (Framing Theory). Фрэйминг буюу хүрээний онол нь хэвлэл мэдээлэл үйл явдал, асуудлыг хэрхэн мэдээлж, сурвалжилж байгаа арга барил, агуулгыг судалдаг. Нэг ижил асуудлыг өөр өөр арга барилаар сурвалжлах нь өөр өөр хариу үйлдэлд нөлөөлдөг бөгөөд энэ нь хэвлэл мэдээлэл юу мэдээ болохыг шийдэж байгаатай ижил хэмжээний чухал хэмээн судлаачид тайлбарладаг. Гэрэл зурагчин зураг авахдаа аль хэсгийг нь тодруулах, ямар хэсэгт хүмүүсийн анхаарлыг татах, юуг нь авахгүй үлдээх зэргээр сонголт хийдэгтэй адил загварын онолоор сэтгүүлчид үйл явдал, асуудлыг тусгахдаа дээрхтэй адил нарийвчлан сонгодог. (David Tewksbury, 1997) Хүрээний онол нь мэдээлэл хүлээн авагчдын ойлголтыг төлөвшүүлэхийн тулд тухайн мэдээг кодлохдоо зарим хэсгийг өгүүлэхгүй байхын зэрэгцээ асуудал, үзэгдэл үйл явцын тодорхой хэсгийг зориудаар сонгож тодотгох үйл явц юм (Н.Ариунзаяа, 2023)

Праймингийн онол /Priming Theory/ нь танин мэдэхүй сэтгэл зүйн онол бөгөөд олон нийтийн ухамсарт тодорхой мэдээлэл, ойлголт суулгаснаар дараагийн мэдээллийг хэрхэн ойлгож хүлээн авах нөхцөл бүрддэг гэж үздэг. Үзэгчид нэг сэдэв, нэг дүр төрхийг дахин дахин харах нь тухайн сэдвийн ой санамжийг идэвхжүүлдэг.

Тодруулбал уур амьсгалын өөрчлөлтийн тухай байнга гарах нь энэ сэдэв их чухал гэж үзэхэд нөлөөлнө. Мэдээллийн давтамж, хүрээ, сэдэв нь нийгмийн сэтгэл зүйд урт хугацааны нөлөө үзүүлдэг байна.

Нийгмийн сүлжээний алгоритмууд олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд ямар нөлөө үзүүлж буйг судалсан Александро Гандини (Alessandro Gandini), Сильвия Килинг (Silvia Keeling) болон Урбано Ревильо (Urbano Reviglio) нарын хамтран хийсэн “Public opinion formation in the digital age” сэдэвт бүтээлд (Gandini, 2025) алгоритмын нийгмийн санаа бодолд үзүүлж буй нөлөө буюу “algorithmic public opinion” гэсэн шинэ ойлголтыг дэвшүүлсэн байна. Энэ нь алгоритмууд (жишээлбэл Facebook, TikTok, X/Twitter) хүмүүсийн юу үзэж, юу хэлэлцэхийг тодорхой хэмжээнд чиглүүлдэг гэж дүгнэсэн. Өмнөх судалгаанууд “хуурамч мэдээ”, “мэдээллийн хөөс” /filter bubble/ гэх мэт тодорхой үзэгдлүүдийг авч үзэж ирсэн боловч, нийтийн санаа бодлыг алгоритмын орчинд бүрэлдүүлж буй тухай авч үзсэн нь дутмаг байсныг зохиогчид онцолжээ. Олон нийтийн санаа бодол нь зөвхөн хүмүүсийн үзэл бодлоор бус, алгоритмын бүтэц ба логигоор хэлбэрждэг хэмээн үзэж байгаа юм. Энэ үзэгдэл нь мэдээллийн олон талт байдалд эерэг, сөрөг аль алианаар нь нөлөөнө гэж үзсэн. Нийгмийн сүлжээгээр түгэх мэдээлэл олон нийтийн үзэл санааны индэр биш платформын алгоритмын шийдвэрүүдээр гардаг. Энэ байдал нь “нийтийн санаа бодол” хийгээд “алгоритмын бодлого” хоёрын огтлолцол дээр бий болсон шинэ төрлийн үзэгдэл юм гэж дүгнээд байна. Судалгааны дүгнэлтээр, олон нийтийн санал бодлыг бүрэлдүүлэхэд алгоритмууд хүчтэй нөлөө үзүүлдэг гэжээ. Дээрх судлаач нарын үзэж буйгаар өдгөө олон нийтийн санаа бодол бүрэлдэн тогтох үйл явцад уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээс илүү дижитал платформын алгоритм илүү нөлөөлөх болсон. Дижитал платформууд контентийг эрэмблэх, устгах, далдлах, эсвэл илүү тодруулах, харагдах байдлыг нь өөрчлөх, эсвэл худлаа мэдээлэл гэх мэтээр шошголох замаар нөлөөлж байна. Эдгээр нь автомат хийгээд ил тод, шударга биш байгаа тул зарим судлаачид үүнийг ардчилал, ил тод байдалд эрсдэлтэй хэмээжээ. (Gandini, 2025)

Эрсдэлийн харилцаа. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар, иргэд олон нийтэд энэхүү үйл явцаас болж учирч болох аюул заналын талаар хамгийн сайн үр дүнтэй мэдээлэх хэрэгсэл бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал медиа юм. Цаашлаад энэ сэдвээр мэргэжлийн байгууллага, шийдвэр гаргагчдын хооронд ойлгомжтой, үр дүнтэй мэдээлэл дамжуулах нь бас нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, нийгэмд үзүүлэх үр нөлөө билээ. Иргэд олон нийтэд учирч болох эрсдлийг ойлгуулах, түүнд хэрхэн бэлтгэх, хариу үйлдэл үзүүлэх талаар мэдлэг мэдээлэл өгч, дадал зуршлыг суулгах зорилготой хоёр талт харилцаа хэмээн мэргэжилтнүүд тодорхойлсон байдаг. Байгаль орчин, эрүүл мэнд гэх зэрэг салбарын аюул, эрсдлийн нөхцөл байдлыг мэдээлэх, зан үйл төлөвшүүлэх, олон нийтийн итгэл оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг эрсдлээс сэргийлэх, зөв шийдвэр гаргах чадвартай болгох, цаашлаад эрсдлийн талаарх дуулиан шуугиан, айдасыг буруулах зэрэг үйл явцыг эрсдийн харилцаа (Teresa L. Thompson, 2011) хэмээн тодорхойлдог байна. 1970-аад онд эрсдэлийн талаарх харилцаа нь ихэвчлэн олон нийтийн эрсдэлийн талаарх үзэл бодлыг өөрчлөх, хүлээн зөвшөөрүүлэх чиглэлд төвлөрдөг байв. Харин сүүлийн жилүүдэд олон нийтийн итгэлцлийг сэргээх, оролцоог нэмэгдүүлэх дээр төвлөрөх болсон (Frewer, 2004) “Эрсдэлийн харилцаа гэдэг нь иргэд, байгууллага хооронд эрсдэл хийгээд, эрсдэлтэй холбоотой хүчин зүйлс, эрсдэлийн талаарх ойлголт болон үзэл бодлыг солилцох харилцан идэвхтэй процесс юм” (Covello, 2001) Тодруулбал эрсдэлийн харилцаа нь зөвхөн мэдээлэл дамжуулах биш, харин хүмүүсийн ойлголт, санаа бодол, итгэлцлийг оролцуулсан харилцан үйлчлэлийн процесс юм гэж үзсэн.

Эрсдлийн харилцаа гэдэг нь зөвхөн мэдээлэл дамжуулах биш, харин хүмүүсийн ойлголт, айдас, үнэлэмж, итгэлцлийг харгалзан үзсэн хоёр талт харилцаа бөгөөд сүүлийн үеийн онолын ойлголтод сэтгэл зүй, нийгэм, соёл, улс төрийн хүчин зүйлсийг эрсдэлийн ойлголтод оруулдагаараа онцлог болж байгаа юм. Байгалийн гэнэтийн гамшиг, цар тахал, эрүүл мэндийн хямрал, үйлдвэрлэл технологийн осол зэрэг нөхцөлд хамгийн чухал үүрэгтэй энэ онол 1980 оноос хойш хөгжиж ирсэн бөгөөд нийгмийн эрүүл мэндийн харилцаа болон гамшгийн менежментийн судалгаанаас салбарлан олон салбарт хэрэглэгдэх болсон. Өдгөө эрсдэлийн харилцааны онолыг нийгмийн эрүүл мэнд, байгаль орчны бодлого, технологи, эрчим хүч, улс төр, засаглал гэх мэт салбаруудад хэрэглэдэг.

Судлаачид эрсдэлийн харилцааны 7 зарчмыг тодорхойлсон (Covello, 2001).

Үүнд:

1. Итгэлцэл /итгэлцэл байхгүй бол мэдээлэл үнэ цэнгүй/
2. Хоёр талт процесс /Сонсох, ойлгох, хариу өгөх/
3. Айдас, бухимдлыг хүндэтгэх /Хүмүүсийн сэтгэл хөдлөлийг үгүйсгэх биш, ойлгох/
4. Ил тод, үнэн зөв мэдээлэл өгөх /Хэтэрхий оройтсон эсвэл нууцласан мэдээлэл итгэлцлийг алдагдуулна/
5. Хүмүүсийн соёл, үнэлэмжийг ойлгох /Эрсдэлийг ойлгох нь соёлын ялгаанаас хамаардаг/
6. Тасралтгүй харилцаа /Хямралын үед төдийгүй урьдчилан болон дараа нь ч мэдээлэл өгөх ёстой/
7. Шинжлэх ухаан ба сэтгэлзүйг уялдаа /Зөвхөн тоон мэдээлэл бус, хүний сэтгэл хөдлөлийг давхар авч үзэх/

Энэ судалгааны ажил шинжлэх ухаан төвтэй мэдээллийн загвараас хүн төвтэй, оролцоонд суурилсан загвар руу шилжүүлсэн чухал эргэлтийн цэг болсон. Өнөөдрийн COVID-19, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, эрүүл мэндийн хямралын үед ашиглагдаж буй орчин үеийн эрсдэлийн харилцааны үндэс болсон хэмээн тэмдэглэсэн байна

Эрх зүйн ухамсар. Уур амьсгалын өөрчлөлт байгаль хамгаалалын тухай олон нийтийг чиглүүлэх, үзэл бодлыг төлөвшлүүлэх, хууль дүрэм сахиулах, бодитой үйл, үйлдэл хийлгэх зэрэгт хамгийн хүчтэй нөлөөлөх зүйл бол энэ чиглэлээр гарсан төрийн хууль, бодлого, хөтөлбөр, кампанит ажил юм. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хууль, бодлого, хөтөлбөрүүд нь байгаль орчныг хамгаалж, тогтвортой хөгжлийг хангах үндсэн зорилготой, Гэхдээ бодит үр дүн бол иргэдийн ухамсар, оролцоо, хэвлэл мэдээллийн хэрэгслийн агуулга чанараас ихээхэн шалтгаана гэж үздэг. Бүүр цаашилбал хуулийн хэрэгжилт ч зөвхөн төрийн зохицуулалт бус иргэдийн ухамсар дадал хэрэглээний хэв маягаас шууд хамаардаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хуулийг олон нийтэд ойлгомжтой байдлаар сурталчилан таниулах, хэрэгжүүлэх биелүүлэхийг уриалах, хэрэгжилтийн сайн туршлагыг харуулах маягаар олон нийтийн эрх зүйн мэдлэг өгч, итгэл үнэмшлийг дээшлүүлдэг. Мөн эсрэгээр нь хуулийг буруу тайлбарлах, хуулийн хэрэгжилтийн алдаа дутагдлыг хэт онцлох, нэг талыг барих зэргээр иргэдийн итгэлийг бууруулж хууль ёсны үнэт зүйлийг сулруулдаг алдаа дутагдал гаргах нь бий. Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хуулийн талаарх мэдээллийг бодит тэнцвэртэй хүргэж нийгмийн хандлагыг зөв чиглүүлэх шаардлага энэ сэдэв асуудлын хүрээнд онцгой чухал билээ.

Эрх зүйн ухамсар гэдгийг нийгэм дэх эрх зүйн үзэгдэл, түүний бодит байдалд хандах үзэл бодол, мэдлэг оюун, онол сэтгэгдлийн бүрдэл цогц гэж ойлгож болно (Д.Баярсайхан, 1996) Эрх зүйн ухамсар нийгмийн амьдралд идэвхитэй, нөлөөлөгч үүрэг гүйцэтгэнэ. (Ч.Тэлмэн, 2021) Эрх зүйн ухамсар нь эрх үүргийг мэдрэх, ойлгох, түүнийг ухамсарлан сахихад чиглэгдсэн ухамсар бөгөөд нийгэмд нөлөөлөх хүчин чадлаараа харьцангуй дээд түвшинд илэрсэн байдаг хэмээн судлаачид онцолсон байна. Тийм учраас бидний судалгааны үндсэн асуудал болох уур амьсгалын өөрчлөлт, байгаль хамгаалалттай холбоотой эрх зүйн баримт бичиг, төрийн бодлого хөтөлбөр зэрэг нь, зөвхөн төрийн үйл ажиллагааны хүрээнд бус, иргэн бүрийн ухамсрын түвшинд хэрэгжих ёстой агаад энэхүү ухамсарын төлөвшилд хэвлэл мэдээлэл хэрэгсэл ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Иргэн хүн эрх, үүргээ мэдэх түүнийгээ ойлгож хэрэгжүүлэн сахихыг эрх зүйн ухамсар хэмээнэ гэж эрх зүйн онолын судлаачид санал нэгтгэйгээр тодорхойлжээ. Тиймээс олон нийтийн боловсрол, соёл, итгэл үнэмшил, мэдээллийн хүртээмж өндөр байх тусам хууль хэрэгжих нь сайжирна. Тиймээс л нийгмийн хөгжил өндөр орнуудад хуулийн хэрэгжилт сайн байж иргэд нь хуулиа мэдэх төдий бус дээдлэн хэрэгжүүлэх хандлагатай болдог юм.

Уур амьсгалтай холбоотой хууль, бодлого. Монгол улсын хууль эрх зүйн тогтолцоонд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ямар зохицуулалт байдгийг судлав. Байгаль орчныг хамгаалах суурь хууль бол Монгол улсын үндсэн хууль юм. Монгол улсын үндсэн хуулийн Монгол улсын бүрэн эрхэт байдал гэсэн 1-р бүлгийн 6-р зүйлд байгаль орчин хамгаалал, төрийн үндсэн эрхийн асуудал зэрэгт суурь болох зүйл заалтууд байдаг. Мөн 1-р бүлгийн 10-р зүйлд *“Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй”* (хууль, 1992) гэсэн заалтууд байгаа ба уур амьсгалын олон улсын гэрээ конвенц, пактад манай улс нэгдсэн орсон байдгийн суурь нь эдгээр заалтууд болдог гэж үзэж болно. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих зарчмууд олон хууль тогтоомжид тусгагдсан боловч Уур амьсгалын өөрчлөлтийн талаар бие даасан хууль одоогоор байхгүй байна. Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хууль, бодлого, хөтөлбөрүүд нь байгаль орчныг хамгаалж, тогтвортой хөгжлийг хангах үндсэн зорилготой. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хууль (УИХ, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995) нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, нийгэм-эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулан үйл хэрэг болгох, өнөө болон ирээдүйн үеийн ашиг сонирхлыг хангахын тулд байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны нөхцөлийг нь нөхөн сэргээхтэй холбогдсон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулж байгаа бөгөөд хуулийн үндсэн үзэл баримтлал, иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг ойлгуулах, олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх нь эрх зүйн ухамсарыг бүрдүүлэх нэг чухал ажил болдог. Түүнчлэн Агаарын тухай хууль (УИХ, Агаарын тухай хууль, 2012) нь хүний амьдрах орчны чанарыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор агаарын чанарыг хянах, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг хянах замаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээг хуульчилсан байдаг. Иргэн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлснээр төрөөс ямар ямар дэмжлэг урамшуулал авч болох, Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарал, шингээлт болон тэдгээртэй холбоотой

ямар үүрэг хүлээсэн, төрийн байгууллага албан тушаалтан хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй бол хүлээлгэх харицлага зэрэг мэдээллийг хэвлэл мэдээлэл, цахим сувгууд, олон нийтийн оролцоотой компанит ажил зэргээр дамжуулан олон нийтэд түгээж, эрх зүйн ухамсарыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Эрх зүйн ухамсар ба хэвлэл мэдээлэл. Монгол Улсын Их Хурлын 2011 оны 02 дугаар тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” (хөтөлбөр, 2011) баталсан ба энэхүү хөтөлбөр 2011-2021 он хүртэл хэрэгжээд дууссан. “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” бол төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоог дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн бодлогын баримт бичиг юм. Хөтөлбөрийн эхний шатны биелэлтийн тайланд (биелэлт, 2017) дурдсанаар эхний үе шатны (2011–2016) хэрэгжилтийн нийт дундаж биелэлт 89–95 хувьтай байсан бөгөөд “олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллээр хангах, идэвхтэй оролцоог дэмжих” зорилт нь бүх түвшинд тогтмол, амжилттай хэрэгжсэн гэж дүгнэжээ. Тайлангаас үзэхэд 2015 онд хэвлэл мэдээллийн байгууллагууд, төрийн байгууллагууд хамтран нийт 1080 гаруй удаагийн мэдээ, сэрэмжлүүлэг, ярилцлага, нэвтрүүлэг дамжуулсан бөгөөд 21 аймаг, 319 сумын 195,000 гаруй иргэнд мессежээр цаг уур, байгалийн аюулт үзэгдлийн мэдээлэл хүргэсэн нь мэдээллийн хүртээмж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үнэлжээ. Гэсэн хэдий ч хөтөлбөрийн хэрэгжилт нь зарим зорилтод төсөв, хүний нөөцийн дутагдал, мэдээллийн тэгш бус байдал, орон нутгийн оролцооны сул байдал зэрэг шалтгаанаар сааталтай хэрэгжсэн байна. Энэ нь хэвлэл мэдээллийн орчны ялгаатай байдал, мэдээллийн чанар, хүртээмжтэй холбоотой болохыг тайланд онцолсон (биелэлт, 2017). Иймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд зөвхөн мэдээлэл дамжуулах үүрэгтэй бус, харин иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэх, бодлогын хэрэгжилтэд итгэх итгэлийг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй. Хэрэв хэвлэл мэдээлэл шинжлэх ухаанч, тэнцвэртэй мэдээллийг тогтмол хүргэж чадвал иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт гүнзгийрч, нийгмийн хариуцлага, хуулийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд танилцуулсан “Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” (сайд, 2025) мэдээлэлд тодорхой дурдсанаар, манай орны байгаль орчинд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цаг уур, экосистемийн доройтол эрчимтэй явагдаж, сүүлийн 80 жилд дундаж температур 2.4 хэмээр нэмэгдэж, 832 нуур ширгэж, мөсөн голуудын талбай 29.9 хувиар буурч, нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилтөд өртсөн байна. Эдгээр баримт нь Монгол Улс дэлхийн дулаарлын нөлөөнд хамгийн эмзэг орны нэг болохыг харуулж байгаа бөгөөд олон улсын байгууллагуудын үнэлгээгээр манай улс уур амьсгалын өөрчлөлтөд эрсдэлтэй 10 орны тоонд багтаж байна. Үүнтэй уялдан Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг тэргүүлэх чиглэл болгож, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг 2024 онд шинээр байгуулсан, мөн “Алсын хараа–2050” бодлогод хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг 2050 он гэхэд тэглэх зорилт тавьсан нь мэдээллийн үнэн бодит байдал, бодлогын залгамж чанарын тод жишээ юм. Ерөнхий сайдын илтгэлд дурдсанаар 2021–2024 онд 650 булаг, шанд, рашааны эхийг хамгаалж, 40 хөв цөөрөм байгуулж, ойжуулалт, нөхөн сэргээлт 10.9 сая га-д хийгдэж, ойн сангийн хэмжээ 8.48 хувь болж нэмэгдсэн нь уур амьсгалын бодлогын бодит ахиц, эерэг үр дүн юм. Мөн 2017–2024 онд Сайншанд, Цэций зэрэг салхин цахилгаан станц, 12 байршилд нарны цахилгаан станцуудашиглалтад орсноор сэргээгдэх эрчим хүчний нийлбэр хүчин чадал 4 дахин өсөж, зөвхөн энэ

салбарт 1 сая гаруй тонн хүлэмжийн хийг бууруулсан нь олон улсын хэмжээнд Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийн амжилттай жишээнд тооцогдож байна. Ийм мэдээллийг үнэн зөв, шинжлэх ухаанд тулгуурлан тайлбарлах нь хэвлэл мэдээллийн нийгмийн хариуцлагын илэрхийлэл бөгөөд иргэдийн уур амьсгалын эрх зүйн ухамсарыг төлөвшүүлэх гол механизм юм. Түүнчлэн IRIM судалгааны хүрээн БОАЖЯ хамтарсан “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа” (БОАЖЯ, 2023)-аар Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цөлжилт, усны хомсдол, байгалийн гамшгийн давтамжийн өсөлт зэрэг байгалийн тэнцвэрт байдалд ноцтой өөрчлөлт гарч буй өнөөгийн нөхцөлд хэвлэл мэдээлэл нь олон нийтийн ойлголт, хандлага, дадлыг төлөвшүүлэх стратегийн гол хэрэгсэл болж байна. Судалгаагаар Монголчуудын 67.3 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдээлэл сонссон, 92.7 хувь нь уг асуудалд санаа зовниж байгаа ч ердөө 23.6 хувь нь өөрийн мэдлэгийг хангалттай гэж үнэлсэн нь олон нийтийн ойлголт гүнзгий биш, мэдээлэлд итгэх түвшин сул байгааг харуулдаг. Иргэдийн дийлэнх нь уур амьсгалын өөрчлөлтийн шалтгааныг хүний буруутай үйл ажиллагаатай (84%) холбож тайлбарласан боловч, тухайн өөрчлөлтөд өөрсдийн оролцоо, үүргийг хангалттай ухамсарлахгүй байгаа нь анзаарагдсан. Тухайлбал, 78.6 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө байгаа гэж үзсэн ч 67.1 хувь нь “энэ нөлөө ойрын ирээдүйд тохиолдохгүй” гэж хариулжээ. Энэ нь олон нийтийн дунд асуудлыг “одоо биш”, “бусдад хамаатай” гэж хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлж буйг харуулдаг бөгөөд ийм хандлага нь хууль бодлогын хэрэгжилт, иргэний оролцоонд саад болдог. Хэвлэл мэдээлэл энэхүү “өөрөөсөө ангид” хандлагыг өөрчилж, иргэдэд уур амьсгалын өөрчлөлт бол алс холын бус, өдөр тутмын амьдрал, эрүүл мэнд, эдийн засаг, амьжиргаанд нөлөөлж буй бодит асуудал гэдгийг нотолгоотой мэдээллээр дамжуулан ойлгуулах үүрэгтэй. Жишээлбэл, “Хүрээлэн” болон “Ногоон шошго” зэрэг баримтат нэвтрүүлгүүд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан мал аж ахуйн хохирол, усны нөөцийн багасалт, орон нутгийн иргэдийн дасан зохицох туршлагыг харуулснаар иргэдийн ойлголт, санаа зовнил, хариу арга хэмжээ авах хүсэлд эерэгээр нөлөөлж чадсан байна.

Дүгнэлт

Английн нэрт философич, улс төрийн онолч Жон Локк хүмүүс өөрийн итгэл үнэмшлийг ихэвчлэн бусдын санал бодолд тулгуурлан гаргадаг тухай санал дэвшүүлээд өөрөөр хэлбэл, бидний итгэл үнэмшил хэмээх зүйл бусдын итгэл үнэмшлийн тусгал юм гэж үзсэн байна. Германы нийгэм судлаач, Элизабет Ноэль-Нойманы дэвшүүлсэн Дуугүй байдлын эрчлээ буюу “the spiral of silence” онолын гол санаа нь хүн өөрийн үзэл бодлын эсрэг олонх байгаа нөхцөлд бусдын гадуурхалт өртөхөөс эмзэн өөрийн санаа бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэхээ хязгаарладаг тухай авч үзсэн. Энэ онолоор олонхийн санал давамгайлан, цөөнхийн санал алдагдаж хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой нэг үзэл санааг түлхүү хүргэн олон нийтийн санааг нэг тийш нь хэлбийлгэх хүчтэй механизм гэж үздэг.

20-р зууны дунд үеэс олон нийтийн санаа бодолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөөг судлан үзэж олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд хэвлэл мэдээлэл маш хүчтэй нөлөөлж байна хэмээн дүгнэсэн. Энэхүү үр нөлөөг судалдаг хэд хэдэн онолууд бий. Аженда сеттинг, прайминг, фрэймингийн онолоор хүмүүсийг юуны тухай бодохыг юуг чухал гэж үнэлэхийг ямар утгаар ойлгох вэ гэдгийг заадаг, үр нөлөө үзүүлдэг хэмээдэг.

Сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээний алгоритмууд олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд ямар нөлөө үзүүлж буйг эрчимтэй судалж байна. Facebook, Tik-

Tok, X/Twitter зэрэг нийгмийн сүлжээний алгоритмууд хүмүүсийн юу үзэж, юу хэлэлцэхийг тодорхой хэмжээнд чиглүүлдэг. Олон нийтийн санаа бодол нь зөвхөн хүмүүсийн үзэл бодлоор бус, алгоритмын бүтэц ба логигоор хэлбэрждэг хэмээн үзэж байгаа юм. Дижитал платформууд контентийг эрэмблэх, устгах, далдлах, эсвэл илүү тодруулах, харагдах байдлыг нь өөрчлөх, эсвэл худлаа мэдээлэл гэх мэтээр шошголох замаар нөлөөлж байгааг судалгаагаар нотолсон байна.

Эцэст нь уур амьсгалын өөрчлөлтийн тухай олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд иргэдийн соёл уламжлал, мэдээлэл авч буй орчин нөхцөл, нийгмийн харилцаа болон хувь хүний сэтгэл зүйн байдал ухамсар мэдлэг зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үр нөлөөг авч үздэг онолын дагуу энэ сэдвийг нийгмийн чухал асуудал болгон төлөвшүүлэх, иргэд ямар өнцгөөр ойлгож энэ өөрчлөлтийг сааруулахад ямар хувь нэмэр оруулахыг нь тодорхойлж болох юм. Мөн олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэхэд хүчтэй нөлөөлж буй дижитал платформын алгоритмыг ашиглах шаардлага ч байхыг үгүйсгэхгүй. Эрүүл мэнд, байгаль орчин зэрэг сэдвийг мэдээлэх онол арга зүй эрсдлийн харилцааны аргуудыг ашиглах уур амьсгалын мэдээллийг түгээх зарчмыг баримтлах нь зүйтэй юм. Төрийн хууль, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх, олон нийтэд эрх зүйн ухамсарыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, социал медиа маш өндөр нөлөөтэй бөгөөд иргэдийн эрх зүйн соёл, мэдээллийн боловсрол, төрийн ил тод, хариуцлагатай бодлого хоорондын уялдаа зөв төлөвшиж чадвал, хуулийг дээдлэх зарчим бодит амьдралд хэрэгжиж, нийгэм шударга, хариуцлагатай болж, тогтвортой хөгжлийн чиглэлд бодит ахиц дэвшил гаргах боломж бүрдэнэ.

Эшлэл

- Carballo, M. L.-E. (2018). *Communication, public opinion, and democracy: New challenges*.
- Childs, H. L. (1965). *Public opinions: Nature, formation, and role*.
- Council, N. R. (1989). *Improving risk communication*. Washington, DC: National Academy Press.
- Covello, V. T. (2001). *Risk communication: Evolution and revolution*. Baltimore: Johns Hopkins University Press.
- D'Alessandro, S. (2023). From the pseudo-environment to the meta-verse: Recontextualising Lippmann's thought. *Cambio Journal*. Retrieved from <https://oaj.fupress.net/index.php/cambio/article/view/13251>
- David Tewksbury, D. A. (1997). The cognitive bases for framing effects. In D. A. David Tewksbury, *Media effects*.
- Donsbach, W. (2008). *Handbook of public opinion research*.
- Fischhoff, B. (1995). Risk perception and communication unplugged: Twenty years of process. *Risk Analysis*. <https://doi.org/10.1111/j.1539-6924.1995.tb00308.x>
- Frewer, L. (2004). The public and effective risk communication. Retrieved from <https://www.science.org/doi/10.1126/science.3563507>
- Gandini, A. K. (2025). Public opinion formation in the digital age. Retrieved from <https://journals.sagepub.com/doi/10.1177/29768640251323147>
- Gunn, J. A. (1983). *Beyond liberty and property: The process of self-recognition in eighteenth-century political thought*. Montreal.
- Habermas, J. (1962). *The structural transformation of the public sphere: An inquiry into a category of bourgeois society* (T. Burger & F. Lawrence, Eds.).
- Herbst, S. (2011). *Critical perspectives on public opinion*.
- Lippmann, W. (1922 [1992]). *Public opinion*. New York. Retrieved from <https://eclass.uoa.gr/modules/document/file.php/MEDIA237/book%20Lippmann%20Public%20Opinion.pdf>
- Locke, J. (1959 [1690]). *An essay concerning human understanding*. New York.

- May, P. (2013). *Theories of public opinion*. Retrieved from <https://digitalcommons.unl.edu/cgi/viewcontent.cgi?article=1251&context=sociologyfacpub>
- Noelle-Neumann, E. (1984). *The spiral of silence: Public opinion – Our social skin*. Chicago. Retrieved from <https://labiblioteca.mx/llyfrgell/2576.pdf>
- Renn, O. (1992). Concepts of risk: A classification. *Risk Analysis*. <https://doi.org/10.1111/j.1539-6924.1992.tb01321.x>
- Sandman, P. M. (1987). *Risk communication: Facing public outrage*. Washington, DC: Environmental Protection Agency.
- Scheufele, D. A. (2000). Twenty years of spiral of silence research: A conceptual review and empirical outlook. *International Journal of Public Opinion Research*. Retrieved from <https://academic.oup.com/ijpor/article-abstract/12/1/3/739823?redirectedFrom=fulltext&login=false>
- Slovic, P. (1987). Perception of risk. <https://doi.org/10.1126/science.3563507>
- Thompson, T. L., & Perry, R. P. (2011). *The Routledge handbook of health communication*. <https://doi.org/10.4324/9780203846063>
- А.Оюунгэрэл. (2008). *Бидний заавал мэдэх ёстой онол*. Retrieved from https://mongolianjournalism.blogspot.com/2008/06/blog-post_24.html
- Б.Баярсайхан. (1996). *Эрх зүйн онол*. Улаанбаатар.
- Б.Болд-Эрдэнэ. (2017). *Олон нийтийн харилцаа*. Улаанбаатар.
- Б.Болд-Эрдэнэ. (2024). Кантын “Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй”-н сэтгүүл зүйн асуудал. *Сэтгүүл зүй*, 24.
- Д.Мягмарсүрэн. (2012). *Spiral of Silence*. Retrieved from <https://ulstur.blogspot.com/2012/05/spiral-of-silence.html>
- БОАЖЯ. (2023). *Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа*. Улаанбаатар. Retrieved from <https://gggi.org/wp-content/uploads/2023/07/GGGI-Mongolia-Kap-Study-Mongolian23.07.25.pdf>
- Ж. С. Мерриам, Ч. М. (1847). *Public opinion*. Retrieved from <https://www.merriam-webster.com/dictionary/public%20opinion>
- Н.Ариунзаяа, Д. (2023). Сэтгүүл зүйн нөлөөлөлийн динамик: гурван онолыг задлах нь. *Сэтгүүл зүй*, 46.
- УИХ. (1995). *Байгаль орчныг хамгаалах тухай хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/8935>
- УИХ. (2012). *Агаарын тухай хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8669>
- хөтөлбөр, У. а. (2011). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/6709>
- хууль, М. у. (1992). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/367>
- Ч.Тэлмэн. (2021). Хуульчийн эрх зүйн ухамсар, түүний онцлог. *Academia.edu*.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Н.Ариунзаяа, Д. (2003). Сэтгүүл зүйн нөлөөлөлийн динамик: гурван онолыг задлах нь. *Сэтгүүл зүй*, Улаанбаатар.
- Б.Болд-Эрдэнэ. (2007). *Олон нийтийн харилцаа*. Улаанбаатар.
- Д.Баярсайхан. (1996). *Эрх зүйн онол*. Улаанбаатар.
- А.Оюунгэрэл. (2008). *Бидний заавал мэдэх ёстой онол*. Улаанбаатар.
- Ч.Тэлмэн. (2021). Хуульчийн эрх зүйн ухамсар, түүний онцлог. *Academia.edu*.
- БОАЖЯ. (2023). *Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа*. Улаанбаатар.
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар. (2025). Retrieved from <https://www.parliament.mn/nn/74934/>
- Улсын Их Хурал. (1995). *Байгаль орчныг хамгаалах тухай хууль*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/8935>

- Улсын Их Хурал. (2012). Агаарын тухай хууль. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8669>
- Монгол Улсын Үндсэн Хууль. (1992). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/367>
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр. (2011). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/6709>
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн биелэлт. (2017). Retrieved from <https://www.parliament.mn/nm/74934/>
- Carballo, M. L.-E. (2018). Communication, public opinion, and democracy: New challenges.
- Covello, V. T. (2001). Risk communication: Evolution and revolution. Baltimore: Johns Hopkins University Press.
- David Tewksbury, D. A. (1997). The cognitive bases for framing effects. In D. A. David Tewksbury, Media effects.
- Frewer, L. (2004). The public and effective risk communication.
- Gandini, A. K. (2025). Public opinion formation in the digital age.
- Gunn, J. A. (1983). Beyond liberty and property: The process of self-recognition in eighteenth-century political thought. Montreal.
- Habermas, J. (1962). The structural transformation of the public sphere: An inquiry into a category of bourgeois society.
- Lippmann, W. (1922 [1992]). Public opinion. New York.
- May, P. (2013). Theories of public opinion.
- Thompson, T. L., & Perry, R. P. (2011). The Routledge handbook of health communication.
- Мерриам, Ж. С., & Мерриам, Ч. М. (1847). Public opinion. Retrieved from <https://www.merriam-webster.com/dictionary/public%20opinion>

Summary

This study explores the formation of public opinion on climate change through the lenses of media influence, risk communication, and legal consciousness. Drawing on the theoretical frameworks of Lippmann, Habermas, Noelle-Neumann, Covello, and Slovic, the paper argues that public perception of climate issues is mediated by information framing, trust, and social participation. Effective communication and media literacy can enhance citizens' engagement and support the implementation of environmental policies in Mongolia.

Keywords: public opinion, media influence, risk communication, legal awareness, climate change

ТЕЛЕВИЗИЙН ХӨРӨГ НЭВТРҮҮЛЭГ БҮТЭЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

С.Бэлгүүнзаяа*

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн докторант*

Түлхүүр үгс: Телевиз, продакшн, ур чадвар, үзэгчид, уран бүтээлчид, хөрөг нэвтрүүлэг, баримтат кино, контент, судалгаа.

Оршил. Телевизийн контент, тэр дундаа хөрөг нэвтрүүлэг нь нийгмийн үнэт зүйл, хүний амьдралын түүх, соёлын илэрхийллийг олон нийтэд хүргэж, бодит байдлын талаарх ойлголтыг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй. Баримтат болон хөрөг жанр нь мэдээллийн чанарын гол үзүүлэлт бөгөөд үзэгчдийг бодит амьдрал, нийгмийн харилцааг ойлгоход чиглэдэг гэж судлаачид үздэг (Nichols, 2017). Хэвлэл мэдээллийн бүтээлийн нийгмийн орчинд үзүүлэх нөлөөний талаар (McQuail, 2010) “мэдээллийн байгууллагууд нь олон нийтийн соёлын хэв загвар, үнэлэмжийг төлөвшүүлэх институцийн үүрэгтэй” хэмээн онцолдог.

Энэ утгаараа телевизийн хөрөг нэвтрүүлэг бүтээх үйл явц нь зөвхөн уран сайхны найруулга бус, салбарын институцийн зохион байгуулалт, редакцын бодлого, техник-технологийн бааз, хүний нөөцийн чадавхи зэрэг олон хүчин зүйлээс хамаарсан нэгдмэл бүтээлч процесс юм. Иймд хөрөг нэвтрүүлэг бүтээгчдэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох нь салбарын хөгжлийн чиг хандлага, контентийн чанарыг хэмжих чухал судалгааны зорилт болдог.

Энэхүү судалгааны гол зорилго нь хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн мэргэжлийн ур чадвар, бүтээлч ажиллагааны бэрхшээл, салбарын зохицуулалт, техник-технологийн хүртээмж болон хөгжлийн боломжийг илрүүлэхэд оршино. Судалгааг 2024 оны 11 дүгээр сард баримтат бүтээлээр дагнаж ажилладаг 47 уран бүтээлчийн дунд явуулж, тоон болон чанарын аргыг хослуулсан холимог арга зүйг ашигласан. Holistic ойлголт бий болгоход холимог арга зүй үр дүнтэй гэж (Creswell, 2014) тэмдэглэсэн нь энэхүү судалгааны арга зүйтэй нийцнэ.

Анкетийн судалгаа нь уран бүтээлчдийн туршлага, арга барил, бүтээлийн чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэхэд чиглэсэн бол чанарын мэдээлэл нь

бүтээлч үйл явц дахь сорилтыг илүү гүнзгий тодруулсан. Судалгааны үр дүн нь хөрөг нэвтрүүлгийн өнөөгийн төлөв болон тулгамдсан асуудлыг системтэй тодорхойлох ач холбогдолтой.



График 1. Судалгаанд оролцогсдын нас, хүйсийн бүтэц

Насны бүтцийн хувьд судалгаанд оролцогчдын 55.3 хувь нь 35–44 насны, 29.8 хувь нь 45–54 насны, 10.6 хувь нь 25–34 насны, 4.3 хувь нь 55-аас дээш насныхан байна. Хүйсийн хувьд 59.6 хувь нь эрэгтэй, 40.4 хувь нь эмэгтэй байв.




График 2. Респондентуудын ажил, мэргэжлийн байдал

Судалгаанд оролцогчдын 38.3 хувь нь найруулагч, 34 хувь нь сэтгүүлч, редактор, 10.6 хувь нь зураглаач, 6.4 хувь нь зохиолч, судлаач, мөн 6.4 хувь нь хөтлөгч, жүжигчин, 4.3 хувь нь продюсер, менежер гэж хариулсан нь судалгаанд гол төлөв мэргэжлийн уран бүтээлчид хамрагдсаныг харуулна.




График 3. Уран бүтээлчдийн харьяалагдах газар, ажлын байр

Нийт уран бүтээлчдийн 59.6 хувь нь телевизэд, 23.4 хувь нь хувийн студи, продакшнд ажилладаг, 17 хувь нь чөлөөт уран бүтээлч байна.




График 4. Респондентуудын уран бүтээлийн туршилага, ажилласан жил

Судалгаанд оролцогчдын 19.1 хувь нь 20 буюу түүнээс дээш жил баримтат нэвтрүүлгийн төрлөөр ажилласан, 46.8 хувь нь 10–20 жилийн туршлагатай, 25.5 хувь нь 5–10 жил, 6.4 хувь нь 2–5 жил, 2.1 хувь нь 1–2 жил ажилласан байна. Энэ бүтцээс харахад оролцогчдын дийлэнх нь 10 ба түүнээс дээш жилийн туршлагатай, мэргэшсэн уран бүтээлчид бөгөөд шинэ үеийн залуу уран бүтээлчдийн эзлэх хувь харьцангуй бага байгаа нь цаашдын хүний нөөцийн төлөвлөлтөд анхаарах шаардлагатайг илтгэнэ.




График 5. Хөрөг баатрын дүр сонголт (олон сонголтот хариулт)

Хариултаас үзэхэд хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн 74.5 хувь нь урлаг, соёл, спортын алдартнуудыг, 55.3 хувь нь эгэл жирийн хүмүүсийг гол баатраар сонгодог байна. Алдартнуудыг онцлох нь үзэгчдийн сонирхлыг татах, амжилтын түүхийг баримтжуулах, урам зориг өгөх зорилготой бол эгэл жирийн хүмүүсийг тусгах нь нийгмийн “эгэл баатар”-уудын оролцоог нэмэгдүүлж, тэдний амьдралын туршлага, үнэ цэнийг олон нийтэд ил тод, бодитойгоор хүргэх ач холбогдолтой.

Мөн респондентуудын 25.5 хувь нь улс төрчид, бизнес эрхлэгчдийг, 12.8 хувь нь түүхэн хүмүүсийг, 6.4 хувь нь социал нөлөөлөгчдийг онцолдог гэж хариулсан нь хөрөг нэвтрүүлэг бодлогын шийдвэр гаргагчид, эдийн засаг, бизнесийн орчин, соёлын өв, орчин үеийн мэдээллийн орчноос үлгэр авсан олон талт баатар сонголттой байгааг харуулж байна. Эдгээр нь тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээ, үзэгчдийн сонирхол, баримтат бүтээлийн ач холбогдлыг харгалзан үзэж буйг илтгэнэ.




График 6. Хөрөг нэвтрүүлгийн нийгэм-сэтгэлзүйн нөлөөлөл, уран бүтээлчийн өөрийн үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 87.2 хувь нь өөрсдийн бүтээл болон гол баатраар дамжуулан нийгэмд тодорхой хэмжээнд нөлөөлж чаддаг гэж үзсэн бол 12.8 хувь нь үүнийг үгүйсгэсэн байна. Үүнийг хүлээн авахуйн онолын (reception theory) үүднээс тайлбарлавал, үзэгчид хөрөг нэвтрүүлгийн агуулгыг өөрийн туршлага, үнэт зүйл, нийгмийн орчинтой уялдуулан хүлээн авч, зохиогчийн санаатай нийцсэн эсвэл өөр тайлбар бий болгох боломжтой.

Баримт өгүүлэх (documentary storytelling) арга зүй нь бодит үйл явдал, хувь хүний түүхийг баримтад тулгуурлан хүүрнэж, үзэгчдэд итгэл үнэмшил төрүүлэхэд чиглэнэ. Иймд хөрөг нэвтрүүлэг нь мэдээлэл өгөхөөс гадна тухайн хүний үзэл санаа, амьдралын үнэт зүйлийг нийгэмд түгээж, үзэгчдийн хандлага, үнэлэмжид нөлөөлөх чадамжтай гэж үзэж болно.



График 7. Хөрөг нэвтрүүлэг бүтээхдээ чухалчилдаг зүйлс

Судалгаанд оролцогчдын 61.7 хувь нь хөрөг нэвтрүүлэгт сэдэв, хүнийг хослуулан авч үзэх нь зүйтэй гэж үзжээ. Тэдний ойлголтоор хөрөг нэвтрүүлэг нь нэг талаас хувь хүний амьдрал, дотоод мөн чанар, нөгөө талаас тухайн хүний оршин буй нийгэм, цаг үе, түүхэн нөхцөл байдлыг хамтад нь тусгах ёстой. Энэ нь хүн ба орчны харилцан үйлчлэл, нийгэм-улс төрийн нөхцөл байдлыг зэрэг харуулах интеграцчилсан хандлагатай нийцэж байна.

Оролцогчдын 23.4 хувь нь хөрөг нэвтрүүлгийг зөвхөн хувь хүний дотоод

ертөнц, сэтгэлгээ, үнэт зүйлсийг төвд авч үзэх ёстой гэж үзсэн нь баримтат киноны психологийн чиг баримжаатай нийцнэ. Харин 14.9 хувь нь сэдэв, нийгэм, цаг үеийн асуудлыг голчилж, хүнийг тухайн нөхцөл байдлын тусгал гэж харахыг зөвтгөсөн нь нийгмийн реализмын онол, баримтат киноны нийгмийн шүүмжлэлт хандлагатай уялдаж, түүх, улс төр, нийгмийн үйл явцыг тодруулж, үзэгчдийг тухайн асуудалд анхаарлаа хандуулахад чиглэж байгааг харуулж байна (Rabiger, 2014).

Эдгээр үр дүнгээс харахад хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн хандлага ялгаатай боловч нийтлэг чиглэл нь хүн ба нийгмийн харилцан хамаарлыг илэрхийлэхэд оршиж байгаа бөгөөд хүнийг тодорхой орон зай, цаг үе, нийгмийн нөхцөл дунд байршуулан харуулахыг чухалчилж байна.



График 8. Хөрөг нэвтрүүлэг бүтээх сонирхолт төрөл, сонголт

Судалгаанд оролцогчдын 48.9 хувь нь баримтат киноны хэлбэрийг ашиглан хөрөг бүтээхийг илүүд үздэг гэж хариулсан нь тухайн хүний дүрийг түүхэн, нийгмийн, соёлын контексттэй нь хамт баримтад тулгуурлан харуулах сонирхол давамгайл байгааг харуулна. 31.9 хувь нь уран сайхны найруулгатай хөрөг найруулгын хэлбэрийг, 19.1 хувь нь ярилцлагын, ток шоу хэлбэрийг илүүд үзсэн байна.

Ингэснээр уран бүтээлчид баримт, уран сайхны өгүүлэмж, шууд харилцааны арга зүйг өөрийн онцлогт тохируулан ашиглаж, үзэгчдийн хүлээн авах түвшин, сонирхолд нийцүүлэхийг зорьж буй нь харагдана. Баримтат киноны хэлбэрийг сонгосон олонхийн хандлага нь хүний дүрийг өргөн хүрээтэй, түүхэн үнэ цэнтэй мэдээлэлтэй хамт үлдээх, нийгэмд бодитой, нөлөөтэй байдлаар хүргэх боломжийг үнэлж байгааг илтгэнэ. Гэвч орчин цагийн телевизийн хөрөг нэвтрүүлгүүд баримтат киноны онол, арга зүйн хүрээнд, хөрөг нэвтрүүлгийн уламжлалт хувилбараар хийгдсэн нь харьцангуй хомс байгааг судалгаа харуулж байна.




График 9. Монголын телевизүүд хөрөг нэвтрүүлэг хангалттай бүтээж байгаа эсэх

Судалгаанд оролцогчдын 31.9 хувь нь Монголын телевизүүд хөрөг нэвтрүүлгийг хангалттай хэмжээнд бүтээж, олон нийтэд тогтмол хүргэж байна гэж үзсэн бол 68.1 хувь нь шаардлагатай түвшинд хүрэхгүй байна гэж дүгнэжээ. Энэ нь хөрөг нэвтрүүлгийн үйлдвэрлэл, хүртээмж, редакцын бодлого болон санхүүжилт, зохион байгуулалтын түвшинд тулгамдсан асуудлууд байгааг илтгэнэ.

Орчин цагийн телевизийн хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн уран чадварыг үнэлэхэд оролцогчдын 8.5 хувь нь “маш сайн”, 51.1 хувь нь “сайн”, 38.3 хувь нь “дунд”, 2.1 хувь нь “муу, хангалтгүй” гэж дүгнэсэн нь мэргэжлийн өндөр түвшний бүтээлүүдийн зэрэгцээ найруулга, арга зүй, ур чадварын ахиц шаардлагатай хэсэг байгааг харуулж байна.




График 10. Мэргэжлийн чадавхжуулах сургалтын хэрэгцээ, хамрагдалтын байдал

Судалгаанд оролцогчдын 78.7 хувь нь гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтад хамрагдах хэрэгцээтэй гэж үзсэн нь уран бүтээлчид ур чадвараа тасралтгүй сайжруулах, олон улсын туршлага судлах эрмэлзэлтэй байгааг харуулна. 21.3 хувь нь сургалтын шаардлагагүй гэж хариулсан нь туршлага, бие даан хөгжих хандлагатай холбоотой байж болно.

Гэвч ажил олгогч байгууллагын түвшинд мэргэжил дээшлүүлэх бодлого сул байна. Респондентуудын 46.8 хувь нь “хааяа нэг хамруулдаг”, 53.2 хувь нь “огт хамруулдаггүй” гэж хариулсан нь телевиз, продакшнууд уран бүтээлчдийн тасралтгүй хөгжлийг системтэй дэмжихгүй байгааг илтгэнэ.

Мэргэжлийн боловсролын тасралтгүй хөгжил (lifelong learning)-ийн үүднээс авч үзвэл хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн мэргэшил, ур чадварыг тогтмол ахиулж, шинэ арга зүй, технологийн дэвшлийг эзэмшүүлэх нь бүтээлийн чанар, салбарын өрсөлдөх чадварт шууд нөлөөлөх хүчин зүйл юм. Иймд телевиз, продакшнууд уран

бүтээлчдээ тогтмол хөгжүүлэх системтэй сургалтын бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

Үлгэр дууриал авдаг уран бүтээлчид, суралцах эх сурвалж

Судалгаанд “Танд хувь уран бүтээлчийнхээ үүднээс үнэлж, суралцаж явдаг хөрөг, баримтат кино бүтээгч бий юу? (гадаад, дотоод). Хэрэв байгаа бол түүний уран чадварын онцлогийг дурдана уу?” гэсэн асуумжийг багтаасан. Хариултаас үзэхэд телевизийн хөрөг, баримтат кино бүтээгчид ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийн тулд Монголын болон олон улсын нэрт уран бүтээлчдийн бүтээл, арга барилаас зорилготойгоор суралцдаг байна.

Монголын алтан үеийн найруулагч, сэтгүүлчдийн бүтээлүүд нь түүхэн уламжлал, арга барилын суурь болж өнөөгийн уран бүтээлчдэд үлгэр дууриал болж байгаа бол National Geographic, Netflix зэрэг олон улсын баримтат бүтээлүүд нь орчин үеийн найруулга, өгүүлэмжийн арга техникийг эзэмших гол эх сурвалж болжээ.

Иймд телевизийн хөрөг, баримтат кино бүтээгчдийн мэргэшил, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд дотоодын болон олон улсын шилдэг туршлагаас суралцах боломжийг өргөжүүлэх нь чухал болох нь судалгааны дүнгээс тодорхой байна.




График 11. Хөрөг нэвтрүүлгийн эфирийн давтамж, үйлдвэрлэлийн хугацаа

Судалгаанд оролцогчдын 36.2 хувь нь хөрөг нэвтрүүлгийг нэг сар тутам, 21.3 хувь нь 21 хоног тутам, 17 хувь нь 14 хоног тутам, 19.1 хувь нь долоо хоног тутам, 6.4 хувь нь гурван сар тутам бэлтгэж, эфирт хүргэх нь зохимжтой гэж үзжээ. Олонхийн санал нэг сар тутмын давтамжийг илүүд үзсэн нь баримтат хөрөг нэвтрүүлгийн судалгаа, бэлтгэл ажлыг хангалттай хугацаанд гүйцэтгэх, агуулгын гүнзгийрэл, бүтээлийн чанарыг хадгалах шаардлагатай уялдаж байна.

Баримтат хөрөг нэвтрүүлэг нь тухайн хүний амьдрал, уран бүтээл, түүхэн нөхцөл байдлыг нарийвчилсан судалгаа, баримтад тулгуурлан хүүрнэх онцлогтой тул нэг сараас богино давтамж нь бүтээлийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзэх үндэслэл бий. Иймд судалгааны дүн телевизийн редакц, продакшнуудад хөрөг нэвтрүүлгийн эфирийн хуваарийг төлөвлөхөд чухал баримжаа болж өгч байна.

Судалгаанд оролцогчдын 63.8 хувь нь хөрөг нэвтрүүлэг “хэт нэг талыг барьсан, магтаал давамгайлсан” шинжтэй гэж үзсэн нь редакцын бодлого, контентын агуулгад шүүмжлэлтэй хандах шаардлагатайг харуулна. 38.3 хувь нь “зохиол, тайлбарын чанар хангалтгүй”, 36.2 хувь нь “найруулга, зураг авалт, эвлүүлгийн чанар сул”, 34 хувь нь “сэтгүүлч, хөтлөгчийн ур чадвар дутмаг”, 46.8 хувь нь

“хэлбэр давамгайлж, агуулгын гүнзгийрэл хангалтгүй” гэж хариулжээ.




График 12. Телевизийн хөрөг нэвтрүүлгийн нийтлэг дутагдалтай талууд (олон сонголтот хариулт)

Мөн “мэдээллийн багтаамж хангалтгүй”, “судалгааны үндэслэл дутмаг” гэж судалгаанд оролцогчдын 19.1 хувь нь үзжээ. Энэ нь хөрөг нэвтрүүлгийн бүтэц, агуулга, найруулгын түвшинд анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Эдгээр дүн нь хөрөг нэвтрүүлгийн агуулга, найруулга, бүтэц, үйлдвэрлэлийн бүх үе шатанд чанарын бодлого хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан арга зүйг бэхжүүлэх, техник-технологийн шинэчлэл хийх, уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадвар, бүтээлч орчныг дэмжих бодлого шаардлагатайг тод харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 63.8 хувь нь “нэвтрүүлгийн багийн мэргэжлийн ур чадвар дутмаг”, 52.2 хувь нь “цалин хангамж, урамшуулал хангалтгүй”, 46.8 хувь нь “судалгаа хийх цаг хугацаа, эх сурвалж гүнзгийрүүлэх бололцоо хязгаарлагдмал” гэж үзжээ. 38.3 хувь нь “телевиз, редакцын дэмжлэг, хараат бус байдлын орчин сул”, 31.9 хувь нь “техник, технологийн хангамж дутмаг”, 14.9 хувь нь “санхүүжилт, ивээн тэтгэгчдийн оролцоо бага”, мөн 14.9 хувь нь “Соёлын яамны бодлогын түвшний дэмжлэг шаардлагатай” гэж тэмдэглэсэн байна.




График 13. Бүтээлийн чанарт нөлөөлж буй хүчин зүйлс

Эдгээрээс харахад хөрөг нэвтрүүлгийн бүтээлийн чанарыг сайжруулахын тулд мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, судалгаанд суурилсан бүтээлч

арга зүйг төлөвлөх, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр, байгууллагын бодлогын дэмжлэг, техник-технологийн шинэчлэл, бүтээлч орчинг бэхжүүлэх цогц бодлого шаардлагатай байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монголын телевизүүдийн хөрөг нэвтрүүлэг бүтээх үйл явц, уран бүтээлчдийн мэргэжлийн чадвар, бүтээлч ажиллагаанд тулгамдаж буй гол бэрхшээлүүдийг системтэйгээр тодорхойлж, үйлдвэрлэлийн бүтцийн өнөөгийн төлөв болон хөгжлийн боломжийг үнэллээ. Судалгаанд оролцогчдын бүтэц, ажлын туршлага, бүтээлч арга барилын талаар цуглуулсан мэдээлэл нь хөрөг нэвтрүүлгийн чанар, үр нөлөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг олон талт байдлаар илрүүлэх боломж олгов.

Юуны өмнө, судалгаанд хамрагдсан уран бүтээлчдийн дийлэнх нь 10 ба түүнээс дээш жилийн ажлын туршлагатай, баримтат төрөлд мэргэшсэн боловч шинэ үеийн залуу уран бүтээлчдийн оролцоо харьцангуй бага буй нь салбарын хүний нөөцийн тогтвортой байдлын асуудлыг харуулж байна. Хөрөг нэвтрүүлгийн баатар сонголт нь олон талт бөгөөд урлаг, спорт, соёлын алдартнууд давамгайлдаг ч эгэл жирийн хүмүүс, түүхэн зүтгэлтнүүд, бодлогын шийдвэр гаргагчдыг онцлох оролдлого түгээмэл байгаа нь контентийн төрөлжилтийн эсрэг хандлагыг илтгэв.

Судалгааны үр дүнгээс харахад хөрөг нэвтрүүлгийн нийгмийн нөлөөллийн талаар уран бүтээлчдийн ихэнх нь өөрсдийн бүтээл нийгмийн ойлголт, үнэлэмжид тодорхой хэмжээнд нөлөөлж чаддаг гэж үнэлсэн нь documentary storytelling болон reception theory-ийн онолын ойлголттой нийцэж байна. Хөрөг нэвтрүүлгийн төрөл сонголтын хувьд уран бүтээлчид баримтат киноны хэлбэрийг илүүд үзэж байгаа нь баримт, хүний түүх, нийгмийн контекстыг уялдуулан харуулах сонирхол давамгай байгааг харууллаа.

Гэсэн хэдий ч үйлдвэрлэлийн түвшинд тулгамдсан асуудлууд тодорхой байна. Судалгаанд оролцогчдын олонх нь хөрөг нэвтрүүлэг хангалттай хэмжээнд бэлтгэгддэггүй, редакцын бодлого, санхүүжилт, хүний нөөцийн зохион байгуулалт сул байгааг тэмдэглэсэн. Мөн бүтээлийн чанарт нөлөөлж буй асуудлуудаас мэргэжлийн багийн ур чадварын ялгаа, дутмаг судалгаа, техникийн боломж хязгаарлагдмал байдал, урамшууллын тогтолцооны сул тал, редакцын хараат бус байдлын асуудлууд нийтлэг давтагдсан нь энэ төрлийн контентын чанар, хүртээмжийг бууруулж байна. Түүнчлэн уран бүтээлчид дотоодын болон олон улсын баримтат бүтээлчдээс суралцах эрмэлзэл өндөр боловч тогтвортой сургалт, чадавхжуулах бодлого хангалтгүй байна.

Эдгээрээс дүгнэхэд, телевизийн хөрөг нэвтрүүлгийн салбарт чанар, бүтээмжийг сайжруулахын тулд дараах гол чиглэлээр бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд: мэргэжлийн ур чадварын тасралтгүй хөгжлийн тогтолцоо бүрдүүлэх, редакцын бодлого ба бүтээлч үйл явцыг хараат бус, чанарын шалгуурт нийцүүлэн сайжруулах, техник-технологийн шинэчлэл хийх, судалгаанд суурилсан бүтээлийн арга зүйг хэвшүүлэх, санхүүжилт, урамшууллын тогтвортой механизмыг бий болгох зэрэг асуудал багтана.

Эцэст нь, энэхүү судалгаа нь Монголын телевизийн хөрөг нэвтрүүлгийн өнөөгийн төлөвийг бодитой үнэлж, салбарын хөгжилд шаардлагатай бодлогын түвшний санал, шийдлийн үндсийг тавьж байгаа бөгөөд цаашид илүү өргөн хүрээний, олон талт судалгаа хийх замаар хөрөг нэвтрүүлгийн чанар, бүтээмжид

нөлөөлөх хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

Эшлэл

- Creswell, J. W. (2014). *Research design: Qualitative, quantitative, and mixed methods approaches* (4th ed.). Sage Publications.
- McQuail, D. (2010). *McQuail's mass communication theory* (6th ed.). London, UK: Sage Publications.
- Nichols, B. (2017). *Introduction to documentary* (3rd ed.). Bloomington: Indiana University Press.
- Rabiger, M. (2014). *Directing the documentary*. Burlington, MA, USA: Focal Press.

Ашигласан бүтээлийн жагсаалт:

- Bernard, S. C. (2010). *Documentary storytelling: Creative nonfiction on screen*. Focal Press.
- Creswell, J. W. (2014). *Research design: Qualitative, quantitative, and mixed methods approaches* (4th ed.). Sage Publications.
- Exploring the art of documentary storytelling: The essence of documentary filmmaking. (n.d.). Retrieved from <https://www.learn documentary.com/blog/exploring-the-art-of-documentary-storytelling>
- McQuail, D. (2010). *McQuail's mass communication theory* (6th ed.). Sage Publications.
- Nichols, B. (2017). *Introduction to documentary* (3rd ed.). Indiana University Press.
- Rabiger, M. (2014). *Directing the documentary* (6th ed.). Focal Press

Summary

This study examines the creative competencies of Mongolian television portrait program producers, the challenges they encounter during the production process, and emerging developmental trends in the field. Conducted in November 2024 with 47 professionals primarily engaged in documentary production, the research explores their professional experience, creative methods, technological use, educational background, and the organizational and regulatory environment of the media sector. Using a mixed-methods design that integrates surveys and questionnaires, the study identifies key obstacles affecting production quality, evaluates the creative and technical skill levels of producers, and highlights opportunities for strengthening professional development and improving television portrait program production.

Keywords: Television, production, skills, audiences, creators, portrait program, documentary film, content, research.

ЦАХИМ ОРЧИНД ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙН ТАРХАЛТЫГ ХЯЗГААРЛАХ БОЛОМЖ

Г.Мэндхүү*, Сайханмэнд**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн
дэд профессор, доктор (Ph.D)*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн магистрант*

Түлхүүр үгс: Интернэт, мэдээллийн дайн, баримт шалгагч, технологийн шийдэл, эрх зүйн зохицуулалт

Оршил. Өмнө нь мэдээлэл эрж хайж олох нь ихээхэн бэрхшээлтэй, цаг хугацаа, хүчин чармайлт шаардсан үйл явц байсан. Харин орчин үед мэдээлэл олж авах нь хялбар болсон. Гагцхүү уг мэдээлэл үнэн бодит байдалд нийцэж байна уу гэдгийг магадлан, шүүлтүүртэй хандах нь гол асуудал болоод байна. Бидний амьдарч байгаа энэ эрин үед интернэтийн сүлжээнд холбогдсон компьютер, гар утастай хүн болгон мэдээлэл хүлээн авагч төдийгүй, өөрөө мэдээлэл бий болгож, түгээн дэлгэрүүлэгч болсон. Урд хожид байгаагүй ийм нөхцөл байдлын улмаас үнэн бодит байдалд нийцэхгүй мэдээлэл нийгэмд тархаж, хуурамч мэдээллийн уршгаар хүмүүс төөрөгдөлд автаж буруу шийдвэр гаргахад хүргэдэг байна. Өнөө үед хуурамч мэдээлэл тархаж байгаа гол талбар нь цахим орчин болсон гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Иймд цахим орчинд хуурамч мэдээллийн тархалтыг хэрхэн хязгаарлах вэ? гэдэг асуудлыг судлах нь чухал юм. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн зорилго нь цахим орчинд тархаж байгаа хуурамч мэдээллийн нөлөөнд автахгүйн тулд Монголын нийгэм ямар алхам хийх нь оновчтой вэ гэдэг асуултад хариулт олоход оршиж байна. Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн юм. Үүнд:

-хуурамч мэдээллийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй судалж мөн чанарыг нь тодорхойлох;

-дэлхийд тэргүүлэгч зарим улс орны төр засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлыг тоймлон судлах;

-Монгол Улсад цахим орчинд хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлахын тулд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг судалж үнэлэх

Материал ба судалгааны арга зүй. Сонгож авсан сэдвийн дагуу судалгааны ажлыг гүйцэтгэхдээ нийгмийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэдэг түүхчлэн үзэх, нэгжээс ерөнхий рүү шинжлэх, харьцуулах, мөн SWOT анализ хийх арга ашиглалаа. Хуурамч мэдээллийн тухай ойлголт, түүний мөн чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсны дараа Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Казахстан, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Европын Холбооны гишүүн орнуудад хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлахын тулд ямар арга хэмжээ авч байгаа тухай баримтуудыг нээлттэй эх сурвалжаас авч, харьцууллаа. Үүний дараа Монгол Улсад хуурамч мэдээлэл тархаж, олон нийтийг төөрөгдөлд оруулж байгаа нөхцөл байдалд SWOT анализын аргаар тодруулсан юм. Ингэснээр манай улсын нөхцөл байдал, онцлогт тохирсон шийдлийг санал болгох боломж бүрдэнэ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан цаг үеийн шинжтэй үйл явдал, үзэгдлийн тухай мэдээлэхээс гадна тодорхой асуудлыг хөндөж, олон нийтийн анхаарлын төвд оруулж, нийгмийн санаа бодлыг төлөвшүүлэх боломжтой. Иймд улс орны төрийн эрх баригчид, улс төрчид, геополитик, стратеги судлаач нар, цэрэг батлан хамгаалах салбарынхан мэдээллийг “зэвсэг” гэдэг өнцгөөс нь авч үзэж ашиглаж ирсэн байдаг. Дэлхийн улс орнууд ямар нэгэн сөргөлдөөний үеэр цэрэг зэвсгийн хүч ашиглаж ялалт байгуулахаас гадна өөртөө ашигтай нөхцөл байдлыг үүсгэхийн тулд урьдчилан төлөвлөж бэлтгэсэн мэдээллийг тогтмол хэвлэл, радио, телевиз, цахим мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгээж байгаа жишээ олон байгаа. “Мэдээллийн дайн” гэдэг нэр томьёо бий болж шинжлэх ухаанд судалгааны эргэлтэд орсон нь ч тохиолдлын хэрэг биш юм. АНУ-ын эрдэмтэн Т.Рон “Зэвсгийн тогтолцоо ба мэдээллийн дайн” илтгэлдээ “мэдээллийн дайн” гэдэг ойлголтыг хэрэглэжээ. (Кихтан В.В., Качмазова З.Н., 2018) Өнөө үед “мэдээллийн дайн” нь онолын түвшнээс хальж, аль хэдийнээ бодит амьдралд хэрэгждэг болсон гэдгийг дэлхийн олон орны судлаачид хүлээн зөвшөөрч байна. Мэдээллийн дайны үед ашигладаг нэг зэвсэг нь хуурамч мэдээлэл (англи. disinformation) юм. Хуурамч мэдээлэл нь интернэт бий болсноор гэнэт гарч ирсэн зүйл биш. Эртний хүмүүс ч хуурамч мэдээлэл санаатайгаар түгээж өөртөө давуу байдал бий болгож, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахад ашиглаж байсныг түүхийн ном судраас олж үзэх боломжтой. Орчин үед интернэтийн сүлжээ бий болсноор үнэн бодит байдалд нийцэхгүй хуурамч мэдээлэл тархах цар хүрээ нь эрс нэмэгдсэн тул анхаарал татсан асуудал болоод байгаа юм. Disinformation гэдэг нэр томьёог Монгол Улсын Аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн мэргэжилтнүүд хуурамч мэдээлэл гэж орчуулах санал дэвшүүлсэн байдаг. Олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх, үнэнийг бүрхэгдүүлэх зорилгоор хуурамч мэдээлэл түгээдэг.

Дэлхийн улс орнууд хуурамч мэдээллийг хязгаарлахын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгааг тоймлон авч үзье. ОХУ-ын эрх баригчид хуурамч мэдээллийн эсрэг тэмцэхэд хүчин чармайлт гаргаж байгаа гэж албан ёсоор мэдэгддэг бөгөөд “Олон нийтийн харилцаа, мэдээллийн технологи, харилцаа холбооны хяналтын алба” (орос хэлээр – Роскомнадзор) хэмээх байгууллагыг 2008 онд байгуулсан. Тус байгууллага нь ОХУ-ын нутаг дэвсгэрт интернэтийн сүлжээтэй холбоотой асуудлыг хариуцдаг бөгөөд веб сайт нээх зөвшөөрөл, веб сайт хаах, гадаадын орнуудын веб сайт руу ОХУ-ын нутгаас хандах боломж олгох эсэхийг ч шийддэг. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ) ба цахим орчинтой холбоотой харилцааг зохицуулах хэд хэдэн хууль ОХУ-д хүчин төгөлдөр үйлчилж байна. Жишээ нь, Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Худал мэдээг хориглох тухай хууль, Оросын армийг үгүйсгэхийн эсрэг хууль, Гадаадын агентын тухай хууль зэргийг дурдаж болно. Эдгээр хуулийг зөрчсөн гэж шүүх

үзвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх ял оноодог. Хуурамч мэдээлэл тархаж байгаа гол орчин нь Facebook, Instagram зэрэг өрнөдийн орнуудад үүссэн нийгмийн сүлжээ гэдэг байр суурийг ОХУ-ын эрх баригч баримталж байна. Иймд одоо ОХУ-д Facebook, Instagram зэрэг нийгмийн сүлжээг хориглож, үүний оронд Vkontakte, Odnoklassniki зэрэг ОХУ-д үүсгэн байгуулсан нийгмийн сүлжээг хэрэглэхийг ард иргэддээ уриалах болсон. ОХУ-д төрийн өмчийн радио, телевиз, Засгийн Газраас эрхлэн гаргадаг өдөр тутмын сонин хүчирхэг хэвээрээ байгаа бөгөөд хувийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьцааг эзэмших замаар төр хяналтаа тогтоосон. ОХУ-д амжилттай ажиллаж байгаа хараат бус, чөлөөт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хуруу дарам цөөхөн. Өрнөдийн орнууд ОХУ-ын эрх баригчдыг хэвлэлийн эрх чөлөөг хумьж байгаа, иргэдийнхээ үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг илт зөрчдөг, хөрш орнуудад болон барууны улс орнуудад худал мэдээлэл тараадаг гэж буруутгаж байна. Харин ОХУ-ын төрөөс дээрх гомдол нь үндэслэлгүй гэж тайлбарладаг.

БНХАУ-ын хуурамч мэдээлэлтэй тэмцэхийн тулд технологийн болон хууль эрх зүйн, үзэл суртлын аргуудыг хослуулан хэрэглэдэг. БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гадаадын орны зарим веб сайт руу нэвтэрч орох боломжгүй. Интернэтийн сүлжээтэй холбоотой харилцааг зохицуулах үүргийг БНХАУ-ын аж үйлдвэр ба мэдээллийн технологийн яам, Мэдээллийн системийн төрийн удирдлагын газар - SASAC, БНХАУ-ын Коммунист намын үзэл суртлын хэлтэс зэрэг байгууллагууд хүлээжээ. Facebook, Instagram, Youtube зэрэг өрнөдийн орнуудад үүсгэн байгуулсан нийгмийн сүлжээ, сошиал медиа руу нэвтрэх боломжгүй бөгөөд БНХАУ-д Wechat, Weibo, Youku зэрэг үндэснийх нь сайтууд бий. Үүний зэрэгцээ цахим орчинд түгээгдэж байгаа мэдээллийн агуулга, хэлбэр нь БНХАУ онцгой ач холбогдол өгөхийн зэрэгцээ төрийн мэдлийн телевиз, радио, мэдээллийн агентлагийн үйл ажиллагааг бэхжүүлж, хүчирхэгжүүлэхэд онцгой анхаардаг.

Казахстан Улсад хэвлэл мэдээллийн салбар төрөөсөө хэт хамааралтай. Нийгэмд тархаж байгаа аливаа мэдээллийг төр бүрэн хяналтдаа байлгахыг эрмэлздэг. Казахстан улсын “Мэдээлэл, нийгмийн хөгжлийн яам” нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой бүх харилцааг зохицуулдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах зөвшөөрөл олгох, цуцлахаас гадна ташаа мэдээлэл, нийгэмд тогтворгүй байдал үүсгэх эрсдэлтэй гэж сэжиглэсэн тохиолдолд хянан шалгах ажлыг хариуцдаг. Хууль эрх зүйн орчин талаасаа олон нийтийн хэвлэл мэдээллийг зохицуулсан нэг эх хуультай, ташаа, төөрөгдүүлсэн мэдээлэлтэй холбоотой асуудал эрүүгийн болон захиргааны хуулиар зохицуулагддаг. Казахстаны улсад аливаа ташаа, төөрөгдүүлсэн мэдээллийг үндэсний аюулгүй байдал, нийгмийг сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл эрүүгийн хэрэгт холбогдуулдаг хуулийн зохицуулалттай. Казахстан улсад сэтгүүлч мэргэжлийг үзэл суртлын зэвсэг, төрийн үзэл санааг л иргэдэд дамжуулах үүрэгтэй гэдэг байдлаар хандаж байгаа нь ажиглагдав. Тус улсын Засгийн Газар сэтгүүлчдийн дунд магадлан итгэмжлэл явуулж тусгай үнэмлэх олгодог. Тус үнэмлэхийг сэтгүүлч авснаар төрийн байгууллагуудаас мэдээлэл авах эрхтэй болдог. Өөрөөр хэлбэл магадлан итгэмжлэгдэж байж мэдээллийн эх сурвалжтай холбоо тогтоох боломж нь ихсэнэ. Казахстан Улс мэдээлэл-сэтгэл зүйн түрэмгийллээс сэргийлэх үндэсний чадавхаа нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн боловсрол олгох хичээлийг ЕБС-ийн дунд ангиас нь эхлэн заавал судлах хичээл болгосон. Мөн адил төстэй хичээлийг ахлах сургуульд сонгон суралцах хичээл хэлбэрээр оруулдаг байна.

АНУ бол Үндсэн Хуульдаа “Конгресс хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхийг

хязгаарласан хууль батлахыг хориглоно” хэмээн заалт оруулсан байдаг. Иймээс аль ч цаг үед АНУ-д үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарлахгүй гэсэн бодлого хэрэгжиж иржээ. Гэхдээ АНУ-д гол радио, телевиз, тогтмол хэвлэл, цахим мэдээллийн сайтууд нь томоохон медиа корпорацын бүрэлдэхүүнд байдаг. Жишээлбэл, “The Walt Disney” компанийн бүрэлдэхүүнд Disney Channel, ESPN, Pixar, Marvel Studios, ABC, Hulu зэрэг телевизийн суваг, кино студи байдаг бол Warner Bros корпорацын бүрэлдэхүүнд HBO, Warner Bros. Pictures, CNN, Discovery Channel, Eurosport зэрэг кино студи, телевизийн суваг байдаг. Тус улсад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хүчтэй нөлөөтэй боловч иргэд нь хуурамч мэдээлэлд автаж төөрөгдөлд орох нь түгээмэл байдаг гэж Холбооны Засгийн Газар дүгнэжээ. Хуурамч мэдээлэл тархаж байгаа гол талбар нь цахим орчин гэж үзээд АНУ-ын Холбооны Засгийн Газрын шийдвэрээр цахим орчинд хяналт тавих, хуурамч мэдээллийг илрүүлж устгах үүрэгтэй мэргэшсэн байгууллага ажиллуулж байна. Тухайлбал, 2018 онд Кибер Аюулгүй Байдлын Агентлаг (англи. Cybersecurity and Infrastructure Security Agency), 2020 оны Конгрессын сонгуулийн дараа АНУ Кибер аюулгүй байдлын орон зайн агентлаг (Cybersecurity and Infrastructure Security Agency) “CISA” хов, цуу ярианд хяналт тавих ажлыг эхлүүлсэн. Мөн нийгмийн сүлжээг үүсгэн байгуулсан технологийн компаниудтай хамтран ажиллаж хуурамч мэдээлэл цацагдсан бол тодорхой шалгуур үзүүлэлтээр задлан шинжилж, шаардлагатай бол тархах хүрээг нь хумих арга хэмжээг авдаг. АНУ-д хуурамч мэдээлэлд автахас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга бол иргэдийн боловсролыг дээшлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай мэдлэгтэй болгох явдал гэж үздэг байна. Жишээлбэл, “АНУ-ын иргэний боловсрол олгох төв”-ийн (англи. iCivic) хэвлэл мэдээллийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр зохиож ерөнхий боловсролын сургуулиудад санал болгодог байна.

Европын Холбооны гишүүн орнууд хуурамч мэдээллийн тархалтыг зогсоохын тулд хамтран ажилладаг онцлогтой. Европын Холбооны гишүүн 27 улс цахим аюулгүй байдлыг хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах, цахим орчин дахь харилцааг зохицуулах тус тусын үндэсний хэмжээний хуультай. Гэхдээ эдгээр хуулиуд нь Европын Холбооны салбар байгууллагуудаас баталсан эрх зүйн баримт бичгийн агуулгатай харшлах ёсгүй. Европын Холбооноос хуурамч мэдээллийн эсрэг авч байсан арга хэмжээ нь эхэн үедээ няцаалт хийх байсан бол сүүлийн үед Европын нэгдмэл байдлаар хуурамч мэдээлэлд хариу урвал үзүүлэх бодлого баримтлах болсон байна. Европын Холбоо нь “Төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх кодекс”, “Стратегийн коммуникацын салбар дахь Европын Холбооны төлөвлөгөө” зэрэг баримт бичгүүдийг баталжээ. 2018 онд Европын Холбооны гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага Европын комисс интернэтийн сүлжээ дэх төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх ажлын хүрээнд цахим платформууд үйл ажиллагаагаа ил тод болгох, Европын Холбооны орнуудын нутаг дэвсгэрт явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлагнадаг болох санаачилга гаргасан. Энэ хүрээнд “Төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх кодекс” (Code of Practice on Disinformation) хэмээх баримт бичгийг боловсруулсан. Уг баримт бичгийн нөхцөлүүдийг зөвшөөрч нэгдэх эсэх нь цахим платформуудын сайн дурын асуудал байх болно гэж тодотгосон. 2018 оны 10 дугаар сард энэ кодекс Facebook, Google, Twitter, Mozilla, 2019 оны 5 дугаар сард Microsoft компани, 2020 оны 6 дугаар сард Tik Tok нэгдсэн байна. Түүнчлэн интернэт орчинд зар сурталчилгаа явуулдаг томоохон аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр нэгдсэн. Төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх бодлого хэрэгжүүлэх явцдаа Европын Холбооноос авч хэрэгжүүлсэн дараагийн алхам нь хараат бус баримт шалгагчдыг дэмжих явдал байв.

Үүний тулд 2019 онд “Европын цахим хэвлэл мэдээллийн ажиглалтын төв” (European Digital Media Observatory /EDMO) үүсгэн байгуулжээ. Тус байгууллага 2020 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Хэвлэл мэдээллийн байгууллагууд, судлаачид, баримт шалгагчдад зориулсан салбар дундын хамтын төв бөгөөд хуурамч мэдээлэлд няцаалт өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 2019 оны 3 дугаар сарын 18-нд төөрөгдүүлсэн хортой мэдээллийн тухай шуурхай сэрэмжлүүлэх системийг (Rapid Alert System) Европын Холбооноос ажиллуулж эхэлсэн байна. Шуурхай сэрэмжлүүлэх систем нь дараах байдлаар ажилладаг. Европын Холбооны аль нэгэн гишүүн орон төөрөгдүүлсэн хортой мэдээлэл түгээж байгаа кампанит ажиллагааг илрүүлсэн бол Европын Комисс руу мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд тухайн мэдээллийн сэдэв, агуулга, мэдээлэл түгээж байгаа арга хэрэгсэл, болзошгүй үр дагаврын тухай дурдсан байдаг. Дараагийн шатанд уг мэдэгдлийг хүлээн авсан Европын Комиссын харьяа шинжээчдийн баг уг мэдээллийг шалгаж, дүн шинжилгээ хийнэ. Тэдний гаргах дүгнэлтэд үнэн бодит байдал, цар хүрээ, боломжит эрсдэлийн тухай өгүүлсэн байна. Гуравдугаар шатанд, хэрвээ төөрөгдүүлсэн хортой мэдээлэл түгээж байгаа нь тодорхой бөгөөд Европын үнэт зүйлс, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлнэ гэж дүгнэлт гаргасан бол Европын Комисс нь бүх гишүүн орнуудынхаа төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх ажлыг хариуцсан байгууллагууд руу сэрэмжлүүлэг тараана. Дөрөвдүгээр шатанд, сэрэмжлүүлэг хүлээн авсан гишүүн орнууд нь төөрөгдүүлсэн хортой мэдээлэлтэй тэмцэх хариу арга хэмжээг өөрсдийн онцлогтоо нийцүүлэн зохион байгуулна. Төөрөгдүүлсэн хортой мэдээлэл түгээж байгаа кампанит ажлыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлэн судлах, үнэн бодит байдалд нийцэхгүй мэдээллийг няцаасан мэдэгдэл гаргаж иргэдэд анхааруулна. Шуурхай сэрэмжлүүлэх систем нь төөрөгдүүлсэн хортой мэдээлэл түгээж байгаа кампанит ажиллагааны тухай цаг алдахгүй мэдэх, хамтын хүчээр хариу арга хэмжээ авахад дөхөм болдог. Мөн төөрөгдүүлсэн хортой мэдээллийн эсрэг тэмцэж, түүний эсрэг хариу арга хэмжээ авч байгаа туршлага солилцох, сургаж авах талбар болж байна. Цахим орчинд хуурамч мэдээллийн тархалтыг зогсооход иргэд өөрсдөө гол үүрэгтэй гэж Европын Холбоо үзэж байна. Иймд мэдээлэлд шүүлтүүртэй хандах, хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвартай болгохын тулд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас эхлээд их дээд сургуулийн оюутнуудад тусгай хичээл зааж байна.

АНУ-ын социологич, эрдэмтэн Ф. Сиберт, Т. Петерсон, У. Шрамм нар 1956 онд хамтран судалгаа хийсний үр дүнд “Хэвлэлийн дөрвөн онол” хэмээх бүтээл бичсэн. Уг бүтээлд дэлхийн улс орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны зарчим, нийгэмд гүйцэтгэж байгаа үүрэг оролцоо, нөлөөлөл, төр засгаас ОНМХ-д хандах хандлага зэрэгт ажиглалт хийж “сэтгүүл зүйн авторитари онол”, “нийгмийн хариуцлагатай сэтгүүл зүйн онол”, “зөвлөлт маягийн коммунист онол”, “сэтгүүл зүйн либертари онол” байдаг гэж нотолсон. Сэтгүүл зүйн салбар, хэвлэл мэдээллийн орчин нь улс төрийн дэглэм, тогтолцооноосоо хамаарч байгаа гэдэг таамаглалыг дээрх гурван эрдэмтэн нотолсон. Манай судалгааны ажлын явцад хуримтлуулсан баримт мэдээлэл, хийсэн ажиглалт нь “Хэвлэлийн дөрвөн онол” дагуу тайлбар дүгнэлт гаргахад хүргэсэн юм. Улс төрийн дэглэмийн хувьд авторитари шинжтэй улс орнууд ОНМХ-ийн үйл ажиллагаа, сэтгүүлчдийн уран бүтээлийн агуулга, цахим орчин, нийгмийн сүлжээ дэхь иргэдийн мэдээллийн харилцаанд хатуу хяналт тогтоосон байна. Харин либерал чиг баримжаатай улс орнуудад сэтгүүл зүйн салбарын үйл ажиллагаанд төр засаг нь аль болох хөндлөнгөөс оролцохгүй байх, нийтийн эрх ашгийг хамгаалахын тулд цахим орчинд тархаж байгаа хуурамч мэдээлэлд хязгаарлалт тогтоохыг оролдож байна.

Авторитари дэглэмтэй улс орнуудад хуурамч мэдээ, төөрөгдүүлсэн хортой мэдээлэл түгээсэн, бусдыг (ялангуяа улс орны лидерийг) гүтгэж нэр төрийг нь гутаасан гэж үзвэл 1-5 жил шоронд хорих ял оноодог хуулийн зохицуулалтай байна. Харин хэвлэлийн эрх, эрх чөлөөг дэмждэг улс орнуудад үнэн бодит байдалд нийцэхгүй мэдээллийг нь устгах (устгуулах), залруулга хийх боломжийг олгож, их хэмжээний мөнгөн торгууль оноох бодлого баримталж байна. Хуурамч мэдээ, төөрөгдүүлсэн хортой мэдээллийг ялгаж таних чадварыг ард иргэдэд эзэмшүүлэхийн тулд улс орон бүр өөрийн онцлог нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулж ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зааж байна. Судалгаанд хамрагдсан орнуудын хэвлэл мэдээллийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж үзэхэд, бага балчир насанд нь хүрээлэн байгаа орчных нь тухай бодит мэдээлэл, ойлголт өгөх, баримтыг харьцуулах чадвар суулгахад чиглэсэн агуулгатай байна. Мөн интернэтийн сүлжээний хэрэглээний соёл, мэдээлэл хайх, нийгмийн сүлжээнд хувийн аюулгүй байдлаа хэрхэн хангах тухай зааж сургаж байна. Нас ахих тусам дээрх үндсэн ойлголтоо улам гүнзгийрүүлж, мэдээллийн агуулга хэлбэрт дүн шинжилгээ хийх, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилладаг үндсэн зарчим, үүргийг тайлбарлаж, өөрсдөө контент бүтээх, кибер халдлагад өртөхөөс сэргийлэх тухай зааж сургаж байна.

Хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлахын тулд Монгол Улсад ямар алхам хийж байгааг одоо авч үзье. Манай улсын хувьд иргэдийн олонх нь нийгмийн сүлжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж эндүүрч байна. Үүний шалтгаан нь интернэтэд холбогдсон компьютер, гар утастай хүн бүр мэдээлэл хүлээн авагч, мэдээлэл үйлдвэрлэгч, мэдээлэл түгээгч болсон энэ үед мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллага ба үзэл бодлоо илэрхийлж байгаа хувь хүний хоорондын зааг ялгаа багассантай холбоотой. Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг. (Зулькафиль.М, 2018)

Эдгээр нь өөрийн гэсэн редакцтай, хүний нөөцтэй, мэргэжлийн хэм хэмжээг баримтлан ажиллахыг чармайдаг. Сэтгүүл зүйн онолд эдгээрийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ) гэж нэрлэдэг. Сэтгүүл зүйн салбарын багш, судлаачид бид интернэтийн сүлжээг бүхэлд нь ОНМХ гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдэгт санал нэгддэг. Төрийн эрх бүхий байгууллагаас албан ёсоор зөвшөөрөл (лиценз, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл гм.) үйл ажиллагаа явуулж байгаа өөрийн гэсэн редакцтай, бүх нийтэд хамаарал бүхий цаг үеийн шинжтэй үйл явдал, үзэгдэл, баримтыг цуглуулж, боловсруулж сэтгүүл зүйн бүтээл бэлтгэж, түүнийгээ олон түмэнд тогтмол давтамжтай түгээдэг веб сайтыг л ОНМХ-ийн тоонд оруулж тооцож болно гэдэг байр суурийг сэтгүүл зүй судлаачид баримталдаг. Интернэтийн сүлжээнд тулгуурлаж үйл ажиллагаа явуулдаг Facebook, Twitter, YouTube гэх мэт нийгмийн сүлжээг (social network) хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж тооцож болохгүй. Учир нь нийгмийн сүлжээнд бүртгүүлсэн ямар ч хэрэглэгч цахим орон зайд өөрийн хуудсыг бий болгож, түүндээ өөрийн үзэл бодлоо бичиж, гэрэл зураг, аудио видео бичлэг оруулж тодорхой хүрээллийн хүмүүст мэдээлэл түгээдэг. Ийм мэдээллийн агуулга нь гол төлөв хувь хүний дотоод ертөнц, ахуй амьдралтай холбоотой байдаг. Тухайн хүн сэтгэл санааны байдал, сэтгэл хөдлөл зэргээ нийгмийн сүлжээнд цахим хуудастаа илэрхийлж болно. Энэ бүх мэдээлэл нь илүү хувийн шинжтэй, гол төлөв найз нөхөд, дотнын хүмүүст нь зориулагдсан байх нь нийтлэг. Иргэдээс гадна янз бүрийн чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж

ахуйн нэгжүүд, төрийн байгууллагууд, ОНМХ-үүд нийгмийн сүлжээнд өөрсдийн албан ёсны хуудас (page) нээх нь ердийн үзэгдэл болов. Аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд ийнхүү нийгмийн сүлжээнд албан ёсны хуудсаа нээснээр харилцагч, үйлчлүүлэгч, хэрэглэгчидтэйгээ илүү эргэх холбоо сайжирна, бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлнэ, салбар дотроо нэр хүндээ өсгөнө гэсэн найдлага тавьдаг. Сонин сэтгүүлүүд, мэдээний төрөлжсөн веб сайтууд шинэ нийтлэлийнхээ линкийг байршуулах, радио телевизийн сувгууд эфирээ нийгмийн сүлжээгээр давхар шууд дамжуулах гэх мэт мэдээлэл хүлээн авагчдын тоогоо нэмэгдүүлэх зорилгоор технологийн бүх боломжийг идэвхтэй ашиглаж байна. Зарим сэтгүүлч олон нийтийн сүлжээнд хувийн аккаунт үүсгэхээс гадна ажил мэргэжлээ тодотгосон хуудас давхар үүсгэсэн байдаг. Уг талбартаа өөрийн үзэл бодлоо дэлгэрэнгүй бичих, өөрийн уран бүтээлээ сурталчлах зэрэг үйлдэл хийдэг. Гэтэл ихэнх интернэт хэрэглэгч нар хувь сэтгүүлч мэргэжилтэй хүн өөрийн цахим хуудсаар илэрхийлсэн хувийн үзэл бодол төдий цөөн мөр эх бичвэрийг нь сэтгүүл зүйн уран бүтээл мэтээр эндүүрч ойлгодог. “Нийгмийн сүлжээ бол ОНМХ юм.” гэсэн буруу ойлголт нийгэмд төлөвшөөд байна.

Манай судалгааны хүрээнд 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 1 дүгээр сарыг дуусах хүртэл хоёр сарын хугацаанд ажиглалт хийхэд Facebook нийгмийн сүлжээнд монгол хэлээр 50 хуурамч мэдээлэл тархсан байлаа. Өөрөөр хэлбэл, манай Монгол Улсад өдөрт хамгийн багадаа нэгээс хоёр хүртэлх тооны төөрөгдүүлсэн хуурамч мэдээлэл нийгмийн сүлжээгээр цацагдаж байна гэсэн үг юм. Судалгаа хийсэн хугацаанд олон нийтийн сүлжээнд цацагдсан үнэн бодит байдалд нийцэхгүй 50 хуурамч мэдээг сэдэв, хийсэн аргаар нь ангилсан.

Сэдэв	Тоо	Хувиар
Санхүү	13	26%
Эрүүл мэнд, анагаах ухаан	9	18%
Олны танил хүмүүсийн хувийн амьдрал	9	18%
Аваар, байгалийн гамшиг	5	10%
Уул уурхайн салбар	3	6%
Шинжлэх ухааны нээлт	3	6%
Гэмт хэрэг	2	4%
Шашин	1	2%
Бусад: гадаадын иргэдийн эсрэг чиглэсэнүндэс угсаагаар ялгаварласан гм.	5	10
Нийт	50	100%

Хүснэгт 1. Хуурамч мэдээллийн сэдвийн ангилал

Манай улсад 2020 онд байгуулагдсан “Монголын баримт шалгагчдын төв” нийгмийн сүлжээнд тархсан мэдээллийг нягталж үнэн бодит байдалд нийцэж байгаа эсэхийг нь өөрийн сайтдаа болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх гэж оролддог. Үнэн бодит байдалд нийцэхгүй мэдээллээс ард түмнийг сэрэмжлүүлсэн үүнээс өөр дорвитой алхам, арга хэмжээ, үндэсний хэмжээний хөтөлбөр байгаа эсэх нь бүрхэг байна. 2020 оны 6 дугаар сарын 29-нд манай улсын төрийн болон төрийн бус байгууллага, Үндэсний олон нийтийн радио, телевиз зэрэг нэр бүхий 15 байгууллага Монгол улсад хэвлэл мэдээллийн суурь боловсролыг нийгмийн бүхий л хүрээнд хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, шийдвэр гаргагч болон олон нийтийн

мэдлэг, ойлголт, хандлагыг дээшлүүлэх, бодлого шийдвэрт нөлөөлөхөд оролцогч талуудын нэгдмэл хүчин чармайлт, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх зорилготой Үндэсний сүлжээ байгуулахад гарын үсэг зурж байв. Уг баримт бичигт УИХ-ын Тамгын Газар, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Цагдаагийн Ерөнхий газар, Харилцаа Холбооны зохицуулах хороо, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний Нийгмийн Үндэсний Эвсэл, Глоб интернэйшл төв, Д.Нацагдоржийн нэрэмжит төв номын сан, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, МҮОНТВ-ийн “Гэр бүл” суваг, Хүүхэд Хамгааллын Үндэсний сүлжээ, Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн Газрын “Радио, телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлого, зохицуулалтын газар”, Монголын Хэвлэлийн Хүрээлэн нэгдсэн байна. Гэвч энэ “Үндэсний сүлжээ”-ний үйл ажиллагаа одоо ямар түвшинд байгаа, дээр нэр дурдсан олон байгууллагууд хэрхэн хамтран ажилладаг, ямар үүрэг, оролцоотой байх тухай дэлгэрэнгүй мэдээлэл нээлттэй эх сурвалжуудаас олдоогүй. 2020 оны 9 дүгээр сарын 23-нд Цагдаагийн Ерөнхий Газар худал мэдээлэлтэй тэмцэх бие даасан нэгж байгуулснаа зарласан бөгөөд тухайн үед энэ тухай өдөр тутмын хэвлэл, мэдээний сайтуудаар мэдээлсэн юм. Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, хурандаа Ж.Амгалан нь хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Эдийн засгийн аюулгүй байдал, хүн амын удмын сангийн аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын аюулгүй байдалд нөлөөлж байгаа энэ бүхэн үндэсний аюулгүй байдлын эсрэг чимээгүй дайн, хорлон сүйтгэх ажиллагаа, мөн үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээлэл тараах, бусдыг гүтгэх, доромжлох гэмт хэргийн шинжтэй мэдээллийг шалгах, таслан зогсоох чиглэлээр тухайн нэгж нь цахим орчинд худал мэдээлэлд хяналт шалгалт явуулна” гэж цохон тэмдэглэж байв. 2020 оноос “Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв” НҮТББ нь үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь зорилгоо технологи болон Монголын сэтгүүл зүйн экосистемд нийцсэн менежментийн хосолсон шийдлийг нутагшуулна гэж тодорхойлжээ. Хувийн хэвшил, төрийн байгууллагуудад социал маркетингийн контент үйлдвэрлэх үйлчилгээ үзүүлэх замаар санхүүжилт босгож, өөрийн www.uzeg.agency платформыг хөгжүүлэхийн зэрэгцээ “Mongolian Fact-Checking Center”-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байна. “Mongolian Fact-Checking Center” нь цахим орчинд цацагдаж буй мэдээллийг баримтаар нягталж, олон нийтэд үнэн, зөв мэдээлэл хүргэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Олон нийтэд аливаа мэдээллийн баримтыг нягтлах арга замыг үлгэрлэн зааварчлах, тэдний мэдээллийн боловсролыг дэмжих, сайжруулах зорилготой. “Mongolian Fact-Checking Center” нь АНУ-ын Poynter академийн дэргэдэх Олон улсын баримт шалгах сүлжээний (англи IFCN) баталгаат гишүүн байгууллага болсон. Түүнээс гадна Монгол Улсаас “Meta” компанийн Хөндлөнгийн баримт шалгах түнш болсон байгууллага. “Mongolian Fact-Checking Center”-ийн мэдээлэл шалгасан тайланд үндэслэж Meta компанийн алгоритм ажиллаж, facebook болон instagram-д тухайн мэдээлэлд үнэлгээ өгдөг. Мөн ижил төстэй агуулга болон хуваалцсан, реакц болон сэтгэгдлээр идэвхжүүлсэн тохиолдол бүрд мэдэгдэл хүргүүлэн, хуурамч мэдээллийг бууруулах чиглэлээр ажилладаг. “Mongolian Fact-Checking Center” нь редакцын зарчмаар ажилладаг бөгөөд орон тооны байнгын баримт шалгагч ажиллуулдаг. Редакц нь өөрсдийн сонголтоор сэжигтэй гэж үзсэн мэдээллийг, эсвэл иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд үндэслэн баримтын үнэн зөв эсэхийг нягталж шалгах ажлыг гүйцэтгэдэг. Аливаа мэдээллийг нягтлан шалгахдаа заавал анхдагч эх сурвалжтай холбогдоно. Холбогдох боломжгүй, эсвэл өгөгдсөн хугацаанд хариу авч амжаагүй нөхцөлд учир шалтгааныг заавал баримт шалган нийтлэхдээ дурдана. “Mongolian

Fact-checking Center” нь анхдагч эх сурвалжтай заавал холбогдох ч эцсийн дүгнэлтэд баталгаат эх сурвалжийн мэдээллийг чухалчилж үзнэ. Анхдагч болон баталгаат эх сурвалжийн мэдээллээр тухайн баримтыг батлах, эсвэл няцаах тохиолдолд тухайн эх сурвалжийг заавал ил тод мэдээнэ. Зөвхөн тухайн эх сурвалжийн хувийн аюулгүй байдал, эдийн засгийн баталгаат байдалд сөргөөр нөлөөлөхүйц тохиолдолд дурдахгүй байж болно. Гэхдээ энэ тухай аль болох дэлгэрэнгүй мэдээнэ гэсэн зарчим баримталдаг байна. (Монголын баримт шалгалгчдын төв, Баримт шалгах үйл ажиллагааны журам)

Хэлэлцүүлэг

Швейцарь улсын Цюрихын их сургуулийн эрдэмтэн Эдда Хумпреб, Франк Эссер, Антверпын их сургуулийн эрдэмтэн Петер Ван Аелст нар 2020 онд “Онлайн хуурамч мэдээлэлд тэсвэртэй байдал: Үндэстэн дамнасан харьцуулсан судалгааны хүрээ” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн. Тэд дэлхийн аль улсын иргэд цахим орчин дахь хуурамч мэдээлэлд автаж байгааг, ямар нөхцөлд хуурамч мэдээлэл өргөн цар хүрээтэй тархаж байгаа зүй тогтлыг судалсан байна. (Humprecht, Edda ; Esser, Frank ; Van Aelst, Peter, 2020)

Хэрвээ тухайн улсад:

-Үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь иргэдийнхээ оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй (өөрөөр хэлбэл хүмүүс сонин, радио, телевиз, мэдээний веб сайтад итгэдэггүй) бол хүмүүс албан бус мэдээллийн эх сурвалж, нийгмийн сүлжээнд хандах нь нэмэгддэг байна;

-Зар сурталчилгааны зах зээлийн орон зай их бол худал мэдээ, хуурамч мэдээлэл тархах нь таатай нөхцөл болдог байна;

-Нийгмийн сүлжээ (social network), нийгмийн медиа (social media) хэрэглээ их бол худал мэдээ, хуурамч мэдээлэл улам их тархах магадлал нэмэгддэг.

Энэ судалгааг хийсэн эрдэмтэд дараах гол дүгнэлтийг хийсэн. Энэ нь: улс төрчид, нийгмийн зүтгэлтнүүд, олны танил хүмүүс популизм бага хийдэг бол, иргэд нь албан ёсны ОНМХ-д итгэх итгэл өндөр бол, олон нийтийн статустай радио телевиз (public radio and public television) нь хүчирхэг бол, хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагаанд нийгмийн бүх гишүүд ямар нэг байдлаар оролцоотой бол, нийгмийн сүлжээ, сошиал медианы хэрэглээ бага бол цахим орчинд хуурамч мэдээлэл, худал мэдээ тархах нь бага байх болно. Дээрх эрдэмтдийн хийсэн судалгааны ажлын гол үзэл санаатай уялдуулан Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба цахим орчны өнөөгийн байдалд SWOT анализ хийж үзэв.

Давуу тал	-Үндэсний хэмжээний ОНМХ-ийн систем бүрэлдсэн. -Мэдээллийн харилцааг зохицуулах бодлогын баримт бичгүүд, хууль эрх зүйн орчин бүрэлдсэн. -Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх хангагдсан. -Монгол Улсад интернэт хэрэглээний үзүүлэлт хүн амын тоотой харьцуулахад харьцангуй сайн. -ХМХ-үүд нь social network идэвхтэй ашиглаж сэтгүүл зүйн бүтээлийн хүртээмжээ нэмэгдүүлэхэд анхаардаг. -Суурь боловсролыг үнэ төлбөргүй байна. Хүсвэл хувийн өмчийн ЕБС-д хүүхдээ сургаж болно. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг БСШУЯ-ны мэргэжилтнүүд хянаж, баталж сургалтад ашиглаж байна.	Боломж	-ОНМХ-д тавигдах техник технологийн шаардлага, шалгуурыг чангатгах, хүний нөөц, мэргэжлийн редакцын зөвлөлтэй байх шаардлага тавих боломжтой. -Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, үндэсний түүх, өв уламжлал, ёс суртахуун, шударга зан чанарыг сурталчилсан, шинэ инновацыг дэмжсэн агуулгатай нэвтрүүлэг, хөтөлбөр, кино бүтээх хангалттай хүний нөөц бий. -Гадаадын орнуудад чиглэсэн Монголыг сурталчлах тайз дэлгэцийн бүтээл гаргах, “Монголын дуу хоолой” радио станц, MNB World теле сувгийн үйл ажиллагааг өргөжүүлэх -ЕБС-д хэвлэл мэдээллийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулах. Энэ нь бие даасан, эсвэл нийгмийн тухай мэдлэг хичээлийн хүрээнд байж болно. -E-Mongolia системийг ашиглан иргэдэд санаачилгаараа ташаа мэдээлэл, төөрөгдүүлсэн хортой мэдээллийн тухай баримт шалгагч нар мэдээлдэг болох
Сул тал	-Хүн амын тоотой харьцуулахад хэт олон хэвлэл мэдээллийн байгууллагатай болсон нь нийгмийн санаа бодлыг төлөвшүүлэхэд бэрхшээл үүсгэсэн. -ОНМХ, мэдээллийн харилцааг зохицуулдаг хуулийн хэрэгжилт нь хангалттай хэмжээнд хүрээгүй. -Бусдыг гутаан доромжлох, ОНМХ-ийг хувийн явцуу ашиг сонирхолд ашиглах хандлага илэрдэг. -Мэргэжлийн редакцтай ОНМХ, ба social media-ын зааг ялгааг олон нийт мэдэхгүй байна. -Social network ашиглах соёл төлөвшөөгүй. Цахим орчинд цацагдаж байгаа мэдээлэлд иргэд дүн шинжилгээ хийж, шүүлтүүртэй хандах чадвар дутмаг.	Аюул занал	-Монголын ОНМХ-д гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, телевизийн хөтөлбөрт аль нэг улсын соёл, ахуй, амьдралын хэв маягийг сурталчилсан гадаадын нэвтрүүлэг, хөтөлбөр, киноны эзлэх хувь нэмэгдэх хандлага даамжирна. -Янз бүрийн эх сурвалжууд social network-д баталгаагүй, нягталж шалгаагүй мэдээлэл нийлүүлж нийгэмд хагарал, талцал, үл ойлголцол, хүмүүс төр засагт итгэх байдал буурах, бүгдийг үгүйсгэх, хоосон шүүмжлэх сэтгэлгээг төлөвшүүлэх аюултай. -Нийгмийн сүлжээнд тархаж байгаа дуулиантай цочирдом мэдээлэл нь нийгэмд айдас төрүүлж, нийт хүн амын сэтгэцийн эрүүл эмгэг үүсгэнэ

Хүснэгт 2. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба цахим орчны онөөгийн байдалд хийсэн SWOT анализ

Дүгнэлт

Хуурамч мэдээлэл гэдэг ойлголт нь хүн төрөлхтний мэдээллийн харилцаа бий болсон үеэс л бий болсон бөгөөд ХХI зуунд интернэтийн сүлжээ мэдээлэл харилцааны гол хэрэгсэл болсон энэ үед хуурамч мэдээлэл тархах цар хүрээ нь урд хожид байгаагүйгээр нэмэгдсэн тул дэлхийн бүх улс орны хувьд анхаарлаа хандуулах ёстой асуудал болж хувирсан байна. Хуурамч мэдээлэл бэлтгэж түгээж байгаа эх сурвалж нь хувь хүн, тодорхой ашиг сонирхлоороо нэгдсэн бүлэглэл, улс төрийн нам, гадаад оронд үүсгэн байгуулагдсан үндэстэн дамнасан корпорац, гадаадын улсын төр засгийн байгууллага ч байх бүрэн боломжтой. Дэлхийн улс орон бүр хуурамч мэдээллийн тархалтыг хязгаарлахын тулд хууль баталж, тухайн хуулийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн цахим орчин дахь харилцааг зохицуулах чиг үүрэгтэй төрийн байгууллага үүсгэн байгуулсан байна. Мөн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах баримт шалгагчдыг дэмжиж байна. Мэдээлэлд шүүлтүүртэй ханддаг чадвартай болгохын тулд бага наснаас нь эхлэн хэвлэл мэдээллийн боловсрол олгох сургалт явуулж байна. Зарим улс оронд тусдаа хичээл зааж байгаа бол зарим улс оронд ерөнхий боловсролын бусад хичээлийн агуулгад нь хэвлэл мэдээллийн боловсролын тухай агуулгыг оруулсан байна. Манай улсын төр засгаас, хууль хяналтын байгууллагууд, сайн дурын төрийн бус байгууллагууд хуурамч мэдээлэлтэй тэмцэх хүрээнд тодорхой алхмыг хийж байна. Гэхдээ технологи тасралтгүй хөгжиж байгаа учраас хүч нэмэгдүүлэн ажиллах хэрэгтэй гэсэн сорилттой тулгараад байгаа юм. Монгол Улс бол ардчилсан тогтолцоотой, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг Үндсэн Хууль болон бусад хуулиараа баталгаажуулсан улс. Иймд иргэдийнхээ эрхийг зөрчихгүйгээр цахим орчинд хуурамч мэдээллийг хязгаарлах алс хэтийн зорилгодоо хүрэхийн тулд мэдээлэлд шүүлтүүртэй ханддаг чадвар суулгах хичээлийг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулах нь оновчтой хувилбар юм. Түүнээс гадна өөрийн гэсэн редакцтай хэвлэл мэдээллийн байгууллагууд уран бүтээлээ чанаржуулж, аль нэг улс төрийн нам, ашиг сонирхлын бүлгээс хараат бус ажиллаж, сэтгүүлчид ёс зүйтэй ажиллаж, тэнцвэртэй мэдээллийг ард түмэнд хүргэх нь хуурамч мэдээлэл нийгэмд тархахаас сэргийлэхэд гол нөлөө үзүүлнэ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Кихтан, В. В., & Качмазова, З. Н. (2018). *Информационная война: Понятие, содержание и основные формы проявления*. Вестник Волжского университета имени В.Н. Татищева, 2(2)
- Зулькафиль, М. (2018). *Сэтгүүл зүйн тайлбар толь* (х. 147). Улаанбаатар: “Удам соёл”.
- Humprecht, E., Esser, F., & Van Aelst, P. (2020). *Resilience to online disinformation: A framework for cross-national comparative research*. The International Journal of Press/Politics, 25(3).
- Аюулгүй байдал судлалын хүрээлэн. (2019, November 4). Хуурамч мэдээ, хэвшинж, үр дагавар, нийгмийн сэтгэлзүйд үзүүлэх нөлөө-1. Retrieved December 15, 2024, from <https://niss.gov.mn/archives/1624>
- Зулькафиль, М. (2018). *Сэтгүүл зүйн тайлбар толь*. Улаанбаатар: “Удам соёл”.
- Монголын баримт шалгалгчдын төв. (2020). *Баримт шалгах үйл ажиллагааны журам*. Retrieved December 15, 2024, from <https://mfcc.mn/fcp-html/>
- Кихтан, В. В., & Качмазова, З. Н. (2018). *Информационная война: Понятие, содержание и основные формы проявления*. Вестник Волжского

- университета имени В.Н. Татищева, 2(2).
Сиберт, Ф., & бусад. (2016). *Хэвлэл мэдээллийн дөрвөн онол* (Орч. Зулькафиль).
Улаанбаатар: “Удам соёл”.
Humprecht, E., Esser, F., & Van Aelst, P. (2020). Resilience to online disinformation:
A framework for cross-national comparative research. *The International Journal
of Press/Politics*, 25(3).

Summary

In this article, the author discussed the possibility of limiting the spread of false information in the digital environment. The digital environment becoming a part of humanity's everyday use has created many advantages. At the same time, negative phenomena are also emerging, one of which is false information. Many countries around the world are focusing their attention on limiting the spread of false information. The author concluded that it is important to study the methods used by countries with differing political systems, economic situations, technological developments, and press freedom to limit the spread of false information, and to seek a suitable alternative for the specific circumstances of Mongolia.

Keywords: internet, information warfare, fact-checker, technological solutions, legal regulation

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН МАНИПУЛЯЦИ: МЕТА ТӨЛБӨРТЭЙ СУРТАЛЧИЛГААНЫ САНГИЙН ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН ШИНЖИЛГЭЭ

Д.Идэржаргал*, Л.Анударь**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд
профессор, доктор*

***МУИС-ийн Улс төрийн мэдээлэл харилцааны магистрант*

Түлхүүр үгс: Медиа манипуляци, Фэйсбүүкийн төлбөртэй сурталчилгаа, улс төр, мэдээлэл, алгоритмын нөлөө

Оршил. Медиа манипуляцийн талаарх ойлголт олон улсад 1920-иод оноос эхлэн сэтгэл судлал, улс төр, сэтгүүл зүйн шинжлэх ухааны огтлолцол дээр судлагдахуун болж эхэлжээ. Хүн төрөлхтний мэдээлэл хүлээн авах, дамжуулах, цуглуулах орчин, хэрэгсэл өөрчлөгдөхийн хэрээр манипуляцийн арга техник, онолын ойлголт ч үсрэнгүй өөрчлөгдөж ирсэн байна. Манайд энэ талаарх ойлголт ардчиллын өмнө улс төрийн ухуулга ба түүнийг хэрхэн боловсронгуй болгох талаас судлагдаж байсан ч ардчилаас хойш чөлөөт хэвлэл олширч эхэлснээр анх улс төрийн сонгууль, олон нийтийн үзэл бодолд өөрт ашигтайгаар эргүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглаж болдог талаарх ойлголт судлагдаж эхэлжээ. Улс төрийн манипуляци гэдэг үгийг ашигласан анхны[1] гэж хэлж болохуйц бүтээл 1998 онд хэвлэгдэж байжээ. Хожим нь энэ чиглэлээр хэд хэдэн өгүүлэл хэвлэгдэж байсан нь сонгуулийн сурталчилгаа, дипломат ажиллагаа зэрэгтэй холбон тайлбарласан өгүүллүүд байв.

Харин энэ судалгааны бүтээлээр медиа манипуляцийн онолын түүхэн хөгжил, орчин үеийн чиг хандлагыг тогтоож, манай мэдээллийн орчинд хэрхэн хэрэгжиж буйг бодитэйс дээр тулгуурлан гаргаж ирэх болно.

Судалгаанд бичиг баримт боловсруулах аргаар медиа манипуляцийн онолын шинжилгээг хийж, түүн дээр үндэслэн медиа манипуляцийн үндсэн шалгууруудыг боловсруулсан. Мөн Мета компанийн сурталчилгааны сан (Meta Ad Library)-гийн нээлттэй өгөгдлийг ашиглаж, 2025 оны 09 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 15-ны хооронд нийт **842 улс төрийн агуулгатай сурталчилгаа, 63 фэйсбүүкийн хуудаст**

тоон шинжилгээ хийж, түүний голлох постуудад контентын шинжилгээ хийсэн. Кэйс судалгаанд МАН-ын дотоод эрх мэдлийн зөрчил болох **Д.Амарбаясгалан ба Г.Занданшатар** нарын хоорондын улс төрийн зөрчлийг сонгон авч, тухайн үеэр фэйсбүүкээр дамжуулан хэрэгжүүлсэн мэдээллийн ажиллагааг системтэйгээр судалсан.

“Медиа манипуляци гэж юу вэ?”

Нэр томъёоны үүсэл, утга зүйн гарлыг авч үзвэл “Манипуляци” хэмээх үг нь латин хэлний **“manipulus”** буюу “гарын атгалт”, “багц зүйл” гэсэн үгнээс гаралтай бөгөөд *manus* буюу гар, *plere* буюу дүүргэх, барих гэсэн хоёр үгний нийлбэр юм. Анх физик утгаараа “гараар удирдах, зохицуулах” гэсэн утгатай байсан бол XIX зууны сүүл үеэс сэтгэл зүйн утгаар буюу **“хүний итгэл үнэмшил, хандлагыг нөлөөлөх, удирдах”** гэсэн ойлголт болж өргөжжээ (Bernays, 1928). Энэ нь улмаар XX зууны эхэн үеэс улс төр, олон нийтийн харилцаа, сэтгүүл зүйн салбаруудад мэдээллийн нөлөөллийг системтэй судалж эхэлсэн нь “медиа манипуляци” гэх ойлголтын үндэс болсон. **Уолтер Липпман** өөрийн *“Нийтийн үзэл бодол”* бүтээлдээ “хэвлэл мэдээлэл бодит байдлыг гажуудуулж, ‘хийсвэр орчин’ үүсгэдэг” гэж дүгнэсэн (Lippmann, 1922). Түүний үзлээр олон нийт мэдээллийг бодит туршлагаар биш, медиагаар дамжуулан хүлээн авдаг тул тэдний бодит байдлын тухай ойлголт зохиомол орчны бүтээгдэхүүн болдог. Энэ санаа нь орчин үеийн медиа манипуляцийн үндэс суурь юм. Медиа манипуляцийг тайлбарласан хэдэн зуун онол байдгаас тухайн түүхэн хугацааны мэдээллийн орчны онцлогийг харуулсан бөгөөд одоо ч хуучраагүй хэд хэдэн онол байгаа юм.

Он	Онол / чиглэл	Судлаач	Гол санаа	Медиа манипуляцтай холбогдох тайлбар
1922	“Хийсвэр орчин”	Уолтер Липпман	Медиа бодит байдлыг орлуулсан зохиомол ойлголтын орчин (“pseudo-environment”) бүтээдэг.	Олон нийтийн бодол санаа бодит туршлага бус, мэдээллийн дүрслэл дээр суурилан төлөвшдөг гэдгийг тайлбарласан суурь онол.
1927	Суртал ухуулгын онол, харилцааны загвар	Харолд Лассуэлл	Харилцаа нь “хэн - юу - ямар сувгаар - хэнд- ямар үр нөлөөгөөр” өрнөдөг бүтцэт процесс.	Манипуляцийн механизмыг эх сурвалжаас авхуулаад үр нөлөө хүртэлх бүх шаттай нь тайлбарлах онолын суурь.
1964	Медиа экологи	Маршалл Маклюэн	“Хэрэгсэл өөрөө мэдээлэл” буюу агуулгаас илүү хэрэгсэл нийгмийн ухамсарт нөлөөлнө.	Манипуляци зөвхөн мессежээр бус, технологи, сувгийн бүтцээр дамжин нөлөөлдөгийг тайлбарласан.
1972	Сэдэв тогтоох онол (Agenda-setting)	МакКомбс болон Шоу	Медиа олон нийтийн бодлын эрэмбийг тогтоож, анхаарлыг чиглүүлдэг.	Аль асуудал чухал мэт ойлгогдохыг медиа тодорхойлдог нь манипуляцийн гол механизм.

1993	Хүрээ тогтоох онол (Framing)	Роберт Энтман	Мэдээллийг ямар өнцгөөр хүргэж байгаагаас үнэлэмж, ойлголт бүрэлддэг.	Үйл явдлыг эерэг, сөрөг, тодорхой өнцгөөр зохиомлоор хүргэх замаар олон нийтийн хандлагыг удирдана.
1985-2000-аад	Астротурфинг	Ллойд Бентсен (нэршил),	Бодит олон нийтийн дэмжлэг мэт харагдах хиймэл сүлжээг зохион байгуулалттай бий болгох практик.	Хуурамч хаяг, зохион байгуулалттай сэтгэгдэл, масс репост ашиглан нийтийн санаа бодлыг хуурай дэмжлэгээр төөрөгдүүлэх арга.
2014	Платформын “хаалгач алгоритм”	Гиллеспи, Напполи	Редакторын оронд платформын алгоритм мэдээллийг хэнд харагдахыг шүүнэ.	Алгоритм манипуляцийн шинэ субъект болж, харагдах байдал өөрөө зохион байгуулагдана.
2016	Анхаарлын эдийн засаг	Тим Ву, Зубофф	Хүний анхаарал эдийн засгийн бараа болсон; эмоцид суурилсан контент давамгайлдаг.	Айдас, уур бухимдал дээр суурилсан мэдээлэл илүү хурдтай тархдаг нь сэтгэл зүйн манипуляцийн үндэс болдог.
2017	Мэдээллийн гажуудлын хүрээ	Уордл ба Дерахшан	Худал мэдээллийг 3 төрөлд ангилна: алдаатай, зориудын, төөрөгдүүлсэн.	Орчин үеийн манипуляцийн контентыг ангилсан системчилсэн суурь загвар.
2018	Тоон суртал ухуулга (Computational propaganda)	Вулли, Ховард	Ботууд, автомат контент, тархацын систем ашигласан улс төрийн мэдээллийн дайн.	Масс түгээх, хиймэл дэмжлэг үүсгэх технологит суурилсан манипуляци.
2019	Дийпфэйк технологи	Мюллер, Чесни	Хиймэл оюунаар бодит мэт дүрс, дуу үүсгэдэг технологи.	Итгэлцлийн үндсийг эвдэж, “ямрыг үнэн гэж мэдэх вэ?” гэдэгт эргэлзээ үүсгэн манипуляци гүнзгийрч байна.

Хүснэгт 1. Медиа манипуляцитай холбогдох онолуудын түүхэн хөгжил

Энэхүү онолуудын түүхэн хөгжлөөс харахад медиа манипуляцийн сонгодог болон хоёрдугаар үеийн онолууд мэдээлэгч ба үр нөлөөг илүү чухалчилж байсан бол дижитал мэдээллийн орчны шинэ үеийн онолууд суваг буюу алгоритм, мэдээллийн хүрээ тогтоолт, хүлээн авагчийн анхаарлын сэтгэл зүй гэсэн гурвал хүчин зүйлд төвлөрч байна. Ийнхүү медиа манипуляцийн механизм нь энгийн суртал ухуулгаас автоматжсан, сэтгэл хөдлөлд тулгуурласан систем рүү хувьсан өөрчлөгдсөн гэдгийг харуулж байна.

Эдгээр онолуудын нийтлэг болон онцлог талыг харьцуулж, медиа манипуляцийн дараах үндсэн 5 шалгуурыг гаргаж байна. Үүнд:

1. **Мэдээлэгчийн шинж** - нөлөөллийг санаачлагч, зохион байгуулагч субъект, далд эх сурвалж, хиймэл оролцооны илрэл;

2. **Мессежийн бүтэц** - хүрээ тогтоолт, анхаарлын чиглүүлэлт, хэсэгчилсэн гуйвуулалт;

3. **Суваг ба түгээлтийн арга зам** - уламжлалт медиа, сошиал сүлжээ, алгоритмд суурилсан масс тархац, автоматжуулсан систем;

4. **Хүлээн авагчийн сэтгэл зүйд нөлөөлөх** - айдас, уур бухимдал, бахархал зэрэг сэтгэл хөдлөлд тулгуурласан хандлага, үнэлэмжийг өөрчлөх аргачлал;

5. **Үр нөлөөний илрэл** - олон нийтийн анхаарлын шилжилт, итгэл үнэмшлийн өөрчлөлт, улс төрийн зан үйлд үзүүлэхийг завдаж буй нөлөө.

Энэхүү онолуудын түүхэн хөгжлөөс харахад медиа манипуляцийн механизм нь энгийн суртал ухуулгаас автоматжсан, сэтгэл хөдлөлд тулгуурласан систем рүү хувьсан өөрчлөгдсөн гэдгийг харуулж байна.

Манай улсад ч аливаа улс төрийн зөрчил, сонгуулийн кампанит ажил, олон нийтийн санаа бодлыг чиглүүлэхдээ олон нийтийн сүлжээг гол талбараа болгодог практик хэрэгжээд хэдэн жилийн нүүрийг үзэж байна. Нийгмийн үзэл бодлыг хуваасан, талцуулсан мэдээллийн сенсаци тогтмол нийгмийн сүлжээнд цацагдаж, мэдээллийн орчин замбараагүй болсныг хэрэглэгчид бид өөрсдөө гэрчилнэ. Хэдий цахим орчинд хүмүүс үймэлдэж, эмх замбараагүй байдал бий болж, аливаа нэг зүйл хямралын хэмжээнд хүрсэн мэт мэдрэмж бидэнд төрдөг ч, бодит нөхцөл байдал дээр энэ мэдрэмжийг зохиомлоор төрүүлэх зорилготой “багийнхан” бий болгодог. Энэ мэтчилэн медиагаар дамжуулан манипуляци хийж байна гэж хардахуйц олон үйл явдал болдгийг бид үнэхээр зохион байгуулалттай эсэхийг баталж чадахгүй, таамаглалын төдийд ихэд ярих болсон. Иймд манай мэдээллийн орчинд манипуляци хийгдэж байна уу? хийгдэж байгаа бол ямар онолын хүрээнд, ямар техникээр хийгдэж байгааг судлах зорилгоор саяхан болсон улс төрийн үйл явдал дээр шинжилгээ хийсэн нь Ерөнхий сайд Г.Занданшатар болон УИХ-ын дарга асан Д.Амарбаясгалан нарын улс төрийн зөрчил байлаа. Эхэндээ зөрчил төдий илэрсэн энэ үйл явдал нь гурван сар шахуу хугацаанд үргэлжилж, улс төрийн хямрал үүсэх нөхцөл байдалд хүргэсэн юм.

Хямрал үүссэн нөхцөл:

Л.Оюун-эрдэнийн Засгийн газар огцорсны дараа 2025 оны зургадугаар сарын 13-нд ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн томилох саналын дагуу түүний тамгын газрын даргаар ажиллаж байсан Г.Занданшатарыг Ерөнхий сайдад дэвшүүлж, УИХ санал хураан томилсон. Гэвч Г.Занданшатарын хувьд өмнөх засгийн газар огцорсон улс төрийн шинэ нөхцөл байдлаас үүдэн МАН-ын даргын албан тушаалыг аваагүй, Засгийн газарт эрх мэдэлтэй боловч МАН-д албан ёсны эрх мэдэлгүй байсан юм.

Ингээд МАН-ын Бага хурлаар намын даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх нь тодорхой болсон ба есдүгээр сарын 12-нд тухайн үед УИХ-ын даргаар ажиллаж байсан Д.Амарбаясгалан МАН-ын даргад нэр дэвшихээ зарласан. Үүнээс өмнө талуудын зөрчлийн шинж тэмдгүүд хэдийн илрээд эхэлсэн байсан ба есдүгээр сарын 27, 28-нд болсон МАН-ын Бага хурлаар Амарбаясгаланг намын даргаар батламжилсан. Энэ үйл явдал нь зөрчлийг зогсоох шалтгаан болоогүй бөгөөд Ерөнхий сайд Г.Занданшатар УИХ-ын гишүүн Б.Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар есдүгээр сарын 30-нд томилсон ч үүнийг УИХ хүлээн

зөвшөөрөөгүй. Тэрээр томилогдохоосоо өмнө Амарбаясгалант “Нүүрсний хулгай” гэх нүүрс олборлолт, борлуулалттай холбоотой авлигын хэрэгт холбогдуулж буруутгаж байсан.

Харин нөгөө талаас буюу Д.Амарбаясгалангийн талаас Г.Занданшатарын Засгийн газрыг огцруулах асуудлыг хөндөж эхэлсэн бөгөөд 10 дугаар сарын 17-нд Засгийн газрыг УИХ дахь санал асуулгаар огцруулахаар шийдсэн юм. Гэвч гурван өдрийн дараа буюу 10 дугаар сарын 20-нд ерөнхийлөгч У.Хүрэлсүх Засгийн газрыг огцруулсан шийдвэрт хориг тавьсан юм. Үргэлжлүүлэн Засгийн газрыг огцруулсан үйл явцыг хууль зөрчсөн эсэх маргаан Үндсэн хуулийн цэцэд хүрч 10 дугаар сарын 22-нд Г.Занданшатарын Засгийн газар огцорсон хуулийн үйл явцыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэн хүчингүй болгосон нь түүнийг албан тушаалдаа үлдэхэд хүргэсэн.

Үргэлжлүүлэн сөргөлдөгч талууд 11 дүгээр сарын 15-нд болох намын их хуралд бэлтгэж байсан боловч талууд зөвшилцөлд хүрэхээр шийдэн 11 дүгээр сарын 12-нд Д.Амарбаясгалан болон Г.Занданшатар нар намын даргын сонгуульд өрсөлдөхөөс татгалзаж буйгаа зарласан юм. Ингэснээр МАН-ын Их хурлаар Монгол тухайн үед Эдийн засаг, хөгжлийн сайдаар ажиллаж байсан Н.Учралыг намын даргаар сонгосон нь энэхүү зөрчлийг намжаасан.

Энэхүү улс төрийн зөрчил нь оргилдоо хүрч, оролцогч талууд маргаантай нөхцөл байдлыг өөрсдийн талд ашигтай эргүүлэхийн тулд Метагийн төлбөртэй сурталчилгааг ашиглан олон нийтийн санаа бодолд нөлөөлөх зохион байгуулалттай ажил хийснийг тус хугацаан дахь Мета платформын төлбөртэй сурталчилгааны тайлангаас харж болно.




График 1. Д.Амарбаясгалан болон Г.Занданшатар нарыг дэмжигч хуудсуудын кампанит ажилд зарцуулсан мөнгөн дүн

Энэхүү улс төрийн зөрчлийн үед Д.Амарбаясгалангийн хувьд 80 мянган ам.доллар, Г.Занданшатарын хувьд 9,5 мянга орчим ам.доллар ашигласан болохыг Метагийн нээлттэй өгөгдлийн сангийн тайланд тулгуурлан гаргаж ирсэн юм. Ингэхдээ 2025 оны 8-11 дүгээр саруудад Монгол улсаас нийт төлбөр төлж сурталчлуулсан (бүүстэлсэн) 639 хаягийн контентууд дотроос 100 ам.доллараас дээш дүнгээр бүүстэлсэн нийт 95 хаягийг ялган авсан. Энэ жагсаалтаас өндөр

мөнгөн дүн зарцуулсан хаяг тус бүрийн агуулгыг нягтлан тус кэйсийн хүрээнд хамгийн их дурдаглаж байсан “Амарбаясгалан”, “Занданшатар”, “нүүрсний хулгай”, “нүүрс”, “хулгайч”, “ардын нам”, “МАН” зэрэг түлхүүр үгсээр хайж, оролцогч талуудад хамаралтай фэйсбүүкийн хуудсуудыг гаргаж ирсэн. Үүний үр дүнд 2025 оны 9 есдүгээр сарын нэгнээс 2025 оны 11 дүгээр сарын 15-ны хооронд буюу тус улс төрийн хямралын эрчимжих хугацаанд 63 фэйсбүүк хуудсын 832 контентыг 90 мянга орчим ам.долларын төлбөртэйгөөр сурталчлуулсан байсан ба үүнээс 43 фэйсбүүк хуудсан 600 гаруй контентыг Д.Амарбаясгалан 80 гаруй ам.доллар, Г.Занданшатарын хувьд 23 фэйсбүүк хуудсын 200 гаруй контентыг 9,5 мянга орчим ам.доллар зарцуулж сурталчлуулсан нь дата шинжилгээнээс харагдаж байгаа юм.

Энэ нь Д.Амарбаясгаланг дэмжигч хаягууд илүү олон тооны Facebook хэрэглэгчдэд хүрснийг илтгэх бөгөөд судалгааны хугацаан дахь 75 орчим хоногийн хугацаанд дээрх хэмжээний мөнгийг сөргөлдөгч талууд зарцуулсан байна. Харин дараагийн графикт нийт хаягуудыг улс төрийн хамаарал, дэмжлэгийн байдлаар нь ангилсан ба энэ хэсэгт мөн Д.Амарбаясгаланг дэмжсэн хаягууд Г.Занданшатарыг дэмжсэн хаягуудаас ойролцоогоор хоёр дахин их байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл Д.Амарбаясгаланг дэмжигч хаягууд илүү олон мэдээллийн сувгаар буюу Facebook хуудсаар дамжуулан их хэмжээний мөнгө зарцуулан олон нийтэд хүрсэн байна.




График 2. Д.Амарбаясгалан болон Г.Занданшатар нарыг дэмжигч хуудсуудын тоо

Харин дараагийн графикт нийт хаягуудыг улс төрийн хамаарал, дэмжлэгийн байдлаар нь ангилсан ба энэ хэсэгт мөн Д.Амарбаясгаланг дэмжсэн хаягууд Г.Занданшатарыг дэмжсэн хаягуудаас ойролцоогоор хоёр дахин их байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл Д.Амарбаясгаланг дэмжигч хаягууд илүү олон мэдээллийн сувгаар буюу Facebook хуудсаар дамжуулан их хэмжээний мөнгө зарцуулан олон нийтэд хүрсэн байна.

10 дугаар сар нь Д.Амарбаясгалан болон Г.Занданшатар нарын зөрчлийн хувьд чухал цаг үе байсан бөгөөд энэ үед өрсөлдөгчөө гутаах, дайрах үзэгдлүүд нэмэгдэхтэй зэрэгцээд Засгийн газрыг огцруулах эсэх асуудал гол асуудал болсон явдал байсан юм. Энэ сард хоёр талууд нийт 599 сурталчилгааг түгээсэн байгаа ба 9 болон 11 дүгээр сарыг нийлүүлснээс ойролцоогоор хоёр дахин их байгаа юм.

Дээрх дүгнэхэд Д.Амарбаясгаланг дэмжигч хуудсууд Г.Занданшатарын хуудсуудаас зохион байгуулалт (coordination), нөөц (хуудасны тоо, зарцуулсан мөнгөн дүн) зэргээр давамгайлж байсан гэж дүгнэж болохоор байна.




График 3. 9-11 сарын хооронд түгээсэн нийт сурталчилгааны тоо

Хэдийгээр зөрчилд оролцогч эдгээр талууд тус кампанит ажлыг санхүүжүүлсэн гэдэг шууд нотолгоо байхгүй ч мэдээлэл түгээсэн хугацаа, түүнд гаргасан зардал, сүлжээний хэлбэр, мэдээллийн агуулга зэргээс харахад өөр хэн нэгэн дэмжигч үзэл бодлынхоо хүрээнд ийм өндөр төлбөрөөр, ийм өндөр зохион байгуулалттай ажилласан гэхэд итгэхэд бэрх.

Мэдээллийн агуулга, өгүүлэмж болон манипуляцийн техникийг нарийвчлан илрүүлэх зорилгоор оролцогч талуудын мэдээлэл түгээж байсан голлох сувгуудын тус бүр 90 контент буюу нийт 180 гаруй төлбөртэй постод контент шинжилгээ хийж үзсэн болно. Шинжилгээний үр дүнд дараах үр дүнгүүд илэрсэн.

Мэдээлэл түгээсэн нийт хуудсуудын нэрээс харахад “мэдээ” “мн” гэсэн үг хэллэг бүх хуудсуудын нэрэнд орсон байсан ба албан ёсны мэдээллийн хаяг мэт дүр үүсгэж олон нийтийг төөрөгдүүлэх зорилготой байсан нь харагдаж байгаа юм. Эдгээр фэйсбүүк хуудсуудаас хамгийн их мөнгө зарцуулсан хуудас нь Д.Амарбаясгалангийн хувьд “Шинэ эхлэл”, Г.Занданшатарын хувьд “Монгол мэдээ” хуудсууд байсан юм.

Мэдээллийн агуулга, өгүүлэмж болон манипуляцийн техникийг нарийвчлан илрүүлэх зорилгоор оролцогч талуудын мэдээлэл түгээж байсан голлох сувгуудын тус бүр 90 контент буюу нийт 180 гаруй төлбөртэй постод контент шинжилгээ хийж үзсэн болно. Эдгээр 180 гаруй контентыг өгүүлэмж болон бүүст хийсэн дүнгээр харахад дараах дүр зураг харагдаж байна.

Дээрх хоёр графикаас харахад Д.Амарбаясгаланг дэмжсэн кампанит ажлын стратеги нь **олон хуудсаар ижил агуулгыг давтамжтай, өндөр төсөвтэй түгээж**, тархацын тоон хэмжээг зориудаар өсгөсөн нь ажиглагдлаа.

Контентын агуулгын хувьд:

- Г.Занданшатарын танхимын үйл ажиллагааг шүүмжилсэн.
- Д.Амарбаясгаланг дэмжсэн УИХ-ын гишүүдийн ярилцлага, чуулганы үеэр хэлсэн бүхий богино бичлэгүүд




График 4. Д.Амарбаясаланг дэмжсэн хуудсууд ба түгээсэн сурталчилгааны тоо

СЭТГҮҮЛ ЗҮЙН ШҮҮМЖ, СУДАЛГАА




График 5. Г.Занданишатарыг дэмжсэн хуудсууд болон түгээсэн сурталчилгааны тоо

· Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн байр суурь бүхий мэдээллүүдийг түлхүү тараасан байна.

Үүнээс медиа манипуляцийн түгээмэл техникүүд болох **сонгож мэдээлэх (framing)**, хиймэл олон нийт үүсгэх (астратурфинг) буюу олон сувгийн давтамжит түгээлтээр “давагдсан үнэн мэт ойлголт” бий болгох гэх мэт **мэдээллийн хүрээгээр тоглодог нарийн манипуляцийн техникүүд** байсан нь ажиглагдав. Ингэж нэг талын өнцгийг өндөр санхүүгийн нөлөөгөөр давамгайлуулж харагдуулах нь:

- бодит, тэнцвэртэй, редакцын шалгууртай контентын үзэлт, органик хандалтыг шахаж,
- хэрэглэгчдийг **мэдээллийн хөөс (filter bubble)**-д оруулж,
- олон нийтийн бодитой, бүрэн мэдээлэл авах эрхийг системтэйгээр хязгаарлаж буй хэлбэр хэмээн үнэлэгдэхээр байна.



График 6. Д.Амарбаясгаланг дэмжигч хуудсуудын сэдвийн өгүүлэмж ба сурталчилгааны төлбөрийн хэмжээгээр багцлан харуулсан нь

Харин Г.Занданшатарын кампанит ажлын стратеги нь цөөн тооны хуудсаар, харьцангуй бага зардлаар буюу ихэнх тохиолдолд 100 ам.доллараас бага үнийн дүнгээр түгээсэн байна. Гэсэн ч агуулгын хувьд гарчгаар төөрөгдүүлэх (misleading headlines) хурц, туйлширсан үг хэллэг ашиглах, айдас, уур бухимдлыг өдөөх замаар сэтгэл хөдлөлд суурилсан эх сурвалжаар нотлогдоогүй хуурамч агуулгаар харлуулах хандлага давамгайлсан байна. Энэ нь органикаар хандалтыг өдөөж байгаа нь бага дүнтэй хэдий ч хүрсэн хүмүүсийн тооноос харагдаж байгаа юм. Ингээд хоёр талыг харьцуулбал:

Д.Амарбаясгаланг дэмжигч талын хувьд мэдээллийн агуулгыг харьцангуй бодит эшлэлд суурилуулсан ч асар өндөр санхүүгийн нөлөөгөөр олон сувгаар давтан тарааж, мэдээллийн орчны тэнцвэрийг алдагдуулах **“тоон давамгайлалд**

суурилсан манипуляци” ашигласан.

Г.Занданшатарыг дэмжигч талын хувьд цар хүрээ багатай ч сэтгэл хөдлөл, сенсаци, хуурамч мэдээ, гарчгийн төөрөгдөл ашиглан хүлээн авагчдын бодол сэтгэлд шууд нөлөөлөхийг зорьсон “агуулгын хурц хэлбэрт суурилсан манипуляци” явуулсан.

Эдгээр шинжилгээний үр дүнд суурилан дүгнэхэд манай улсад медиа манипуляци хийгдэж байгаа нь өгүүллийн эхний хэсэгт дурдсан манипуляцийн шалгууруудыг тус кэйс хангаж буй байдлаас илэрхий болж байна. Ингэхдээ платформын алгоритмд суурилсан байдлаар ихээхэн санхүүжилттэй кампанит ажил хийсэн болох нь тогтоогдлоо.




График 7. Г.Занданшатарыг дэмжигч хуудсуудын сэдвийн өгүүлэмж ба сурталчилгааны төлбөрийн хэмжээгээр багцлан харуулсан нь.

Хэдийгээр зөрчилд оролцогч эдгээр талууд энэ кампанит ажлыг санхүүжүүлсэн гэдэг шууд нотолгоо байхгүй ч мэдээлэл түгээсэн хугацаа, түүнд гаргасан зардал, сүлжээний хэлбэр, мэдээллийн агуулга зэргээс харахад өөр хэн нэгэн үзэл бодлынхоо хүрээнд ийм өндөр төлбөрөөр, ийм өндөр зохион байгуулалттай ажилласан гэхэд

итгэхэд бэрх. Ийм төрлийн манипуляцийг зохицуулах нь улс орнуудын хувьд сорилт болж байгаа ба шууд хатуу зохицуулалт хийхээс илүүтэй энэ чиглэлийн судалгааг олшруулж, арга техникийг олон нийтэд таниулах нь хамгийн том хамгаалалт болж байна (Bennett, W. Lance; Livingston, Steven, 2018).

Ашигласан бүтээлийн жагсаалт

Bennett, W. L., & Livingston, S. (2018). The disinformation order: Disruptive communication and the decline of democratic institutions. *European Journal of Communication*, 33(1), 122–139.

Bernays, E. L. (1928). *Propaganda*. New York, NY: Horace Liveright.

Lippmann, W. (1922). *Public opinion*. New York, NY: Harcourt, Brace and Company.

Summary

This article presents the findings of a study examining how media manipulation is being implemented within Mongolia’s political information environment, based on open data from Meta’s Ad Library on paid political advertising. Within the scope of the study, the historical development of media manipulation theory and contemporary trends are synthesized, and five key criteria are developed focusing on digital platform algorithms, the attention economy, and emotion-based mechanisms of influence.

The empirical analysis covers data from 842 political advertisements distributed in Mongolia between September 1 and November 15, 2025, as well as data from 63 Facebook pages. As a case study, the research focuses on the political conflict between D. Amarbaysgalan and G. Zandanshatar within the Mongolian People’s Party (MPP).

The results of quantitative and content analysis indicate the prevalence of highly funded and organized dissemination, astroturfing, agenda-setting/framing practices, and narratives grounded in fear and anger. In alignment with platform algorithms, emotionally driven content was delivered to the public more intensively than policy-oriented information. The study demonstrates that algorithm-based, systematic media manipulation is being practically implemented within Mongolia’s information environment and emphasizes the importance of enhancing research-based understanding and increasing public awareness of such influence.

[1] The academic article “Political Manipulation” written in 1998 by researcher E. Munkhtsetseg is assumed—based on my search—to be the earliest work on this topic.

Keywords: Media manipulation, Facebook advertising, political communication, information environment, platform algorithms

ТЕЛЕВИЗИЙН УРАН САЙХНЫ КИНОНЫ ҮЗЭЛ САНАА, ДҮРСЛЭЛ ҮЗЭГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙ, НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛД НӨЛӨӨЛӨХ НЬ (1990 оноос өмнөх Монголын уран сайхны кинонд буддын шашныг дүрсэлсэн байдлын жишээн дээр)

Л.Ариун*

**Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Сэтгүүл зүй,
медиатехнологийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) дэд профессор*

Түлхүүр үгс: Суртал ухуулга, уран сайхны кино дахь буддын шашны агуулга, телевизийн үр нөлөө, телевизийн уран сайхны кино

Оршил. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр дундаас телевизийн үзэгчдэд үзүүлэх үр нөлөөг хэмжээлшгүй хэмээдэг. Үүссэн цагаасаа эхлэн үзэгчдийн анхаарлын төвд байж дэлгэцээр үзүүлсэн бүхнээрээ үзэгчдийн итгэл үнэмшлийг авч байлаа. Өдгөө телевиз гэсэн байр сууриа социал медиагийн дижитал контентод алдаж байгаа ч үзэгчдийг соронз мэт татаж буй тэдгээр контентууд телевизийн сэтгүүл зүйн үндсэн арга зүй, арга барилаар бүтээдэг видеонууд байна. Энэхүү анхаарал татах өндөр чадвараа дагаад үзэгч олон нийтэд үзүүлэх үр нөлөө мөн адил өндөр байдаг. Судлаачид телевизийн үүрэг, үр нөлөөг мэдээлэх, соён гэгээрүүлэх, боловсрол олгох, зохион байгуулах, зугаацуулах хэмээн тодорхойлсон байдаг ба эдгээр шинж чанараараа үзэгчдийн итгэл үнэмшил, соёл, боловсрол, шийдвэр гаргах үйл явц цаашлаад сэтгэл зүйд ч маш их нөлөө үзүүлдэг хэмээдэг.

Телевиз уран сайхны киног үзэгчдэд өргөн хүрээнд хүргэх, хүлээн авах орчныг бүрдүүлдэг гол суваг. Телевизийн сувгаар дамжин хүргэж буй уран сайхны кино тэр дундаа 1990 оноос өмнө гарсан уран сайхны кинонд буддын шашныг хэрхэн дүрслэн үзүүлж буй байдал, тэр нь үзэгчдийн сэтгэл зүй, соёлын үнэлэмж, нийгмийн ойлголтод хэрхэн нөлөөлдөгийг судлах нь энэхүү судалгааны ажлын зорилго юм.

Үндэслэл

Социализмын үед Монгол Улсад телевиз, кино нь төрийн үзэл суртал түгээх хамгийн гол хэрэгсэл байв. “Хүн ардыг гэгээрүүлэхэд “кино” гэгч үзвэр асар их үүрэг гүйцэтгэсэн. 1921 онд Ардын хувсгал ялснаас хойш хүн амын зонхилох хэсэг

нь бичиг үсэг мэдэхгүй байсан нөхцөлд соён гэгээрүүлэх, цаашид нам төрийн үзэл бодлыг сурталчлах, Марксист онолыг түгээн дэлгэрүүлэхэд кино урлаг нь чухал хэрэглүүр болох юм байна гэдгийг ойлгож, түүнийг өргөн ашиглах нь зүйтэй юм гэж үзсэн байна” (Т.Сарантуяа, 2015) гэж кино судлаачид тэмдэглэсэн байна. Энэ нь Монголын кино урлаг үүссэн цагаасаа эхлэн суртал ухуулгын зорилготой байжээ гэж үзэж болохоор байна. Энэ үед уламжлалт буддын шашныг “хуучин феодалын дэглэмийн үлдэгдэл”, “ард түмнийг мунхруулдаг хүч” хэмээх агуулгаар ТВ болон уран сайхны кинонуудад гажуудуулан дүрслэж байв. Судлаачид телевизийн бүхий л нэвтрүүлэг үзэгчдийг соёл, ёс суртахуунд сургаж байдаг хэмээдэг. “Телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөр бүхэн аль ч талаараа олон нийтийн соёл боловсролтой холбогдож, тэдгээрийн дотроос ард түмнийг соён гэгээрүүлэх чиглэлийг дагнан барьсан шинжлэх ухаан, боловсрол, соёл урлагийн тусгай нэвтрүүлэг хөтөлбөрүүдийн энэ шинж бүр ч ил тодорхой байдаг” (Л.Норовсүрэн, 2009) хэмээн доктор Л.Норовсүрэн “Телевизийн сэтгүүл зүй” номондоо тэмдэглэсэн байна. Тиймээс улс орнууд гадны соёл, үнэт зүйлийг сурталчилсан нэвтрүүлэг, кино, контент гаргах нь үндэсний соёлд сөргөөр нөлөөлдөг хэмээн үзэж 1970 оноос хойш Европын орнууд “мэдээллийн чөлөөтэй урсгал”-ыг соёлын нөлөөллийн хэрэгсэл гэж үзэж үндэсний соёл, хэл, үнэт зүйлсийг хамгаалах бодлого хэрэгжүүлж ирсэн байдаг. Энэ бодлого телевиз, кино, хөгжим, дижитал медиа салбарт үндэсний соёл уламжлалаа шингээсэн контент давамгайлуулах, гадаад контент, үндэсний соёлыг үгүйсгэж гутаасан нэвтрүүлгийг хязгаарлах хэлбэрээр хэрэгжиж байна. Монгол улсад 2021 оноос хойш арилжааны телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 хувиас доошгүй, өргөн нэвтрүүлгийн телевизийн 60 хувиас доошгүй нь үндэсний бүтээл, нэвтрүүлэг байна хэмээн хуульчилсан (шаардлага, 2021) Ийнхүү 1970 оноос хойш телевизийн кино, урлагийн бүтээлүүд олон нийтийн үзэл, үнэт зүйл, соёл, нийгмийн сэтгэл зүйд хүчэй нөлөөлдөг юм байна хэмээн судлаачид үзэж “Соёлын түрэмгийлэл” /cultural aggression буюу cultural imperialism/ хэмээн нэр томъёогоор тодорхойлж ирсэн байдаг. Соёлын түрэмгийлэл бол эдийн засаг, улс төр, мэдээлэл, соёлын ноёрхлын цогц систем юм. Үндэсний соёлоо үгүйсгэн устгаж гадаадын соёл, үзэл суртал, бизнесийн сонирхолд уусан улмаар соёлын хараат байдал бий болдог хэмээдэг. (Schiller, 1969) Мөн соёлын түрэмгийлэл гэдэг нь өөрийн хэл, шашин соёл, үнэт зүйл, амьдралын хэв маяг зэргийг тулгах үйл явц юм. Энэ нь улс төрийн ноёрхол, эдийн засгийн хамаарал, мэдээллийн урсгал зэргийг бий болгоход үндсэн хүчин зүйл болдог гэж судлаачид тодорхойлжээ. Саид (Said, 1993) ийн үзснээр, соёл нь зөвхөн ард түмний үнэт зүйл, сэтгэлгээний илэрхийлэл бус, харин империализмын үзэл санааг бүрдүүлэх, түгээх, зөвтгөх механизмын нэг хэсэг юм. Тиймээс соёлын бүтээлүүд нь эрх мэдэл, ноёрхлын системийг хадгалах болон эсэргүүцэх аль алинд ч ашиглагддаг гэжээ. Соёлын түрэмгийлэлийн тухай онолын үүднээс судлагдаж эхэлсэн нь 1970 он, жишээ авдаг нь Америкийн соёлын түрэмгийлэл хэдий ч энэ үйл явц манай оронд 1930- аад оноос кино үйлдвэрлэл эхэлсэн цагаас л уламжлалт шашин, соёлоо илт гутаан доромжилж, мушгин гуйвуулан Марксист онол, шинэ социалист хүнийг төлөвшүүлэх, хуучин нийгмийг няцаах, нам төрийн бодлогыг сурталчлан бүтээсэн кинонууд ард түмний үзэл бодол, үнэт зүйл, соёлд нэвт шингэж ирсэн байдаг. Энэхүү үзэл суртлын нөлөөгөөр Монгол үндэсний соёлын онцлог, уламжлал алдагдаж, өөрийн үнэт зүйлийн итгэл үнэмшил суларч гадаадын соёлыг шүтэх үзэл хандлага түгж, үндсэний хэл бичиг солигдон өөрчлөгдөж түүнийг дагасан соёлын олон сайхан зүйлс устаж үгүй болсон сөрөг нөлөөтэй.

Онолын үндэслэл. 1921 онд ардын хувсгал ялсанаас хойш социалист үзэл

суртлыг түгээх, уламжлалт буддын шашныг бүрэн устгах төрийн бодлого хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Энэ үйл явцад кино, дуу хөгжим, жүжиг уран зохиол, сонин, радио, телевиз зэрэг нийтийн соёлын хэрэгсэлийг ашигласан юм. Суртал ухуулга, соёлын түрэмгийлэл, мэдээллийн манифуляцийн арга хэрэгсэл ашиглан 70 жилийн турш хийсэн зорилтот ажлын үр нөлөөг нийгмийн ухааны олон салбарын хүрээнд судлах шаардлагатай юм. Нийтийн соёлын хэрэгслээр буддын шашныг гутаан үгүйсгэн буруугаар ойлгуулж ирсэн суртал ухуулга, соёлын түрэмгийлэл, мэдээллийн манифуляцийн тухай үндсэн ойлголт, аргуудын талаар авч үзье.

Суртал ухуулга нь нийгмийн сэтгэл зүй, үзэл бодол, итгэл үнэмшлийг тодорхой зорилгод нийцүүлэн өөрчлөх, чиглүүлэх зорилготой мэдээллийн системтэй үйл ажиллагаа юм. Britannica-д тайлбарласнаар “бусдын итгэл үнэмшил, хандлага, үйл хөдлөлийг янз бүрийн бэлгэдэл, мэдээллийн аргаар системтэйгээр удирдах буюу нөлөөлөх оролдлого” гэж тодорхойлжээ (Britannica, 2024) Үүнтэй ижил утгаар Encyclopedia of Military Science-д суртал ухуулгыг “тодорхой байр суурийг дэмжүүлэх буюу захирагдуулах зорилгоор харилцаа холбоог системтэй ашиглах, итгэл үнэмшилд нөлөөлөх зорилготой үйл ажиллагаа” гэж тэмдэглэсэн байна. (Science, 2013) Энэ тодорхойлолтоос харахад суртал ухуулга нь зөвхөн мэдээлэл түгээх бус, үзэл суртлыг төлөвшүүлэх, нийгмийн ухамсарт зохиомол үнэлэмж бий болгох хэрэгсэл юм гэж ойлгож болохоор байна. Collins English Dictionary-д суртал ухуулгыг “төр, хөдөлгөөн зэрэг тодорхой байгууллага, зорилгын төлөө эсвэл эсрэгээр нь мэдээлэл, мэдэгдэл зэргийг зохион байгуулалттайгаар түгээх үйл ажиллагаа” гэж тодорхойлдог (Dictionary C. E., 2024). Cambridge Dictionary-д бол суртал ухуулгыг илүү ёс зүйн талаас авч үзэж, “хүмүүсийн үзэл бодолд нөлөөлөх зорилгоор мэдээлэл, санааг санаатайгаар түгээдэг бөгөөд энэ нь бүх баримтыг ил тод гаргахгүй, эсвэл нэг өнцгөөс л онцлон харуулах хэлбэртэй байдаг” гэж тайлбарлажээ (Propaganda., 2024) “Шашныг газрын хөрснөөс арчиж, цагаан цаас бүтээх, түүн дээрээ социалист үзэл суртлыг бичихийн тулд коммунистууд хүмүүний түүхэн дэх хамгийн том суртал ухуулгын аяныг өрнүүлсэн. Тийм ч учраас бид ихэвчлэн суртал ухуулга гэсэн үгийг шуудхан социалист нийгэмтэй холбож ойлгодог болсон.” (сонин, 2015) хэмээн “Зууны мэдээ” сонинд гарсан “Суртал ухуулгаар дутахуй” нийтлэлд өгүүлсэн байна. Эдгээр тодорхойлолтоос үзэхэд суртал ухуулга нь аливаа төр, байгууллага, улс төрийн хүчний зорилгод нийцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ухамсарт нөлөөлөх системтэй үйл ажиллагаа бөгөөд тухайн нийгмийн үнэт зүйл, итгэл үнэмшилд гүнзгий нөлөөлөх сэтгэл зүйн болон соёлын зэвсэг гэж ойлгож болно.

Херберт Шиллер соёлын түргэмгийллийг Америкийн эзэнт гүрний “албадлага ба ятгалгын байгууллагуудын нөлөө” гэж тодорхойлсон. Түүний хэлснээр энэ нь бусад оронд Америкийн амьдралын хэв маягийг түгээх, түүнтэй дасан зохицохыг шахах үйл явц юм хэмээсэн (Schiller, 1969). Шиллерийн үзэж буйгаар соёлын түргэмгийлэл нэвтрүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хамгийн хүчтэй зэвсэг болдог. Энэ үйл явцын зорилго нь хүмүүсийг шинэ соёлын бэлгэдлийн хүрээнд тусгаарлаж, хэдэн үеийн дараа ч гэсэн тэднийг өөрийнхөө уугуул соёлоос татгалзуулан, шинэ соёлыг “өөрийнх” гэж хүлээн зөвшөөрүүлэх юм. Ийнхүү соёлын инженерчлэл нь эцэстээ тухайн ард иргэдийг “энэ газар нутаг биднийх” гэх ойлголт руу чиглүүлэх зорилготой байдаг гэж тэр үзжээ.

Мэдээллийн манипуляци гэдэг нь мэдээллийг зориудаар өөрчлөх, нуух, эсвэл гуйвуулах замаар хүлээн авагчийн сэтгэхүй, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх үйл ажиллагаа юм. Энэ нь үнэн мэдээлэл дээр үндэслэсэн ч тухайн баримтыг

хэсэгчлэн, нэг өнцгөөс харуулж, тодорхой зорилгод нийцүүлэн ашигладаг онцлогтой (McCornack, 1992) Мөн бусдыг төөрөгдүүлэх зорилгоор мэдээллийг санаатайгаар худал эсвэл гажуудуулсан байдлаар хүргэх үйлдэл юм. Энэ нь хуурамч мэдээллийг түгээж, итгэл үнэмшлийг хянах нэг хэлбэр (Fallis, 2015) Бас нэгэн онцлог нь сэтгэл хөдлөлийг ашиглан мэдээлэлд итгэх итгэлийг бий болгох зорилготой, ухамсартайгаар бүтээгдсэн сэтгэлзүйн нөлөөллийн техник юм (Bakir, 2018) Өөрөөр хэлбэл, мэдээллийн манипуляци нь шууд худал хэлэх бус, харин үнэн мэдээллийг буруу хүргэх, эсвэл баримтыг сонгон харуулах замаар хүний ойлголтыг хянах илүү нарийн, сэтгэлзүйн арга юм.

Хэдийгээр суртал ухуулга, мэдээллийн манипуляц, соёлын түрэмгийлэл бүгдэд олон түмний итгэл үнэмшил, хандлага зан төлөвийг нь өөрчилж, шийдвэр гаргалтад нь нөлөөлөх зорилготой ч тус тусын онцлог шинжүүд байна. Суртал ухуулга нь тодорхой зорилготой бүлэг буюу төрийн санаачилгаар ихэвчлэн үндэсний үзэл, төрийн үнэт зүйл, үзэл суртлыг түгээдэг. Бодит байдлыг гажуудуулж, нэг өнцгөөс харуулдаг улс төр, шашин, эдийн засгийн зорилгоор хүмүүсийн итгэл үнэмшил, хандлага, зан төлөвийг чиглүүлэх зорилготой, зохион байгуулалттай мэдээллийн үйл ажиллагаа юм. Жишээ нь: Социализмын үеийн уран сайхны кинонд буддын шашныг “мухар сүсэг”, “хөгжилд саад болж буй хүчин зүйл” хэмээн үзүүлсэн нь төрийн суртал ухуулга байсан гэж үзэж болно. Мэдээллийн манипуляци бол бүх төрлийн мэдээлэлд ашигладаг арга. Олон нийтийн итгэл төрүүлэх биш төөрөгдүүлэх зорилготой. Бусдын итгэл үнэмшил, шийдвэр гаргалтад нөлөөлөхийн тулд мэдээллийг санаатайгаар гажуудуулах, нуух, эсвэл хэт онцлох үйлдэл юм Жишээлбэл: Социализмын үеийн уран сайхны кинонд лам нарыг “ард түмнийг мөлжигч, залхуу, зальтай” байдлаар дүрсэлсэн нь бодит байдлыг гажуудуулж, үзэл сурталд нийцүүлсэн гэж үзэж байна. Соёлын түрэмгийлэл хэмээх ойлголт бол тухайн улс, нийгмийн соёлын үнэт зүйл, үндэсний хэл, соёл, амьдралын хэв маяг, итгэл үнэмшилд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нөлөөлөх зорилготой. Урлаг, соёл, боловсрол, медиа, шашин, хэл зэргээр нөлөөлж өөрийн соёлын үзэл санааг “үндэсний мэт” болгож тогтоодог. Жишээ авбал, Монголд Зөвлөлтийн соёлын бодлогоор үндэсний хэл бичгийг сольж кирилл үсэг нэвтрүүлсэн, орос боловсрол, урлагийн хэв маягийг стандарт болгосон, социалист кино, уран зохиолоор дамжуулан “шинэ хүн”-ийг төлөвшүүлэх хуучин соёл уламжлалыг “элэрч баларсан”, “бүдүүлэг харанхуй” гэж уран сайхны кино, уран зохиол, хэвлэл мэдээлэлээр дүрслэн ойлгуулж үндэсний шашин соёлыг бүр мөсөн устгасан нь соёлын түрэмгийллийн хэлбэр байв.

Судалгааны ажил.

Монголд анх уран сайхны кино 1936 онд “Монгол хүү” нэртэйгээр гарснаас хойш 1990 он хүртэл нийт 174 уран сайхны кино бүтээжээ (Д.Цолмон, 1995) Социалист үеийн (1936–1990) кино урлаг нь төрийн хяналттай үйлдвэрлэл, үзэл суртлын нөлөө давамгайлсан онцлогтой байв (Ц.Цэвэлсүрэн, 2024) Судалгааны объект болгож буддын шашны агуулга гарах 25 уран сайхны кино сонгож авсан ба энэ кинонууд өдгөө ч жил бүр наадам, цагаан сар зэрэг үндэсний тэмдэглэлт баяруудаар телевиз бүрээр гардаг. Тухайлбал “Цогт хунтайж” (1945), “Сэрэлт”, “Нүгэл буян” (1967) “Гологдсон хүүхэн” (1961), Түмний нэг (1962), “Зэрэг нэмэхийн өмнө” (1965), “Гарьд магнай” (1983) кинонуудыг мэдэхгүй монгол хүн гэж байхгүй билээ. Гэтэл энэ кинонуудад буддын шашны үндсэн сургаал номлолыг мушгин гуйвуулж, лам хувраг хүнийг гутаан доромжилсон өнгө аястай үзүүлж уламжлалт соёл, зан заншлыг хуучирч хоцорсон, бүдүүлэг гэж итгэн үнэмшүүлэх зорилготой байв.

Судалгааны объект болгон сонгон авсан 25 киноны нэрсийн жагсаалт:

Монгол хүү (1936)
 Норжмаагийн зам (1938)
 Сүхбаатар (1942)
 Сүхбаатар (1945)
 Сэрэлт (1957)
 Ардын элч (1959)
 Гологдсон хүүхэн (1961)
 Түмний нэг (1962)
 Нүгэл буян (1963)
 Зэрэг нэмэхийн өмнө (1965)
 Хүний мөр (1965)
 Төөрсөөр төрөлдөө (1966)
 Үер (1966)
 Төгсгөл (1967)
 Өглөө (1968)
 Агуйн нууц (1969)
 Талын цуурай (1970)
 Хуучин сүмийн нууц (1982)
 Тэмцлийн оч (1982)
 Гарьд магнай (1983)
 Үүр цайхын өмнө (1983)
 Зарлаагүй дайны оршил (1984)
 Саруул талын ерөөл (1984)
 Ард аюуш (1984)
 Би чамд хайртай (1985)

Энэ кинонуудад бурхан шашин, лам хувраг, хийд оронтой холбоотой дүрслэл, харилцан яриа, үг хэллэг, үйл явдал ямар нэг хэмжээгээр гардаг тул “буддын шашны агуулга ямар нэг хэмжээгээр гардаг” гэсэн шалгуур үзүүлэлтээр сонгож авсан. Гарч буй агуулгыг хандлагаар нь аваад үзвэл 25 киноны 23 нь буюу 92 хувь нь сөрөг 2 кино буюу 8 хувь нь саармаг буюу эерэг, сөрөг аль нь ч биш агуулга гаргаж байна.

Үзүүлж буй дүрслэлийг судлаачийн өнцгөөр ангилан авч үзвэл:

Сүм хийд, бурхан шүтээнийг

- Сүм хийдийг хуучирсан агуулах, хашааны байдлаар
- Бурхан шүтээнийг хуучирч хоцрогдсон агуулгаар
- Ядуу, ядарсан байдлын дүрслэл дээр
- Бурхан шүтээнийг алт мөнгөөр хийсэн хөрөнгө, эд хэрэгсэл
- Түүхийн дурсгал, урлагийн бүтээл

Лам, хувраг хүнийг

- Мэхлэгч, шуналтай, авилагч
- Газар нутгаа зарсан, ядуу ард түмнийг дарлан мөлждөг
- Зодоонч, танхай, балмад
- Шалиг, завхай
- Боловсрол мэдлэг муу

Иргэд, ард түмнийг

- Ядуу учраас сүм хийдэд мөргөж залбирдаг
- Мунхаг, харанхуй тул бурхан ламд сүсэгтэй
- Төөрсөн, төөрөлдсөн хүн /буруу замаар будаа тээсэн хүн/
- Хоцрогдсон арчаагүй хүн бурхан, шүтээнд мөргөдөг
- Гэрийн мухар сахисан эмэгтэй хүмүүс голдуу шүтлэгтэй байдаг

Ийм өнцөг, агуулгаар хүргэж байгаа нь ажиглагдлаа. Эдгээрийг харилцан яриа болон үг хэллэгээр, дүрслэлээр, хөгжим чимэглэлээр, үйл явдлаар харуулж байв.

Үг хэллэгээр: Х.Дамдин найруулагчийн 1983 хийсэн “Үүр цайхын өмнө” кинонд Орос айлд зочлохоор ирсэн монгол эр “Би загасны мах иддэггүй. Монголчууд бид “Богд эзний сүнс” гэдэг юм” гэхэд Орос эр “Монголчууд одоо бурханд залбираад, Богд эзнээс айхаа больсон хаа газрын ядуу хүмүүс адилхан би ядарсан хүмүүст туслах дуртай” гэсэн бол уг кинонд бадарчин Да хүрээнд Сүхбаатартай эргэн таарахдаа үхлийн ирмэгт байх агаад “Духаа цоортол мөргөж, хэлээ цуцтал маани мэгзэм уншсан ч ямар ч бурхан тэнгэр аварсангүй” гэсэн харилцан яриа гарсан нь олон нийтэд үзэл бодол суулгах киноны гол санаа өгүүлэмж илэрч байгаа юм. 1984 онд Г.Жигжигсүрэн найруулагчийн найруулсан “Зарлаагүй дайны оршил” кинонд Фонтод хүнс хүргэхээр явах гэж буй өвгөжөөр хүнд эхнэр нь “Бурхандаа мөргөөд яв” гэхэд “Чи миний өмнөөс мөргөчих бурханд мөргөх зав алга” хэмээн хариулдаг нь бурхан шүтээн гэдэг зүйл огт ач холбогдолгүй зүйл, үүнийг гэрийн мухар сахисан эхнэр хүн л хийдэг, монгол хүн шинэ зүйл, шинэчлэлд тэмүүлж шинэ хүн болж байна гэсэн санааг илэрхийлжээ гэж үзэж байна.

Дүрслэлээр: Ж.Бунтар найруулагчийн 1983 онд найруулсан “Тарьд магнай” кинонд Богд хаан их хатны хамт даншиг наадам үзэж байгаа хэсэг. Жирийн харц ардын хүү барилдаад давахад их хатан “Би ийм наадам үзэхгүй” хэмээн шилбэ татаад явж байгаагаар дүрсэлдэг. Өөрөөр хэлбэл энгийн ардад дээрэлхүү өөрийн хүслээр бүгдийг хийдэг хязгааргүй эрх мэдэлтэй тэднийг буулгах хэрэгтэй гэсэн санаа гарсан. Мөн энэ кинонд Равсал баяныг хэрүүл өдөж байгаад айрганд толгойг нь дүрдэг, Далайцэрэнг чулуугаар шиддэг хэсэгт лам дүүрүүд гарна. Р.Доржпалам найруулагчийн 1984 онд найруулсан “Саруул талын ерөөл” кинонд пионерууд “Бүхий олон багачууд” дууг дуулан жагсаал нааш ирж байгаа бол цааш харан сүм хийдэд мөргөж байгаа хөгшин хүний дүрс, болон пионер хүүхдүүдийн жагсаал даган сонирхож гүйж яваа лам хүүхдүүдийн дүрс гарна. Мөн залуу бүсгүй лам хоёрын дүр бүхий жүжиг олны өмнө тоглож байгаа хэсэг гарах байгаа ба залуу бүсгүй “Гэлэн гуай гэлэн гуай гутал хувцас байхгүй яанам бэ” гэх агуулгатай дуу дуулахад гэхэд “гайгүй дээ барьц харамжаар болно до” хэмээх хариу дуулах зэргээр хошин маягаар харуулж үзэгчид шоолон инээлдэнэ. Мөн олны өмнө үг хэлж буй хэсэгт “Олны итгэл бишрэлийг далимжуулан даварч буй муу сайн хар шар феодалууд” гэх мэтээр илтгэлийн хэсэг гарна

Хөгжим, чимэглэл, өнгө гэрлээр: Сүм хийд, лам хүний дүрсний хэсэг бараан, хог шороотой, хуучирч гандсан, уранхай ноорхой, өнгө зүсгүй дүрслэл, хөгжим чимэглэл нь уйтгартай, эсвэл түгшүүр айдас төрүүлэх маягаар гарах нь ажиглагдлаа. Сүхбаатар (1942) кинонд Богдыг ордноос гарч ирэхэд түгшүүртэй ая эгшиглэн олон түмнийг бужигнуулах үзэгдэл гардаг.

Үйл явдлаар: Монголын анхны киноны нэг “Норжмаагийн зам” (1938) Нэг хашааны 2 айлын жирэмсэн эмэгтэй төрөхөөр өвдөж эхлэхэд Цэрэндулам эмнэлэгт

хүүгээ төрүүлэн баяр баясгалан болж байхад Норжмаагийн ээж нь гэртээ лам залж гүрэм уншуулсаар төрөлт нь бүтэлгүйтэж буйг зэрэгцээ эвлүүлгээр үзүүлсэн дуугүй кино юм. “Гологдсон хүүхэн” (1961) Үр хүүхэдгүй Баян Болдынх зарц Долингорын хүүхдийг өргөж авахын тулд ловон ламаар мэргэлүүлдэг. Ловон лам оронд нь Бөнжөө гуайнд байдаг өөрийн нууц хүүхэд Магсарыг өргүүлэхийн тулд Долингорын охиныг “заяа муутай, хулгайч худалч хүн болох юм байна” хэмээн хэлж өргөж авахаа больж нөхөр нь эзэнгүй байхад зарцынхаа эхнэрийг нь орхиж нүүдэг. Мэргэлж байхдаа Болдын эхнэрийн судсыг атгаж сээтэгнэж байгаагаар дүрсэлсэн нь нэг бус удаагийн явдал бусыг Долингорын эхнэр нөхөртэйгээ ярьж байхдаа жигшин ярьж байгаа нь лам нарыг шалиг завхай явдалтайн дээр хувийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн тулд хүний амьдралыг золиосолдог увайгүй улс мэтээр дүрсэлсэн. Мөн Ловонгийн байр байдлыг эхнэр нь хэлээд байхад Долингор хүүгээ том болохоор нь шавь болгохоор аваачиж үлдээсэн ба хүү нь уйлаад байхад орхиод явж байгаагаар лам нарт ардууд ямар их гэнэнээр итгэдгийг, бага балчир хүүхдийг лам болгож байгааг шүүмжилжээ. Долингорыг хүнд хүчир албанд явсан хойгуур хүү нь ламын зодуур амсан шархаа даалгүй нас барж байгааг харуулсан нь лам нарыг харгис гэж харуулахын зэрэгцээ лам нарын шавь сургалтыг шүүмжлэн харуулсан.

“Нүгэл буян” (1963) Уг кино нь нэрнээсээ эхлээд шашныг шүүмжилсэн утгатай бөгөөд кино эхлэхдээ л сүм хийд лам нарын дүрсийг гунигийн аян дээр өгүүлэгч гунигт шүлэг уншиж эхэлдэг. Буддын 600 гаруй сүм хийдэд 1000 гаруй лам нар жанч нөмрөн хий дэмий сууж улс орны ажиллах хүчийг хий дэмий үрж байсан ба ард түмэнд зовлонгийн үе байсан хэмээн өгүүлдэг. Нэгэн хөөрхийлэлтэй эх охины амьдралын түүхээр лам нарыг шалиг завхай явдалтай, ярьж хэлдэгээсээ тэс өөр явдал мөртэй, огтоосоо шашин бол ариун биш, хүний амьдралын садаа тээг юм хэмээх утгыг шууд дүрслэн үзүүлсэн.

Ийнхүү социализмын үеийн кино урлаг, түүний араас телевиз зэрэг мэдээллийн хэрэгсэл нь суртал ухуулга, соёлын түрэмгийлэл, мэдээллийн манифүляцийн нарийн аргуудаар үйлчилж нэг талаас хүмүүсийн сэтгэл зүй, үзэл бодолд нөлөөлж, нөгөө талаас уламжлалт соёлыг системтэйгээр устгаж шинэ соёлыг суулгаж ирсэн арга хэрэгсэл болж байсан юм. Буддын шашны үзэл сургаал, үнэт зүйл, лам нарын боловсрол мэдлэг чадварын тухай илтэд гажуудуулан үзүүлэх нь кино урлагийн гол зорилго бөгөөд социалист Монголын соёлын бодлогын чухал хэсэг байв. Хамгийн гол нь энэхүү үзэл суртал, соёлын түрэмгийлэл, мэдээллийн манифүляци өнөө хүртэл үргэлжлэн үйлчилж байна. Өдгөө бурхны шашныг дээрх кинонуудад дүрсэлснээр ойлгож, үзэл бодлоо илэрхийлж явдаг нь хүмүүс багагүй бий. Тиймээс соёл боловсролын салбар, хэвлэл мэдээллийн салбар тэр дундаа телевизүүд 1930-1990 оны хооронд хийсэн уран сайхны киног хэрхэн яаж гаргах вэ гэдэг асуудлыг даруй шийдвэрлэх нь зүйтэй юм. Манай орон үндсэн хуулиндаа мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх эрх чөлөөг хуулчилж өгсөн ардчилсан улс. Тиймээс эдгээр киног олон нийтэд гаргахгүй хориглох, хаах шийдвэр байж болохгүй юм Тиймээс эдгээр үзэл сурталтай, худал төөрөгдүүлсэн мэдээлэл бүхий киног гаргахдаа дараах аргыг хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн зөвлөмж санал дэвшүүлж байна

Тайлбар зүүлт хийх

Кино гаргахын өмнө эсвэл дараа “энэ бүтээлд суртал ухуулгын шинж агуулж болзошгүй”, “түүхэн баримтад тулгуурласан ч үзэл санаа нь тухайн бүтээлчдийн байр суурь юм” гэх анхааруулга, тайлбар өгөх. Үзэгчийг бодит байдлыг эргэцүүлэхэд

бэлтгэх, сэтгэн бодох орон зай үлдээх нь чухал.

- дэлгэцийн нэг буланд ийм агуулга бүхий бичиг тогтмол байрлуулах, эсвэл
- кино эхлэхээс өмнө анхааруулга бичиг гаргах,
- киноны доогуур үе үе бичиг гүйлгэх гэх зэрэг хэлбэрүүд байж болно.

Зарим телевизийн нэвтрүүлэг эхлэхийн өмнө үзэгчээ бэлдэх, үзэх үзэхгүй сонголт хийлгэхийн тулд анхааруулга гардаг жишиг бий. Жишээлбэл: “энэхүү нэвтрүүлэгт цус болон буу зэвсэгтэй холбоотой эвгүй дүрс гарах тул зүрх судасны өвчтэй, жирэмсэн хүн үзэхгүй байна уу” гэсэн агуулга бүхий анхааруулга дэлгэцэнд гаргадаг. Яг энэ мэт киноны өмнө “Энэхүү кино социализмын үзэл суртлын үүднээс хийгдсэн байж болзошгүй тул Монгол уламжлал, бурхны шашны тухай агуулга нь гажуулдсан өнгө аястай байх, энэ нь тухайн цаг үеийн нөхцөл байдал, уран бүтээлчийн байр суурь юм” гэх маягаар анхааруулсан тайлбар дэлгэцэнд өгч хийж болох юм.

Мэргэжлийн үүднээс шүүх, хяналт тавих, хэлэлцүүлэг өрнүүлэх

Телевизийн редакц, ёс зүйн зөвлөл, уран бүтээлчдийн хороо зэрэг газруудаар киноны агуулгыг урьдчилан шалгах ёстой. Хэрвээ кино ялгаварлан гадуурхсан, үзэл суртлын хэт нэг талыг баримталсан бол түүнийг шууд цацахгүй. Харин шинжлэн судлах, хэлэлцүүлэгтэй хамтатгах хэлбэрээр гаргаж болно. Цаашлаад үзэгчдэд суртал ухуулгын арга, хэлбэр, нөлөөллийг задлан ойлгуулах өргөн хүрээний хэлэлцүүлэг киноны өмнө хойно хийж байж гаргах нь үр нөлөөтэй юм. 25-р суваг телевиз нь “Кино эхлэхийн өмнө” хэмээн нэвтрүүлэг байдаг ба тэрхүү кино бүтсэн түүх, тухайн цаг үеийн нөхцөл байдал зэргийн киноны уран бүтээлчид болон кино судлаачид мэргэжилтнүүдээр яриулдаг сайн жишиг бий.

Дүгнэлт

Монголд кино үйлдвэрлэл эхэлсэн цагаасаа эхлэн буддын шашин, лам сүм хийдийн сөрөг талаас нь үзүүлж шинэ улс төрийн тогтолцоог төлөвшүүлэх зорилготой байсан. Социализмын үзэл санааг иргэд олон нийтэд шинээр суулгахын тулд үзэл суртлын, соёлын түрэмгийллийн, мэдээллийн манифуляцын арга техникийг ашиглан кино урлаг, утга зохиол, сонин, радио, телевиз гэх мэт мэдээлэл түгээх бүхий л хэрэгслүүдийг ашиглан ажиллаж иржээ. Үүний үр нөлөөгөөр буддын шашин олон нийтийн ухамсар, сэтгэл зүйд ёс суртахуунгүй, хоцрогдсон, шинжлэх ухааны эсрэг зүйл гэх хуурамч итгэл үнэмшил, үзэл хандлага сууж шашин соёлын уламжлал тасарч, үнэт зүйл нь алдагдсан. Энэхүү үзэл суртлын нөлөөгөөр Монгол үндэсний соёлын онцлог, уламжлал алдагдаж, өөрийн үнэт зүйлийн итгэл үнэмшил суларч гадаадын соёлыг шүтэх үзэл хандлага түгж, үндэсний хэл бичиг солигдон өөрчлөгдөж түүнийг дагасан соёлын олон сайхан зүйлс устаж үгүй болсон сөрөг нөлөөтэй. 1990 оноос хойш хэвлэл мэдээллийн болон киноны орчин өөрчлөгдөж, шашин соёлын болон ёс суртахууны үнэт зүйл хэлбэрээр сэргэж эхэлсэн хэдий ч социализмын үед бүтээсэн кино болон урлагийн бүтээлийг ямар нэгэн тайлбар хэлэлцүүлэггүйгээр гаргаж байгаа нь учир дутагдалтай юм. Телевизээр гарч буй уран сайхны кино нь нийгмийн ухамсар, зан төлөвийг төлөвшүүлэх хүчтэй нөлөөтэй хэрэгсэл юм. Монголын өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизүүд цагаан сар, наадам гэх мэт үндэсний тэмдэглэлт өдрүүдээр бусад жирийн өдрүүдээр ч социализмын үед хийсэн үзэл суртлын үүдээс үндэсний шашин, соёлыг мушгин, гуйвуулж гүтгэж доромжилсон өнгө аятай кинонуудыг гаргадаг нь нийгмийн ухамсар, олон нийтийн үзэл хандлагад нөлөөлсөөр байна. Кино болон телевизээр

гарч буй дүрслэлүүд хүний бодит ертөнцийн талаарх сэтгэхүйг төлөвшүүлж, хүмүүсийн урт хугацааны ой санамжид хадгалагдаж, зан төлөвт нөлөөлж, хор хөнөөлтэй дадал бий болгож, хүн хоорондын харилцаанд сөрөг үр дагавар үзүүлж буй тухай сүүлийн үеийн судалгаанд онцолсон байна. Хэвлэл мэдээлэл тэр тусмаа дүр дүрслэлээр үзүүлдэг кино, телевиз, видео контентууд нийгмийн бодит байдлын талаарх итгэл үнэмшил бий болгодог болохыг тогтоосон. Тиймээс энэ хүчтэй нөлөөтэй чанараараа өнөөг хүртэл социализмын үзэл суртлаар тархи угаалт, буруу худал мэдээлэл уран сайхны киногоор дамжуулан хүргэж байна гэж үзэж тайлбар зүүлт, мэргэжлийн олон талт эх сурвалжтай хэлэлцүүлэг, ярилцлагатай хавсарган гаргах хэрэгтэй юм. Харин ч олон түний итгэл үнэмшилд өндөр нөлөө үзүүлдэг энэ чанараа ашиглан үндэсний уламжлал, шашин соёлынхоо үнэт зүйлийг дэлгэрүүлсэн үнэн зөв, баримттай мэдээлэл хүргэж буддын шашны хамгийн гол үнэт зүйл, сургаал номлол болох ёс зүй, ёс суртахуун, эрүүл зөв амьдрал, энэрэл нигүүлсэл, өршөөл уучлалын сэдэвт контент түгээх нь чухал байна. Ялангуяа өргөн нэвтрүүлгийн телевизүүд (18 телевиз бий) татвар төлөгчдийн мөнгөөр сар бүр татаас авдаг тул олон нийтийн эрх ашигт нийцсэн, үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, ёс суртахуун, өв уламжлалаа дээдэлсэн бүтээлүүд хүргэх нь зүй ёсны үүрэг билээ.

Эцэст нь тэмдэглэхэд соёл, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтраад энэ үзэл суртлыг үр нөлөөг арилгах, уламжлалт соёлоо сэргээх, буддын шашны үнэт зүйлийг үнэн зөв мэдээлэх таниулах, ёс зүй, соёлыг хэл ялангуяа ярианы болон бичгийн хэлээр дамжуулах суулгах, хэл, өв уламжлалыг сэргээх, ном бүтээх, контент хийх энэ бүхнийг бодлого хөтөлбөрт суулгуулах зэргээр шашны байгууллагууд, соёлын байгууллагууд, залуус, сургууль, урлаг судлаачид зэрэгтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Эшлэл

- Bakir, V., & McStay, A. (2018). Fake news and the economy of emotions: Problems, causes, solutions. *Digital Journalism*, 6(2), 154–175. <https://doi.org/10.1080/21670811.2017.1345645>
- Britannica. (2024). *Propaganda*. Retrieved from <https://www.britannica.com/topic/propaganda>
- Cambridge Dictionary. (2024). *Propaganda*. Retrieved from <https://dictionary.cambridge.org/dictionary/english/propaganda>
- Collins English Dictionary. (2024). *Propaganda*. Retrieved from <https://www.collins-dictionary.com/dictionary/english/propaganda>
- Fallis, D. (2015). What is disinformation? *Library Trends*. <https://doi.org/10.1353/lib.2015.0014>
- Wikipedia. (n.d.). *Суртал ухуулга*. Retrieved from https://mn.wikipedia.org/wiki/Суртал_ухуулга
- McCormack, S. (1992). *Information manipulation theory*. Retrieved from <https://scholar.google.com/scholar>
- Said, E. W. (1993). *Culture and imperialism*. New York, NY: Alfred A. Knopf.
- Schiller, H. I. (1969). *Mass communications and American empire*. Encyclopedia of Science. (2013). *Propaganda*.
- Цолмон, Д. (1995). *Монгол кино*. Улаанбаатар.
- Норовсүрэн, Л. Н. (2009). *Телевизийн сэтгүүл зүй*. Улаанбаатар.
- З.М., Сонин. (2015, June 9). Суртал ухуулгаар дутахуй. Retrieved from <https://gogo.mn/r/08n4o>

- Сарантуяа, Т., & Н. (2015). *Монголын кино үзвэр*. Улаанбаатар.
- Цэвэлсүрэн, Ц. (2024). A historical analysis of the genre in Mongolian cinematic art. *International Journal of Sciences: Basic and Applied Research*.
- Т.Х., Шаардлага. (2021, January 21). *Legalinfo.mn*. Retrieved from <https://legalinfo.mn>

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Bakir, V. &. (2018). Fake news and the economy of emotions: Problems, causes, solutions. *Digital Journalism*,
- Britannica. (2024). Propaganda. Retrieved from Britannica
- Dictionary, C. (2024). Propaganda. Retrieved from
- Fallis, D. (2015). What is disinformation? *Library Trends*. doi:<https://doi.org/10.1353/lib.2015.0014>
- McCornack, S. (1992). Information manipulation theory. Retrieved from
- Propaganda., C. D. (2024). Propaganda. Retrieved from
- Said, E. W. (1993). *Culture and imperialism*. New York: NY: Alfred A. Knopf.
- Schiller, H. I. (1969). *Mass Communications and American Empire*.
- Д.Цолмон. (1995). Монгол кино.
- Л.Норовсүрэн, Н. (2009). Телевизийн сэтгүүл зүй . Улаанбаатар
- Т.Сарантуяа, Н. (2015). Монголын кино үзвэр . Улаанбаатар .
- Ц.Цэвэлсүрэн. (2024). A Historical Analysis of the Genre in Mongolian Cinematic Art . *International Journal of Sciences: Basic and Applied Research*.

Summary

Due to ideological influence, the unique characteristics and traditions of Mongolian national culture have been eroded, weakening people's belief in their own cultural values. This has led to the spread of attitudes that idealize foreign cultures, the alteration and replacement of the national language and script, and the loss of many cultural elements associated with them—resulting in significant negative impacts.

Cultural, educational, and media organizations need to work together to eliminate the influence of this ideology, revive traditional culture, accurately communicate and promote the core values of Buddhism, and cultivate ethics and culture—especially through spoken and written language. It is also necessary to restore the language and heritage, create books and content, and integrate all of this into policies and programs. To achieve these goals, cooperation among religious institutions, cultural organizations, youth, schools, and scholars of art and culture is essential.

Keywords: propaganda, Buddhist content in fictional films, television influence, television drama.

ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ МЭДЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖИЙН ШИНЖИЛГЭЭ

Er, Dengdalai (Эрдэнэдалай)*
С.Амартүвшин** /Холбоо баригч зохиогч/

**МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант*

***МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн дэд
профессор, доктор (Ph.D)*

Түлхүүр үгс: Эх сурвалж, мэдээ, сэдэв, эх сурвалжийн төрөл, эх сурвалжийн түвшин, эх сурвалжийн контент анализ

Оршил. Мэдээллийг баттай, найдвартай эх сурвалжаас олж ашиглах нь сэтгүүлчийн ажлын чухал хэсэг юм. Сэтгүүл зүйн онолын үүднээс мэдээллийг эх сурвалжаар баталгаажуулж дамжуулах нь үнэн бодит, тэнцвэрт мэдээллийн үндэс болж, хариуцлагатай, ёс зүйтэй, чанартай мэдээллийн чухал хүчин зүйлд тооцогддог.

Олон улсын толь бичгүүд “Source” (Эх сурвалж) гэдэг үгийг сэтгүүл зүйн явцуу тутгаар нь маш тодорхой тайлбарласан байдаг.

“Merriam-Websterийн толь”-д “Мэдээлэл нийлүүлэгч нэгэн (хүн). Анхдагч баримт бичиг эсвэл үндсэн баримт бичиг” гэжээ (Source. In Merriam-Webster.com dictionary.).

“Кэмбрижийн толь бичиг”-т “Мэдээллээр хангадаг хэн нэгэн эсвэл ямар нэг зүйл.” (Source. In Cambridge.org Dictionary.) гэсэн бол “Оксфордын англи хэлний толь”-д “Мэдээлэл олж авч болох хүн, ном, баримт бичиг. Аливаа зүйлийн үүсэл, гарал үүслийн цэг” (Source. In Oxford Learner’s Dictionaries.) хэмээн тус тус тодорхойлжээ.

Монголын сэтгүүл зүйн онол-практикт эх сурвалжийн талаарх тодорхойлолтууд түгээмэл байна. “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д “...Сэтгүүлч сонгож авсан сэдвийнхээ үндэслэлийг сайжруулах зорилгоор олж авсан мэдээллийг өгсөн хүн ба баримт, бусад эх үүсвэр мөн” (Норовсүрэн, 2025, хууд. 255) гэжээ. МУИС-иас гаргасан “Сэтгүүл зүйн үндэс” хамтын бүтээлд “Эх сурвалж бол сэтгүүлчийг нийтлэл, нэвтрүүлгээ бэлтгэхэд үндэс суурь болж буй хүн, баримт, үйл явдал юм”

(Болд-Эрдэнэ, 2021, хууд. 343) хэмээн өргөн утгаар нь тодорхойлсон тодорхойлолт байх бөгөөд сэтгүүл зүйн баримт сонголт боловч дан баримт сэтгүүл зүйн бүтээл болоход хангалтгүй, түүнийг эх сурвалжаар баталж нотолж, баяжуулж байдаг учраас үйл явдал, үзэгдлийн талаарх мэдээллийг боловсруулахад үндсэн хэсэг болдгийг онцолжээ.

Профессор М.Зулькафиль “Сэтгүүл зүйн тайлбар толь”-доо “Сэтгүүл зүйн онол, хэрэглээ, арга зүйд “эх сурвалж” хэмээх ойлголт чухал байр эзэлдэг. Учир нь сэтгүүл зүйн бүтээлийн үр өгөөж, үр ашиг, нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь ямар эх сурвалжаас мэдээлэл олж авсан, ямар баримтад үндэслэн бичсэнээс шууд шалтгаалдаг” (2007, хууд. 77) хэмээн ач холбогдол талаас нь тодорхойлсон нь итгэл үнэмшлийн хүчин зүйлийг чухалчилж буй явдал юм.

Эдгээр тодорхойлолтоос үзэхэд ерөнхий утгаараа “эх сурвалж” нь аливаа зүйлийн “тарал үүсэл, эхлэл” юм. Сэтгүүл зүйд “**мэдээлэл, тайлбар өгч буй хүн**” эсвэл “**мэдээлэл, тайлбар агуулсан бичгийн эх үүсвэр**”-ийг тодорхойлсон явцуу утгатай байна. Үүнээс аман болон бичгийн эх сурвалжийн үндсэн ангилал гарна.

Эх сурвалж нь сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны судалгааны хамгийн чухал ойлголтуудын нэг, судалгааны гол чиглэл болж тогтсон байдаг. 1970-аад оны үед Британийн соёл судлалын эрдэмтэн Холл “эх сурвалжууд бол нийгмийн үнэний үндсэн тодорхойлогч” гэсэн онолын баримтлалыг санал болгосон бөгөөд мэдээллийн хэрэгслүүд үнэндээ бие даан мэдээ гаргах чадваргүй бөгөөд зөвхөн эх сурвалжийг ашигласнаар тодорхой сэдвийг бодитой тайлбарлан мэдээлэх чадвартай гэж дүгнэжээ (Hall & Scraton, 1981, хууд. 340). Орчин цагт сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны судалгаанаас эхлээд социологи, соёлын судалгаа зэрэг салбарууд руу өргөжиж, судлаачид мэдээллийн эх сурвалжийн бүлгүүд олон нийттэй харилцах харилцааг ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслийн хоорондын харилцаа холбооны хүч шилжихэд анхаарлаа хандуулж эхэлж байна (Cottle, 2007).

Мэдээний эх сурвалжийн талаар сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны онол, мэдээ бичих, ярилцлага хийх чиглэлээр олон сурах бичиг, нэг сэдэвт бүтээлд энэ асуудлыг нарийвчлан авч үзсэн. Харин Хятадын сэтгүүл зүйн практик судалгаанд эх сурвалжийн баталгаажуулалт (Багана, 2004), төрөл (Суй шан, 2021, хууд. 86), ангилал (Бүрээчин, 2002), эх сурвалж ашиглаж буй байдал (Suhua, 2006), арга техник (Хуайю, 2022) зэргийг судалсан байна.

Монголд сонины эх сурвалжийн судалгаагаар 2007 онд доктор (Ph.D) Т.Оюунбилэг “Монголын сонины мэдээллийн эх сурвалжийн өнөөгийн байдал, тугамдсан асуудлууд” сэдвээр эрдмийн зэрэг хамгаалжээ (Оюунбилэг, 2007). Тус диссертацид Монголын сэтгүүл зүйн эх сурвалжийн байдлыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагаас социологийн судалгааны асуулгын аргаар тулгамдаж буй асуудлуудыг голлон тогтоохыг зорьсон байна. Мөн Болд-Эрдэнэ Б., Чойсамба Ч., Энхцэцэг Н., Базар Ч. “Өдөр тутмын сонины нийгэм-улс төрийн сэдэвт мэдээний эх сурвалжийг судлах нь” сэдэвт бүтээл гарчээ. Нууц эх сурвалжийн асуудлыг эрэн сурвалжилгын дангасан судалгаанд (Базар, 2007) л онцлон авч үзжээ. Товчхондоо эх сурвалжийн талаарх суурь судалгаа, макро түвшний судалгаа дутмаг байв.

Цахим орон зайн эмх замбараагүй, баталгаагүй, эх сурвалжгүй мэдээллийн урсгалаас болж уншигчдын хэвлэл мэдээлэлд итгэх итгэл сулрах, мэдээллийн чанарт эргэлзэх байдал улам бүр нэмэгдэж байна. Гэтэл эх сурвалжгүй мэдээлэл хэвлэлээр түгсээр байна. Үүнээс үүдэн мэдээллийн эх сурвалжийн судалгааг хийх шаардлагатай хэмээн үзэж, юуны өмнө хамгийн “баталгаатай” гэгддэг “өдөр

тутмын сонин”-г сонгон мэдээний эх сурвалжид нь шинжилгээ хийхийг зорив.

Судалгаанд өдөр тутмын сонинг, бичлэгийн төрлөөр нь мэдээг сонгов. Мэргэжлийн сэтгүүл зүйн эх сурвалжийн гол объект нь мэдээ бөгөөд мэдээний эх сурвалжийн талаарх ойлголт бусад төрлийн бичвэрийн эх сурвалжийн үндэс болж чаддаг.

Ингээд дараах объектыг сонгож түүвэр болон контент анализ хийлээ. Монгол Улсын “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонин, БНХАУ-ын “Ардын өдөр тутмын сонин” -ы 2004, 2014, 2019, 2024 оны тус бүрийн хагас жилийн буюу 6 сарын дугаарын мэдээг түүвэрлэлээ.

Арга зүйн хувьд өдөр тутмын сонины мэдээллийн гол төрөл болох мэдээний түүвэрт үндэслэн, цаг хугацааны тодорхой мөчлөг дунд эх сурвалжийн ашиглалтын байдлыг хэмжих мэдээний сэдэв, дэлгэрэнгүй болон товч мэдээний төрөл, мэдээний эх сурвалжтай болон эх сурвалжгүй байдлаар кодлон бүртгэл хийж, нэгтгэсэн өгөгдлийг статистик болон дүн шинжилгээний аргаар боловсруулж шинжилсэн юм.

Нэгж мэдээг бүртгэн кодлохдоо нэг стандартаар кодлох журмаар боловсруулсан.

Мэдээ бүрт заавал нэг л үндсэн сэдэв (C1–C4) онооно. Хэрэв олон эх сурвалж байвал гол эх сурвалжийг кодлоно (хамгийн хүчтэй, эхний, гол ишлэл). A1–A6, N1–N6 гэх мэт. Хэрэв мэдээ огт эх сурвалжгүй бол кодлохгүй, зөвхөн S0 гэж тэмдэглэнэ.

Кодлох үедээ эхлээд мэдээг бүрэн уншаад, дараа нь дарааллын дагуу кодлох (дундаас нь таамаглаж тэмдэглэхгүй). Кодлох нэгж нь нэгж мэдээ байна. Нэгж мэдээ нь мэдээний товч, дэлгэрэнгүй хэлбэртэй бичвэр байх бөгөөд тус бүрийг “нэгж” гэж үзэж кодлов. (жишээ нь: “Мэдээ + богино тайлбар” → нэг мэдээ).

Мэдээ бүрийг дараах шалгуурыг харгалзан дэс дарааллаар кодлоно. Үүнд, Мэдээний хэлбэр (дэлгэрэнгүй / товч), эх сурвалж байгаа эсэх (эх сурвалжтай / эх сурвалжгүй), мэдээний сэдэв (нийгэм, улс төр, эдийн засаг, соёл-спорт гэх мэт).

Улмаар кодлох тэмдэглэгээг дараах байдлаар хийсэн. Мэдээний хэлбэрээр **D** – Дэлгэрэнгүй мэдээ /Өргөн хэмжээний, тайлбар, ишлэл, олон эх сурвалж агуулсан мэдээ, Жишээ нь, хэрвээ мэдээ догол үргэлжилсэн, дэлгэрэнгүй тайлбар, ишлэлтэй бол → **D** гэх. **T** – Товч мэдээ /Богино, ихэвчлэн 1–3 өгүүлбэртэй, мэдээллийн товч утгатай/ “*ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, Гуандун мужийн Намын Хорооны нарийн бичгийн дарга Ли Ши хэд хэдэн судалгааны аялалд оролцов*” гэх лийд маягийн 1–3 өгүүлбэртэй хэсэг бол → **T**

Эх сурвалжтай эсэхийг кодлохдоо **S1** – Эх сурвалжтай мэдээ /мэдээнд тодорхой нэг хүн, байгууллага, баримт, эх үүсвэр дурдагдсан/, **S0** – Эх сурвалжгүй мэдээ /“мэдээлж байна”, “бололтой”, “хэллээ” гэхээс өөр, тодорхой эх сурвалжгүй/

Жишээ: “Эрүүл мэндийн яамны мэдээлснээр...” → **S1** гэх бол, “...гэж мэдээлснийг...”, “магадгүй ийм шийдвэр гарсан бололтой” → **S0** гэж кодлов.

Мэдээний сэдвийг кодлохдоо **C1** – Нийгэм /гэмт хэрэг, осол, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, амьдралын чанар г.м./, **C2** – Улс төр /УИХ-ын чуулган, Засгийн газрын үйл ажиллагаа, төрийн өндөрлөгүүдийн айлчлал, хууль, шийдвэр, төрийн бодлого, намын үйл ажиллагаа г.м./ **C3** – Эдийн засаг /бизнес, татвар, үнэ ханш, зах зээл, хөгжил, хөрөнгө оруулалт г.м./ **C4** – Соёл, спорт /урлаг, соёлын арга хэмжээ, тамирчдын амжилт, соёлын эвент г.м./ Жишээ: “Махны үнэ өсөх

шалтгааныг судлав” → **С3**, “Парламентын шинэ хуулийн талаар...” → **С2** гэж кодолсон.

Ингээд түүвэр дэх нэгж мэдээг кодлохдоо жишээ нь “Өчигдөр Эрүүл мэндийн яамнаас томуугийн дэгдэлтийн талаар мэдээлэл хийлээ...” (Өдрийн сонин, 2019.11.05) гэсэн мэдээг мэдээний хэлбэр нь → **D** (дэлгэрэнгүй гэж үзье), эх сурвалжтай бол → **S1**, сэдэв нь → **C1** (эрүүл мэнд – нийгэм) гэх байдлаар кодлов.

Контент анализынхаа үр дүн нь судлагдаж буй үзэгдлийг зөв илэрхийлж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд дараах төрлийн баталгаажуулалтыг ашиглав.

Нэгд, **агуулгын баталгаажуулалтыг** судалгаанд ашигласан ангилал, шалгуур болох мэдээ эх сурвалжтай эсэх, мэдээний сэдэвчилсэн ангилал зэрэг өгүүллийн гол судлагдахуунтай шууд уялдсан үзүүлэлтүүдийг бүрэн хамаруулж, улмаар агуулгын баталгаажуулалт хангагдсан гэж үзсэн.

Хоёрт, хэмжилтийн баталгаажуулалтаар “дэлгэрэнгүй мэдээ”, “товч мэдээ”, “эх сурвалжтай мэдээ”, “эх сурвалжгүй мэдээ” зэрэг ойлголтуудыг кодлох журамд тодорхой үйлдлийн шинж байдлаар тогтоосон. Ингэснээр онолын ойлголтыг бодит өгөгдөлд тогтвортой, давтагдахуйц байдлаар хэмжих боломж бүрдсэн. Иймээс судалгааны дотоод логик, харьцуулалт гажуудал багатай гэж үзнэ.

Энэхүү судалгаанд ашигласан найдвартай байдлын үзүүлэлтүүд болон баталгаажуулалтын аргууд нь контент анализын үр дүнг шинжлэх ухааны үндэслэлтэй, давтагдахуйц, итгэлтэй болгох боломжийг хангасан гэж үзэж байна. Иймд судалгааны дүгнэлт нь зөвхөн тайлбар төдий бус, арга зүйн хувьд баталгаатай гэж үзнэ.

Ингээд түүврийн контент аналитикс сонин тус бүрээр болон нэгтгэсэн тоон үзүүлэлтүүдийг хүснэгт, графикаар илэрхийлж, тайлбар дүн шинжилгээ хийсэн байдлыг танилцуулъя. Нийт түүврийн хэмжээ: **22930** мэдээнд шинжилгээ хийв. Үүнийг сонин тус бүрээр үзвэл:

- **Өдрийн сонин /Монгол/:** Нийт **7826** мэдээ (1861+2053+2184+1728).
- **Зууны мэдээ /Монгол/:** Нийт **8040** мэдээ (1864+1996+2208+1972).
- **Ардын өдрийн сонин /Хятад/:** Нийт **7064** мэдээ (1371+1781+1853+2059).

Дээрх аргачиллаар 3 сонины эх сурвалжтай мэдээний үр дүнг нэгтгэн харьцуулж шинжилж үзэв. /График 1./




График 1. 3 сонины эх сурвалжтай мэдээний үзүүлэлт, оны бүрийн хагас жилийн байдлаар

Сонинуудын ерөнхий чанарыг (2004-2024 оны нийлбэр дүнгээр) эх сурвалжтай мэдээгээр эрэмбэлбэл:

Өдрийн сонин: Нийт **5674** мэдээ (1364+1292+1722+1356).

Зууны мэдээ: Нийт **5164** мэдээ (1283+1261+1328+1292).

Ардын өдрийн сонин: Нийт **4002** мэдээ (734+1127+1146+1295).

Энэ үзүүлэлтийг нийт мэдээний тоотой харьцуулж харвал /График 2/ дараах зураглал гарна.




График 2. Эх сурвалжтай мэдээг нийт мэдээний тоотой харьцуулбал:

Энэ хэдийгээр тоон үзүүлэлт боловч сонинуудын томоохон зөрүүг илэрхийлж байна.

“Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонин дөрвөн оны нийлбэр дүнгээр эх сурвалжтай мэдээг хамгийн өндөр үзүүлэлттэй нийтэлсэн байна. Харин сонгосон онуудын дүнг үзвэл “Өдрийн сонин” өсөлт эрчимтэй (График 3), “Зууны мэдээ” тогтмол (График 5) байгаагаар ялгарч байлаа. Эх сурвалж ашиглахдаа хандаж буй ийм үр дүн нь хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүйн дүр зураг юм. Харин “Ардын өдрийн сонин” нь 2004 онд хамгийн бага (734) эх сурвалжтай мэдээтэй байсан ч, 2024 он хүртэлх өсөлтөөрөө бусдыгаа гүйцэх төлөвтэй байгаа нь мэргэжлийн хандлага нь өссөнийг илтгэж байсан ч улс төрийн сэдэвт мэдээ нь эх сурвалж давамгайл байгаа нь (Хүснэгт 4) үзэл суртлын нэг урсгалт, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх суртал ухуулгын хэвлэлийн шинж байдлыг илтгэж байлаа. Мөн онцлох үзүүлэлтүүдэд (он тус бүрээр) дүн шинжилгээ хийхэд:**Хүснэгт 1.** Онцлох үзүүлэлт

Он	Сонин (хамгийн их)	Тоо	Сонин (хамгийн бага)	Тоо
2024	Ардын өдрийн сонин	1295	Зууны мэдээ сонин	1202
2019	Өдрийн сонин	1722	Ардын өдрийн сонин	1146
2014	Зууны мэдээ	1261	Ардын өдрийн сонин	1127
2004	Өдрийн сонин	1364	Ардын өдрийн сонин	734

Хүснэгт 1. Онцлох үзүүлэлт

2019 оны онцгой тохиолдол: “Өдрийн сонин” 2019 онд 1722 мэдээ эх сурвалжтай нийтэлсэн нь гурван сонины дөрвөн оны бүх үзүүлэлтээс хамгийн өндөр нь байна. Энэ нь тухайн онд тус сонин эх сурвалжийн шаардлагаа чангатгасныг илтгэж болно.

“Ардын өдрийн сонин”-ы өсөлт: 2004 онд хамгийн бага (734) байсан тус сонин 2024 онд 1295 эх сурвалжтай мэдээтэй болж, бусад сонинуудтайгаа ойртож очсон нь хамгийн эрчимтэй өссөнийг харуулна.

Улмаар бид статистикт үндэслэн сонины эх сурвалжтай мэдээний чиг хандлагад дүн шинжилгээ хийв.

Сонин	2019 (Тоо)	2024 (Тоо)	Өөрчлөлт (Тоо)	Өөрчлөлт (%)
Өдрийн сонин	1722	1356	-366	-21.25%
Зууны мэдээ	1328	1202	-126	-9.49%
Ардын өдрийн сонин	1146	1295	+149	+13.00%

Хүснэгт 2: Мэдээний эх сурвалж ашиглалтын чиг хадлага (2019-2024 оны өөрчлөлт)

Энд хоёр гол чиг хандлага харагдаж байна. Уналтын чиг хандлага гарч, “Өдрийн сонин” болон “Зууны мэдээ” сонин 2019 оноос 2024 онд эх сурвалжтай мэдээний тоо буурсан байна. Ялангуяа, “Өдрийн сонин” эх сурвалжтай мэдээ -21.25%-ийн хамгийн огцом бууралтыг үзүүлжээ. Энэ нь сонинд гардаг мэдээний тоо, давтамж буурсантай шууд холбоотой байв.

Ерөнхий давтамжаар “Зууны мэдээ” сонин эх сурвалжтай мэдээ гаргах хэмжээгээрээ хамгийн **тогтвортой** байдлыг хадгалсан (бага зэргийн бууралттай) нь мэдээний чанарт анхаарал тавьдаг редакцын тогтвортой байдлыг илтгэж байв.

Одоо сонин тус бүрээр дүн шинжилгээ хийе.

“**Өдрийн сонин**” 7 хоногтоо гаригийн 6 өдөр гардаг бөгөөд 16, 24 нүүрээр гарч байна. 2004, 2014, 2019, 2024 оны хагас жилийн буюу 7-12 сард нийт 6895 дэлгэрэнгүй мэдээ, 931 товч мэдээ, бүгд 7826 мэдээ нийтлэгджээ. Сүүлийн үед мэдээ нийтлэх нь огцом буурсан байна.

Мэдээний сэдвийн эрэмбэ (бүх хугацааны нийлбэрээр) гаргаж үзвэл нийгэм (3251) хамгийн чухал сэдэв болж байлаа. Нийгмийн сэдэвтэй мэдээ 2019 онд хамгийн өндөр (947) байгаад 2024 онд буурсан ч (2019 оноос 762 болж 185-аар цөөн) хамгийн их мэдээтэй сэдэв хэвээрээ байна. Энэ нь ардчилсан чөлөөт хэвлэлийн иргэдийн дуу хоолойг чухалчилдаг, нийгмийн сэдэв асуудалд төвлөрдөг хариуцлагатай, ёс зүйтэй хандлагыг илэрхийлж байлаа. Мөн улс төр (2774) чухал сэдэв хэвээр байна. Улс төрийн мэдээ 2014 онд хамгийн өндөр (816) байсан бол 2024 онд 519 болж огцом буурсан байна. Улмаар 2024 оны нийт мэдээний тооны бууралтад улс төрийн сэдвийн бууралт (2019 оноос 219-өөр буурсан) голлон нөлөөлжээ. Энэ нь төр засгийн мэдээ, мэдээллийг түгээх сонины гэрээ хэлцэл, улс төрийн харилцаатай холбоотой байхыг үгүйсгэхгүй. Соёл урлаг, спортын мэдээ (1036) хэдийгээр дээрх хоёр сэдвээс цөөн байсан ч “Өдрийн сонин”-ы мэдээллийн зугаацуулах үүрэгтэй холбоотой сонин содон мэдээг цөөнгүй гаргадаг шинж чанарыг тодотгож байсан юм. Харин эдийн засгийн мэдээ (765) цөөн боловч хэрэгцээтэй мэдээллийн сэдэв

байсаар иржээ. 2004 оноос хойш тогтмол өсөж, 2024 онд хамгийн өндөр (228) үзүүлэлттэй болсон нь “Өдрийн сонин”-ы эдийн засгийн мэдээлэлд өгөх анхаарал нэмэгдсэнийг харуулж байна.

	2024. 7-12 дугаар сар			2019. 7-12 дугаар сар			2014. 7-12 дугаар сар			2004. 7-12 дугаар сар			
Сэдэв	Дэлгэрэнгүй мэдээ	Товч мэдээ	Нийт	Дэлгэрэнгүй мэдээ	Товч мэдээ	Нийт	Дэлгэрэнгүй мэдээ	Товч мэдээ	Нийт	Дэлгэрэнгүй мэдээ	Товч мэдээ	Нийт	Нийт
Нийгэм	725	37	762	886	61	947	783	68	851	559	132	691	3251
Улс төр	437	82	519	617	121	738	724	92	816	623	78	701	2774
Эдийн засаг	197	31	228	182	24	206	166	13	179	127	25	152	765
Соёл урлаг, спорт	183	36	219	251	42	293	159	48	207	276	41	317	1036
Дүн	1542	186	1728	1936	248	2184	1832	221	2053	1585	276	1861	7826

Хүснэгт 3: “Өдрийн сонин”-ы мэдээний тоон үзүүлэлт

Мэдээний дэлгэрэнгүй, товч төрлийн харьцаа чухал байдаг. Өдрийн сонин мэдээгээ харьцангуй дэлгэрэнгүйгээр хэлбэрээр (85%-89%) нийтэлдэг байна. Товч мэдээний хувь 2004 онд хамгийн өндөр (14.83%) байснаа буурч, сүүлийн 10 жилд (2014, 2019, 2024) 10%-11% орчимд тогтворжжээ. Энэ нь тус сонин мэдээллийг товч байдлаар бус, дэлгэрэнгүй тайлбарлах, ингэхдээ эх сурвалжтай мэдээлэх бодлого баримталж ирснийг харуулж байна. Үүгээрээ бусад сониноос эрс ялгарч байсан юм.

“Өдрийн Сонин”-ы эх сурвалжийн харьцааны шинжилгээ (2004-2024) дараах үр дүнгүүд гарсан юм.



График 3. Он жилүүдийн эх сурвалжтай мэдээний үзүүлэлтүүдийн харьцуулалт

Эх сурвалжтай мэдээний хувь сүүлийн 20 жилд тогтмол өсөх гайхалтай хандлагыг харуулсан нь энэхүү дүн шинжилгээний хамгийн гол цэг юм. Тогтмол

өсөлт (52.34% → 82.87%) 2004 онд нийт мэдээний тал орчим хувь нь (52.34%) эх сурвалжтай байсан. 2014 онд 61.23% болж өссөн. 2019 онд 78.84% болж нэлээд огцом өсөлт хийсэн. 2024 онд хамгийн өндөр үзүүлэлт болох 82.87%-д хүрсэн.

Энэ нь “Өдрийн сонин” нь цаг хугацаа өнгөрөх тусам мэдээллийн баталгаа, үнэн зөв байдал, сэтгүүл зүйн хариуцлагыг тавьдаг шаардлагаа чандлан сайжруулсан гэдгийг илтгэж байна. Сонин нь мэдээ бэлтгэхдээ заавал эх сурвалжийг дурдах бодлого, стандартыг тууштай хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгчээ. Эсрэгээрээ эх сурвалжгүй мэдээний бууралт (47.66% → 17.13%) мөн ажиглагдсан нь сонины чанарын өсөлтийг давхар баталж байна.

Чанарын ийм өсөлттэй “Өдрийн сонин” нь 20 жилийн дотор эх сурвалжтай мэдээний хувь хэмжээг 52%-иас 82% хүртэл нэмэгдүүлсэн нь сонины мэргэжлийн ёс зүй болон редакцийн стандартын тогтмол, амжилттай сайжруулалтыг харуулсан маш эерэг хандлага юм. Хэдийгээр 2024 онд нийт мэдээний тоо мэдэгдэхүйц буурсан ч (1728 болсон), үлдсэн мэдээнүүд нь хамгийн өндөр чанар, баталгаатай (82.87% эх сурвалжтай) байжээ. Энэ нь сонин тооноос илүү чанарыг чухалчилж эхэлснийг илтгэж байна.

“Ардын өдрийн сонин” Хятадын хамгийн нэр хүндтэй, өргөн тархсан цогц өдөр тутмын сонин, “төв” дэсийн гол хэвлэл мэдээллийн хэрэгсэл тул сонгов. Тус сонин нь Хятадын нийгмийг төлөөлж буй яриа” (Хуан Ин, 2007) гэж үнэлэгддэг.

“Ардын өдрийн сонин”-ы 2004, 2014, 2019, 2024 оны 7-12-р саруудад нийтлэгдсэн мэдээлэлд эх сурвалжийн тоон шинжилгээг хийсэн үр дүнг авч үзье. Нийт 7064 мэдээ бүртгэгдсэний 6402 дэлгэрэнгүй мэдээ, 662 товч мэдээ нийтлэгджээ.

Сэдэв	2024. 7-12 дугаар сар			2019. 7-12 дугаар сар			2014. 7-12 дугаар сар			2004. 7-12 дугаар сар			Нийт
	Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			
	Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		
Нийгэм	612	34	646	553	27	580	518	39	557	424	12	436	2219
Улс төр	588	86	674	626	63	689	549	112	661	482	29	511	2535
Эдийн засаг	252	73	325	186	29	215	246	18	264	117	32	149	953
Соёл урлаг, спорт	384	30	414	327	42	369	278	21	299	260	15	275	1357
Дүн	1836	223	2059	1692	161	1853	1591	190	1781	1283	88	1371	7064

Хүснэгт 4: “Ардын өдрийн сонины мэдээний тоон үзүүлэлт:

Сэдэв, товч дэлгэрэнгүй мэдээгээр эх сурвалжтай мэдээллийн тоо тогтмол өсөх

хандлагатай байна (1371-ээс 2059 болж). Энэ нь мэдээллийн хэрэгслийн цар хүрээ, мэдээ гаргах давтамж нэмэгдсэнийг илтгэж болно. Товч мэдээний тоо 2004 (88)-өөс 2024 (223) онд мэдэгдэхүйц нэмэгдсэн нь мэдээллийн хурд, шуурхай мэдээллийн хэрэгцээ өссөнийг харуулж байна. Гэхдээ товч мэдээний өсөлт нь эх сурвалжтай мэдээний үр дүнд сөрөг нөлөөтэйг, цаашлаад эх сурвалжтай мэдээлэх зарчимд харшлахыг анхаарах шаардлагатай.

Улс төрийн сэдэв нь бүх онуудад хамгийн их мэдээтэй буюу нийт 2535 байна. 2019 онд хамгийн өндөр (689) байсан бол 2024 онд арай буурч (674) байгаа ч тэргүүлсэн хэвээр байна. Энэ бол коммунист хэвлэлийн нам, төрийн суртал ухуулгын мэдээллийн нөлөө, төр засгийн олон нийтийн санаа бодолд улс төрийн эх сурвалжуудын үзүүлэх нөлөөллийн илрэл юм. Нийгмийн сэдэв нь нийт 2219 мэдээтэйгээр хоёрдугаарт орж байгаа бөгөөд 2004 оноос (436) 2024 онд (646) хамгийн ихээр өссөн (210-аар) сэдэв байна. Энэ нь нийгмийн асуудал, амьдралын хэв маягийн сэдэв чухалчилж байгааг илтгэнэ. Эдийн засгийн мэдээнүүд 2004-2019 оны хооронд хэлбэлзэлтэй байгаа ч 2024 онд 325 -аар хамгийн өндөр хэмжээнд хүрсэн нь тухайн үеийн эдийн засгийн идэвхжилтэй холбоотой байж болно. Харин 2019 онд (215) харьцангуй багассан нь анхаарал татаж байна.

Энэ үзүүлэлт дэх мэдээний сэдэв тус бүрийн эх сурвалжтай мэдээллийн статистикийг жил жилийн нэгдсэн дүнгээр авч үзэж шинжилгээ хийе.




График 4. Эх сурвалжтай болон эх сурвалжгүй мэдээний харьцаа

Энэхүү диаграмм нь 2004, 2014, 2019, 2024 онуудын харьцуулалтаар “Ардын өдрийн сонин”-д нийтлэгдсэн мэдээний эх сурвалжтай болон эх сурвалжгүй мэдээний тоо болон хувийг харуулжээ. Нийтлэг хандлага (2004-2024)-ыг харвал судалгаанд хамрагдсан хугацаанд (2004-2024) эх сурвалжтай мэдээний тоо тогтмол өсөх хандлагатай байна. 2004 онд 734 байсан бол 2024 онд 1295 болж ойролцоогоор 2/3 дахин өссөн нь мэдээллийн шуурхай байдал нэмэгдэж, мэдээний багтаамж өссөн дүр зургийг илтгэж байв. Энэ нь 20 жилийн хугацаанд мэдээллийг баримтаар нотлох, эх сурвалжийг заах явдал сонины контентод чухал үүрэг гүйцэтгэх болсныг илтгэж байна. Эсрэгээрээ эх сурвалжгүй мэдээний тоо мөн өссөн байна (2004 онд 637-гоос 2024 онд 764). Гэсэн хэдий ч, 2019 оноос 2024 онд эх сурвалжтай мэдээний тоо 1146-аас 1295 болж өсөхөд, эх сурвалжгүй мэдээний тоо 707-оос 764 болж харьцангуй удаан өссөн нь эерэг үзүүлэлт юм.

Эх сурвалжтай мэдээний хувь (хувь1) хугацааны туршид тогтмол нэмэгдсэн нь хамгийн гол эерэг дүгнэлт юм. 2004 он: 53.5%, 2014 он: 63.27%, 2019 он: 61.84% (бага зэрэг буурсан ч өндөр хэвээр), 2024 он: 62.89% (хамгийн өндөр үзүүлэлт) болжээ. Энэ нь “Ардын өдрийн сонин”-ы мэдээллийн нарийн шалгалт, баталгаажилт (journalistic rigor) өндөр түвшинд хүрч байгааг харуулж байлаа. 2024 онд нийт мэдээний

гуравны хоёр орчим нь эх сурвалжтай болсон байна.

Эх сурвалжгүй мэдээний хувь (хувь2) буурах хандлагатай байсан. 2004 онд 46.5%, 2024 онд 36.4% болсон нь мэдээллийн чанар, сэтгүүл зүйн хариуцлага сайжирч, сэтгүүлчид мэдээний эх сурвалжийг дурдахад илүү их анхаарал хандуулж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч улс төрийн сэдэвтэй холбоотойгоор эх сурвалжийн тоон үзүүлэлтүүд өсч байсан юм.

Одоо “Зууны мэдээ” сонины эх сурвалжийн шинжилгээг нарийвчлан хийснийг танилцуулъя.

“Зууны мэдээ” сонин улиралд 62-65 дугаар, А2 форматаар 7 хоногт 5 удаа, 8-16 нүүрээр хэвлэгддэг байна. Мэдээллийн багтаамжийн хувьд бусад сониноос ялгарах онцлог булангуудаараа хүртээмжтэй, хэрэгцээт материал хүргэхийг зорьдог (Мөнхжаргал, 2025, хуудсд. 28-29).

Ингээд тус сонины мэдээллийн түүвэрт шинжилгээнд дүн шинжилгээ хийе.

	2024. 7-12 дугаар сар			2019. 7-12 дугаар сар			2014. 7-12 дугаар сар			2004. 7-12 дугаар сар			
Сэдэв	Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			Дэлгэрэнгүй мэдээ			Нийт
	Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		Товч мэдээ	Нийт		
Нийгэм	577	349	926	883	368	1251	645	151	796	676	139	815	3788
Улс төр	354	167	521	406	146	552	653	136	789	535	102	637	2499
Эдийн засаг	164	19	183	157	38	195	99	27	126	121	41	162	666
Соёл урлаг, спорт	319	23	342	173	37	210	242	43	285	214	36	250	1087
Дүн	1414	558	1972	1619	589	2208	1639	357	1996	1546	318	1864	8040

Хүснэгт 5. “Зууны мэдээ” сонины 2004, 2014, 2019, 2024 оны хагас жилийн буюу 7-12 сард нийтлэгдсэн мэдээний сэдвийн харьцуулалт:

Дээрх хүснэгтийн үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж үзвэл “Зууны мэдээ” сонины гол анхаарал нийгэм сэдэвт чиглэж ирсэн бөгөөд энэ төрлийн мэдээлэл 2019 оноос хойш огцом буурсан. Харин соёл урлаг, спортын сэдэв өсөн нэмэгдэж байна. Улс төрийн сэдэвт мэдээ мэдэгдэхүйц багассан нь тус сонины контентын чиглэл өөрчлөгдсөнийг илэрхийлнэ. Сэдвийн ийм өөрчлөлт нь өдөр тутмын сонинд гарч болох бөгөөд тус сонины нийгэм, улс төрийн сэдэв, үйл явдлыг тусгах талд чиг хандлага буурсан бөгөөд спорт, соёл урлагийн мэдээллийн чиглэлд ач холбогдол өгөх болсныг илтгэж байлаа. Улмаар нийт мэдээний тоо 2019 оноос хойш мэдэгдэхүйц буурсан нь дээрх гол чиглэлийн мэдээний /улс төр, нийгэм/ бууралттай шууд хамааралтай байна.




График 5. Эх сурвалжтай болон эх сурвалжгүй мэдээний харьцаа

Эх сурвалжтай мэдээний тоо 2004 оноос (1283) 2019 он хүртэл (1328) бага зэрэг өсчээ. Энэ нь сонины мэдээллийн найдвартай байдал, баримт нотолгоонд тулгуурлах хандлага тогтвортой байсныг харуулж байна. Энэ нь сонины мэдээллийн найдвартай байдал, баримт нотолгоонд тулгуурлах чанар буурч байсан сөрөг хандлагыг илэрхийлж байна. Харин 2024 онд эх сурвалжтай мэдээний тоо (1202) бусад онуудаас хамгийн бага буюу буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь товч мэдээний тоон үзүүлэлт өссөнтэй холбоотой байлаа. Гэхдээ эх сурвалжгүй мэдээний хувь 2019 оныхоос бага зэрэг буурчээ. Энэ нь тухайн жилд мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох тал дээр бага зэрэг эерэг өөрчлөлт гарсан байж болохыг харуулна.

Хэдийгээр эх сурвалжтай мэдээ (60%-68%) давамгайлж байгаа ч эх сурвалжгүй мэдээллийн хэмжээ (31%-40%) нь цаг хугацааны явцад томоохон хэмжээгээр нэмэгдсэн нь мэдээллийн баталгаажуулалтдаа, ялангуяа эх сурвалжаар баталгаажуулах асуудалд анхаарах шаардлага оршсоор байгааг харуулж байна.

“Зууны мэдээ” сонины эх сурвалжгүй мэдээний хувь өндөр байдал ийнхүү буурахгүй тогтмол, эсэргээрээ өсөх чигтэй байгаагийн үндсэн шалтгаан нь товч мэдээ олноор нийтэлж байгаатай холбоотой байлаа. Зарим товч мэдээнд эх сурвалж дурдах үзэгдэл тохиолдож байвч маш цөөн байсан юм.

Тус судалгаа өдөр тутмын сонины эх сурвалжийн нөхцөл байдлыг тодруулахдаа дээрх гурван шалгуур үзүүлэлтээр авч үзсэн нь хязгаарлагдмал шинжтэй юм. Цаашид бид түүвэртээ эх сурвалжийн төрөл ангилал, түвшин зэргээр шалгуурыг нэмснээр бодит нөхцөл байдал дахь асуудлуудыг илүү тодруулах чанарын шинжилгээ рүү орох болно.

Өдөр тутмын сонины мэдээний гаралт Монголын сонинд харьцангуй буурах төлөвтэй байна. Энэ нь шуурхай мэдээний орон зай хумигдах хандлагыг илтгэж байв. Үүний зэрэгцээ сонины дэлгэрэнгүй, товч мэдээг нийтлэх бодлого өөр өөр байгаагаас (“Өдрийн сонин”-д дэлгэрэнгүй мэдээ түлхүү нийтлэгддэг бол “Зууны мэдээ” товч мэдээг харьцангуй олноор нийтэлдэг нь мэдээний нийт үзүүлэлтэд нөлөөлж байв) эх сурвалж ашиглах байдалд эрс тэс үр дүн гарахад нөлөөлсөн байна.

Ерөнхий дүр зургаар “Өдрийн сонин” эх сурвалж ашиглах талаараа чанарын эрс өсөлттэй байгаа бол “Зууны мэдээ” сонин тогтвортой байдлаа хадгалж байна. “Өдрийн сонин” хэдийгээр эх сурвалжийн түвшин өндөр байгаа ч мэдээг бууруулж, мэдээллийн шуурхай байдлыг орхигдуулах хандлагаа эргэж харах цаг болжээ. “Зууны мэдээ” сонинд нөлөөлсөн “товч мэдээ”-ний эх сурвалжгүй голчлон нийтлэгддэг байдал чанарын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байлаа. Иймд

эх сурвалжгүй мэдээллийн хэмжээ (31%-40%) нь эх сурвалжаар баталгаажуулсан мэдээллийн чанарт анхаарах шаардлага байгааг харуулж байна. “Ардын өдрийн сонин” нь олон жилийн давтамжаас харвал эх сурвалжтайгаар мэдээ нийтлэх тал дээр онцгой анхаарч ирсэн байна. Энэ нь мэдээллийн чанар, сэтгүүл зүйн хариуцлага сайжирч, сэтгүүлчид мэдээний эх сурвалжийг дурдахад илүү их анхаарал хандуулж байгааг харуулж байна. Гэхдээ мэдээ нийтлэх тоон үзүүлэлт тогтмол өссөн нь эх сурвалжгүй мэдээний түвшин олон жилийн дунджаар хадгалагдаж байгаа үр дүн гарахад нөлөөлжээ. Иймд эх сурвалжгүй мэдээний гаралтад анхаарал хандуулж, хатуу хяналт тавих, эх сурвалж нягтлах, баталгаажуулах шаардлага тулгамдсаар байна.

Эдгээр дүгнэлтэд үндэслэн сонин тус бүр мэдээний эх сурвалжийн тус тусын дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.

- “Өдрийн сонин”-ы хувьд төр, засгийн мэдээг шууд, идэвхгүй дамжуулагч бус ашиг сонирхолын бус эх сурвалжаар давхар тэнцвэржүүлэх, мэдээллийн бодит байдлыг тодруулах, эрэл сурвалжилгад үндэслэн нийгмийн орчин, иргэдийн аж амьдралаас холбогдох эх сурвалж тодруулга аван нийгэм, эдийн засгийн холбогдолтой сэдэв, үйл явдлын мэдээг бэлтгэх,

- “Зууны мэдээ сонин” мөн дээрх шаардлагыг хангаж ажлахын зэрэгцээ “товч мэдээ”-ний тоог цөөрүүлж, илүү тэнцвэртэй, судалгаатай, эх сурвалж, эшлэл бүхий дэлгэрэнгүй, ашигтай мэдээ бэлтгэхэд чиглэх,

- Ардын өдрийн сонин” нам, төр засгийн мэдээг сэтгүүлчийн бие даан сурвалжлах эрхийг хангах, редакц төр засгийн институтаас ирж буй мэдээг, бичгийн эх сурвалжийн мэдээллийг аман эх сурвалж /албан ёсны/-аар бататгах, тэнцвэртэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Эцэст нь өдөр тутмын сонины мэдээллийн баталгаат чанарыг илтгэх мэдээний эх сурвалжийнхаа нөхцөл байдалд редакц, сэтгүүлчид байнга анхаарч ажиллах нь хэрэглэгчид баталгаагүй, хуурамч мэдээлэлд эргэлзэж, залхах болсон энэ цаг үед уншигчдынхаа итгэлийг өсгөх чанартай мэдээллийн нэг чухал үзүүлэлт болох юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Багана. (2004). *Монгол үндэстний ойр үе орчин үеийн сонины үйлсийн тухай анхны шинжлэл*. Хөххот, ӨМӨЗО.
- Базар, Ч. (2007). *Эрэн сурвалжлах сэтгүүл зүй*. Улаанбаатар: Адмон.
- Болд-Эрдэнэ, Б. (2021). *Сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар: МУИС хэвлэлийн газар.
- Бүрээчин, Д. (2002). *Дундад улсын сонин сэтгүүлийн түүхэн тойм*. Хөххот.
- Зулькафиль, М. (2007). *Сэтгүүл зүйн тайлбар толь*. Улаанбаатар: МУИС хэвлэл үйлдвэр.
- Мөнхжаргал, Х. (2025). *Хэвлэл мэдээллийн цахим шилжилтийн судалгаа: Өдөр тутмын сонины convergence-ийн жишээгээр* (Магистрын зэрэг горилсон бүтээл). Улаанбаатар: МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэнхим.
- Норовсүрэн, Л. (2025). *Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь*. Улаанбаатар: Сэлэнгэпресс.
- Оюунбилэг, Т. (2007). *Монголын сонины мэдээллийн эх сурвалжийн өнөөгийн байдал, тугамдсан асуудлууд*. Улаанбаатар.
- Суй Шан, Л. Ш. (2021). Нэгдсэн хэвлэл мэдээллийн эрин дэх уламжлалт сонины мэдээ бичихэд тулгарч буй бэрхшээл, боломжуудын тайлбар. *Сурвалжлах*,

- найруулах, бичих, 02.
- Сю, Ж. (2001). Мэдээллийн эх сурвалж ба ангиллын судалгаа. *Орчин үеийн мэдээлэл сэтгүүл*, 68–76.
- Хуайю, Л. (2022). Хэвлэл мэдээллийн нэгдэн нийлэх үйл явцын цаг үе дэх уламжлалт сонины мэдээний бичлэгт хийсэн задлан шинжилгээ. *Соёлын аж үйлдвэр сэтгүүл*, 78–96.
- Cambridge Dictionary. (n.d.). *Source*. Retrieved from <https://dictionary.cambridge.org/dictionary/english/source>
- Cottle, S. (2007). *Ethnography and news production: New(s) developments in the field*. *Sociology Compass*, 1(1), 1–16.
- Dictionary.com. (n.d.). *Source*. Retrieved from <https://www.dictionary.com/browse/source>
- Hall, S., & Scraton, P. (1981). *Law, class and control*. In G. M. M. Fitzgerald (Ed.), *Crime and society*.
- Merriam-Webster. (n.d.). *Source*. In *Merriam-Webster.com dictionary*. Retrieved from <https://www.merriam-webster.com/dictionary/source>
- Oxford Learner's Dictionaries. (n.d.). *Source*. Retrieved from <https://www.oxfordlearnersdictionaries.com/definition/english/source>
- Suhua, C. (2006). *Мэдээллийн эх сурвалжийн хувьсал ба ашиглалтын тухай* (Master's thesis). Jinan University.

Summary

Research on information sources is an important issue in news and information analysis. Daily newspaper news is a type of news that requires high verification by sources. However, news is still published without sources. Therefore, a study that covers daily newspaper news for a certain period of time and determines the actual situation is necessary. In this article, a sample of daily newspaper news was analyzed using content analysis to clarify the practical situation of newspaper news sources. Previous studies have aimed to solve theoretical-practical problems, but have not sufficiently determined what the reality is. Most studies have deviated from the issue of pure journalistic information verification by distinguishing between permanent and occasional sources, studying cultural groups, competitors, and their public relations. When studying the sources of daily newspapers, the sample was analyzed using the following coders: topic, short and detailed news, and news with and without sources. In terms of sources, the two Mongolian newspapers have high quality indicators, but there is a need to pay attention to the issue of short news stories and news that do not cite sources. While there is a growing trend in Chinese newspapers to report news with professional accountability, ideologically driven state news sources and news source networks have a strong negative impact. The results of the study show that while the responsibility to verify the source of news in daily newspapers is increasing, some problems such as this still exist.

Keywords: Journalistic Source, news, topic, short and detailed news, source types, source content analysis

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХУДАЛ МЭДЭЭЛЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Б.Болормаа*

**Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Сэтгүүл зүй,
медиа технологийн тэнхимийн багш, доктор(Ph.D)*

Түлхүүр үгс: Цахим Орчин, Худал Мэдээлэл, Контент Модераци, Зохицуулалт, Хиймэл Оюун

Оршил. Сүүлийн жилүүдэд хиймэл оюун (AI) болон алгоритмд суурилсан дижитал технологиудын хурдацтай хөгжил нь худал мэдээллийн тухай уламжлалт ойлголтыг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна. Өмнө нь худал мэдээллийн тархалтыг голчлон мэдээний агуулгын үнэн зөв байдал, мэдээлэл түгээгчийн санаатай үйлдэл, эсвэл хэрэглэгчийн мэдээлэл ялган таних чадвартай холбон тайлбарлаж ирсэн бол өнөөдөр хиймэл оюунд суурилсан системүүд мэдээллийг автоматаар үүсгэх, эрэмбэлэх, хувиргах замаар түүний хүрээ, нөлөөг өмнөхөөс хавьгүй өргөжүүлж байна. Ялангуяа гүн сургалтад тулгуурласан алгоритмууд нь мэдээллийн урсгалыг хэрэглэгч бүрт өөр өөрөөр хэлбэржүүлж, худал мэдээллийн тархалтыг хурдасгахын зэрэгцээ олон нийтийн ойлголт, итгэлцэлд гүнзгий нөлөөлөх болжээ.

Судлаачид худал мэдээллийн асуудлыг зөвхөн агуулга болон дамжуулалтын түвшинд авч үзэх нь хангалтгүй болохыг онцолдог. Тухайлбал, Филип М. Наполи худал мэдээллийг дижитал орчинд мэдээлэл бүтээгч, дамжуулагч, хэрэглэгчийн олон талт ашиг сонирхол хоорондоо нарийн сүлжилдсэн сүлжээний асуудал гэж үзэх ёстойг тэмдэглэсэн байдаг (Napoli, 2019). Үүнтэй адилаар, Тошико худал мэдээллийг “мэдээллийн үүсэлт, урсгал, түгээлт, дамжуулалт, хүлээн авах бүтцийг хамарсан цогц системийн асуудал гэж үзэх нь илүү оновчтой” болохыг онцолж (To-shiko, 2018), асуудлын хүрээг илүү өргөн өнцгөөс дахин тодорхойлох шаардлагатайг дэвшүүлсэн байна. Эдгээр судалгааны байр суурь нь худал мэдээллийг хувь хүний түвшинд төвлөрсөн ойлголтоос ангид, харин дижитал экосистемийн бүтэц, технологийн логиктой уялдуулан тайлбарлах онолын суурийг бүрдүүлж байна.

Гэсэн хэдий ч өнөөгийн судалгаанд худал мэдээллийн тухай ойлголтыг агуулгын хувьд хувь хүний үзэл санаа, төөрөгдүүлсэн, буруу эсвэл худал мэдээлэл тараах үйлдлийн хувьд түүний сэдэл, санаатай, санамсаргүйгээр[1] төдийхнөөр, мөн

хэрэглэгчийн танин мэдэх чадвар болон зан төлөвийн хүрээнд авч үзэх хандлага давамгайлсан хэвээр байгаа бөгөөд хиймэл оюунд суурилсан алгоритм, дамжуулагч цахим платформуудын гүйцэтгэж буй бүтэцчилсэн үүрэг харьцангуй орхигдсоор байна. Цахим платформууд нь мэдээллийн “саармаг дамжуулагч[2]” бус, харин контентыг эрэмбэлэх, харагдах байдлыг зохицуулах, тодорхой мэдээллийг илүү өргөн түгээх замаар нийгмийн мэдээллийн орчныг идэвхтэй бүрдүүлэгч болж буй нь худал мэдээллийн нөлөөг ойлгоход зайлшгүй анхаарах асуудал юм.

Иймд энэхүү өгүүлэл нь хиймэл оюунт технологиор дэмжигдсэн цахим орчин дахь худал мэдээллийн асуудлыг “мэдээлэл дамжуулагч” цахим платформуудыг нэгтгэсэн “системийн” хүрээнд онолын түвшинд авч үзэхийг зорьж байна. Түүнчлэн, хиймэл оюун болон алгоритмд суурилсан платформууд худал мэдээллийн үүсэл, тархалт, нөлөөлөлд хэрхэн оролцож буйг задлан шинжилж, худал мэдээллийн талаарх ойлголтыг “контентын асуудал”-аас “системийн асуудал” руу өргөтгөн тайлбарлахад оршино. Ингэснээр хиймэл оюунт эрин үе дэх худал мэдээлэл, цахим платформын хариуцлагын асуудлыг судлах онолын хүрээг баяжуулж, цаашдын бодлого, зохицуулалтын судалгаанд ашиглах боломжтой суурь ойлголтыг дэвшүүлэхийг зорьж байна.

Судалгааны арга зүй

Цахим платформ болон хиймэл оюун нь сэтгүүл зүйн бүтээлийн үйлдвэрлэл, түгээлт, хэрэглээний бүхий л үе шатанд гүнзгий нөлөө үзүүлж, улмаар онол-практикийн судалгааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болоод байна. Хиймэл оюунд суурилсан технологиор дамжин түгж буй худал мэдээллийг нийгэм, хэвлэл мэдээлэл, ёс зүйн олон өнцгөөс судлах боломжтой хэдий ч, энэхүү өгүүлэл нь уг асуудлын эрх зүйн зохицуулалтын хүрээнд, ялангуяа мэдээлэл түргэгч цахим платформуудын хариуцлагын асуудалд төвлөрөн авч үзнэ.

Эрх зүйн зохицуулалт, түүний бодлогын шинжилгээнд худал мэдээлэлтэй холбоотой дараах хоёр суурь асуудал тулгардаг.

- Нэгдүгээрт, худал мэдээлэл тараах үйлдэл нь үг хэлэх эрх чөлөөний хүрээнд хамгаалагдах эсэх;
- Хоёрдугаарт, хэрэв тодорхой нөхцөлд хамгаалагдах боломжтой гэж үзвэл, түүнийг ямар шалгуур, ямар хязгаарлалтын хүрээнд хэвлэл мэдээллийн холбогдох хууль тогтоомжид зөвшөөрөх ёстой вэ гэсэн асуудал юм.

Энэхүү өгүүллийн зорилго нь дээрх асуултуудад шууд норматив хариулт өгөхөд бус, харин худал мэдээлэл дамжуулж буй цахим платформын зохицуулалтыг хэвлэл мэдээллийн хамаарал бүхий эрх зүйн зохицуулалтын хүрээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатайг онолын түвшинд тайлбарлахад оршино. Монгол Улсад Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар хэлэлцэж буй энэ цаг үед уг асуудлыг сонгон авч үзэж буй нь бодлогын болон онолын хувьд онцгой ач холбогдолтой юм.

Худал мэдээ: нийгэмд үзүүлэх нөлөө, үр дагавар

Хүний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө. Хиймэл оюуныг их хэмжээний өгөгдлийг өндөр хурд, нарийвчлалтай боловсруулах чадвар, хүний шууд оролцоогүйгээр бие даан шийдвэр гаргах түвшин, мөн гүн сургалтад суурилсан системүүдийн шийдвэр гаргах процесс “хар хайрцагжилт”-ын шинжтэй болж, үр дүнг тайлбарлахад

хүндрэлтэй болсон гэсэн гурван үндсэн онцлогоор тодорхойлж болно (Gillespie, 2018). Сүүлийн үед, текст, дүрс, дуу хоолой, видео зэрэг контентыг автоматаар үүсгэх чадвартай хиймэл оюунт системүүд өргөн хэрэглээнд нэвтэрснээр хүний оролцоо, ёс зүйн үнэлгээ, мэргэжлийн хяналтад тулгуурлаж ирсэн олон шийдвэр, үйл явцыг алгоритмд шилжүүлэх хандлага нэмэгдэж байна. Хэдийгээр хиймэл оюун нь мэдээлэл боловсруулах хүчин чадлаараа хүнийг давж байгаа ч түүний гаргасан үр дүнг заавал “үнэн”, “зөв” гэж үзэх боломжгүй бөгөөд бие даасан шийдвэр гаргах чадвар, “хар хайрцагжилт”-ын онцлогоос шалтгаалан хүний хяналтгүйгээр төөрөгдүүлсэн мэдээлэл үүсэж, нийгэмд хурдан тархах эрсдэл нэмэгдэж байна. Судалгаагаар хүмүүс хиймэл оюунаар үүсгэсэн худал мэдээлэлд хүний гараар бүтсэнээс илүү итгэх хандлагатай байгаа нь уг эрсдэлийг улам ноцтой болгож байна (Pennycook and Rand, 2020; MacKenzie et al. 2025).

Практик түвшинд уг эрсдэл гүн сургалтад суурилсан хуурамч дүрс, дуу хоолой бүхий контентоор тод илэрч байна. Тухайлбал, 2024 оны хоёрдугаар сард Google-ийн хиймэл оюун Gemini хэрэглэгчийн “1943 оны Германы цэргийн дүр төрх” гэсэн хүсэлтийг буруу тайлбарласнаар түүхэн бодит байдалд нийцэхгүй, нийгмийн хувьд эмзэг дүрсүүдийг үүсгэж, улмаар уг функцийг түр хаахад хүрсэн нь хиймэл оюун хүний анхны зорилгоос давсан контент санаандгүйгээр бий болгох эрсдэлийг харуулсан жишээ юм (Milmo, 2024). Мөн хиймэл оюуны дэмжлэгтэйгээр уран бүтээлч, жүжигчдийн нүүр царайг ашиглан порнограф контент бүтээж, дотоодын хуулийн байгууллагад илчлэгдсэн тохиолдлууд гарсаар байна (Asahi Shimbun, 2020). Эдгээр нь ихэвчлэн тодорхой зорилготой хүмүүсийн гар аргаар бүтээсэн санаатай үйлдэл давамгайлдаг бөгөөд зохиогч нь хариуцлага хүлээх ёстой гэж үздэг. Гэвч Gemini-ийн жишээнээс харахад хиймэл оюун хүний санаанаас давсан агуулга үүсгэж, нэр төр, эрх чөлөөнд халдсан нөхцөлд хүний аюулгүй байдалд заналхийлэх эрсдэл нэмэгдэж, хариуцлагын асуудал илүү төвөгтэй хэлбэрээр тавигдаж байна.

Монгол Улсад ч мөн адил төрийн өндөр албан тушаалтнууд болох Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит компанийн удирдлагуудын дүр төрх, дуу хоолойг хиймэл оюунд суурилсан технологиор дуурайлган бүтээж, олон нийтийн сүлжээгээр түгээсэн бодит тохиолдлууд бүртгэгдсэн байна. Эдгээр контент нь улс төр, сонгуулийн орчинтой нягт уялдан тархсан бөгөөд зарим тохиолдолд Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газраас эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь дижитал орчин дахь худал мэдээлэл нь зөвхөн ёс зүйн зөрчил бус, харин хүний нэр төр, сэтгэлзүйн аюулгүй байдал, олон нийтийн итгэлцэлд бодит эрсдэл учруулж байгааг харуулж байна.

Ийм төрлийн эрсдэл нь зөвхөн Монгол Улсад хязгаарлагдахгүй бөгөөд сонгуулийн кампанит ажлын үеэр тодорхой нэр дэвшигчийг гутаан доромжлох, сонгогчдыг төөрөгдүүлэх зорилгоор deepfake технологид суурилсан бичлэг, контентыг олон нийтэд түгээсэн тохиолдлууд дэлхийн олон оронд бүртгэгджээ. Үүний хариуд АНУ-ын Калифорни болон Техас мужууд сонгогчдыг төөрөгдүүлэх зорилгоор deepfake технологиор бүтээсэн улс төрийн контентыг түгээхийг хориглосон хууль баталсан нь (Assembly Bill 2839 “Protecting Democracy Against Election Disinformation and Deepfakes”) уг асуудалд чиглэсэн эрх зүйн бодит хариу арга хэмжээний жишээ болж байна. Түүнчлэн 2024 оны Мюнхений аюулгүй байдлын бага хурлын үеэр 20 гаруй технологийн компани сонгуулийн үеэр хиймэл оюунаар бүтээгдсэн төөрөгдүүлсэн контентоос урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаанд нэгдэхээр тохиролцсон нь deepfake болон худал мэдээлэл нь олон улсын түвшинд анхаарал татсан, нэгдсэн хариу шаардсан асуудал болсныг илтгэж байна.

Мэдээж, үнэн ба худлыг илрүүлэх баримт шалгах технологи хөгжиж байгаа ч энэ нь “муур, хулгана хөөцөлдөх” мэт төгсгөлгүй өрсөлдөөн болж, эцэст нь “үнэнийг таних” нь улам хэцүү болж байгааг дурдах нь зүйтэй.

Эдгээр нөхцөл байдлыг “хүний аюулгүй байдал” хэмээх ойлголтоор тайлбарлах боломжтой. НҮБ-ын 1994 оны Хүний хөгжлийн тайланд хүний аюулгүй байдлыг айдас болон хомсдолоос ангид байх (freedom from fear, freedom from want) үзэл санаатай холбон тайлбарлаж, хүний өдөр тутмын амьдрал, нэр төр, эрх чөлөө, оролцоог хамгаалахыг аюулгүй байдлын салшгүй хэсэг гэж үзсэн байдаг (UNDP, 1994). Энэ утгаараа хиймэл оюунаар үүсгэгдэж, цахим платформоор дамжин түгж буй худал мэдээлэл нь хүний эрх, нэр төр төдийгүй сэтгэлзүйн болон нийгмийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх асуудал болж байна.

Хүний аюулгүй байдлын энэхүү ойлголт нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн үндэсний тогтолцоотой нягт уялддаг. 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгд амьд явах эрх, 13 дахь хэсэгт нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдлыг хамгаалах эрхийг баталгаажуулсан нь дижитал орчин дахь мэдээллийн эрсдэлийг хүний аюулгүй байдлын хүрээнд авч үзэх эрх зүйн суурь болж байна (Монгол Улсын Үндсэн хууль, 1992). Үүний зэрэгцээ, Монгол Улс нь Хүний эрхийн олон улсын үндсэн гэрээ, тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR), Хүүхдийн эрхийн конвенц, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэгт нэгдэн орсон бөгөөд эдгээр гэрээний хэрэгжилтийг хангах үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн дагуу хүлээдэг. Үндэсний түвшинд эдгээр үүргийг хэрэгжүүлэхэд Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь хараат бус хяналтын байгууллагын хувьд хүний эрх зөрчигдөж буй асуудлыг судлах, санал дүгнэлт гаргах, бодлогын зөвлөмж боловсруулах үүрэгтэй.

Олон улсын түвшинд ч мөн адил НҮБ, ЮНЕСКО зэрэг байгууллагууд дижитал орчин дахь мэдээллийн эрсдэлийг хүний эрхийн асуудалтай холбон тайлбарлаж, хиймэл оюунд суурилсан системүүд нь хүний нэр төр, хүний эрх, сайн сайхан байдалд нийцсэн байх, мөн ил тод байдал ба хүний хяналтыг хангах шаардлагатайг онцолжээ (UNESCO, 2021). Иймд хиймэл оюуны автономн, хар хайрцагжилт, контент үүсгэх чадамж нь технологийн дэвшил төдий бус, харин хүний нэр төр, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах чадвар, улмаар хүний аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна (UNDP, 1994). Энэ нөхцөлд хиймэл оюуны нөлөөг хүний аюулгүй байдлыг хамгаалах хүрээнд зохистой эрх зүйн зохицуулалтын шаардлага тулгарч байгааг энд тэмдэглэх нь зүйтэй.

1. Ардчилсан улс төрийн процесст үзүүлэх нөлөө

2016 онд Оксфордын Англи хэлний толь бичиг “post-truth” буюу “үнэний дараах” гэдэг үгийг “оны үг” хэмээн нэрлэсэн. Тус толь бичигт энэ үгийг “объектив баримтаас илүү хувь хүний сэтгэл хөдлөл, итгэл үнэмшилд тулгуурлан олон нийтийн санаа бодолд нөлөөлөх үзэгдэл” гэж тодорхойлжээ. Уг ойлголт өмнө нь ч академик болон олон нийтийн хэлэлцүүлэгт ашиглагдаж байсан боловч 2016 оны Их Британийн Европын Холбооноос гарах санал хураалт, мөн АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр “үнэний дараах улс төр” (post-truth politics) гэх хэллэг өргөн хэрэглэгдэх болж, улс төрийн шинжтэй ойлголт болон төлөвшсөн юм.

“Үнэний дараах улс төр” гэдэг нь улс төрийн маргаан, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц нь бодит баримт, шинжлэх ухаанч нотолгоо, баталгаатай мэдээлэлд бус, харин сэтгэл хөдлөл, субъектив итгэл үнэмшил, олон нийтэд таалагдах уриа, үг хэллэгт тулгуурлан өрнөх үйл явцыг илэрхийлдэг. Өөрөөр

хэлбэл, үнэн ба нотолгоонд суурилсан олон нийтийн рациональ хэлэлцүүлэг ач холбогдлоо алдаж, түүний оронд эмоци, уур хилэн, итгэл үнэмшил, “таалагдах” үгс давамгайлсан улс төрийн орчин бүрэлддэг байна. Энэхүү үйл явцыг Германы философич Юрген Хабермасын нийтийн хэлэлцүүлгийн онолоор тайлбарлах боломжтой. Түүний үзлээр ардчиллын үндэс нь иргэд эрх мэдлээс ангид, нээлттэй орон зайд баримт, үндэслэлд тулгуурлан харилцан маргалдаж, улмаар нийтлэг ойлголцолд хүрэх боломжтой байх явдалд оршдог. Нийтийн хэлэлцүүлэг нь зөвхөн мэдээлэл солилцох орон зай бус, харин улс төрийн шийдвэр гаргалтын хууль ёсны суурь бөгөөд энэ орчинд илэрхийлэгдсэн үзэл бодол нь олон нийтийн “рациональ шүүлт”-ээр дамжин төлөвшдөг (Habermas, 1989). Харин алгоритмд суурилсан үнэний дараах улс төр нь ардчиллын институциудыг шууд үгүйсгэхээс илүүтэйгээр, тэдгээрийн суурь үндэс болсон нийтийн рациональ хэлэлцүүлгийг аажмаар доройтуулж буй хэлбэр юм.

Түүнчлэн, хуурамч мэдээллийн тархалтаас үүдэлтэй үнэний дараах улс төр нь иргэдийн улс төрийн үнэлэмж, шүүлтийг системийн түвшинд гажуудуулж, улмаар сонгуулийн үйл явц болон ардчилсан шийдвэр гаргалтыг үе шаттайгаар алдагдуулдаг (Bennett, W. and Steven, L, 2018). Иймээс уг үзэгдлийг зөвхөн мэдээллийн хямрал бус, ардчилсан засаглалд тулгарч буй бүтцийн шинжтэй сорилт хэмээн ойлгох шаардлагатай.

Үүнээс гадна хиймэл оюунд суурилсан синтетик мэдээлэл, ялангуяа deepfake технологийн хөгжил нь үнэний дараах улс төрийн эрсдэлийг улам хурцатгаж байна. Монгол Улсад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд иргэдийн дийлэнх нь deepfake технологийн талаар хангалттай мэдлэггүй бөгөөд жинхэнэ ба хуурамч мэдээллийг ялгах чадвартаа итгэлгүй байгаагаа илэрхийлсэн нь нийтийн рациональ хэлэлцүүлэг бодитойгоор алдагдаж буйг харуулж байна (Б.Наранбаатар, Б.Намуун 2024). Түүнчлэн хэвлэл мэдээллийн тэргүүлэх сайтууд deepfake-ийн аюулын талаар мэдээлэх боловч түүнийг хэрхэн таних, яагаад ардчилалд сөрөг нөлөөтэй талаар системтэй, боловсрол олгохуйц тайлбар хийж чадахгүй байгаа нь алгоритмд суурилсан мэдээллийн орчны гажуудлыг улам гүнзгийрүүлж байна. Хабермасын онолд ардчиллын үндэс нь рациональ хэлэлцүүлэг гэж үздэг бол синтетик мэдээлэл өргөн тархсан орчинд иргэд бодит ба хуурамч мэдээллийг ялгах чадвараа алдаж, уг рациональ шүүлтийн суурь бодитойгоор нурж байгааг Монголын жишээ тод харуулж байна.

Нөгөө талаас ийм улс төрийн орчныг бүрдүүлж буй гол хүчин зүйл нь цахим платформуудын алгоритм юм. Алгоритм нь хэрэглэгчийн “лайк”, “сэтгэгдэл”, “хуваалцах” зэргээр илрэх зан төлөвт тулгуурлан контентыг “танд зориулав” хэмээн ангилж, шүүж, ижил төрлийн мэдээ мэдээллийг давамжтайгаар харуулдаг. Үүний үр дүнд хэрэглэгчид өөр үзэл бодол, эсрэг байр суурьтай мэдээлэлтэй харилцах боломжоо алдаж, зөвхөн өөрийн итгэл үнэмшлийг баталгаажуулах мэдээллийн орчинд орших хандлага нэмэгддэг. Үүнийг “echo chamber”, өөрөөр хэлбэл “өөрийн дуугаа өөртөө буцаан сонсдог орчин” хэмээн нэрлэдэг бөгөөд монгол хэлэнд “дундын танхимын эффект” гэж орчуулж болно. Хүмүүс зөвхөн өөрийн үзэл бодолтой нийцсэн мэдээллийг хүлээн авч, ижил үзэлтэй хүмүүстэй харилцахыг илүүд үзэх бөгөөд улмаар мэдээлэл нь бодит баримтад бус, харин эмоци, уур хилэн, итгэл үнэмшилд тулгуурлах хандлага давамгайлдаг. Энэ нь үнэний дараах улс төрийн суурийг бүрдүүлдэг гол нөхцөл болдог. Тухайлбал, сонгуулийн үеэр тодорхой нэр дэвшигчийг хэт магтан дөвийлгөх, эсвэл өрсөлдөгчийг гүтгэн доромжлох мэдээлэл нь үнэн эсэхээс үл хамааран олон нийтийн дунд хурдтай

тархах хандлагатай. Нэг “танхим”-д орших бүлгүүд өөрсдийн итгэл үнэмшилд нийцэж л байвал худал мэдээллийг ч эргэлзэлгүйгээр цааш түгээдэг. Үүний үр дүнд хүмүүс өөр өөр “үнэн”-д итгэж эхэлдэг ба “бодит” үнэн ба “худал” үнэний ялгаа бүдгэрсэн орон зай бий болдог.

Ийм нөхцөлд ардчилсан улс төрийн процессийн үндсэн зарчим болох иргэдийн олон нийтийн мэдээлэлд суурилсан, ухамсартай шийдвэр гаргалт буруу чиглүүлэгдэж, улмаар поларизаци буюу үзэл бодлын туйлшрал эрчимжих хандлага ажиглагддаг. Үүний үр дагаварт нийгмийн бүлгүүдийн хоорондын хуваагдал гүнзгийрч, нийтийн зөвшилцөл, харилцан итгэлцэл доройтдог. Ийнхүү ардчилсан системийг тодорхойлох сонгуулийн тогтолцоо, парламентын засаглал зэрэг төлөөллийн институци хэлбэрийн хувьд оршин тогтносоор боловч тэдгээрийг бодитоор ажиллуулдаг суурь нөхцөлүүдийн агуулга алдагдаж, ардчиллын эрсдэл үүсэх нөхцөл бүрддэг. Үүнийг судлаачид ардчилал гадаад хэлбэрээ хадгалсан боловч дотроосоо элэгдэх, өөрөөр хэлбэл “ардчиллын хоосрол” бий болох эрсдэл хэмээн тодорхойлдог (Mounk, 2018).

Үзэл бодлын энэхүү туйлшрал нь Монголын улс төрийн орчинд бодлогын агуулгад суурилсан маргаанаас илүүтэйгээр намчирхал, хувь хүн төвтэй дайсагнал, “бид–тэд” гэсэн сэтгэлзүйн хуваагдал хэлбэрээр илэрч байна. Тухайлбал, сонгуулийн үеэр улс төрийн намуудын бодлогын ялгаа тодорхой бус хэвээр байх нөхцөлд иргэд нийгмийн сүлжээнд туйлширч, харилцан дайсагнах хандлага нэмэгддэг. Үүний зэрэгцээ хот–хөдөө, баян–ядуу, ахмад–залуус зэрэг нийгмийн бүлгүүдийн хоорондын үл ойлголцол гүнзгийрч, өөр үзэл бодол, шинэ санааг ойлгон хүлээн авах чадамж сулран, субъектив болон сэтгэл хөдлөлд суурилсан хандлага давамгайлах байдал ажиглагдаж байна

Хэвлэл мэдээллийн “мэдээлэх” үүрэгт үзүүлэх нөлөө

Хэвлэл мэдээллийн “мэдээлэх” үүрэг нь ардчилсан нийгмийн суурь зарчмуудын нэг бөгөөд иргэд бодит, үнэн зөв, олон талт мэдээлэлд тулгуурлан нийгмийн амьдралд оролцох боломжийг хангахад чиглэдэг. “Мэдээлэх” үүргийн талаар профессор М.Зулькафиль “Хэвлэл мэдээллийн гол үүрэг нь мэдээлэх үүрэг мөн бөгөөд орчин үед мэдээллийн үнэ цэн, ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, энэ ойлголтыг энерги, матери зэрэг ойлголтын түвшинд авч үздэг болсон” гэжээ (М.Зулькафиль, 2017, р. 63-67). Профессор Ж.Батбаатар “Мэдээлэл нь олон эшт үзлийг хангахад үйлчлэн, хэнийг ч ялгаварлан гадуурхахгүйгээр нийгмийн гишүүн бүрийн өмнө тэгш нээлттэй байна” хэмээн мэдээлэх үүргийн талаар дурджээ (Ж.Батбаатар, 2010, р. 26). Доктор А.Оюунгэрэл “Хэвлэл мэдээлэл нь нийгэмд учрах аюул болон нийгэмд үүссэн боломжийг нийгмийн үнэлэмжийн системд нээн өгч тайлбарлах буюу шинээр солиход хувь нэмрээ оруулна” хэмээн мэдээлэх үүргийг чухалчлан тэмдэглэжээ (А.Оюунгэрэл, 2009, р. 51).

Эдгээр тодорхойлолтуудаас харахад хэвлэл мэдээллийн “мэдээлэх” үүрэг нь зөвхөн баримт дамжуулах төдий бус, харин нийгэмд бодит мэдээллийн урсгалыг бүрдүүлэх, олон талт үзэл бодлыг тэнцвэртэй тусгах, иргэн бүрт мэдээлэлд тэгш хүртээмж олгох замаар хүний мэдэх эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц ойлголт болох нь харагдаж байна.

Өмнө дурдсанчлан, цахим платформууд нь хэрэглэгчийн сонирхлын “профайл” үүсгэн, контентод оноо өгч, эрэмбэлэн ангилж, шүүж, сонгосны үндсэн дээр ижил төрлийн мэдээ мэдээллийг тогтмол хүргэдэг. Үүний үр дүнд хэрэглэгчид үзэл санааны хувьд ойролцоо, богино, сэтгэл хөдлөл өдөөсөн, нэг талыг барьсан

мэдээлэлд давамгайлан өртөх нөхцөл бүрдэж, бодит байдлыг олон өнцгөөс харуулах, маргаантай, төвөгтэй асуудлыг гүнзгий тайлбарлах хэвлэл мэдээллийн үндсэн үүрэг аажмаар шахагдах хандлага ажиглагдаж байна.

Алгоритмын энэхүү логик нь сэтгүүлчид болон редакцын бодлогод шууд нөлөөлж, хандалт, түгээлт, сурталчилгааны орлоготой уялдан “анхаарал татсан”, “туйлширсан”, “эмоциональ”, “хялбар хандалт авах” мэдээ давамгайлах нөхцөлийг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ нийгмийн ач холбогдол өндөр боловч цаг хугацаа, хөрөнгө, мэргэжлийн ур чадвар шаардсан эрэн сурвалжлах, дүн шинжилгээний сэтгүүл зүй, тэнцвэртэй тайлбар бүхий бүтээлүүдийн эзлэх хувь буурах хандлага илэрч байна. Цаашлаад “clickbait” буюу анхаарал татсан гарчигтай, хурдан хэрэглэгдэх контент илүү ашигтай гэсэн редакцийн хандлага бэхжих нь мэдээллийн чанар, гүнзгийрэлд сөргөөр нөлөөлдөг.

Ингэснээр нийгэмд нэг талыг барьсан, хэсэгчилсэн мэдээллийн урсгал давамгайлж, бодит байдлыг олон талаас мэдээлэх хэвлэл мэдээллийн үүргийн тухай уламжлалт ойлголт бүдгэрэх нөхцөл бүрдэж байна. Судлаачид энэ нөхцөл байдлыг “үзэл бодлын чөлөөт зах зээлийн хэвийн үйл ажиллагаа алдагдан”, иргэдийг олон талт мэдээллээс тусгаарлах хандлага бий болгож буйтай холбон тайлбарладаг (Sunstein, 2017). Үүний зэрэгцээ, “зөвхөн хэвлэл мэдээллийн мэргэжлийн үүрэг алдагдсан гэж оношлох бус, харин иргэдийн мэдэх эрх хэрэгжих бүтцийн орчинд үүссэн системийн доголдол” хэмээн үнэлэх нь зүйтэй гэж Наполи дүгнэсэн байдаг (Napoli, 2019).

Ийм нөхцөлд хэвлэл мэдээллийн “мэдээлэх” үүргийг зөвхөн редакцийн ёс зүй, сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагын хүрээнд тайлбарлах нь хангалтгүй болж байна. Харин мэдээлэл иргэдэд хэрхэн хүрч буй бүтэц, алгоритмд суурилсан түгээлтийн логик, цахим платформуудын эдийн засаг, зохицуулалтын орчин, олон нийтийн мэдээлэл хүлээн авах дадал хоорондын уялдааг системийн түвшинд авч үзэх шаардлага бий болж байна. Цаашид хэвлэл мэдээллийн “мэдээлэх” үүргийг бодитоор хэрэгжүүлэх орчныг хэрхэн бүрдүүлэх, улмаар бодит, тэнцвэртэй мэдээллээр дамжуулан иргэний мэдэх эрх, нийгмийн мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуудлыг онол, бодлого, эрх зүйн хүрээнд цогцоор нь судлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Цахим платформын хууль эрх зүйн зохицуулалт: онол, хэрэглээ

Цахим платформын зохицуулалтын асуудлыг коммон кэрриер (*common carrier*), буюу нийтийн тээвэрлэгчийн онолоор тайлбарлах хандлага судалгаанд түгээмэл байдаг. Нийтийн тээвэрлэгч гэдэг нь тодорхой нөхцөлд хэн нэгнийг ялгаварлан гадуурхахгүйгээр бараа, зорчигч тээвэрлэх, эсхүл мэдээлэл дамжуулах үүрэг хүлээдэг бөгөөд нийгмийн харилцаанд дэд бүтцийн шинжтэй үйлчилгээ үзүүлдэг операторыг хэлнэ. Тухайлбал, төмөр замын компани нь зорчигчийн улс төрийн үзэл бодол, итгэл үнэмшлээс шалтгаалан тасалбар худалдахаас татгалзах боломжгүй бөгөөд энэ нь нийтийн тээвэрлэгчийн ялгаварлан гадуурхахгүй байх үүргийн илэрхийлэл юм. Харин уг компани нь аюулгүй ажиллагааны дүрэм, үйлчилгээний стандарт зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Энэхүү жишээнээс харахад, нийтийн тээвэрлэгчийн онолын хүрээнд эрх зүйн зохицуулалт нь үйлчилгээний хүртээмж, тэгш байдлыг хангахын зэрэгцээ нийгмийн аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байдаг.

Хэрэв цахим платформуудыг нийтийн тээвэрлэгч гэж ангилбал, тэд бүх төрлийн мэдээ мэдээллийг нийгэмд хор хөнөөл учирхуйц аюултай эсэхийг нягталсны үндсэн

дээр дамжуулах хууль ёсны үүрэгтэй болно. 2015 оноос хойш мэдээллийн олон цахим платформууд нь мэдээллийн орчныг эрүүл хэвээр хадгалах, хэрэглэгчдэд тааламжтай үйлчилгээ үзүүлэх зорилгоор контент модераци гэх нэр томьёо бүхий “аюулгүй ажиллагаа” нэрийн доор хяналт зохицуулалтыг бий болгосон байна. Энэ нь хиймэл оюун эсвэл хүний нүдээр платформ дээрх мэдээллийг хянаж, шаардлагатай тохиолдолд платформын операторуудад тааламжгүй гэж үзсэн нийтлэл, сэтгэгдлийг устгах, акаунтыг түгжих, контентыг харагдах дарааллыг өөрчлөх зэрэг арга замаар мэдээллийг зохистой болгох үйл ажиллагааг хэлдэг. Жишээ нь, Yahoo! News нь сэтгэгдлийн хэсгийн эрүүл байдлыг хангах үүднээс зөрчил ихтэй сэтгэгдлийн хэсгийг нуух зэрэг арга хэмжээг авч байгааг бид мэднэ.

Мөн 2017 онд 10-р сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нь Герман Улсын *Netzwerkdurchsetzungsgesetz (NetzDG)* буюу “Нийгмийн сүлжээнд хууль бус контентыг зохицуулах хууль” юм. Тус хууль нь үзэн ядалт, заналхийлэл, терроризмын сурталчилгаа зэрэг контентыг 24 цагийн дотор устгах үүрэг, зөрчлийн тайлан жил бүр гаргах шаардлагыг цахим платформуудад үүрэг болгодог. Энэ нь платформуудыг нийгмийн аюултай мэдээлэлтэй тэмцэх чиглэлд хууль ёсоор хариуцлагажуулсан анхны үндэсний түвшний бодлого байсан.

Үүний дараа хэрэгжиж эхэлсэн Европын Холбооны дижитал платформуудад хамаарах шинэ зохицуулалт нь Дижитал үйлчилгээний тухай хууль (*Digital Services Act, DSA*)[3] юм. Тус хууль нь өмнөхөөс ялгаатай нь хууль бус контент илэрвэл устгах механизмыг шаардахаас гадна ил тод байдал, эрсдэл үнэлэх, алгоритмын мэдээлэл тайлагнах зэрэг үүрэг нэмсэн байна. Дижитал үйлчилгээний тухай хууль нь нийтийн тээвэрлэгчийн онолын логикоос ялгаатай нь платформыг идэвхтэй хяналттай оролцогч гэж үздэг. Мөн платформд тодорхой нөхцөлд хариуцлагаас чөлөөлөх “middleman liability exemption” тогтолцоотой (АНУ-ын CDA §230[4]-тай төстэй).

Сингапур Улсад, 2019 онд цахим мэдээллийн орчинд худал мэдээлэл болон зохион байгуулалттай мэдээллийн манипуляциас хамгаалах зорилготойгоор Худал мэдээллийн тухай хууль (*Protection from Online Falsehoods and Manipulation Act*) -ийг баталсан. Хууль батлагдсанаас хойш, Засгийн газар болон холбогдох агентлагууд цахим орчинд тархаж буй мэдээллийг хянаж, үнэн, худлын шалгуурт тулгуурлан ангилдаг, хэрэв платформ эсвэл мэдээллийн гаргагч нь үнэн бус мэдээлэл тарааж байвал Засгийн газар “Correction Notice” буюу залруулгын мэдэгдэл илгээдэг. Мөн цахим платформууд, худал мэдээллийн түгээлтийг хязгаарлах (*block, down-ranking*), үнэхээр аюултай, нийгэмд хор хөнөөл учруулж болзошгүй контентыг устгах үүрэгтэй. Тухайн шийдвэрийг биелүүлэхгүй тохиолдолд зөрчлийн хэрэг үүсгэж, торгууль, албан ёсны шийтгэл ногдуулдаг. Контент модерацийн хувьд “төрөөс чиглүүлсэн идэвхтэй зохицуулалт” гэсэн ангилалд ордог ч, иргэд олон нийт буюу хэрэглэгчийн мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах үүднээс “Хэрэглэгчдэд контентыг шалгах, засварлах эсвэл эсэргүүцэх боломжийг” хуульд тодорхой заасан нь онцлогтой.

Япон Улсын хувьд, Провайдерын хариуцлагыг хязгаарлах ба мэдээлэл гаргагчийн мэдээллийг ил болгох тухай хууль[5] нь цахим платформ буюу мэдээлэл дамжуулагч нь хэрэглэгчийн нийтэлсэн мэдээллийн агуулгын хариуцлагыг шууд хүлээхгүй, гэвч хууль бус, хор хөнөөлтэй контентыг устгах үүрэг, мөн хохирогчид шүүхээр нэхэмжлэл гаргах боломж” гэсэн үндсэн зарчмуудыг агуулдаг.

Мөн цахим платформуудын зохицуулалт нь зөвхөн хууль тогтоомжийн

хүрээнд хязгаарлагдахгүй бөгөөд олон улс оронд төр, хувийн хэвшил болон цахим платформуудын харилцан уялдаатай хамтын ажиллагаанд суурилсан зохицуулалтын загварыг хэрэгжүүлж байна. Энэхүй хамтын ажиллагаа нь тусгайлан бэлтгэсэн дүрмийн дагуу платформд нийгэмд хор хөнөөл учруулж болзошгүй контентыг хурдан илрүүлэх, устгах эрхийг олгодог. Жишээ нь, Европын Холбооны терроризмын болон хүчирхийллийн агуулга бүхий контентыг илрүүлэх, түгээхгүй болгох үүрэг бүхий төрийн агентлаг (EU Internet Referral Unit) нь платформуудыг контентыг устгах, downranking хийх, акаунтыг түдгэлзүүлэх зэрэг хурдан арга хэмжээ авахад чиглүүлэн платформуудын модерацийн багтай шууд хамтран ажилладаг. Мөн платформд зөвлөгөө өгөх, хяналтын аргачлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бөгөөд өөрийн зохицуулат болон засгийн газрын хяналтыг нэгтгэсэн механизмыг бий болгодог.

Мөн төрийн оролцоогүйгээр Facebook, Microsoft, Twitter, YouTube зэрэг томоохон платформууд өөрсдөө нэгдэн “Терроризмтай тэмцэх дэлхийн интернэт форум (Global Internet Forum to Counter Terrorism)”-ыг зохион байгуулсан. Үүгээр дамжуулан платформууд терроризмын контентыг илрүүлэх, хаах, мэдээллээ хуваалцах системийг ажиллуулдаг ба жишээлбэл, нэг платформ дээр илэрсэн контентыг бусад платформд давхар устгах (Hash-Sharing Database), контентыг хэрхэн илрүүлэх, шүүлтүүрлэх арга барил, автомат болон хүний хянах процессын стандарт (Content Moderation Best Practices) зэргийг нэвтрүүлдэг.

Засгийн газар болон платформуудын хоорондын албан бус хэлбэрийн зөвшилцлөөр олон улс контент модерацийг хэрэгжүүлж байна. Жишээлбэл, улс төрийн сонгуулийн үеэр болон цар тахлын үед эрүүл мэндийн тухай худал мэдээллийг зохицуулах зэргээр энэ үйл ажиллагаа идэвхждэг. Аливаа хуулийн дагуу платформд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлгүй ч, платформууд өөрийн санаачлагаар төртэй хамтран зохицуулдаг онцлогтой байна.

Олон улсын чиг хандлагыг нэгтгэн дүгнэвэл, цахим платформууд нь бидний мэдээлэл дамжуулах, хүлээн авах үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай нийгмийн дэд бүтэц болж байгаагаас үүдэн, мэдээ мэдээллийг аюулгүй, үнэн зөвөөр түгээх тал дээр анхаарал хандуулж, контент модерацийг хэрэгжүүлж, зохицуулалтын үндэслэлийг илүү нарийвчлан тодорхойлж байгааг харж болох юм.

Монгол Улсад дахь цахим платформын мэдээллийн зохицуулалт

Манай улсын хувьд цахим орчин дахь контентын зохицуулалт нь голчлон сонгуулийн үеийн мэдээллийн орчны ил тод байдлыг хангах, мөн цар тахлын үед худал мэдээллээс урьдчилан сэргийлэх зорилгоор батлагдсан хэд хэдэн хууль, журам, захиргааны актуудын хүрээнд хэрэгжиж ирсэн. Тухайлбал, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”, мөн 2020 оны 4 дүгээр сард батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.13-д үндэслэн Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны даргын хамтарсан тушаалаар баталсан “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх журам” зэргээр эрх бүхий байгууллагын дүгнэлтэд тулгуурлан цахим орчны агуулгыг хязгаарлах, устгах шийдвэрүүдийг гаргаж ирсэн.

Нөгөөтэйгүүр, ХХЗХ болон Фэйсбүүк (Meta) компанийн хооронд 2019 оны 6 дугаар сараас эхлэн “ногоон суваг” нэртэй шууд харилцах механизм нээгдэж, хууль

бус контентыг богино хугацаанд шийдвэрлэх хамтын ажиллагаа эхэлсэн. Улмаар 2021 оноос “Government-Case-Work-Channel”-ийг нэвтрүүлснээр энэхүү хамтын ажиллагаа илүү институцилсэн хэлбэрт шилжсэн. Уг сувгаар хууль бус контентыг үнэлэхдээ Meta компанийн Community Standards-ийг баримталдаг бөгөөд эдгээр стандартын агуулга нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон контентийн төрлүүдтэй ихэвчлэн давхцдаг гэж ХХЗХ тайлагнасан байдаг (ХХЗХ, 2021). Гэсэн хэдий ч практикт ялгаа гарч, ХХЗХ-оос Meta-д шилжүүлсэн гомдлын зөвхөн зарим хэсэгт нь бодит арга хэмжээ авдаг нь анхаарал татаж байна. Тухайлбал, 2020 оны Улсын Их Хурал болон орон нутгийн сонгууль, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нийт 914 гомдол ХХЗХ-д ирсэн бөгөөд эдгээрийг Meta-д шилжүүлснээс 68 хувьд нь хариу өгч, 50 хувьд нь арга хэмжээ авсан бол 17 хувийг зөрчилгүй гэж үзсэн байна (ХХЗХ, 2021). Энэ нь цахим орчны зохицуулалтын бодит үр нөлөө нь зөвхөн үндэсний төрийн байгууллагуудын дүгнэлтээс бус, харин олон улсын цахим платформын дотоод бодлого, шийдвэр гаргах чадавхаас өндөр хэмжээгээр хамаарч байгааг харуулж байна.

Мөн 2021 оны 5 дугаар сараас ХХЗХ нь YouTube платформтой “Trusted Partner” горимоор хамтран ажиллаж эхэлснээр хууль зөрчсөн контентыг шууд мэдэгдэх боломж бүрдсэн (ХХЗХ, 2025). Үүнээс гадна, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн агуулга байршуулсан вебсайтуудыг холбогдох байгууллагын шийдвэрийн үндэслэлээр “хар жагсаалт”-д оруулж, улсын дотоод сүлжээгээр дамжуулан хандалтыг хаах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2021 оны байдлаар ийм байдлаар нийт 1,120 орчим вебсайт хаагдсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь зохиогчийн эрхийн зөрчил болон порнографийн агуулгатай холбоотой байсан байна.

Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалтад контентыг үнэлэхдээ хараат бус, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулах албан ёсны шат дамжлага байхгүй нь худал мэдээлэл, үзэн ядалтыг өдөөгч агуулгыг хязгаарлах нэрийн дор иргэдийн мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэт өргөн хүрээнд хязгаарлах эрсдэлийг бий болгож байна гэж зарим судлаачид шүүмжилдэг (Хууль зүй дотоод хэргийн яам, 2020).

Энэхүү маргаан, сорилтын хүрээнд 2023 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан нь дижитал орчин дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой томоохон оролдлого байв. Уг хуулийн төсөл нь цахим орчин дахь гүтгэлэг, доромжлол, хувийн мэдээлэл задруулах, худал мэдээлэл түгээх асуудлыг зохицуулж, хохирогчийн эрхийг хамгаалахад анхаарсан агуулгатай байсан. Гэвч уг хууль нь үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг “хэт өргөн хүрээнд хязгаарлах эрсдэлтэй” гэсэн үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хориг тавин, улмаар хуулийг хүчингүй болсонд тооцсон. Энэ нь Монгол Улсад цахим орчны зохицуулалтыг боловсронгуй болгох оролдлого нь хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хэрхэн тэнцвэржих ёстой вэ гэсэн суурь маргаанд тулгарч байгааг харуулж байна.

Иймд Монгол Улсад цахим орчны зохицуулалтын эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн хэдий ч хэрэгжилтийн тогтвортой байдал, ил тод байдал, мөн олон улсын платформын дотоод бодлогоос хамаарах байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан шударга, тэнцвэртэй зохицуулалт бүрэн хангагдаагүй хэвээр байна. Цаашид иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ худал мэдээлэл, хор хөнөөлтэй агуулгаас хамгаалах зорилгыг

тэнцвэржүүлэхийн тулд хараат бус үнэлгээний механизм, ил тод байдлын стандарт, мөн платформуудтай хийх хамтын ажиллагааны бодит үр нөлөөг дээшлүүлэх шаардлага тулгарч байна.

Дүгнэлт

Хиймэл оюунд суурилсан дижитал технологийн хурдацтай хөгжил нь худал мэдээллийн үүсэл, тархалт, нөлөөллийн хүрээг тэлж, уг асуудал зөвхөн агуулгын үнэн зөвийг хянах хүрэнээс хальж, дижитал экосистемийн бүх түвшинд нөлөөлөх системийн шинжтэй сорилт болон хувирч байна. Энэхүү судалгаагаар худал мэдээллийг хувь хүний санаатай үйлдэл, эсхүл хэрэглэгчийн танин мэдэхүйн сул талтай холбон тайлбарлах уламжлалт хандлага хангалтгүй болж, алгоритмд суурилсан цахим платформуудын мэдээлэл эрэмбэлэх, түгээх логик нь худал мэдээллийн тархалтад шийдвэрлэх нөлөө үзүүлж буйг онолын болон бодит жишээнд тулгуурлан харууллаа.

Хиймэл оюунаар үүсгэсэн синтетик мэдээлэл, deepfake технологид суурилсан контент нь хүний аюулгүй байдал, нэр төр, сэтгэлзүйн дархлаа төдийгүй ардчилсан улс төрийн үндсэн суурь болох олон нийтийн рациональ хэлэлцүүлгийг системийн түвшинд сулруулж байна. Ялангуяа алгоритмд суурилсан “echo chamber” орчин нь иргэдийг олон талт мэдээллээс тусгаарлаж, үнэн ба худлын заагийг бүдгэрүүлэн, үзэл бодлын туйлшралыг эрчимжүүлэх замаар “үнэний дараах улс төр”-ийн нөхцөлийг бүрдүүлж буйг энэхүү өгүүлэл онцлон дүгнэв. Үүний зэрэгцээ судалгаагаар цахим платформууд нь мэдээллийг саармаг дамжуулагч бус, харин нийгмийн мэдээллийн орчныг идэвхтэй бүрдүүлэгч, зохион байгуулагч субъект болж хувирсныг харуулж байна. Иймд худал мэдээллийн зохицуулалтыг зөвхөн агуулгыг устгах, хориглох хүрээнд ойлгох нь зохисгүй бөгөөд платформын алгоритмын ил тод байдал, эрсдэлийн үнэлгээ, хариуцлагын механизм, хараат бус хяналтын тогтолцоог хамарсан цогц зохицуулалт шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Олон улсын зохицуулалтын туршлагууд нь цахим платформуудыг мэдээллийн “саармаг дамжуулагч” бус, харин нийгмийн мэдээллийн орчныг идэвхтэй бүрдүүлэгч, улмаар тодорхой нөхцөлд хариуцлага хүлээх ёстой оролцогч хэмээн үзэх хандлага давамгайлж байгааг харуулж байна. Германы NetzDG, Европын Холбооны Дижитал үйлчилгээний тухай хууль, Сингапурын худал мэдээллийн тухай хууль зэрэг нь ил тод байдал, эрсдэлийн үнэлгээ, платформын хариуцлагыг нэмэгдүүлэхийг зорьсон боловч, нөгөө талаас үг хэлэх эрх чөлөөг хэт хязгаарлах эрсдэл дагуулж болзошгүйг судалгаа мөн харууллаа. Иймд цахим платформын зохицуулалт нь төрийн хатуу хяналт, хориглох арга хэмжээнээс илүүтэйгээр платформын өөрийн зохицуулалтыг хослуулсан, ил тод байдалд суурилсан хяналтын загвар руу шилжиж байгаа нь ажиглагдаж байна. Харин Монгол Улсын хувьд цахим орчны зохицуулалт тодорхой хэмжээнд бүрэлдсэн хэдий ч хэрэгжилтийн ил тод байдал, хараат бус үнэлгээний механизм, олон улсын платформуос хэт хамааралтай байдал зэрэг бүтэцчилсэн сул тал хэвээр байгааг дахин дурдах нь зүйтэй. Цаашид худал мэдээлэлтэй тэмцэх бодлого, эрх зүйн зохицуулалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхийг хязгаарлахад бус, харин мэдээллийн эрхийн баталгааг бэхжүүлэх, иргэдийн итгэлцлийг хамгаалах, ардчилсан нийтийн хэлэлцүүлгийн чанарыг сайжруулахад чиглэсэн ухаалаг, тэнцвэртэй зарчимд тулгуурлах шаардлагатай. Энэ хүрээнд цахим платформын алгоритмын ил тод байдлыг нэмэгдүүлэх, контент модерацийн шийдвэрт хараат бус хяналт бий болгох, мөн сэтгүүл зүйн мэргэжлийн мэдээлэх үүргийг дэмжих институцийн орчныг бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- А.Оюунгэрэл. (2009). *Олон түмний харилцааны онол*. Улаанбаатар: Нөблмөн.
- Б.Наранбаатар, Б.Намуун. (2024). Хиймэл оюунаар бүтээсэн синтетик мэдээлэл олон нийтийн итгэлд нөлөөлөх нь. *Сэтгүүл зүй*, 25, 132–144.
- Ж.Батбаатар. (2010). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар: Бемби сан.
- М.Зулькафиль. (2017). *Орчин үеийн Монголын сэтгүүл зүй*. Улаанбаатар: Урлах эрдэм.
- Харилцаа холбооны зохицуулах хороо. (2021, 3 26). ХХЗХ, Фэйсбүүк компани “Ногоон суваг”-ын хүрээнд CRS системээр хамтран ажиллана. Харилцаа холбооны Зохицуулах Хороо. <https://www.crc.gov.mn/k/37y>
- Харилцаа холбооны зохицуулах хороо. (2021). *Цахим орчны зохицуулалтын зөвлөмж*. Харилцаа холбооны зохицуулах хороо.
- Харилцаа холбооны зохицуулах хороо. (2025, 10 26). *Онлайн контентын зохицуулалт*. Харилцаа холбооны зохицуулах хороо. <https://www.crc.gov.mn/saxim-orny-zoxicuulalt/onlain-kontenty-n-zoxicuulalt>
- Хууль зүй дотоод хэргийн яам. (2020). *Хууль зүй, дотоод хэргийн яам, Иргэдийн оролцоо төсөл, 2020, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ*. Улаанбаатар.
- Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль (шинэчилсэн найруулга)*. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Asahi Shimbun. (2020, 11 19). *The Asahi Shimbun*. <https://www.asahi.com/ajw/articles/13944568>
- Bennett, W., & Steven, L. (2018). The disinformation order: Disruptive communication and the decline of democratic institutions. *European Journal of Communication*, 33(2), 122–139.
- Gillespie, T. (2018). *Custodians of the Internet: Platforms, content moderation, and the hidden decisions that shape social media*. New Haven: Yale University Press.
- Habermas, J. (1989). *The structural transformation of the public sphere: An inquiry into a category of bourgeois society*. Cambridge: MIT Press.
- MacKenzie Jr, W. I., Weber, R., Barr, H. M., Lanius, C., & Tenhundfeld, N. L. (2025). Deepfake label recall: Combating disinformation with labels is especially effective for those who dislike the speaker. *International Journal of Human–Computer Interaction*, 1–15.
- Milmo, D. (2024, 2 22). Google pauses AI-generated images of people after ethnicity criticism. *The Guardian*. <https://www.theguardian.com/technology/2024/feb/22/google-pauses-ai-generated-images-of-people-after-ethnicity-criticism>
- Mounk, Y. (2018). *The people vs. democracy: Why our freedom is in danger and how to save it*. Cambridge: Harvard University Press.
- Napoli, P. M. (2019). *Social media and the public interest: Media regulation in the disinformation age*. New York: Columbia University Press.
- Pennycook, G., & Rand, D. G. (2020). Who falls for fake news? The roles of bullshit receptivity, overclaiming, familiarity, and analytic thinking. *Journal of Personality*, 88(2), 185–200.
- Sunstein, C. R. (2017). *Republic: Divided democracy in the age of social media*. New Jersey: Princeton University Press.
- Toshiko, K. (2018). Artificial intelligence and journalism ethics: Focusing on “fake news.” *32nd Annual Conference of the Japanese Society for Artificial Intelligence*. Tokyo.

UNDP. (1994). *Human development report 1994: New dimensions of human security*.

Oxford: Oxford University Press.

UNESCO. (2021). *Recommendation on the ethics of artificial intelligence*. UNESCO.

[1] Худал мэдээлэл гэх ойлголтыг агуулга болон үйлдлийн мөн чанараар нь дотор нь (i) хуурамч мэдээлэл (disinformation), (ii) алдаатай мэдээлэл (misinformation), (iii) буруу сэдэлтэй мэдээлэл (mal-information) гэж гурав ангилж нь түгээмэл.

[2] “саармаг дамжуулагч” (англиар neutral intermediary эсвэл mere conduit) гэдэг нь мэдээллийн агуулгад оролцолгүй, үнэлэлт дүгнэлт хийлгүй, өөрчлөлт оруулахгүйгээр зөвхөн дамжуулж өгдөг этгээд гэсэн ойлголт юм. Энгийнээр хэлбэл, юуг дамжуулж байгаагаас үл хамааран, “дамжуулж өгсөн” үйлдэлдээ л хариуцлага хүлээдэггүй субъект гэсэн утгатай. Цахим платформууд удаан хугацаанд “Бид бол саармаг дамжуулагч, хэрэглэгчийн нийтэлсэн контентын агуулгад хариуцахгүй” гэж тайлбарлаж ирсэн. Гэвч, контентыг алгоритмаар эрэмбэлдэг, заримыг нь устгадаг, хаадаг учир “саармаг” гэж үзэхэд хүндрэлтэй болсныг энд дурдах нь зүйтэй.

[3] 2022 оны 10 сарт батлагдаж, 2022 оны 11 сар 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

[4] Section 230 нь интернэтийн эхэн үед (1996) онлайн платформуудыг хэрэглэгчийн байршуулсан контентын хууль ёсны мөн биш эсэхэд хамааралтай хуулийн хариуцлагаас өргөн хүрээтэй чөлөөлөх зорилготой байсан. (No provider or user of an interactive computer service shall be treated as the publisher or speaker of any information provided by another information content provider.) Гол санаа нь: Интернэтийн хөгжилд саад болох хэт хатуу хариуцлагыг зөөллөх, “Good Samaritan” зарчмаар сайн дурын модераци хийхийг дэмжих урамшуулах.

[5] Act on the Limitation of Liability for Damages of Specified Telecommunications Service Providers and the Right to Demand Disclosure of Identification Information of the Sender. Тус хуулийн томоохон өөрчлөлтүүд 2021 оны дөрөвдүгээр сард батлагдаж, 2022 оны 10 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Summary

The rapid development of Artificial Intelligence (AI) and algorithm-driven digital technologies has fundamentally reshaped the nature of false information, transforming it from a problem of misleading content into a systemic challenge embedded within digital information ecosystems. This study examines how AI-supported content generation, algorithmic curation, and platform-based content moderation shape the production, circulation, and societal impact of misinformation in contemporary digital environments. The analysis demonstrates that AI-generated and synthetic content, particularly deepfakes, poses serious risks to individual dignity, psychological security, and public trust. Beyond individual-level harm, the large-scale dissemination of false information undermines democratic processes by distorting public deliberation, weakening rational discourse, and encouraging emotionally driven, fact-independent political decision-making. In this sense, false information constitutes not only a media ethics concern, but also a human security and democratic governance challenge. Through a comparative review of international regulatory frameworks, including Germany’s NetzDG, the EU Digital Services Act, and Singapore’s POFMA, the study identifies a global shift toward recognizing digital platforms as active intermediaries, emphasizing transparency, risk assessment, and platform accountability.

The paper analyzes Mongolia's regulatory responses, noting limitations, particularly the absence of independent risk assessment, and concludes that effective governance requires a risk-based approach balancing harm prevention with fundamental rights.

Keywords: Digital Environment, False Information, Content Moderation, Regulation, Artificial Intelligence

МҮОНР-ИЙН МЭДЭЭ, СУРВАЛЖИЛГЫН СЭДЭВ, ЭХ СУРВАЛЖИД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Б.Цэвэлмаа*, Т.Өнөрсайхан**

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн докторант*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, доктор(Ph.D)*

Түлхүүр үгс: Радио сэтгүүл зүй, олон нийтийн радио, сонсогч, мэдээ, сурвалжилга, радиогийн хөтөлбөр

Оршил. Медиа салбарт радиогийн өвөрмөц орон зайг үүсгэн үйл ажиллагаа явуулж буй нийт 48 радио байна. (МХХ, 2024) 1990-ээд оны сүүлчээс аажмаар нэмэгдэж эхэлсэн радиогийн тоо 2012 он гэхэд 84-т хүрч байсан бол яваандаа буурч 2024 он гэхэд 48 болсон байна. Харин 2025 онд Харилцаа Холбооны Зохицуулах хорооны зөвшөөрөлтэй арилжааны радио 65, олон нийтийн радио дөрөв байна гэж бүртгэгджээ. Мэдээллийн технологи, дижитал орчин, мэдээллийн шинэ хэрэгслүүдийн өрсөлдөөн нь радио хүлээн авагчид, дамжуулах хэрэгсэл төдийгүй радиогийн бүтээл үйлдвэрлэл, агуулга, хэлбэрт ийнхүү нөлөөлсөн байна. Ялангуяа энэ өөрчлөлт манай ууган радиогийн бүтээлүүдэд хэрхэн нөлөөлж буйг зарим талаар тодорхойлж гаргахын тулд тус судалгааны өгүүлээрээ МҮОНР-ийн мэдээ, сурвалжилгад ажиглалт, судалгаа хийлээ. Ингэхдээ өдөр тутмын мэдээллийн хөтөлбөр дэх мэдээ, сурвалжилгын сэдэв, эх сурвалжийн тэнцвэрт байдал, төрөл зүйл, радиогийн бүтээлд зайлшгүй тавигддаг гол шалгуур болох бүтэц, хугацаа зэргийг онцлон задалж үзэн судалгааныхаа гол чиглэл болголоо.

Үндсэн хэсэг

“Радио-сонсох”, “телевиз-харах”, “сонин- унших” гэдэг тодотголоор бол радио сонсогчийн “төсөөлөл” нь үйл явдал үзэгдэл юмсыг дүрслэн оносон үг яриа, орчны дуу чимээг ашиглах үйл явцад тулгуурлана. Сонсголоор дамжин хүнд хүрдэг мэдээллийн хэрэгсэлд тавигддаг зүй ёсны шаардлага нь авиа зүй, хэлний зүй, найруулга зүйн хэм хэмжээг хатуу сахих явдал юм. Радио сэтгүүл зүйн бүтээлүүд нь төрөл зүйл, хийцийн хувьд олон талтай байж болно. Гэхдээ сүүлийн жилүүдэд радио сэтгүүл зүйн бүтээлийн төрөл зүйлд шинэчлэл, өөрчлөлт гарч, олон нийтийн хэрэгцээнд нийцсэн шинэ төрлүүд буюу холимог (хайбрид) хувилбарууд үүсэж

Observation on The Content and Format of The MNB News.

Tsevelmaa.B (Ph.D candidate) , Unursaikhan.T (Ph.D)

байна. “Радио анх бий болохоос өмнө бичлэгийн төрөл зүйл төлөвшсөн юм. Бичлэгийн төрөл зүйлийг радио өөрийн болгон ашиглахдаа сонсох онцлогт тохируулжээ” (Чойсамба, 2011).. Сонсохуйд хэлэхүйгээр мэдээлэл дамжуулах үйл ажиллагаа- радио сэтгүүл зүйд хэл харилцааны хэрэглүүрийн хувьд уг байдалдаа тохирсон байгуулалтай байдаг.

Жишээ нь, ямар нэг авианы чанарыг тодорхойлохдоо зөвхөн хэлэхүйн үүднээс биш, ямар утга илэрхийлснийг нь хамт авч үзэх нь зүйтэй. Мөн ямар нэг өгүүлбэрийг зөвхөн утга төгссөн санаа илтгэхийн нь үүднээс биш харин ямар санаа төрүүлэх гэснийг нь ухаарах хэрэгтэй болдог. Жишээлбэл: сэтгэл хөдлөлтэй дуу чимээ (санаа алдах, гаслах, мэгших, ... гм). Өнөө үед зөвхөн дуу чимээ, хөгжим, авиалбараар ч радио сэтгүүл зүйд мэдээлэл хүргэж болж байна. “Радио нэвтрүүлгийг төрлөөр ангилах нь нэг талаас тусгай нэвтрүүлгүүдийн харьцангуй бүтэц байгууламжтай болохыг хүлээн зөвшөөрөх, нөгөө талаас төрлүүдийн онцлог, шинжлэх ухааны түвшинг тодорхойлох шалгуур болох ач холбогдолтой” юм. (Норовсүрэн & Ариунзаяа, 2010)

Оросын радио сэтгүүл зүй судлаачид радиогийн нэвтрүүлгийн төрлийн ангиллыг ерөнхий гурван бүлэгт хуваасан байдаг. “Радио нэвтрүүлгийн төрлийн ангилал радио сэтгүүл зүйн төрлөөс шууд хамааралтай ба радио сэтгүүл зүйг гурав ангилна. Үүнд:

1. Баримтыг мэдээлэх мэдээллийн төрөл
2. Баримт болон үйл явдлыг тайлбарлах шинжлэлт төрөл
3. Баримтыг дүрсжүүлэн илэрхийлэх уран сайхны төрөл гэж ангилна. (Барабаш & et al., 2005)

Ер нь радиогийн төрөл зүйлийг бий болгоход тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг бол төрөл зүйл гэж юу болохыг тодорхойлох явдал юм. Тодорхой төрлүүдтэй, тогтсон хэв маяг, шинж чанаруудтай кино эсвэл уран зохиолоос ялгаатай нь радио төрөл нь илүү уян хатан бөгөөд нарийвчлан ягштал тогтооход хэцүү байдаг. Нөгөө талаар радиогийн төрөл зүйл бий болгоход анхаарах бас нэг чухал зүйл бол сонсогчдын хүлээлт юм. Сонсогчид тухайн төрлийн хөтөлбөрийг өмнөх туршлага дээрээ үндэслэн сонгохдоо юу сонсох талаараа тодорхой хүлээлттэй байдаг. Энэ нь сонсогчид өөрчлөлтөд бэлэн биш байж болох магадлалыг харуулж байгаа тул шинэ формат эсвэл хэв маягийг туршиж үзэхэд эхний үед түвэгтэй байдаг. Гэхдээ агуулгыг сонирхолтой сонгож чадсан тохиолдолд хэлбэр, хийцийг зарим талаар өөрчилж, хувиргаж болдог байна.

Радио сэтгүүл зүйд дээрх ангиллыг ашиглахаас гадна сонсогчдод түгээх байдлаар нь “халуун”, “хүйтэн” (Маклюен, 2003) гэсэн ойлголтыг ашигладаг. “Халуун” гэсэн нэр томъёо нь нэвтрүүлгийн шуурхай, өөрт хамаатай байдал болон сонсогчийн төсөөлөн бодох вертуаль дүрслэл дээр тулгуурлаж тодорхойлогддог. Шууд мэдээлэх, дүн шинжилгээ хийх шаардлагатай шуурхай мэдээ, үйл явдлыг тайлбарлахад ихэвчлэн ашигладаг. Радио сэтгүүл зүйд “халуун” нь ямар мэдээг хэрхэн сурвалжилж, хэрхэн мэдээлэхийг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Сэтгүүлчид мэдээний ач холбогдлыг хурдан үнэлж, сонсогч үзэгчдэдээ үнэн зөв, цаг алдалгүй мэдээлэх чадвартай байх ёстой.

Үүнд ихэвчлэн ярилцлага хийх, олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, үйл явдал болсон газраас сурвалжлах зэрэг орно. Хэвлэл мэдээллийн салбар дижитал хувилбарт шилжиж суурь платформууд ижилсэж байгаа энэ цаг үед радиогийн

бүтээлүүд ч агуулга, хэлбэрийн хувьд хувьсан өөрчлөгдөж байна. Тиймээс радиогийн төрөл зүйл, агуулгын өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд МҮОНР-ийн “Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөрийг задлан үзэж, эрэмбэлэв. “Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөр дэх мэдээ, сурвалжилгын агуулга, сэдэв, эх сурвалжийн онцлогийг харуулахын тулд 2022 оноос хойших гурван жилийн тус бүрийн ижил нэг сарыг түүврийн аргаар сонгож, ингэхдээ сар бүрээс долоо хоног бүрийн нэг хөтөлбөрийг сонгон авлаа. Ингээд нийт 200 нэгж мэдээ, сурвалжилга сонгон авч судалгааны контент анализийн аргыг ашиглан задалж үзлээ. Мэдээллийн тэнцвэрт байдлыг хангахад эх сурвалжийн тоо, тэдгээрийн сонголтыг тодорхойлох, сэтгүүлчийн ур чадварыг тодорхойлоход бүтээлийн бүтцэд шууд нөлөөлдөг нийт хугацаа, сэдэв, түүний ангилал зэргийг гаргахад тоон болон чанарын судалгаагаар илэрхийлсэн болно.

Агуулгаар нь газар зүйн хувьд: гадаадын, дотоодын, тусгаж буй объектоор нь: улс төрийн, гэмт хэргийн, спортын гэх мэт. Хэлбэрээр нь: бичигдсэн байдлаар ерөнхийгөөс нэгж рүү, нэгжээс ерөнхий рүү, уруугаа харсан пирамид, цаг хугацааны дараалал гэж ангиллаа.

Сэдвийн ангиллыг тодорхойлохдоо 200 нэгж мэдээ, сурвалжилгыг ангилан үзэж, дараах ерөнхий хэсгүүдэд хуваалаа.




График 1. Сэдвийн ангилал

Орон даяар цацагддаг, өргөн нэвтрүүлгийн радио сувгийн хувьд улс оронд болж буй улстөр, эдийн засгийн мэдээллийг түлхүү дамжуулдаг байна. Бусад буюу нийгмийн асуудлыг мөн ихээр хөндөж байгаа нь олон нийтийн статустай нь холбоотой бөгөөд нийт үзүүлэлтийн 22 хувийг эзэлж байгаагаас харж болно.

Газар зүйн хамааралт байдлыг дотоодын болон гадаадын гэж ангилж үзлээ. Мэдээллийн хөтөлбөрийн давтамж олон боловч үргэлжлэх хугацаа бага байдаг нь нэг хөтөлбөрт дэлхий дахинд болсон үйл амьдралын мэдээ 1-2 нэгж ороход нөлөөлж байна. Нөгөө талаар мэдээллийн хүртээмжит байдлыг харгалзан үзэж дотоод үйл амьдралын мэдээллийг түлхүү бэлтгэдэг байна. Судалгаанд хамрагдсан нийт мэдээ, сурвалжилгын 91 хувь нь дотоодын үйл амьдралын сэдэвтэй байна. Дээрх дотоодын мэдээллийг газар зүйн байдлаар нь дахин задалж үзвэл Улаанбаатар хотыг тойрсон сэдэвтэй мэдээлэл 87 хувь байна. Өөрөөр хэлбэл, улс оронд болж буй улс төр, эдийн засгийн ихэнх үйл явдал Улаанбаатарт өрнөдөгтэй холбоотой юм. Нөгөө талаар, МҮОНР-ийн хувьд эх орны өнцөг булан бүрт цацагддаг. Гэтэл

мэдээллийн хөтөлбөрийнх нь нийт мэдээ, сурвалжилгын ердөө 13 хувь нь л хөдөө орон нутгийн үйл явдлыг багтаан үзүүлж байна. Энэ хангалтгүй тоо юм. Уг нь МҮОНР-ийн мэдээллийн хөтөлбөрүүд нь орон нутгийн иргэдэд илүү шуурхай, цаг үеийн мэдээлэл өгөх боломжтой. Тэгээд ч энэ нь олон нийтийн радиод тавигдах хүртээмжит байдлыг хангаж байгаа үзүүлэлт юм.

“Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөрүүдийн нийт мэдээ, сурвалжилгын есөн хувийг эзэлж буй дэлхий дахины үйл явдлыг газар зүйн хамааралт байдлыг нь тодруулахын тулд сэтгүүл зүйн олон улсын мэдээллийг ангилж задалдаг судалгааны аргаас “Мэдээлэл сонголтод газар нутгийн хамааралт байдал” (Зулькафиль & etc, 2021) гэсэн ерөнхий үзүүлэлтийг сонгож авлаа. Олон улсын сэтгүүл зүйд мэдээлэл сонголтод газар нутгийн хамааралт байдал гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд дөрөв хувааж газар зүйн байрлалаар нь ангилдаг: “Би монгол хүн”, “Миний хөршүүд”, “Миний холын андууд”, “Би дэлхийн иргэн” гэсэн ангилал юм. Тус ангиллаар авч үзэхэд судалгааны түүвэрт хамрагдсан нэгжүүдийн 0,18 хувь л “Би монгол хүн” гэсэн ангилалд багтаж байна. Орос, Украины дайн, шатахууны асуудал, БНХАУ-ын гадаад бодлого зэрэг нийт олон улсын мэдээллийн 55,5 хувь нь “Миний хөршүүд” хэсэгт багтжээ. “Миний холын андууд” хэсэгт 27,7 хувь, үлдсэн 11,1 хувь нь “Би дэлхийн иргэн” ангилалд багтаж байна.

Эндээс харахад “Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөрүүдэд багтаж буй гадаад мэдээний сонголтыг газар зүйн хувьд ОХУ, АНУ болон Их долоон гүрэн тэргүүлж байна. Энэ үед ОХУ, БНХАУ-ын асуудал олон улсын хэвлэл мэдээллийн гол сэдэв болж байсан нь энэ сонголтод нөлөөлж байсан гэж үзэх талтай юм. Нөгөө талаар дэлхий дахинд болж буй мэдээллийг бэлтгэж буй орчуулагчийн гадаад хэлний мэдлэг ч ямар улсын талаар мэдээ, мэдээлэл сонгож орчуулан хүргэх вэ гэдэгт нөлөөлдөг.

Төрөл зүйлийн тухайд МҮОНР-ийн мэдээллийн хөтөлбөрүүд дэх нэгж материалууд бичлэгийн хоёр төрөлд хамаарна. Мэдээлсэн болон шинжлэлт бичлэгийн төрлөөс мэдээллийн хөтөлбөрүүд нь бүрдэнэ. Ингэхэд нийт түүврийн 21 хувь нь мэдээ, үлдсэн 79 хувь нь сурвалжилгад хамаарч байв. Энд ойлголтын зөрүү гарч буйг хэлэх хэрэгтэй. “Хурд” агентлагт радио мэдээг хийц хэлбэрээр нь тайлант буюу хальстай мэдээ, текстэн буюу цагаан мэдээ гэж ангилдаг. Хальстай мэдээг дараах байдлаар тус агентлагийнхан тодорхойлсон байна. Тухайн сэдэв, асуудлаар эх сурвалжийн байр суурь, үзэл бодлыг бичлэгээр өөрийнх дуу хоолойгоор дамжуулж, бодит тэнцвэртэй мэдээлэл өгөх зорилготой сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл гэж тооцдог байна. Гэхдээ эх сурвалжийн яриаг мэдээлэл өгөх зорилгоор бус тухайн мэдээний баримтыг нотлох, гэрчлэх, амьдшуулах, сонсогчийг татах, итгүүлэн үнэмшүүлэх зорилгоор оруулдаг. Радиогийн хальстай мэдээнд эх сурвалжийн яриа 30 секундээс илүүгүй байх нь зохимжтой гэж үздэг. Харин “цагаан” буюу текстэн мэдээнд эх сурвалжийн мэдээлэл дуу хоолойгоор ордоггүй. Дан текстээр бэлтгэсэн мэдээг өнөөдөр Монголын радиод “цагаан мэдээ” гэж нэрлэж байна. Гэхдээ онолын үндсэн ойлголтоор бол “цагаан мэдээ” нь мэдээ, хальстай мэдээ нь сурвалжилга юм.

Мэдээний тухайд дэлхий дахины үйл явдлыг харуулсан нэгж материалууд бүгд мэдээнд хамаарна. Гэхдээ дотоод үйл амьдралын хэсэгт ч мэдээ орж байв. Цаг бүрт явж буй мэдээллийн хөтөлбөрүүдэд 2-4 сурвалжилга, 0-2 мэдээ дунджаар орж байна. Энэ нь нийт эфирт цацагдах хугацаатай холбоотой юм. Радиогийн хувьд нэгж материалын хугацаа онцгой үүрэг гүйцэтгэдэг. Юуны түрүүнд энэ нь цагаар хэмжигддэг эфиртэй холбоотой, нөгөө талаар радиогийн мэдээ бичих онцлог, мөн

хүлээн авагчийн сонсох эрхтэн дээр тулгуурласан чадамжтай холбоотой билээ. Радиогийн мэдээ шуурхай, товч, энгийн, ойлгомжтой, сонсогчдын бүх давхаргад хандсан, ярианы хэлтэй ойр буюу энгийн хэлээр бичсэн, үйл явдлын баримтат шинжийг хадгалсан байх явдал юм. Энэ онцлогийн талаар доктор Д.Батжаргал, Г.Мэндхүү нар тодорхойлохдоо “Радио мэдээнд хугацаа хамгийн чухал. Одоо цаг дээр ярих хэрэгтэй. Энэ нь цаг үеэ шуурхай тусгаж байгаа нэг хэрэг. Радио мэдээний өөр нэг онцлог нь дуу чимээ бага ордог. Радио мэдээ нь богино өгүүлбэрээр, чихэнд наалдацтай, ярианы хэлэнд дөхүү, тогтооход хөнгөхөн байна.” (Батжаргал & Мэндхүү, 2015) гэжээ.

“Хүн нэг өгүүлбэрээс 13-15 үг л ойлгож, хүлээн авах чадвартай. Эртний Грект Самос арлын шууданч ирж нэгэн урт илгээмж уншсаны дараа спатанчууд эхлэлийг нь мартчихлаа. Төгсгөлийг нь ойлгосонгүй. Хэрхэн эхэлснийг санахгүй байна” (Велле, 2006) гэж байжээ. Радиогийн сурвалжилгын үргэлжлэх хугацаа 1.30-2.0 минут байхад нэг сэдвийг бүрэн гаргах боломжтой. Тэр дундаа сурвалжилгын үндсэн элемент болсон ярилцлага 15-20 секунд байхад хангалттай гэж үздэг.




График 2. Мэдээ, сурвалжилгын үргэлжлэх хугацаа

Радиогийн мэдээллийн хэрэгслийн нэг буюу радиогийн мэдээ, сурвалжилгын үргэлжлэх хугацаанд тавигддаг 1-2 минутын шаардлагыг нийт нэгж материалын 52,4 хувь хангаж байна. Зарим улстөрийн сэдэвт мэдээлэл, ялангуяа УИХ-ын чуулганы мэдээлэл 2-3 минут орох тохиолдол ажиглагдлаа. Харин нэг хүртэл минутанд мэдээ, зарим богино сурвалжилга багтаж байна. Тодруулбал, нийт материалын 15,4 хувь нэг минут хүртлэх мэдээ, 28,8 хувь нь 2-3 минут, 3,2 хувь нь гурваас дээш минут байна. Өөрөөр хэлбэл, радиогийн мэдээллийн хугацаа харьцангуй богино, хөтөлбөрийн хувьд багтаамж сайн байна.

Аливаа бүтээлийн үр өгөөж, үр ашиг, нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь ямар эх сурвалжаас мэдээлэл олж авсан, ямар баримтад үндэслэн бичснээс шууд шалтгаалдаг. Эх сурвалжийг сэтгүүл зүйн практик өргөн болон явцуу утгаар нь авч үздэг. Өргөн утгаар нь эх сурвалж гэдэг бол бидний эргэн тойронд, дэлхий дахинд өдөр тутам болж байгаа үйл явдал, үзэгдэл, баримт юм. Явцуу утгаар нь тухайн сэтгүүлчийн ямар нэгэн мэдээ материал бичих, радио телевизийн нэвтрүүлэг бэлтгэхийн тулд баримт мэдээлэл олж авсан тэр үүсвэр юм. Эх сурвалжийн бүх түвшинг хангаж чадснаар сэтгүүлчийн материал эн тэнцвэрт байдлыг хангаж байна гэж үздэг. “Хурд” агентлагийн мэдээллийн хөтөлбөрүүд дэх сурвалжилгуудад эх сурвалжийн түвшинг хэр хангасныг эх сурвалжаа нэрлэсэн эсэх, эх сурвалжийн тоо, эх сурвалжийн түвшин буюу тэнцвэрт байдлыг хангасан зэргээр нь ангилж

тодорхойллоо.

Радиогийн мэдээ хүлээн авагчийн сонсохуйн мэдрэмжид тулгуурладаг учраас хэн ярьж байгаа, хэн ярилцлага өгсөн зэрэг оролцогч талуудын тодотголыг заавал хэлэхийг шаарддаг. Ингэснээр тухайн мэдээллийн бодитой байдал, итгүүлэн үнэмшүүлэх чадварыг бий болгодог билээ. Нийт судалгаанд хамрагдсан нэгж материалуудын 81,5 хувь нь эх сурвалжаа дурдаж, 18,4 хувь дурдалгүй өнгөрч байна. Ихэнхдээ дэлхийн мэдээнд эх сурвалжаа дурдалгүй өнгөрч байна. Түүвэрт орсон нийт сурвалжилгыг эх сурвалжийн тоогоор задлан үзлээ. Нэг эх сурвалжтай сурвалжилга 74,4 хувь, хоёр эх сурвалжтай 19,7 хувь, гурван эх сурвалжтай нь 5,8 хувийг эзэлж байна. Эдгээрийн 70,9 хувь нь албаны эх сурвалжийг голложээ. Энэ нь эх сурвалжийн тэнцвэрт байдлыг зарим талаар хангаж чадахгүй байгаагийн баталгаа юм.

Радиогийн мэдээ сурвалжилгуудад ажиглагдсан нэг дутагдалтай тал бол сэтгүүлчийн эрэл хайгуул юм. Идэвхгүй буюу “урсгал” мэдээнд хэтэрхий их ач холбогдол өгч олон нийтийн эрх ашигт шууд хандсан мэдээ, сурвалжилга бэлтгэх нь дутмаг байна. Чөлөөт сэтгүүл зүйн үндсэн хэмжүүрийн нэг бол иргэний сэтгүүл зүй, эрэн сурвалжлах үйл ажиллагаа юм. Монгол орны өнцөг булан бүрт хүрч буй өргөн нэвтрүүлгийн радиогийн хувьд Улаанбаатар хот тойрсон “урсгал” үйл явдлын мэдээ, сурвалжилгад илүү ач холбогдол өгч буй нь сонсогчдын хэрэгцээ шаардлагыг үл хангасан хэрэг юм. Нөгөө талаар өдрийн эхний мэдээллийн хөтөлбөрүүд ихэнхдээ олон улсын мэдээ, өмнөх өдөр болсон үйл явдлын тойм, эсвэл өмнөх өдөр болсон үйл явдлаас таслан авсан мэдээ, сурвалжилга байна. Гэтэл хүлээн авагчид өглөө ажилдаа явах цаг, орой ажлаас ирэх цагтаа машин дотор радио сонсох зан үйл нэгэнт тогтжээ. Радиогийн өглөөний оргил цагаар ийм мэдээлэл явуулж байгаа нь хүлээн авагчдыг өөрөөсөө түлхэж байгаатай ижил зүйл билээ. Тиймээс өглөөний оргил цагт ач холбогдол өгч энэ үеэр эрэн сурвалжлагчдын бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, иргэнлэг, нийгмийн шинж чанартай “ашигтай” мэдээлэл түгээх нь сонсогчдынхоо олон талт, өргөн хүрээний эрэлт хэрэгцээг хангах тустай төдийгүй тэднийг өөртөө татах нэг арга мөн билээ.

Дүгнэлт

Дээрх судалгааны үзүүлэлтийг нэгтгэж үзэхэд олон нийтийн радиогийн нэгж мэдээ, сурвалжилгууд нь радио сэтгүүл зүйн бүтээлд тавигддаг төрөл зүйл, тоо, цаг хугацааны хэмжээсийн шаардлагыг бүрэн хангаж байна. Харин агуулга сэдвийн хувьд хязгаарлагдмал байгаа нь сэтгүүлчид орон нутагт ажиллах боломж хомс байгаагийн илрэл юм. Эх сурвалжийг тооны талаас нь авч үзвэл нэг эх сурвалжит сурвалжилга давамгайлж байгаа нь радиогийн мэдээ, сурвалжилгын үргэлжлэх хугацаанаас хамаарч байгаа мэт боловч нөгөө талаас эх сурвалжийн олон талт байдал дутмаг байгааг харуулж байна. Цаашилбал 70-аас дээш хувь нь албаны эх сурвалж байна. Энэ үзүүлэлт нь мэдээллийн эх сурвалжийн тэнцвэрт байдал олон талт байдлаасаа төдийгүй чанарын хувьд алдагдсаныг харуулж байна. Олон улсын мэдээнд гадаад эх сурвалжаа ихэнхдээ дурдалгүй өнгөрч байгаа нь ч сонсогчдын итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

Дээрх судалгаагаар тодорхойлж гаргасан эх сурвалж, сэдвийн дутагдалтай байдал нь хүний нөөц, санхүүжилт зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Тиймээс МҮОНР өнөөгийн мэдээллийн зах зээлд өөрийн байр сууриа улам бэхжүүлж, сонсогчдын хүрээгээ тэлэхийн тулд үйл ажиллагааны шинэлэг, олон талт байдлыг нэвтрүүлэх нь зүйтэй юм. Ингэхдээ сонсогчдынхоо хүрээг алдахгүй байхын

тулд тэдний эрэлт хэрэгцээнд үндэслэсэн уян хатан төлөвлөлт, шуурхай байдлаа дээшлүүлж, зах зээлийн мэдрэмжтэй шинэлэг бүтээлийн олон талт байдлыг нэвтрүүлж ажиллах шаардлагатай байна.

Эшлэл

- Маклюэн, М. (2003). *Понимание медиа: Внешние расширения человека* (т. 27). Москва.
- Монголын Хэвлэлийн хүрээлэн. (2025). *Монголын хэвлэл мэдээлэл* (т. 36). Улаанбаатар.
- Чойсамба, Ч. (2011). *Сонины мэдээллийн бичлэгийн төрөл зүйл* (т. 5). Улаанбаатар.
- Норовсүрэн, Л., & Арнунзаяа, Н. (2010). *Радио сэтгүүл зүйн үндэс* (т. 244). Улаанбаатар.
- Барабаш, Л., & бусад. (2005). *Радиожурналистика* (т. 477). Москва.
- Зулькафиль, М., нар. (2021). *Сэтгүүл зүйн үндэс* (т. 278). Улаанбаатар.
- Батжаргал, Д., & Мэндхүү, Г. (2015). *Радиогийн тухай А–Я хүртэл* (т. 85). Улаанбаатар.
- Дойче Велле академи. (2006). *Радио сэтгүүлчийн гарын авлага*. Орчуулсан М. Мөнхмандах. Улаанбаатар.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Амарзаяа, Л. (2009). *Радио сонсох урлаг*. Улаанбаатар.
- Болор, Г. (2015). *Радио нэвтрүүлгийн дуун найруулгын онцлог* (Докторын диссертаци). Улаанбаатар.
- Батжаргал, Д., & Мэндхүү, Г. (2015). *Радиогийн тухай А–Я хүртэл*. Улаанбаатар.
- Барабаш, Л. Д., & бусад. (2005). *Радиожурналистика*. Москва.
- Дагиймаа, Д. (2009). *Радио сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар.
- Дойче Велле академи. (2006). *Радио сэтгүүлчийн гарын авлага*. Орчуулсан М. Мөнхмандах. Улаанбаатар.
- Зулькафиль, М., нар. (2021). *Сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар.
- Монголын Хэвлэлийн хүрээлэн. (2024). *Монголын хэвлэл мэдээлэл*. Улаанбаатар.
- Маклюэн, М. (2003). *Понимание медиа: Внешние расширения человека*. Москва.
- Норовсүрэн, Л., & Ариунзаяа, Н. (2010). *Радио сэтгүүл зүйн үндэс*. Улаанбаатар.
- Чойсамба, М. (2011). *Сонины мэдээллийн бичлэгийн төрөл зүйл*. Улаанбаатар.

Summary

The article discusses the analysis public radio news program. When the above research indicators are combined, public radio news and reports fully meet the requirements for radio journalism in terms of genre, number, time scale, and source level. However, the limited content and subject matter indicate that journalists lack opportunities to work in the local area. This depends on many factors, including human resources and funding.

Keywords: Radio journalism, public radio, audience, news, reportage, radio program.

БНХАУ-ЫН МОНГОЛ ХЭЛНИЙ ШИНЭ МЕДИАГИЙН ХЭРЭГЛЭГЧДИЙНСУДАЛГАА

Ү Тианбао (Wu Tianbao)*

**БНХАУ-ын ӨМӨЗО-ы Эдийн засаг, Аж ахуйн Их Сургуулийн Олон нийтийн
харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)*

*БНХАУ-ын ӨМӨЗО-ы нийгмийн шинжлэх ухааны төлөвлөгөөний чухал төсөл,
(бүртгэлийн дугаар: 2024NDA195)*

Түлхүүр үгс: Мэдээллийн шинэ технологи, шинэ медиа хэрэгсэл, хэрэглэгч, Өвөр Монголын сэтгүүл зүй, медиа платформ

Оршил. Мэдээллийн технологийн хөгжил хүмүүс хоорондын хэлний бэрхшээлийг багасгаж, хэвлэл мэдээллийн салбарыг ч олон хэл дээр, зардал багатайгаар мэдээллээ түгээх боломжийг бий болгосон билээ. Технологийн Вэб 1.0-ээс Вэб 3.0 хүртэлх шинэ медиа хэрэгслийн хэлбэр нь зөвхөн мэдээлэл түгээгч байгаад зогсохгүй бизнесийн загвар, мэдээллийн эко систем, орчин үеийн шинэчлэлтүүдийг авчирсан. Эдгээр шинэчлэлт нь үндэстэн хоорондын мэдээлэл солилцоо, харилцаа холбоо, интеграцлал, түүнчлэн монгол хэлийг түгээх шинэ талбаруудыг бий болгоод зогсохгүй урьд өмнө байгаагүй үр дүнтэйгээр хөгжүүлсэн юм. Ялангуяа БНХАУ дахь монгол үндэстэнд зориулсан шинэ медиа хэрэгслүүд монгол хэл, бичгээр дамжуулан тухайн улсын соёл, түүхийг харуулах чухал арга зам болж байна. Онлайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэдгээрийн гар утсанд зориулсан хувилбарт аппликейшнүүд зэрэг шинэ медиа нь мэдээлэл түгээхэд улам бүр чухал үүрэг гүйцэтгэж байна.

Нөгөө талаар сүүлийн үеийн шинэ медиа хэрэгслийн үзэгч, уншигч, сонсогчдыг “хүлээн авагч” гэсэн уламжлалт ойлголтыг ашиглан тайлбарлах, судлах боломжгүй болсон байна. Хүлээн авагчид бүрэлдэхэд нийгмийн янз бүрийн хүчин зүйлс нөлөөлдөг. Хүлээн авагчид нь зөвхөн технологийн бүтээгдэхүүн төдийгүй нийгмийн амьдралын бүтээгдэхүүн юм (McQuail, 1997). Макзуэлын энэ тайлбарын үүднээс авч үзвэл хүлээн авагчид нь зөвхөн хэвлэлийн мэдээллийн хэрэглэгчид биш тэд мөн нийгмийн үндсэн гишүүд, нийгмийн удирдлага, олон нийтийн харилцаанд оролцогчид юм (Чингуан Г., 2021). Тэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж мэдлэг олж авах, мэдээлэл авах эрхтэй. Тэдний нас ч мэдээллийн технологийн хялбар хэрэглээний үр нөлөөгөөр залуужиж байна. Сүүлийн зургаан сарын хугацаанд

интернэт ашигласан зургаа ба түүнээс дээш насны Хятад Улсын оршин суугчид бол Хятадын интернэт хэрэглэгчид юм (CNNIC, Хятадын интернэтийн хөгжлийн 31 дэх статистикийн тайлан, 2014) гэсэн үүднээс авч үзвэл Хятадын интернэт хэрэглэгчид бүгд онлайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, гар утасны аппликейшны үйлчлүүлэгчид буюу шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчид юм.

2024 оны зургаадугаар сарын байдлаар Хятад Улсын интернэт хэрэглэгчдийн тоо бараг 1.1 тэрбум болсон нь 2023 оны 12 дугаар сараас 7.42 саяар өссөн тоо бөгөөд интернэтийн нэвтрэлтийн түвшин 78.0% байна (CNNIC, Хятадын интернэтийн хөгжлийн 54 дэх статистикийн тайлан, 2024). 2017 оны байдлаар Хятад Улсад 100 гаруй радио, телевизийн суваг монгол хэлээр нэвтрүүлэг цацаж, 120 тогтмол хэвлэл, 21 сонин Хятад Улс дахь таван сая орчим монгол үзэгчдэд болон Монгол Улс зэрэг хөрш зэргэлдээ орнуудад төрөл бүрийн мэдээллийг хүргэж байжээ (Сариланг, 2017). 2017 онтой харьцуулахад уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо буурсан боловч монгол хэлээр мэдээлэл түгээх үйл ажиллагаа явуулж буй шинэ медиа хэрэгслийн тоо, төрөл зүйл өдөр бүр нэмэгдэж байна. Жишээлбэл, Хятадын Монголын мэдээний сүлжээ, CCTV.com (монгол хувилбар), Naolebao.com зэрэг монгол хэл дээрх онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээ, блог, микроблог, онлайн уран зохиол, соёлын үйлчилгээ үзүүлж байна. Ийм үйлчилгээ үзүүлэхэд гол платформууд нь монгол хэлээр iOS, Android болон бусад үйлдлийн системд урьдчилан суулгасан шинэ гар утасны терминалууд, Huluke, Mongolian Learning Pass, Bainu, Gaga Show, Chomog, egshig зэрэг программууд, WeChat, Douyin, Kuaishou, Xiaohongshu, Sina Weibo, мөн утасгүй дижитал телевиз, тээврийн хэрэгсэл дэх гар утасны телевиз, телевизийн байгууллага зэрэг багтаж байна.

Энэхүү судалгаа нь БНХАУ-ын монгол хэлний шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчидын ерөнхий дүр зургийг цогцоор нь, системтэйгээр танилцуулах бөгөөд үүнд тэдний сэтгэл зүй, зан үйлийн болон хэлний онцлогийг шинжлэн нэгтгэн дүгнэж, тэдгээрийг бүлгийн төрөлд ангилж үзсэн болно.

БНХАУ-д орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүлээн авагч буюу хэрэглэгчидын судалгаа нь Хятад Улсын шинэчлэл, өөрчлөлтийн дараа буюу 1978 оноос хойно гарч ирсэн шинэ үзэгдэл юм. (Гуанран & Шуанген, Шинэ эрин үеийн үзэгчдийн судалгааны тойм, орчин үеийн олон нийтийн харилцаа, 1999). 1982 онд БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Сэтгүүл зүй, харилцаа холбооны хүрээлэнгийн санаачилгаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн сүүлийн 40 гаруй жилийн хүлээн авагч буюу хэрэглэгчидын талаарх судалгааны үр дүнг нэгтгэсэн байна. Тухайлбал, 2001 онд хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглэгчидын судалгаагаар, Шанхай хотын оршин суугчдын 72.6% нь сонин тогтмол уншдаг, 88.1% нь телевиз үздэг, 36.1% нь радио сонсдог, 43.8% нь ном уншдаг, 7.5% нь интернэт ашигладаг бол Ланжоу хотын оршин суугчдын 71.6% нь сонин тогтмол уншдаг, 88.5% нь телевиз үздэг, 22.6% нь радио сонсдог, 55.8% нь ном уншдаг, 4.2% нь интернэт ашигладаг байсан байна. Энэ нь нийгмийн давхарга, боловсролд нөлөөлж “хүчтэй” болон “сул” бүлгүүдийн хооронд мэдлэгийн зөрүү их байгааг харуулж байна (Жиан & Фей, 2014).

Цаашилбал, 2013 оны “Шинэ медиа орчин дахь медиа хэрэглээний зан үйлийн онцлог шинж чанар: 2013 оны хотын хэрэглэгчдын шинэ медиа хэрэглээний зан үйлийн судалгааны тайлан”-д (Линнань, Жижин, & Вэйжун, 2014) дурдсанаар шинэ медиа хэрэгслийн давуу тал нь нэмэгдэж, дэлгүүр хэсэх, амьдралын хэв маягийн мэдээлэл авах хамгийн тохиромжтой суваг болж байгааг харуулж байна. Бээжин дэх шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдын зан үйлийн шинж чанарыг

нэгтгэн дүгнэсэн 2019 оны тайланд “хэрэглэгчид гурван шинж чанартай байдаг: шинэ медиа хэрэгслийг их ашигладаг, байр сууриа илэрхийлэх оролцоо их, шинэ медиа хэрэгсэлд сонирхолтой ч хэрэглээ нь бие даасан байдалтай” гэж онцолсон байна (Вэнбо, 2019). Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчидын судалгааны дүнг нэгтгэн үзэхэд, тэдгээр нь мэдээ мэдээллийн талаарх онолын судалгаа, мэдээллийн шинэчлэлийн эмпирик хэрэглэгдэхүүн, баримт нотолгооны мэдээллийн санг бүрдүүлээд зогсохгүй хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийн түүх болдог” (Гуанран & Шуангэн, Шинэ эрин үед манай орны үзэгчдийн судалгааны тойм ба үнэлгээ, 1999) байна.

Судалгааны асуулга, ярилцлага, ажиглалт хийж, ингэхдээ гол түүвэрлэлт + гүнзгий ярилцлага + ердийн түүвэрлэлт + газар дээрх уулзалт + квот түүвэрлэлт + оролцооны ажиглалтын арга зүйг ашиглалаа. Асуулга, ярилцлагын судалгаанд Хятадад амьдарч, суралцаж буй төрөл бүрийн мэргэжлийн ажилтан, ажилчид, оюутнууд хамрагдсан. “Гол түүвэрлэлт + гүнзгий ярилцлага”-д шинэ медиа хэрэгслийн үйл ажиллагаа, менежментэд оролцдог холбогдох засгийн газрын агентлаг, аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд багтсан болно. “Ердийн түүвэрлэлт + газар дээрх уулзалт”-д интернэт дэх нөлөөлөгчид, “квотын түүвэрлэлт + оролцооны ажиглалт”-д оролцогчдыг сонгохдоо хүн ам зүйн зарчмуудыг баримталж, хүйс, нас, мэргэжил, бүс нутаг, боловсролын түвшинд суурилсан шинжлэх ухааны харьцааг хангаж авсан болно. Онлайн болон офлайн аргаар нийт 510 хүчинтэй асуулгын хуудас, 29 хүнтэй ярилцлагын тэмдэглэл, 6 газар дээрх уулзалтын тэмдэглэлийг цуглууллаа. Энэхүү судалгааны өгөгдөл болон агуулгыг ӨМӨЗО-ы Нийгмийн шинжлэх ухааны төлөвлөлтийн төслийн судалгааны багийн 2024.09.01-11.30-ы хооронд “Монгол хэлний шинэ медиа хэрэгслийн бүтэц ба хойд хил хязгаарын соёлыг түгээх судалгаа”-ны хүрээнд судлаач нэгтгэж, шинжилсэн болно. Судалгаанд оролцогчдын 55.14% нь эмэгтэй, 44.86% нь эрэгтэй. Бүх оролцогч монгол үндэстэн байсан бөгөөд дийлэнх нь 30-40 насны (42.37%) болон 18 ба түүнээс доош насны (23.36%) хүмүүс байв. Ажил мэргэжлийн хувьд төрийн албан хаагчид/төрийн байгууллагын ажилтнууд хамгийн өндөр хувийг (37.38%), эзэлж байсан бол дараа нь оюутнууд (24.3%) орж байна. Оршин суугаа газрын хувьд судалгаанд оролцогчдын 47% нь хот суурин газар, 53% нь орон нутгийн иргэд байв.

Нийгэмс Судлаач Кацын санал болгосон “хэрэглээ ба сэтгэл ханамж”-ийн онол дээр үндэслэн авч үзвэл хэрэглэгчид тодорхой хэрэгцээгээ хангахын тулд монгол хэлний шинэ медиа хэрэгслээр харилцдаг гэж үзэж болохоор байна. Америкийн сэтгэл судлаач Маслоугийн санал болгосон физиологийн, аюулгүй байдал, хайр ба харьяалал, өөрийгөө үнэлэх, өөрийгөө танин мэдэх хэрэгцээ, мөн Хятадын сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны эрдэмтэн Пэн Ланы санал болгосон интернэт хэрэглэгчдийн харилцаа, агуулга, үйлчилгээний хэрэгцээнд үндэслэн энэхүү өгүүлэлд хэрэглэгчдын сэтгэл зүйн шинж чанарыг өөрийгөө танин мэдэх, хүрээлэн буй орчны талаарх мэдлэг, үйлчилгээг хүлээн зөвшөөрөх гэсэн гурван хэмжээсээр шинжилсэн.

“Хэвлэл мэдээллийн хүртээмж”-ийн онолын хүрээнээс эхлэн энэхүү өгүүлэлд шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдын идэвхгүй хүлээн авалтаас идэвхтэй болох, мэдээлэл хүлээн авахаас мэдээлэл түгээх, бараа бүтээгдэхүүн хэрэглэхээс контент үйлдвэрлэх хүртэлх өөрчлөлтийг шинжилж үзлээ. Хэрэглэгчдын сонголт, цаг хугацаа, сэдэл, туршлага, шинэ медиа хэрэгслийн хэрэглээний талаарх судалгааны үр дүнтэй хослуулан энэхүү өгүүлэлд тэдний зан үйлийн шинж чанарын талаарх ойлголтыг тодорхойлж гаргахыг зорьсон болно.

Монгол хэлний шинэ медиа хэрэгслийн харилцааны нийтлэг хэлний төрлүүдэд бичгийн хэл, өдөр тутмын ярианы хэл, интернэтийн хэл орно. Бичгийн хэл нь албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсвэл янз бүрийн мэдэгдлүүдэд түгээмэл байдаг бол өдөр тутмын ярианы хэл болон онлайн хэлийг богино видео платформууд болон янз бүрийн шинэ медиа хэрэгслийн шууд нэвтрүүлэгт ихэвчлэн ашигладаг.

1. Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн сэтгэл зүйн шинж чанарууд.

Нэгдүгээрт, Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн өөрийгөө танин мэдэх сэтгэл зүй. Хэрэглэгчдын өөрийгөө танин мэдэхүйг бий болгох нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн харилцааны үйл ажиллагаатай нягт холбоотой. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээллийг түгээх, хүлээн авах гэсэн харилцааны үйл явцад тэд өөрсдийгөө танин мэдэх зорилгоог тасралтгүй хэрэгжүүлж, улмаар өөрийн хувь хүний санал бодол нь боловсронгуй болж, тухайн хүний соёлын итгэлийг хүчтэй нэмэгдүүлдэг байна. “Монгол хэлний шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн өөрийгөө танин мэдэх сэтгэл зүйн хэрэгцээг хангаж чадах эсэх” гэсэн хэрэглэгчдын сэтгэл ханамжийн үнэлгээнээс харахад дээрх онолын таамаглал тодорхой болно. Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчид өөрсдийгөө соёлын хүчтэй итгэл үнэмшилтэй гэдэгт бат итгэдэг бөгөөд монгол хэлний шинэ медиа хэрэгсэл нь хувь хүний үйлдвэрлэл, амьдралд эерэг нөлөө үзүүлдэг, соёлын итгэлийг нэмэгдүүлэхэд тусалдаг гэдэгт итгэдэг гэж хариулсан байна. Үр дүн нь монгол хэлний шинэ медиа хэрэгсэл нь улсаа хайрлах, хамгаалах сэтгэмжийг бий болгох, соёлын итгэлийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгааг баталж байна.

Хоёрдугаарт, шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн байгаль орчны талаарх мэдлэгийн сэтгэл зүй. “Монгол хэлний шинэ медиа хэрэгсэл байгаль орчны талаарх мэдлэгийн сэтгэл зүйн хэрэгцээг хангаж чадах эсэх” талаарх асуулгын хариу хэрэглэгчид сэтгэл дундуур байгааг харуулж байв. Ихэнхдээ тэд байгаль орчны талаар гэр бүл, найз нөхдийн хуваалцсан контентыг илүүд үздэг нь эргэн тойрныхоо хүмүүсийн зөвлөмжид итгэх хандлага их байгааг харуулж байна. Үүний дараа албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэргэжлийн байгууллагууд орж байна.

Мэдээлэл технологийн хялбар хүртээмжит байдал нь нэг талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр удирдуулсан нийгэм бий болсонтой маргах аргагүй. Тиймээс судалгааны дараагийн асуулга “Монгол хэлний шинэ медиа хэрэгсэл нь үйлчилгээ хүлээн авах сэтгэл зүйн хэрэгцээг хангаж чадах эсэх” талаар байв. Хэрэглэгчдын сэтгэл ханамжийн үнэлгээг үзэхэд цөөнгүй хэрэглэгч сэтгэл дундуур байна. Тэд “монгол хэлний шинэ медиа хэрэгсэлд боловсорсон үйлчилгээний систем дутагдаж байна”, “янз бүрийн онлайн үйлчилгээний функцтэй монгол хэлний шинэ медиа хэрэгслийн тоо бага”, “монгол хэлний шинэ медиа хэрэгслийн үйлчилгээний функц хязгаарлагдмал байна” гэсэн хариултыг өгсөн байв.

2. Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн зан үйлийн шинж чанарууд.

Хэрэглээний сонголт ба сэдэл. Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчд хэрэглээний хувьд гар утсыг нэгдүгээрт сонгож хамгийн өндөр оноо өгч байв. Дараа нь зөөврийн компьютер болон таблетууд сонголтоороо зэрэгцэж ижил оноо авсан бол суурин компьютер хамгийн бага оноо авсан байлаа. Энэ нь хөдөлгөөнт төхөөрөмжүүдийн түгээмэл байдал болон хэрэглэгчдын медиа сонголтын олон янз байдлыг харуулж байна.

Төрөл бүрийн шинэ медиа хэрэгслийн дунд хэрэглэгчдын сонголтын давтамжийг дараах байдлаар эрэмбэлсэн: видео, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл,

цахим худалдаа, мэдээллийн байгууллагууд, засгийн газрын үйл ажиллагаа. Энэ нь хэрэглэгчдын видео контентэд дуртай байдал, нийгмийн үйл ажиллагаанд оролцох хэрэгцээ, онлайн дэлгүүрийн өргөн тархалтыг харуулж байна. Ихэнх хэрэглэгч Bainu, Gaga Show зэрэг бүхэлдээ монгол хэл дээр бүтээгдсэн аппликейшнуудын талаар хангалттай ойлголтоггүй байдаг тул сонголт болон хэрэглээний түвшин бага байна. Ийм сонголт хийж буй хэрэглэгчд нас залуу, хотжсон, өндөр боловсролтой гэдгээрээ онцлог юм.

Хэрэглээний сэдэл нь ерөнхийдөө хэрэглэгч өөрийгөө танин мэдэх, байгаль орчны талаарх мэдлэг, үйлчилгээ авах хэрэгцээ зэргээр шинэ медиа хэрэгслийг ашиглах сонирхолтой байна. Өөрийгөө танин мэдэхүйтэй холбоотой сэдлүүдийн дунд: харилцаа холбоо, өөрөөр хэлбэл найз нөхөдтэйгээ харилцах хэрэгцээ, монгол хэлний харилцаа холбооны хэрэгцээ зэрэг нь хамгийн өндөр оноо авсан нь нийгмийн хэрэгцээ болон янз бүрийн шинэ медиа платформ дээрх “найз нөхдийн хүрээлэл”-ийн хэрэглэгчдын хэрэглээний сэдэлд үзүүлэх нөлөөллийн ач холбогдлыг харуулж байна. Дараа нь сэтгэл хөдлөл, мэдрэмж, харьяалагдах байдал, аюулгүй байдлын хэрэгцээ, нийгмийн үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл оролцох, харилцан үйлчлэх, хуваалцах хэрэгцээ зэрэг орно. Байгаль орчны мэдлэгтэй холбоотой сэдлүүдийн хувьд олон хүн ахуй амьдралын мэдээллийг олж авахыг сэдэл болгон сонгосон бөгөөд мэдлэгээ өргөжүүлэх сонирхолтой байна. Үйлчилгээ авахтай холбоотой сэдлүүдийн хувьд: зугаа цэнгэл, чөлөөт цаг хамгийн өндөр оноо авсан бөгөөд дараа нь цахим худалдааны үйлчилгээ, олон нийтийн соёлын үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, төрийн үйлчилгээ орж байв.

Хэрэглээний хугацаа ба туршлага. DeFleur-ийн хэвлэл мэдээллийн системийн хамаарлын шинжилгээний хүрээнээс харахад хэрэглэгчд шинэ медиа хэрэгслээс өргөн хамааралтай байгааг харуулж байна. Шинэ медиа хэрэгслээр түгээж буй контентыг илүү сонирхож байгаа, шинэ медиа хэрэгслээр мэдээлэл, үйлчилгээ авах хэрэгцээгээ илүү сайн хангаж чадна гэж үздэгтэй нь холбоотой юм. Ихэнх хэрэглэгчд тодорхой шинэ медиа хэрэгслийн платформуудаас хамааралтай байгаа нь зугаа цэнгэл, сэтгэл хөдлөлийн резонанс, интерактив нөхцөл байдал, сэтгэл хөдлөлийн таних чадвараас үүдэлтэй байна. Тэд эдгээр платформуудыг өдөрт 1-2 цаг ашигладаг болохыг судалгаа харуулж байв.

Судалгаагаар монгол хэлний шинэ медиа хэрэгслийн ашиглалтын хугацаа дундаж үзүүлэлттэй байна. Урт хугацааны хэрэглээ (жишээлбэл, өдөрт 5-аас дээш цаг) мэдэгдэхүйц буурсан болохыг харуулж байна. Ашиглалтын хугацааны хувьд оргил цаг нь 7:00-9:00, 20:00-22:00, доод цэг нь 00:00-05:00 байна. Хэрэглэгчдын дийлэнх нь нэг удаагийн хандалтаар 15 минутаас бага хугацаа зарцуулж байв. Эндээс дүгнэхэд бүтээгдэхүүний хүртээмж, нийгмийн хүртээмж, гар утасны хүртээмж, хувь хүнд тохирсон контент, формат, сэтгэл хөдлөлийн туршлагыг санал болгодог шинэ медиа хэрэгсэл нь хэрэглэгчдын сонирхлыг илүү их татах магадлалтай байна. Судалгаагаар бичвэр мэдээ, график мессеж, аудио нэвтрүүлэгтэй харьцуулахад зураг дээр суурилсан контент, богино хэмжээний видео, цахим худалдааны шууд дамжуулалт, нөлөөлөгч-алдартнуудын шууд дамжуулалт нь үзэгчдэд сонирхолтой туршлага, сэтгэл ханамжийг өгөхөд чухал давуу талтай болохыг тогтоожээ.

Хэрэглээний үнэлгээ. Өнөөгийн байдлаар “тэнүүчилсэн уншигчид” гэсэн үзэгдэл хэрэглэгчдын дунд өргөн тархсан бөгөөд тэр нь хэрэглэгчд бичвэрийг өөрсдийн ойлголтод үндэслэн дахин тайлбарладаг тухай заасан юм. Өөрөөр хэлбэл, мэдээллийн үнэн бодит байдлыг хэрэглэгчид хэрхэн тодорхойлсон тухай асуудал болно. Судалгаагаар хэрэглэгчдын ихэнх нь “шинэ медиа хэрэгслээр дамжуулан

түгээсн контентыг дахин тайлбарласан эсвэл дахин бүтээсэн” гэж хариулт өгсөн байна. Хэрэглэгчид “чөлөөт цагийн хувилбарууд”-д хамгийн их анхаарал хандуулсан бөгөөд дараа нь “хөдөлгөөнт хувилбарууд” болон “ажлын хувилбарууд” орсон байв. Харилцааны хувьд хэрэглэгчдын ихэнх нь “хааяа харилцан үйлчлэх”-ийг сонгосон бол “хэзээ ч харилцан үйлчлэлцээгүй” хүмүүсийн харьцангуй өндөр хувь нь “байнга харилцан үйлчлэлцэх”-ийг илэрхийлсэн нь хэрэглэгчдын ихэнх нь хааяа оролцдог ч нэлээд хэсэг нь оролцдоггүй болохыг харуулж байна. Тус хариултуудыг задлан тайлбарлавал хэрэглэгчдын 85 хувь нь “монгол хэлний шинэ медиа хэрэгсэл дээрх мэдээлэл тодорхой хэмжээнд үнэн бодитой” гэж үзсэн бол 14.64% нь мэдээллийн үнэн бодит байдал тааруу гэж үзсэн байна.

3. Шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн хэлний онцлог шинж.

Нэгдүгээрт, бичгийн хэл. “Монгол хэлний шинэ медиа хэрэгсэлд хэрэглэж буй бичгийн хэллэгүүд”-ийг хэрэглэгчдын ихэнх нь сайшаасан боловч 16% нь муу гэж үзсэн байв. Сэтгэл ханамжгүй байгаагийн шалтгаан нь “бүтээлч сэтгэлгээ дутмаг”, “Хятадаас монгол руу орчуулахад сэтгэлгээнд тааруулдаггүй”, “логик болон дүрмийн алдаа гардаг” гэсэн байв. Үүний зэрэгцээ “бүтээлч бус” гэж хариулсан хүмүүс ерөнхийдөө их сургууль төгссөн буюу түүнээс дээш боловсролтой, 30-40 насныхан байсан нь өндөр боловсролтой хүмүүс бичгийн хэлний найруулгын өндөр хүлээлттэй байгааг харуулж байна.

Хоёрдугаарт, өдөр тутмын хэл яриа. “Монгол хэлний шинэ медиа хэрэгслээр гарч буй өдөр тутмын хэл яриа”-ны талаар хэрэглэгчдын сэтгэл ханамжийн үнэлгээнээс харахад “сэтгэл хангалуун” гэсэн хариулт харьцангуй өндөр байв. Гэсэн хэдий ч эерэг сэтгэгдэл нь бичгийн хэлний талаарх хариултаас хамаагүй бага байв. Сэтгэл дундуур байгаа шалтгаан нь “өдөр тутмын хэлэнд хараалын үгсийг байнга хэрэглэдэг”, “өдөр тутмын хэлийг ойлгоход амаргүй”, “өдөр тутмын хэлэнд бүдүүлэг, хар ярианы хэллэгийг байнга хэрэглэдэг”, “интернэтийн хэллэг нь монгол хэлний онцлог шинж чанаргүй”, “бүдүүлэг, садар самуун үгсийг байнга хэрэглэх”, “үг ярианы баялаг шинжгүй” гэсэн байв. Сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн хэрэглэгчдын цөөн хувь нь “интернэтийн хэллэг моодонд орж байна”, “интернэтийн хэл яриа орчин үеийн чиг хандлагад нийцэж байна”, “интернэтийн хэл яриа нь шинэ медиа хэрэгсэлд сайн тохирч байна” гэх мэт шалтгаануудыг дурдсан байсан. Монгол хэлний шинэ медиа хэрэгслээр гарч буй хэлний илэрхийллүүдэд хэрэглэгчдын ерөнхий хүлээлт нь тэд монгол хэлний хэрэглээний уламжлалыг дагаж мөрдөх, зохисгүй орчуулгаас зайлсхийх, соёлгүй үг яриаг арилгах, хэл ярианы баялаг байдлыг ашиглахад анхаарахыг хүсэж байв.

Дүгнэлт

БНХАУ-ын шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдийн сэтгэл зүй, зан үйл болон хэл яриа нь салангид тусгаарлагдмал ойлголт биш юм. Хэрэглэгчдын талаар судалгаа хийхдээ энэ бүх шинжийг хамтатган авч үзэж сайтар судалснаар орчин үеийн хэрэглэгчдийг таньж ойлгож, үүний үр дүнд хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагааг чиглүүлэх боломж бий болно. Дээрх судалгааг хийснээр монгол хэлний шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдыг гурван төрөлд хувааж болно гэж үзлээ. Үүнд идэвхтэй бүтээгчид, идэвхгүй хэрэглэгчид, зугаа цэнгэлийг чухалчилдаг хүмүүс. Идэвхтэй бүтээгчид нь мэдээллийг идэвхгүй хүлээн авахаас идэвхтэй сонгох, хэвлэл мэдээллийн хэрэглээнээс хэвлэл мэдээллийн үйлдвэрлэл, идэвхгүй санал хүсэлтээс идэвхтэй үнэлгээ, хөшигний ард байгаа нэрээ нууцлахаас идэвхтэй жинхэнэ нэрээр баталгаажуулах руу шилжсэн хэрэглэгчид юм. Энэ бүлэг нь өөрийгөө бүрдүүлэх

сэтгэл зүй, бизнес эрхлэх, орлого олох зорилготой, шинжлэх ухаанч хэвлэл мэдээллийн хэрэглээний зуршилтай, хэвлэл мэдээллийн хэлний илэрхийлэлд өндөр шаардлага тавьдаг.

Үүнд идэвхгүй хэрэглэгчид нь шинэ медиа хэрэгсэлд оролцоо, харилцан үйлчлэл, хэрэглээний түвшин багатай, эсвэл залилан мэхлэх үйл ажиллагааны платформ гэж үздэг хүмүүс юм. Тодруулбал, тэд хэзээ ч монгол шинэ медиа хэрэгслийг ашигладаггүй эсвэл чимээгүй сонсдог ч үүнийгээ нууцалдаг. Бас хуурамч нэрээр худал мэдээлэл түгээх, залилан мэхлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, дэг журмыг алдагдуулах зэргээр нөлөөлдөг. Харин зугаацуулах цэнгүүлэх контент сонирхогч бүлгийн зугаа цэнгэлийн зорилгоор монгол шинэ медиа хэрэгслээр харьцаж, хэвлэл мэдээллийн хүртээмж, хувь хүнд тохирсон зөвлөмж, хэрэглэгчийн туршлагыг сонирхдог. Монгол хэлний шинэ медиа хэрэгслийн хэрэглэгчдын дунд идэвхгүй хэрэглэгчид нь маш цөөнх байгаа бол зугаа цэнгэлийн чиг баримжаатай хэрэглэгчид нь хамгийн том бүлгийг бүрдүүлж байна. Технологийн хэрэглээний хувьд гар утас, гар утасгүй (зөөврийн эсвэл ширээний компьютер ашигладаг), холимог (гар утас болон компьютер хоёуланг нь ашигладаг) гэж ангилж болж байна. Хэрэглэгчдын шинэ медиа хэрэгслийг ашиглах сэдэл нь голчлон чөлөөт цагаа өнгөрөөх, харилцаа холбоо, зугаа цэнгэл, мэдээ мэдээлэл олж авах юм.

Хэрэглэгчдээр дамжуулж БНХАУ-ын монгол хэлний шинэ медиа орчныг судалж дараах дүгнэлтийг хийлээ. БНХАУ-ын Монгол хэлний шинэ медиа хэрэгслийн хамгийн том зорилго бол үндэсний соёлыг түгээх, нийт улсын түүхийг таниулах билээ. Дэлхийн хэмжээний, шинэ гол урсгал болгож монгол хэлний шинэ медиа хэрэгслийг бий болгохын тулд монгол хэлний хэвлэл мэдээллийн интеграцын хурдыг нэмэгдүүлэх, олон нийтийн үйлчилгээг хөнгөвчлөх шинэ стандартууд, төрийн үйлчилгээний системийг бий болгох нь хэрэглэгчдэд ойртсон хамгийн эхний алхам болно. Нөгөө талаар монгол хэлний шинэ медиа хэрэгслийн үйл ажиллагааны менежментийг сайжруулж, судалгаанд дурдагдсан зарим сул талыг анхааран ажилласнаар хэрэглэгчдийнхээ тоог нэмэгдүүлж хамгийн гол зорилго болох монгол хэлний шинэ медиа хэрэгслийн нөлөө бүхий орчныг бий болгоход чухал нөлөө үзүүлнэ.

Эшлэл

- Гуо Чингуан. (2012). *Харилцаа холбооны судалгааны курс* (т. 159). БНХАУ: Ренминь Их Сургуулийн хэвлэл.
- Хятадын Интернет Сүлжээний Мэдээллийн Төв (CNNIC). (2014). *Хятадын интернетийн хөгжлийн 31 дэх статистикийн тайлан*.
- Хятадын Интернет Сүлжээний Мэдээллийн Төв (CNNIC). (2024). *Хятадын интернетийн хөгжлийн 54 дэх статистикийн тайлан*.
- Сариланг. (2017). ӨМӨЗО дахь Монгол хэлний хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцаа холбооны хүчний өнөөгийн байдлын талаарх судалгааны тайлан. *Сэтгүүлийн форум*, №2.
- Ян Гуанран, & Цай Шуанген. (1999). Шинэ эрин үед миний эх оронд хийсэн үзэгчдийн судалгааны тойм, үнэлгээ. *Орчин үеийн харилцаа холбоо*, №2.
- Жан Жиан, & Шен Фэй. (2014). Шинэ харилцаа холбооны орчин дахь Хятадын үзэгчид: Ерөнхий шинж чанар ба бүлгийн ялгаа (1-р хэсэг). *Орчин үеийн харилцаа холбоо*, №3.
- Хэ Линнань, Жонг Жижин, & Кэ Вэйжун. (2014). Шинэ медиа орчин дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээний зан үйлийн онцлог шинж чанар: 2013 онд хотын үзэгчдийн шинэ медиа хэрэглээний зан үйлийн талаарх судалгааны

тайлан. *Сэтгүүлч*, №6.

- Куанг Вэнбо. (2019). Бээжин дэх шинэ хэвлэл мэдээллийн үзэгчдийн онцлог шинж чанарын талаарх судалгааны тайлан. *Сэтгүүл зүй ба бичих урлаг*, №6.
- McQuail, D. (1997). *Audience analysis* (p. 11). London.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Guo Чингуан. (2012). Харилцаа холбооны судалгааны курс (т. 159). БНХАУ: Ренминь Их Сургуулийн хэвлэл.
- 郭庆光. (2012). 《传播学教程》· 第159页· 中国人民大学出版社.
- Жан Жиан, & Шен Фэй. (2014). Шинэ харилцаа холбооны орчин дахь Хятадын үзэгчид: Ерөнхий шинж чанар ба бүлгийн ялгаа (1-р хэсэг). Орчин үеийн харилцаа холбоо, №3.
- 志安、沈菲. (2014). 《新传播形态下的中国受众：总体特征及群体差异（上）》载《现代传播(中国传媒大学学报)》· 2014年第3期.
- Куанг Вэнбо. (2019). Бээжин дэх шинэ хэвлэл мэдээллийн үзэгчдийн онцлог шинж чанарын талаарх судалгааны тайлан. *Сэтгүүл зүй ба бичих урлаг*, №6.
- 匡文波. (2019). 《北京市新媒体受众特征的调查报告》载《新闻与写作》· 2019年第6期.
- Сариланг. (2017). ӨМӨЗО дахь Монгол хэлний хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцаа холбооны хүчний өнөөгийн байдлын талаарх судалгааны тайлан. *Сэтгүүлийн форум*, №2.
- 日郎. (2017). 《内蒙古自治区蒙古语媒体传播力现状调查报告》载《新闻论坛》· 2017年第2期.
- Хятадын Интернет Сүлжээний Мэдээллийн Төв (CNNIC). (2014). Хятадын интернэтийн хөгжлийн 31 дэх статистикийн тайлан.
- 中国互联网络信息中心. (2014). 《第31次中国互联网络发展状况统计报告》.
- Хятадын Интернет Сүлжээний Мэдээллийн Төв (CNNIC). (2024). Хятадын интернэтийн хөгжлийн 54 дэх статистикийн тайлан.
- 中国互联网络信息中心. (2024). 《第54次中国互联网络发展状况统计报告》.
- Хэ Линнань, Жонг Жижин, & Кэ Вэйжун. (2014). Шинэ медиа орчин дахь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэрэглээний зан үйлийн онцлог шинж чанар: 2013 онд хотын үзэгчдийн шинэ медиа хэрэглээний зан үйлийн талаарх судалгааны тайлан. *Сэтгүүлч*, №6.
- 何凌南、钟智锦、可唯中. (2014). 《新媒体环境下的媒介使用行为特征——2013年城市受众新媒体使用行为调查报告》载《新闻记者》· 2014年第6期.
- Ян Гуанран, & Цай Шуанген. (1999). Шинэ эрин үед миний эх оронд хийсэн үзэгчдийн судалгааны тойм, үнэлгээ. Орчин үеийн харилцаа холбоо, №2.
- 鄢光让、蔡双根. (1999). 《我国新时期受众调查的回顾与评估》载《当代传播》· 1999年第2期.
- McQuail, D. (1997). *Audience analysis* (p. 11). London.

Summary

This paper discussed and analyzes the psychological, behavioral and linguistic characteristics of recipients from the perspective of new media, classifies the types of recipients, reveals their typical characteristics, and comprehensively and systematically presents the overall picture of Inner Mongolian new media recipients. The study suggests that Mongolian new media audiences can be divided into three types: active creators, passive recipients, and entertainment-oriented people. Mongolian new media recipients have high cultural confidence and high media literacy. Mongolian new media platforms are characterized by mobility, diversity, flexibility, and fragmentation.

Keywords: new information technology, new media, receiver, Inner Mongolian journalism, media platform

Б.ГАЛААРИДЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН ТОЙМ, СУДАЛГАА

Байгаль*

**МУБИС-ийн НХУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн докторант*

Түлхүүр үгс: Б.Галаарид, сэтгүүлч, сэтгүүл зүйн бичвэр, утга сэдэв, ур чадвар

Хураангуй. Монголын сэтгүүл зүй судлалын хөгжилд хүчээ өргөж яваа хүний нэг нь мэргэжлийн сэтгүүлч, судлаач, доктор Б.Галаарид болох юм. Тэрээр ажил амьдралын гараагаа орон нутгийн сониноос эхэлж, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллага болох Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн ерөнхийлөгч хүртэл алба хааж явахдаа төв, орон нутгийн тогтмол хэвлэлүүдэд бичиж нийтлүүлсэн түүний бүтээлүүдийг тоймлон судлахыг зорив.

Одоогоор олж цуглуулаад байгаа материалд үндэслэн бид Б.Галааридын бүтээлийг сэтгүүлчийн бүтээл, судалгааны бүтээл, уран зохиол, орчуулгын болон редакторласан бүтээл гэсэн таван төрлөөр ангилан судалж болохоор байна.

Мөн сэтгүүл зүйн 111 бичвэрийг утга сэдвээр нь танин мэдэхүйн, хүмүүн, байгаль экологи, улс төр, нийгмийн асуудал хөндсөн өгүүлэл, аян замын тэмдэглэл гэх мэт төрлөөр ангилан судлах боломжтой юм.

Сэтгүүл зүйн бичвэрийн хувьд, сурвалжилга, ярилцлага, сэтгүүл зүйн өгүүлэл, хөрөг, редакцын өгүүлэл, шүүмж, сэтгүүл зүйн эсээ зэрэг аль нь ч байдаг.

Тэдгээр бичвэрүүдэд Б.Галааридын нутаг байгаль, хүн зон, улс үндэстэнээ гэх төв үнэнч овор сэтгэлгээний хандлага хийгээд тодруун багтаамжтай гарчиглах, зураглан хөрөглөж өгүүлэх, энгийн ойлгомжтой хэл найруулгаар илтгэх ур чадвар тодорхой байна гэж үзэж байна.

Оршил. Сэтгүүлч, судлаач, сэтгүүл зүйн доктор /Ph.D/, Кино урлагийн дээд сургуулийн дэд професоор Бадам-Очирын Галаарид нь монголын сэтгүүл зүйн салбарт 40 гаруй жилийн хөдөлмөр, ухамсарт амьдралаа зориулсан, манай энэ цаг үеийн тэргүүлэх сэхээтэн, эрдэмтэн, сэтгүүлчийн нэг юм. Түүний уран бүтээл, судалгааны ажил нь олон талтай бөгөөд уран зохиол, сэтгүүл зүйн чиглэлээр голлох бүтээлээ туурвисан боловч мөн гоц үзэгдэл, далд ухамсар, бөө мөргөл, тэнгэр үзлийн талаар ч чамгүй олон бүтээл туурвиж, нийгэмд танигдсан судлаач хүн юм.

Бид энэ удаад зөвхөн сэтгүүлчийн хөдөлмөр, ур чадварыг нь онцлон, 1980-аад оноос хойш бичиж, төвийн болон орон нутгийн сонин, сэтгүүлд нийтлүүлсэн болон хожим нь дээжлэн эмхтгэл болгосон бүтээлд нь орсон нийтлэл, бичвэрийг тоймлон үзэж, зарим задлан шинжилгээ хийснээ толилуулж байна. Цаашид түүний олон талт бүтээлийг нарийвчлан судлах боломжтой бөгөөд салбар бүрийнх судалгааны тоймыг гаргаж, нэгдсэн том өгүүлэл бичих шаардлага бидэнд байгааг энд онцолж байна.

Нэг: Б.Галааридын намтар, түүний бүтээл

1. Судлаач Б.Галааридын товч намтар

Бадам-Очирын Галаарид нь 1966 онд Говь-Алтай аймгийн Бугат суманд төрсөн. Сумынхаа 8 жилийн сургуулийг 1982, Алтай хотын 10 жилийн 1-р дунд сургуулийг 1984, ЗХУ-ын Уралын их сургуулийн сэтгүүлчийн ангийг 1989 онд тус тус дүүргэсэн.

“Алтайн хөгжил” сонины сурвалжлагч (1989-1990), Улаанбаатар хотын төр, захиргааны хэвлэл “Улаанбаатар” сонины утга зохиолын нарийн бичгийн дарга, албаны дарга (1990-1991), “Монголын залуучууд” сонины сурвалжлагч (1993-1994), төрийн төв хэвлэл “Ардын эрх” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга (1995-1996), “Өнөөдөр” сонины анхны ерөнхий эрхлэгч (1996-1997), “Зууны мэдээ” сонины орлогч эрхлэгч, зөвлөх (2007-2010), “Монгол кино” нэгтгэлийн ерөнхий редактор (2002-2007) зэрэг алба хашиж байсан.

Мөн “Глоб Интернэшл төв” ТББ-ын Удирдах зөвлөлийн даргаар 10 жил, МҮОНРТ-ийн удирдах зөвлөлийн гишүүнээр зургаан жил, 2010-2018 онд Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан. 2018 оноос “Боловсрол, соёл, мэдээллийн гүүр” ТББ-ын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

2013 онд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртсэн. 2018 онд “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил” сэдвээр сэтгүүл зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн анхны доктор юм.

2. Б.Галааридын сэтгүүлчийн бүтээлүүд

Б.Галааридын сэтгүүлчийн бүтээлийг 1989 оноос өмнөх ба хойшхи гэж 2 ангилж болмоор байна. Түүний дунд сургуулийн сурагч байхдаа 1979-1984 онд төв, орон нутгийн сонинд нийтлүүлсэн бичвэрүүдийг идэвхтэн бичигч буюу сонирхогчийн, харин оюутан цагаас эхлэн 1985-1989 онд “Алтайн хөгжил”, “Хөдөлмөр”, “Залуучуудын үнэн” сонинуудад үйлдвэрлэлийн дадлага хийхдээ редакцийн даалгавар, томилолтоор бичиж нийтлүүлсэн бичвэрүүдийг нь дадлагажигч мэргэжлийн гэж үзэж болох бөгөөд 1989 оноос сэтгүүлдээр ажиллаж эхэлсэн цагаас хойш бичсэн бүх бүтээлийг нь мэргэжлийн бүтээл гэж үзэж байна.

1989 он хүртэл “Алтайн хөгжил”, “Пионерийн үнэн” сонин, Монголын радиогийн идэвхтэн бичигч байх үеийн бүтээлээс сонины бичвэр 18 олж, харин радио мэдээний бичлэг, эсвэл уг эх олдсонгүй. Харин 1990 оноос хойш төвийн сонин хэвлэлд нийтлүүлсэн сэтгүүл зүйн бүтээлээ эмхтгэн ном болгож хэвлүүлсэн нь бидний судалгаанд чухал баримт болов. Тэдгээрт өөрийнхөө гол гол нийтлэлийг эмхтгэн хэвлүүлсэн нь голчлон 1989 оноос хойшхи бүтээлүүд нь байлаа.

3.Б.Галааридын судалгааны бүтээлүүд

Б.Галааридын эрдэм шинжилгээ, судалгааны бусад бүтээлүүд сэдвийн хувьд өргөн, Монголын түүх, соёл, ёс заншил, өв уламжлал, шашин шүтлэг, уран зохиол зэрэг олон салбарыг хамарч байна. Тэрээр гоц үзэгдэл, шашин соёлын асуудлаар хүлээн зөвшөөрөгдсөн судлаачийн нэг бөгөөд “Гүртэн чойжинч” (2021), “Монголын тэнгэр үзэл, тэнгэр шүтлэг” (2024) нэг сэдэвт бүтээл хэвлүүлж, “Монголын нэрт зохиолч, төр нийгмийн зүтгэлтэн Ч.Лодойдамбын соён гэгээрүүлэлтийн үйл хэрэг”, “Тэнгэризм – Монголчуудын гүн ухаан”, “Монгол бөөгийн дахин сэргэлт”, “Төрийн тахилгат Ноён уул монголчуудын түүх, уламжлалт соёлын үнэт өвийг хадгалсан газар болох нь”, “Урианхайн түүхтэй холбоотой монгол бөөгийн багц домогт хийсэн шинжилгээ” зэрэг олон өгүүлэл, илтгэл бичсэн байна.

4.Зохиолч Б.Галааридын бүтээлүүд

Б.Галаарид нь Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, утга зохиолын шилдэг бүтээлийн “Алтан өд”, тайз, дэлгэцийн шилдэг бүтээлийн “Гэгээн Муза” шагналтан юм. Тэрээр залуу насандаа шүлэг, өгүүллэг бичих гэж оролдсон ч амжилт олоогүй бөгөөд зохиолч Ж.Дашзэвгийн хамт “Удам” нэртэй уран сайхны киноны зохиол бичсэнийг “Монгол кино” нэгтгэл 2003 онд дэлгэцийн бүтээл болгожээ. Улсын драмын эрдмийн театрын тайзнаа 2006-2012 оны хооронд түүний 3 жүжиг тавигдсан нь “Суудал” (найруулагч Б.Мөнхдорж), Шар тэнгисийн тарчлаан (найруулагч Б.Мөнхдорж), “Эсрэг дурлал” (найруулагч Ч.Найдандорж) зэрэг юм. “Суудал” жүжгийг зохиол оны шилдэгт өрсөлдөн тунаж, “Шар тэнгисийн тарчлаан” жүжгийн зохиолч, найруулагч, хэд хэдэн уран бүтээлчид оны шагнал хүртэж, “Эсрэг дурлал” жүжиг “Гэгээн Муза” наадмын гран-при шагналыг авч, тухайн үедээ ихэд үнэлэгдэж байжээ.

Харин “Тэнгэрийн аялгуу” (2014) ганц хүний жүжиг Д.Сангибатын найруулгаар гадаад, дотоодод олон удаа тоглогдож, шагнал хүртсэн бөгөөд Монголын анхны моно жүжгийн зохиол юм.

Зохиолч Б.Галаарид 2014 оноос хойш хэд хэдэн шалтгааны улмаас жүжиг, киноны зохиол бичээгүй бөгөөд урьд бичигдсэн жүжгийн зохиолуудаа ном болгон хэвлүүлээгүй, зарим зохиол нь үрэгдсэн байдалтай байна.

5.Орчуулагч Б.Галааридын бүтээлүүд

Б.Галаарид 1990-ээд оноос танин мэдэхүйн мэдээ материал орос хэлнээс орчуулж төвийн хэвлэлүүдэд нийтлүүлжээ. 2003 онд Жек Лондоны шилмэл өгүүллэгүүдийг орчуулан “Амьдрахуйн учир” нэрээр, 2009 онд дэлхийн түүхийн эцэг гэгддэг Геродотын “Түүх”-ийн нүүдэлчдэд хамааралтай дэвтэр, 2010 онд ХХ зууны дэлхийн шилдэг 50 романы нэг “Агуу Гэтсби”, 2011 онд оросын зохиолч Варлаам Шаламовын “Колымын өгүүллэгүүд”-ийг “Хорих лагерийн өгүүллэгүүд” нэрээр, 2019 онд Беларусийн сонгодог зохиолч Янка Купалагийн “Сонетууд”-ыг орчуулан хэвлүүлсэн байна. Тэрээр 2011 онд Варлаам Шаламовын өгүүллэгүүдийг орчуулсны төлөө МЗЭ-ийн “Алтан өд” шагнал хүртжээ.

Түүнээс гадна өөрийн сонирхон судалдаг хоёр дахь чиглэлээр олон материал орчуулж сонин сэтгүүлд нийтлүүлж ирснээс гадна П.Одинцовын “Бид бүгдээрээ зомби”, Илья Чусовын “Физикч-гоц мэдрэхүйтний тэмдэглэлүүд”, Константин Филимоновын “Парапсихологийн унших бичиг” номуудыг орчуулан хэвлүүлжээ.

6.Б.Галааридын редакторласан бүтээлүүд

Б.Галааридын мэргэжлийн үйл ажиллагааны нэг чиглэл нь ном, бичвэр редакторлах юм. Түүний редакторласан өгүүлэл, бичвэрийн тоог одоогоор бүрэн гаргах боломжгүй байна. Харин номын тухайд 30-аад ном товхимол байх ёстой гэж өөрөө хэлсэн бөгөөд бид 20 орчмынх нь мэдээллийг цуглуулав. Номоо уншуулж засуулж, өмнөтгөл хийлгэчихээд хэвлэхдээ өөр хүнийг редактор гэж тавих, эсвэл зөвхөн өмнөх үг бичүүлэх тохиолдлууд их байдаг бөгөөд тийм бүтээл одоогоор 10 гаруй бүртгэгдлээ.

Редакторууд ихэвчлэн нэг сэдвээр дагнан мэргэшсэн байдаг. Харин Б.Галааридын хувьд янз бүрийн сэдэвтэй, “солонгорсон” байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, сэтгүүл зүй, шашин судлал, бөө мөргөл, намтар судлал, уран зохиолын зэрэг сэдвийн хувьд харилцан хамааралгүй номуудын редактораар ажиллажээ.

Хураангуйлбал бид Б.Галааридын бүтээлүүдээс бид 224 бүтээлийг олж бүртгэв. Тэдгээрээс сэтгүүлчийн нийтлэл 162, сэтгүүл зүйн судалгааны өгүүлэл, шүүмж 26, сэтгүүл зүй судлалын бүтээл 19, өгүүлэл 7, зохиолчийн нийтлэл 17 тайз, дэлгэцийн бүтээл 6, орчуулгын бүтээл 8, жүжиг 3, редакторласан бүтээл 19 байна.

Хоёр. Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрт хийсэн ажиглалт, судалгаа

1. Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн тойм

Б.Галаарид 20 дугаар зууны наяд оны сүүлч, ерээд оны эхэн үеэс ямар нэгэн асуудлыг хөндөн, задлан шинжилгээ хийсэн нийтлэл, бичвэр, ярилцлага өгүүллүүдийг сонинд хэвлүүлжээ. Тэрээр сэтгүүл зүйн бичвэрүүдээрээ “Хөдөөний хүн” (1992), “Сэтгэлд уяатай Швейцарь орон” (2008), “Switzerland so close to our hearths” (2010 он), “La suisse, si proche de nos coeurs” (2010), “Мэдлэгийг мөнгө болгоё” (2010), “Хэвлэл улс төрөөр гачигдах уу?” (2010), “Номун салхины шивнээ” (2016), “Монголын шилдэг нийтлэл-58” (2018), “Төрт үнэлэгдэж, түмэнд танигдсан түшээ” (2020) зэрэг ном хэвлүүлжээ.

1990 оны сүүлчээс 2010 он хүртэл сэтгүүл зүйн сургалтын салбарт ажиллаж, сэтгүүлчдийг бэлтгэж ирсэн байна. Сэтгүүл зүйн судалгааны ажил нь ч энэ үйлстэй нь холбоотой. Жишээлбэл: түүний сэтгүүл зүйн судалгааны бүтээл “С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийн онцлог, ур чадвар” (2011) номыг дурдаж болно.

Сүүлчийн жилүүдэд тэрээр байгаль экологи, эдийн засаг, прапсихологийн чиглэлээр маш олон мэдээлэлтэй өвөрмөц нийтлэлүүдийг бичсэн байна. Энэ өгүүлэлдээ бид голдуу “Хэвлэл улс төрөөр гачигдах уу?”, “Номун салхины шивнээ”, “Монголын шилдэг нийтлэл-58”, “Мэдлэгийг мөнгө болгоё”, “Хөдөөний хүн” гэх таван бүтээлд үндэслэн Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийг тоймлон гаргалаа.

Хураангуйлбал, таван бүтээлд нийт 208 нийтлэл багтжээ. Үүнд, “Монголын шилдэг нийтлэл-58” дахь 68 нийтлэлийн 44 нь “Хэвлэл улс төрөөр гачигдах уу?”, “Номун салхины шивнээ” номд байгаа ба бусад 24 нийтлэл нь ер давхардаагүй. “Хэвлэл улс төрөөр гачигдах уу?” номын 13 нийтлэл нь “Монголын шилдэг нийтлэл-58” номд сонгогдон орсноос гадна давхцаагүй нийтлэл 26 бий. “Номун салхины шивнээ” номд “Монголын шилдэг нийтлэл-58” номд сонгогдон орсон 31 нийтлэлээс гадна, давхцаагүй нийтлэл бас 17 байна. “Мэдлэгийг мөнгө болгоё” номд нийт 37 нийтлэлээс 16 нийтлэл нь “Монголын шилдэг нийтлэл-58” номд сонгогдсон бөгөөд “Номун салхины шивнээ” номд нэг нийтлэл сонгогдсоноос гадна давхцаагүй нийтлэл 20 байна. “Хөдөөний хүн” номд нийт 16 нийтлэлтэй. Үүнд, 13 нийтлэл нь “Хэвлэл улс төрөөр гачигдах уу?”, “Монголын шилдэг

нийтлэл-58”-д тусдаа 12 ба 8 нийтлэл нь давхцаж, давхцаагүй нийтлэл гурав байна. Эдгээрийг нэгтгэвэл Б.Галааридын сэтгүүл зүйн 111 нийтлэл бидний судалгааны хэрэглэгдхүүн болж, дээрх бүх бичвэрийг үндэслэн дүн шинжилгээ хийв.

2. Сэтгүүлч Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн утга сэдэв, төрөл зүйл

Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн хамарсан утга сэдэв өргөн бөгөөд төрөл зүйл нь баялаг юм. Тэрээр хүмүүн, байгаль, нийгэм, танин мэдхүй, аян замд харсан мэдэрсэн зүйлээсээ сэдэвлэн мэдээ, сурвалжилга, ярилцлага, хөрөг, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, редакцын өгүүлэл, шүүмж, сэтгүүл зүйн эсээ зэрэг олон төрөл зүйлээр бичжээ.

Б.Галааридын мэргэжлийн ур чадварыг тод томруун харуулж чаддаг бичлэгийн төрөл зүйлийн нэг нь сурвалжилга юм. Түүний маш олон бичвэр нь сурвалжилгын үнэн бодит баримтад суурилсан байдаг. Жишээлбэл: “Хөвсгөлд онгоцны сүйрэл боллоо”, “Хөөрхий охин орос цэрэгт буудуулчихсан гэнэ лээ”, “Сэрүүн үхэл” зэрэг сурвалжилга нь бүр тухайн үед болсон буюу түүхэнд болж өнгөрсөн учрын тухай сэтгүүлчийн сурвалжлахаар дамжуулан, уншигчдын анхаарлыг татан, тухайн үйл явдал, холбогдол бүхий сүүлчийн мэдээлэл, байдал хандлага, хөгжлийн явцыг мэдээлж хүргэх ач холбогдолтой болжээ.

Сэтгүүл зүйн өгүүллийн чухал нэг төрөл зүйл бол асуудал дэвшүүлсэн өгүүлэл (Батбаатар.Ж, 2023, хууд. 122) юм. Б.Галааридын бүтээлүүдэд асуудал дэвшүүлсэн өгүүлэл ч олон байдаг. Үүнд энгийн амьдралаас шашин төр, улс гүрэн, эрдэмтэн чадвартан зэрэг олон хүрээ царт хамаардаг. Жишээлбэл: “Эрдэмтдийнхээ чансааг нээлттэй зарлая” гэдэг нийтлэлдээ жинхэнэ эрдэм чадварыг бадруулахыг хичээн чухалчилж, эрдэм шинжилгээнд оршиж буй зүй бус үзэгдлийг илчлэхийг дурдан, эрдэмтэн судлаачдын эрэмбийг үнэн зөв тогтоох, эрдэм шинжилгээний үнэн баттайг эрхэмлэн худал хуурамчийг тэвчихийг уриалсан байна. Энд сэтгүүлч, эрдэмтэн Б.Галааридын эрдэм номын үнэнч зан, үнэнээс зөвийг эрэхийг баримтлан чухалчлах хэрэгтэй гэдэг санаа тодорч байна. Үүнээс гадна, “Шашны хийрхлийг нам байгуултал дэвэргэх далд бодлого”, “Монголчуудыг чандарт мөргүүлж, их хааныг дорд үзэх нүгэлт сэтгэл”, “Хөрөг шатаах хийгээд аврахын цаана”, “Мунхаг сүсэг буюу тэнгэр цэвэрлэж, хаан тодруулагч”, “Хүнээ зөв таньж, шийдлээ зөв гаргах цаг” зэрэг маш олон асуудал дэвшүүлсэн нийтлэл бий.

Хүний тухай сэдэвт хувь хүмүүний хөрөг ба олны хүмүүний хамтын хөргийг онцлон бичсэн нь бий. Үүнд, голдуу содон хүмүүсийн тухай хөрөг бичиж олон нийтэд зориулан, итгэл зориг, ид хүч нэмэрлэсэн ач холбогдолтой. Жишээлбэл: “Монгол бахархлын нэгэн жишээ”-гээр орчуулагч, яруу найрагч О.Чинбаярын мэргэжилдээ үнэ цэнийг дээдэлдэг, зарчимтай байхыг эрхэмлэдэг шилдэг суртал, орчуулгын талаарх олноос хэтийдсэн мэдлэг чадвар, хатуужилтай хөдөлмөр, нарийн хянуур зан төрх зэргийг нь маш олон баримтаар харуулсан байна. Ёстой монгол бахархлын нэгэн жишээг хүүрнэн гаргасан юм.

Аян замын тэмдэглэл (Travelogues, travel notes) гэдэг нь “аяллын түүх” гэсэн утгатай үг юм. Сэтгүүл зүй, уран зохиолын дундын жанр гэгддэг тус төрөл хамгийн эртний төрлүүдийн нэг. (Батбаатар.Ж, Амартүвшин.С, Одмандах.М, 2025, хууд. 129) Аян замын тэмдэглэл нь голдуу сэтгүүлч 2007-2017 оны хооронд албан ажлаар харь гүрнээр явахдаа харсан, сонирхсон зүйлүүдээ тоймлон өгүүлсэн бичвэр болно. Гэхдээ харь нутгийн байгаль ахуйгаас хүн нийгэм, ялангуяа хөгжлийн тухай илүү дэлгэсэн утга сэдэв нь маш тод байна.

Танин мэдэхүйн сэдэвт нийтлэлүүд нь ер нь өөрийн улс үндэстэн, нутаг ус, шилдгээ бадруулан, хоцронгүйг халан сайжруулахыг санаачилсан санаа ил билээ. Жишээлбэл: “Ухааны ундрага нь ухаарал” нийтлэлдээ Ч.Даваадашийн “Бодол ухаарал” номын жишээнд монголчуудад хойч үеэ сурган хүмүүжүүлэх туршлага бүхий аман ба бичгийн амьдрахуйн ухааны ундраа баялаг байдгийг харуулжээ. Мөн залуу хойч үедээ өөрийн өв соёлоо танин мэдэж, сурталчлан бахархахын хүслийг дэвшүүлсэн билээ.

Байгаль орчноо хайрлах, хамгаалахыг чанга шаардсан утга сэдэв нь Б.Галааридын нийтлэлийн бас нэгэн чухал төрөл байгаа юм. Газар нутагтайгаа дайтсан гашуун түүх, одоо болж байгаа эвдэгдлийн үзэгдлийг зааж, монголчуудад газар аргилан гамнах монгол ухаан байдгийг нь сэнхрүүлэв. Жишээлбэл: “Сүрлэг хангайн ой хөвч зэрлэг хэрэглээний золиос болж байна” гэх нийтлэлдээ хүмүүн байгалийн харьцааны өнцгөөс харан, ихээр эвдэгдэж бий бодит жишээгээр үзүүлэн, үзэхэд ой мод хөөрхий, үнэндээ хүмүүн хөөрхий болохийг сануулсан утгатай.

Мөн “Намайг авраач” гэх ярилцлагад, архийг хүмүүнчлэн, архинд хохирогчтой хийсэн ярилцлага юм шиг амьд харилцан яриагаар хүмүүсийг ухааруулан сэнхрүүлэхийг санасан байна. Бас “Дэлхийн түүхийн эцэг-Геродотын суут бүтээл”, “Ц.Буянзаяагийн ‘Морин уруул’ шинэлэг сайхан бүтээл болжээ” гэх номын шүүмж бий. Эдгээр нь бусдын ном бүтээлүүдийн тухай үнэлэн, өөрийн үзэл бодлоо илтгэсэн шүүмж нийтлэл болно.

3. Б.Галааридын сэтгүүлчийн ур чадварын асуудал

Сэтгүүлч хүнийг үнэлэх нэг гол хэмжүүр бол мэргэжлийн ур чадварын асуудал юм. Судлаачид “Сэтгүүлч нь зүгээр л бичих төдий бус, сэтгүүл зүйн үйл ажиллагааны үе шат бүрт мэргэжлийн түвшинд ажил үүргээ гүйцэтгэх онол, арга зүйн мэдлэг, чадвар эзэмшсэн байх учиртай” (Батбаатар.Ж, 2023, хууд. 164) гэж үзэж байна.

Сэтгүүл зүйн бүтээл уншигчдын сэтгэл зүрхэнд хүрэх эсэх, хүмүүсийн санаанд урт удаан хугацаагаар оршиж санаж сэрэхийн дохио болох эсэх нь сэтгүүлчийн ур чадвараас гадна сэтгэлгээнийх нь онцлогоос хамаардаг. Сэтгэлгээний онцлог нь сэтгүүлчийг уран бүтээлчийнх нь хувьд үнэлэх гол хэмжүүрийн нэг юм.

А. Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэр дэх сэтгэлгээний шинэлэг хандлага

Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрүүдээс түүний нутаг байгаль, хүмүүн ард, улс үндэстэн, хэл соёлоо гэсэн чин санааны хандлага тодорхой харагдаж байна. Энэ нь түүний жинхэнэ сэтгүүлчийн хариуцлагат оворыг харуулах төдийгүй, хүмүүн мөс сайтайг ч үзүүлж байдаг. Жишээлбэл: “Цөлжилт гэтэн айсуйг өглөө бүр сануулъя”, “Монголын экологийн байдалд улс орнуудын хамтын хариуцлага чухал байна” зэрэг байгал экологийг чухалчлан сануулсан нийтлэлүүд бий. Бас “Хөдөөний хүн”, “Нүдүүрийн дуу”, “Сургийн газраас бараатай сумны минь хайрхад” зэрэг нутаг ус, хүн ардаа гэсэн сэтгүүлчийн санаа сэтгэлийн илэрхийлэл бүхий нийтлэл байна.

Ялангуяа “Монгол улс уу, монгол үндэстэн үү?”, “Монгол оюун дүрвэх биш хөрвөх ёстой”, “Хэлээ гээвэл бүхнээ гээнэ”, “Монголын төрд хэрэгтэй хүн”, “Авьяас бол ард түмний өмч”, “Уламжлалт монгол сургалтад авах юм их бий” зэрэг олон бүтээлүүдэд үндэстнээ таних, хэл соёлоо хамгаалах, авьяас билгээрээ, оюун ухаанаараа улс үндэстнээ хөгжүүлэхийг хүсэн санаачилсан сэтгэлгээний онцлог бий.

Түүний сэтгүүл зүйн бичвэрт ер нь эзэн хүмүүний хариуцлагат гүн сэтгэлгээ маш илэрхий байдгаараа ялгардаг. Тэрээр хүмүүн нийгэм, ажил амьдрал дунд оршиж бий асуудлыг гярхай харж, зоригтой ярьж, хүмүүст сэнхрүүлэл олгодог.

Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрт хүн зуныхаа тухай санаашрал, төв голч явах, алс хэдийн гүн бодлого, асуудлыг гүнзгий харах чадвар ч илэрч байдгийг доорх жишээнээс харж болно. “Зах нутгаар сонин юу байна”, “Хөгжлийн тухай ярианд умбасан өдрүүд” зэрэг нийтлэлээр хөдөө нутгаар мэдээ занги алдаг оног дуулдаг буюу үнэн худлын дундуур төөрөгдөн байгаа бодит байдалд санаашран, харь гүрнээс сэргэсэн хөжилтийг хүссэн сэтгэлгээ илэрсэн байдаг. Бас “Зөв хүн буюу шударга ёсны үнэ цэнийг ухаарагч”, “Ухааны ундрага нь ухаарал”, “Сайн санааны үзүүр сүү”, “Ухааны ир бяр тэгшрэхээр зөв санаа шийдэл төрдөг” зэрэг нийтлэлүүдэд нь зөв явах, төв шударга байх ба хүн ухаарч амьдрах, ухаанаараа шийдэх чухал гэдэг гүн гүнзгий бодол сэтгэлгээ илэрсэн байв.

Б. Б.Галааридын мэргэжлийн ур чадварын асуудал

Ур чадвар бол шилдэг сэтгүүлчийн бүрэлдүүлбээс зохих чухал нэгэн нөхцөл болно. Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрээс доорх ур чадвар харагдаж байна.

Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн гарчиг нь утга санаагаа багцалж чадсан, ил тодорхой, гүн ухаалаг, хошигнолын шинжтэй. Уншигчдад сэрэгдлийг өгч чадах бөгөөд анхаарлыг нь татах хүчтэй. Жишээлбэл: “АН-ын үед барьсаныг нурааж, МАН-ын үед тарьсныг хатаах аян”, “Намрын ялаа шиг олширсон найр наадам”, “Үнэнийг үнэгүйдүүлэх санаархал”, “Өрөөлийг өмөөрөөд өөрөө хохиров” зэрэг нийтлэлийн гарчгууд үнэнээс гажисан, бодитойгоос хэтийдсэн зэрэг ил тод хошигнолын хөг аястай байхад, “Итгэл гайхамшгийг бүтээдэг”, “Хэлээ гээвэл бүхнээ гээнэ”, “Монгол бол биеэ үнэлэх сайхан хүүхэн биш”, “Монгол оюун дүрвэх биш, хөрвөх ёстой” зэрэг нийтлэлүүд нь итгэл сэтгэлийн хүчин, хэлний чухал чанар, өөрийн хүчирхэгжлийг сануулан заасан гүн ухаалаг утга санаа тодорч байна. Бас “Амьдралын ухаантай хүн төрд түшиг болох нь илүү”, “Хөгжлийн галт тэргэнд амжиж суухын учир”, “Эзэн нь элэвч гавьяа нь үлдэнэ”, “Сүрлэг хангайн ой хөвч зэрлэг хэрэглээний золиос болж байна”, “Архинаас татгалзсан Хэнтийчүүд өөдрөг, өнгөлөг байна” гэх мэтийн маш олон нийтлэлүүдийн гарчигт агуулга санаа, ач холбогдол шууд тодорхой илэрч байна.

Хэл найруулга нь энгийн, тодорхой, ойлгомжтой байна. Жишээлбэл: “Дөрөвтийн системээр дөнгөхгүй нь ээ” гэдэг нийтлэлд, дөрөвтийн систем гэдгийг хэрэглээд ямар ч үр ашиг авчирч чадаагүй тухайн бодит байдалд өөрийн үзлээ илтгэхдээ *“Монгол ширээ дөрвөн хөлтэй гэдэг монголдоо л таарсан онол юм. Дөрөвтийн системээр цаашид явна гэвэл дөнгөхгүй нь ээ. Ажилтай нэртэй ажилгүйчүүдээ хийх юмтай, идэх хоолтой болгосон. Үйлдвэр нэртэй үйлдвэрлэлгүй газруудаа ажилд оруулахсан. Чингэж чадсан цагт дөрөвтийн систем нь ч байна уу, чөтгөрийн систем нь ч байна уу надад хамаа алга, буянаараа болог...”* гэв (Галаарид.Б, 2018). Энэ мэтээр Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн хэл найруулгад уяналж уран сайханжуулах чимэг, чамирхал байхгүй, үнэнч энгийн товч тодорхой, санаа гүн, тусгал гүн зэрэг өөрийн гэсэн өнгө аяс нийтлэг харагдаж байна.

Зураглан хүүрнэх чадвар сайтай. Б.Галаарид бодит дүрслэг зураглан өгүүлж чаддаг. Орчин үеийн хандлагаар авч үзвэл, улс төрийн шог нь сэтгүүл зүйн өгүүлэл гэх ангилалд хамаардаг бөгөөд бичвэрийн бусад зүйлүүдийг бодвол дүр дүрслэлийг чөлөөтэй гаргах, өгүүлж буй сэдэвт тохирох дүр, үйл явдал бодож олох зэрэг харьцангуй чөлөөтэй ажиллах боломж олддог. Б.Галаарид бол

бичвэртээ хошигнолын шинжтэй гарчиг өгдөг бөгөөд ёжлол буюу улс төрийн шог ч туурвидаг. Жишээлбэл: “Өөр гаригийнхныг сурвалжилсан минь” гэх нийтлэл бол нэгэн хувь ёжлол болно. Тус нийтлэлд, нэгдүгээр биеийн бичлэгийн аргаар монгол орон буюу монгол улсын бусад улс орноос ялгарсан онцлогийг маш амьд дүрслэг, бодитой жишээнд ёжлон өгүүлж, ухааруулан сэнхрүүлэхийг хүссэн байна. Үүнд, хүн ардын танилтын хязгаардмал тал буюу дэлхий ертөнцөөс зайдсан хоцронгуй байдал, сайхан байгалаа хайрлах талаар анхаардаггүй буюу бусад орныхон үнэт эрдэнийг нь малтахад хориг саат тавидаггүй бөгөөд хамтардаг сонин үзэгдэл, мод шороо, уул ус эвдрэхэд сэтгэл шаналдаггүй байдалд тэднийг уулаасаа энэ нутгийн уугаал иргэд биш хэмээн ёжолжээ. Энэ мэтчилэн хот суурин дахь чанар тохиролцоо муутай өндөр давхар барилга, хүн ардын ажил амьдралын зохицол алдагдал, уран бүтээлч авъяас билгийн булагдал, соёл заншлын гээгдэл, газар нутгийн алдагдал, архи дарсны шунал, хүн чанарын доройтол зэргийг олон талаас нь гаргаж, зураглан өгүүлсэн байна. Үүгээр дамжаад сэтгүүлч Б.Галааридын давшингүй ертөнцийн үзэлт, өөдрөг амьдрахуйн үзэлт, юуг эрхэмлэх, юуг цээрлэх, юуны төлөө гэдэг өртгийн үзэлтийг нь олж харна. Энэ бүхэн нь уншигчдын сэтгэлийг яахын аргагүй хөндөх нөлөө үйлдэлтэй гэдэг нь маргашгүй.

Хөрөглөх чадвар тодорхой. Б.Галааридын сэтгүүл зүйн бичвэрийн мэргэжлийн ур чадварыг тод томруун харуулж чаддаг бичлэгийн төрөл зүйлийн нэг нь хөрөг юм. Тэрээр “Онцгой цаг үе л түүхэн хүмүүнийг төрүүлдэг”, “Эзэн нь элэвч гавьяа нь үлдэнэ”, “Монгол бахархлын нэгэн жишээ”, “Эгэлгүй хүчитнүүд, хосгүй дуучид, эрдэмт мэргэдийн удам”, “Уралын нийслэлээр овоглосон нэг ангийнхан” зэрэг маш олон хүний тухай нийтлэл бичжээ. Үүнд, ярилцлага, сурвалжилгын мэдээлэлд үндэслэн бүтсэн хувь хүмүүний хөрөг байх бөгөөд ярилцлага, хөргийн эзний талаарх баримт мэдээллийн цогцолборын үндсэн дээр төрсөн бүлэг хүмүүний хөрөг аль нь ч бий.

Дүгнэлт

Бид Б.Галааридын уран бүтээлийг ерөнхийлөн тоймлож, таван төрөлд ангилж үзэв. Эндээс тэрээр зөвхөн сэтгүүлч биш судлаач, зохиолч, олон салбарт сонирхолтой судалгаа хийсэн эрдэмтэн болохыг харуулж байна.

Түүний сэтгүүлчээр ажиллах хугацаандаа бичсэн сэтгүүл зүйн 111 бичвэрийг ажиглаж үзэхэд утга сэдвээр нь танин мэдэхүй, хүн, байгаль экологи, улс төр гэж ангилж болохоор байна.

Төрөл зүйлийн хувьд үйл явдлыг харуулсан сурвалжилга, нийгмийн асуудал хөндсөн өгүүлэл, аяны тэмдэглэл, ярилцлага, сэтгүүл зүйн эсээ гэх мэтийн төрлөөр голлон туурвиж байсныг харж болохоор байна.

Сэтгүүл зүйн бичвэрүүд нь Б.Галааридын эх нутаг, байгаль экологи, хүн зон, улс үндэстэнийхээ төлөө гэх сэтгэлгээний хандлага тод илэрч, хэл найруулгын хувьд энгийн ойлгомжтой, бичлэгийн хувьд олон талтай, сэтгүүлчийн хувьд өөрийн гэх өнгө аястай, ур чадвартай шилдэг сэтгүүлч болох нь тодорхой харагдаж байна.

Эшлэл

Галаарид.Б (2011). *С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийн онцлог, ур чадвар.*

Улаанбаатар хот. Цалиг хэвлэлийн газар

Галаарид.Б (2011). *С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийн онцлог, ур чадвар.*

уб: Цалиг.

- Батбаатар.Ж. (2023). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Батбаатар.Ж, Амартүвшин.С, Одмандах.М. (2025). *Практик сэтгүүл зүй*. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (2011). *С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийн онцлог, ур чадвар*. Улаанбаатар хот. Цалиг хэвлэлийн газар.
- Галаарид.Б. (2018). *Монголын шилдэг нийтлэл-58*. Улаанбаатар хот: “Мөнхийн Үсэг” ХХК.

Ашигласан бүтээлийн жагсаалт:

- Батбаатар.Ж. (2023), “*Суурь сэтгүүл зүй*”. Редактор: Б.Чинзориг, Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (1992), “*Хөдөөний хүн*”. Улиастай.
- Галаарид.Б. (2008), “*Сэтгэлд уяатай Швейцарь орон*”; “*Switzerland so close to our hearths*”, “*La suisse, si proche de nos coeurs*”. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (2010), “*Мэдлэгийг мөнгө болгоё*”. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (2010), “*Хэвлэл улс төрөөр гачигдах уу?*”. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (2016), “*Номун салхины шивнээ*”. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (2020), *Төрд үнэлэгдэж, түмэнд танигдсан түшээ*. Улаанбаатар хот. Цалиг.
- Галаарид.Б. (2014), “*Монголын шилдэг нийтлэл*” цувралын 58-р боть. Улаанбаатар хот.
- Галаарид.Б. (1993), Бүдүүлэг бичих нь хэвлэлийн эрх чөлөө биш. “*Сэтгүүлч*” сэтгүүл.
- Галаарид.Б. Хэвлэл улс төрөөр гачигдах уу? “*Ням гараг*” сонин. 1995.02.19.
- Галаарид.Б. Сонины бизнес. “*Ням гараг*” сонин. 1995.02.19.
- Галаарид.Б. Иргэний сэтгүүлзүй сайн байна уу? galaarid.blogspot.com. 2006.11.28.
- Галаарид.Б. Мөнгөний сэтгүүлзүй. galaarid.blogspot.com. 2006.12.17.
- Галаарид.Б. Шинэ сэтгүүл зүйн үүр хаяарч байна. galaarid.blogspot.com. 2007.01.03.
- Галаарид.Б. (2011), С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийн онцлог, ур чадвар. Улаанбаатар хот. “*Цалиг*”. 2011. х.х.7
- Галаарид.Б. (2018), Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. Улаанбаатар хот. “*Цалиг*”.
- Галаарид.Б. (2021), “Монголын үнэн” сонины бодит түүх. Ред. М.Одмандах. Улаанбаатар хот. Цалиг.
- Галаарид.Б. (2009), Сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг боловсруулах нь. “Хэвлэлийн өөрийн зохицуулалт” гарын авлага. Улаанбаатар хот. х.15-22.
- Галаарид.Б. Монголын шинэ сэтгүүл зүйг түүхчлэх асуудалд// МУИС. НШУС. Эрдэм шинжилгээний бичиг. 2013. №14(393). х.219-225.
- Галаарид.Б. Монголын чөлөөт хэвлэлийн улстөрийн орчин // МУИС. НШУС. Эрдэм шинжилгээний бичиг. 2016. №17(457). Х.121-127.
- Галаарид.Б. (2016), Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал // “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар хот. х.33-38.
- Галаарид.Б. Монголын хэвлэл мэдээлэл хэний гарт байна вэ? // “ХИХ зүйл ба эрх зүйн орчин” хэлэлцүүлэг. УБ., 2008.12.08.
- Галаарид.Б. Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлт шинэчлэлийн эзэд нь байж чадах уу? // ХХ, Фридрих Эбертийн сан. “Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүлчдийн хөдөлмөрлөх эрх” хэлэлцүүлэг. УБ., 2013.05.02.
- Галаарид.Б. Монгол-Оросын хэвлэл мэдээллийн салбар дахь хамтын ажиллагаа // Монгол, Оросын сэтгүүлчдийн анхдугаар форум. УБ., 2016.05.16.
- Галаарид.Б. Цахим сэтгүүл зүйн тулгын гурван чулуу нь профессионализм, ёс зүй, нийгмийн хариуцлага байх ёстой //Монголын цахим сэтгүүлзүйн анхдугаар форум. Улаанбаатар хот. 2015.05.01.


- Галаарид.Б. Хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны өчигдөр, өнөөдөр: Хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо //Хятад, Монголын хэвлэл мэдээллийн VIII форум. Рашаан хот. 2017.11.22.
- Галаарид.Б. Ардчилсан сэтгүүл зүйн өчигдөр, өнөөдөр, маргааш // “Үндсэн хууль ба хэвлэн нийтлэх эрх чөлөө – 30 жил” хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн чуулган. Төрийн ордон. 2022.I.12.
- Галаарид.Б. (2020), Гүртэн чойжинч. Улаанбаатар хот. Цалиг. 2020.
- Галаарид.Б. (2020), Монголын тэнгэр үзэл, тэнгэр шүтлэг. Улаанбаатар хот. Цалиг.
- Галаарид.Б. Монголын нэрт зохиолч, төр нийгмийн зүтгэлтэн Ч.Лодойдамбын соён гэгээрүүлэлтийн үйл хэрэг (Үндсэн илтгэл) // “XX зууны монгол уран зохиолын үнэт зүйл ба Ч.Лодойдамба” эрдэм шинжилгээний хурал. 2017.X.10. Улаанбаатар.
- Галаарид.Б. “Тэнгэрэм – Монголчуудын гүн ухаан” // “Рерих нар ба Монгол” олон улсын II хурал. 2019.VIII.16-18. Улаанбаатар.
- Галаарид.Б. Монгол бөөгийн дахин сэргэлт // МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Монгол Улсын ҮАБ-ын зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын төвөд сувлалын холбоо. “Төр, сүм хийдийн харилцааны өнөөгийн сорилт” эрдэм шинжилгээний хурал. МУИС-ийн номын сан. 2022.V.13.
- Галаарид.Б. Төрийн тахилгат Ноён уул монголчуудын түүх,уламжлалт соёлын үнэт өвийг хадгалсан газар болох нь (үндсэн илтгэл) // “Төрийн тахилгат Ноён уулын түүх, соёл” эрдэм шинжилгээний хурал. 2022.V.14. Сэлэнгэ аймаг. Мандал сум.
- Галаарид.Б. Урианхайн түүхтэй холбоотой монгол бөөгийн багц домогт хийсэн шинжилгээ // Урианхай, тува түмний түүх, соёл, өв уламжлал” олон улсын эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар. 2022.XI.25.

Summary

Ph.D. B.Galaarid, a professional journalist and researcher, is among those who have actively contributed to the development of journalism studies in Mongolia. Beginning his career at a local newspaper and later serving as President of the Mongolian Journalists' Union, he has published extensively in both national and regional print media.

Based on the materials collected to date, this study aims to review and analyze his works, which may be grouped into five categories: journalistic writing, scholarly research, literary works, translations, and edited publications. His 111 journalistic texts may also be classified thematically into cognitive and educational pieces, human-interest writing, environmental and ecological works, political and social issue-based articles, and travel reports. These texts encompass a wide range of journalistic genres, including reportage, interviews, feature articles, profiles, editorials, criticism, and journalistic essays throughout these writings, Galaarid demonstrates a consistent worldview grounded in attachment to his homeland, nature, and national identity. His works are further characterized by concise and expressive titles, vivid descriptive imagery, and a writing style that is clear, straightforward, and accessible.

Keywords: B. Galaarid, journalist, journalistic writing, themes, writing skills



Сэтгүүлийн тухай

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимээс эрхлэн гаргадаг “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний сэтгүүл нь 2001 оноос хойш сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны салбарыг хамарсан эрдэм шинжилгээний ажлуудыг тогтмол хэвлэж ирсэн.

Хянан магадалгаа бүхий “Сэтгүүл зүй” сэтгүүлийн бүх өгүүлэл МУИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн нэгдсэн системд нээлттэй байршдаг бөгөөд 2024 оноос өгүүлэлд DOI дугаар олгож эхэлсэн.

Сэтгүүлд сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны салбарын онол, практик, түүх, шүүмж судалгааг хэвлүүлэх боломжтой.

About the Journal

The academic journal Journalism, published by the Department of Journalism and Mass Communication at the National University of Mongolia (NUM), has regularly disseminated scholarly research in the fields of journalism and mass communication since 2001.

All articles published in the peer-reviewed Journalism journal are openly accessible through the unified system of NUM academic journals, and since 2024 the journal has started assigning DOI numbers to its publications.

The journal welcomes submissions that address theoretical, practical, historical, and critical research in the areas of journalism and mass communication.

Хаяг: МУИС-ийн хичээлийн II байр, 204 тоот, Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим.
Утас: 976-77307730-2314
И-мэйл: iderjargal@num.edu.mn, zulikafili@num.edu.mn

